

МОНГОЛ УЛСЫН СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ
СОЁЛ УРЛАГ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

“СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙН СУДАЛГАА”

УЛААНБААТАР

2019

ГАРЧИГ

НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

А/ Тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, шинжилгээ хийх

I. Хэрэглэгчийн судалгаа.

I.1. Судалгааны зорилго, зорилт, хамрах хүрээ

I.2. Судалгааны түүвэрлэлт

I.3. Судалгааны асуулга боловсруулалт

II. Экспертүүдийн судалгаа

II.1. Судалгааны зорилго, зорилт, хамрах хүрээ

II.2. Судалгааны хамрах хүрээ, түүвэрлэлт:

II.3. Судалгааны асуулга боловсруулалт

Б/ Чанарын судалгаа

I. Чөлөөт ярилцлага

II. Контент анализ

III. Судалгааны харьцуулалт

В/ Судалгааны хүрээнд ашиглагдсан нэр томъёо, ойлголт, үзэл хандлага, ухагдахууны тухайд.

ХОЁР. СУДАЛГААНЫ ҮР ДҮН НЭГТГЭЛ.

II.1 Хэрэглэгчээс авсан социологийн судалгааны нэгтгэл

II.2 Экспертүүдээс авсан социологийн судалгааны нэгтгэл

II.3 Чөлөөт ярилцлага: үр дүн, дүгнэлт

II.4 Контент анализ: үр дүн, дүгнэлт

II.5 Судалгааны харьцуулалт: Дүгнэлт

ГУРАВ. СОЁЛЫН ТӨВ, СОЁЛЫН ОРДНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

III.1. Соёлын төв, соёлын ордны үйлчилгээний өнөөгийн байдал

III.2. Соёлын төв, соёлын ордноос зохион байгуулагддаг сургалтын үйл ажиллагаа

III.3. Соёлын төв, соёлын ордны үйлчилгээний чанар хүртээмж

III.4. Үйлчилгээний орчин

ДӨРӨВ. СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЙЛЧИЛГЭЭГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

ТАВ. СОЁЛЫН ТӨВ, СОЁЛЫН ОРДНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ СТАНДАРТЧИЛАХ НЬ: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

ДОЛОО. АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ЭХ СУРВАЛЖ

НАЙМ. ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

А/ ТООН МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ.

I. Хэрэглэгчийн судалгаа.

I.1. Судалгааны зорилго, зорилт, хамрах хүрээ

“Соёлын үйлчилгээний хүртээмжийн судалгаа”-ны хүрээнд хийгдэж буй хэрэглэгчээс авах социологийн судалгаа нь аймаг нийслэл, сум дүүргийн болон бүс нутгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх зорилго бүхий орон нутгийн соёлын байгууллага¹ болох соёлын төв, соёлын ордны үйл ажиллагаа, үйлчилгээний өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөн хүртээмж, чанарыг сайжруулахад тулгамдаж буй асуудлуудыг томъёолон тус байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах арга замыг тодорхойлох **зорилгыг** дэвшүүлсэн болно.

Дээрх зорилгын хүрээнд дараах **зорилтуудыг** дэвшүүлэн тавилаа.

- Соёлын төв, ордны үйл ажиллагаа, үйлчилгээний байдалд дүн шинжилгээ хийх
- Соёлын төв, ордны үйлчилгээний хүрэлцээ, хүртээмжийн өнөөгийн байдлыг судлах
- Соёлын төв, ордноос иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох

Судалгааны хамрах хүрээ:

Улсын Их хурлаас 2001 онд баталсан “Монгол улсыг бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлал”-ын дагуу нийгэм эдийн засгийн таван бүсийг төлөөлүүлэн сонголт хийхдээ зөвхөн соёлын төв үйл ажиллагаа явуулдаг орон нутаг буюу Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Төв аймгуудыг сонгосон болно.

Харин Улаанбаатарын бүсэд харьяалагдах дүүргүүдийн соёлын ордны үйл ажиллагаа, үйлчилгээний байдалд дүн шинжилгээ хийн, хүрэлцээ, хүртээмжийн өнөөгийн байдлыг судалж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлохын тулд тодорхой респондентуудаас судалгаа авсан болно. Мөн бидний дэвшүүлсэн зорилго, зорилтод нийцэх зарим асуудлуудыг Нийслэлийн соёл урлагийн газар, Бүтээлч үйлдвэрлэл, инновацийн төвөөс 2018 онд хийсэн “Нийслэлийн соёл, урлагийн байгууллагын өрсөлдөх

¹Тус судалгаанд зөвхөн төрийн буюу орон нутгийн өмчийн, төрөөс санхүүждаг орон нутгийн соёл, урлагийн байгууллагыг хамруулан авч үзсэн болно.

чадварыг дээшлүүлж, соёлын үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэх төсөл боловсруулах суурь судалгаа” ны тайлангаас эшлэн ашигласан болно.

I.2. Судалгааны түүвэрлэлт

Түүвэрлэлтийн нэгж: Соёл урлагийн байгууллагын, тэр дундаа төрийн мэдлийн соёлын төв, соёлын ордны үйлчилгээ, үйл ажиллагааны чанар хүртээмж, тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга замын талаар сүүлийн жилүүдэд бүхэлд нь болон хэсэгчлэн олон талаас нь судалсан байна. Тухайлбал: 2001 онд “Монголын соёл урлагийн салбарын менежментийг боловсронгуй болгох үндсэн асуудал”, 2003 онд “Соёлын бодлого, соёл урлагийн байгууллагын санхүүжилт”, 2007 онд “Соёлын үйлчилгээ-хүний хөгжилд”, 2008-2009 онуудад “Соёл урлагийн салбарын хөгжил”, 2010 онд “Хүн амд хүргэх соёл урлагийн үйлчилгээний тулгамдсан асуудлууд”, 2013 онд “Монголын соёлын үйлдвэрлэл, соёл, урлагийн хувьсал, өөрчлөлт”, 2018 онд “Нийслэлийн соёл, урлагийн байгууллагын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, соёлын үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэх төсөл боловсруулах суурь судалгаа” зэрэг судалгаануудад соёл урлагийн байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагааны хүртээмж, чанар, тулгамдаж буй асуудлуудыг судалсан бөгөөд эдгээр нь ихэвчлэн хэрэглэгч, үйлчлүүлэгчийн үнэлгээ, сэтгэл ханамжийн талаас нь авч үзсэн байдаг.

Иймээс аймаг нийслэл, сум дүүргийн хүн амд соёл урлагаар үйлчилдэг, төрийн мэдлийн орон нутгийн соёлын байгууллагад ажилладаг, тулгамдаж буй асуудлуудыг цаг үргэлж мэдэрч, мэдэж байдаг тус байгууллагын эрхлэгч, мэргэжилтнүүд, ажиллагсад, сонирхогчидоос судалгаа авбал мэргэжлийн болон сонирхогчийн үүднээс үйл ажиллагаа, үйлчилгээний өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, тулгамдаж буй асуудлуудыг томъёолон, шийдвэрлэх арга замыг тодорхойлоход илүү бодит, үр дүнтэй шийдэл болно гэж үзсэн учир судалгаанд хамрагдах эх олонлогийн хэмжээг соёлын төв, соёлын ордонд ажиллагсдын тоогоор жишин авч үзлээ.

Судалгааны эх олонлог:

Бүс, аймгууд:

Хүснэгт №1

Бүс	Бүсээс сонгогдсон аймаг	Боломжит респондентууд
Баруун бүс	Баян-Өлгий, Говь-Алтай, Увс	295
Хангайн бүс	Архангай, Баянхонгор, Өвөрхангай	304
Зүүн бүс	Дорнод, Сүхбаатар, Хэнтий	281
Төвийн бүс	Төв аймаг, Дорноговь	115
		995

Улаанбаатарын бүс, дүүргүүд:

Хүснэгт №2

Дүүрэг	Респондентууд
Багануур	33
Багахангай	14
Баянгол	34
Баянзүрх	16
Налайх	24
Сонгинохайрхан	14
Сүхбаатар	=
Хан-Уул	21
Чингэлтэй	7
	163

Түүвэрлэлт

А. Бүс, аймгууд:

Сонгож авсан аймгуудын соёлын төвөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагааг үнэлж дүгнэх чадвартай боломжит респондентууд буюу эх олонлог /N/-ийг 995 гэж үзэн, түүврийн хэмжээ /n/-г тооцоолохдоо итгэх түвшинг өндөр байхаар, эх олонлогийн 40, түүнээс дээш хувийг хамарсан байх нь зүйтэй гэж судалгааны багийн зүгээс тогтов.

Хүснэгт №3

Бүс	Бүсээс сонгогдсон аймаг	Судалгаанд оролцсон респондентууд
Баруун бүс	Баян-Өлгий, Говь-Алтай, Увс	100
Хангайн бүс	Архангай, Баянхонгор, Өвөрхангай	141
Зүүн бүс	Дорнод, Сүхбаатар, Хэнтий	120
Төвийн бүс	Төв аймаг	50
	Нийт	411

Судалгаанд оролцогсад эх олонлогийн 41, 3 % хүрсэн байна.

Б. Улаанбаатарын бүс, дүүргүүд:

Хүснэгт №4

Дүүрэг	Судалгаанд оролцсон респондентууд
Баянгол	34
Баянзүрх	2
Сонгинохайрхан	25
Сүхбаатар	30
Хан-Уул	30
Чингэлтэй	30
Нийт	151

Мөн судалгааны хүрээнд дэвшүүлсэн зорилго, зорилгод нийцэх зарим асуудлуудыг “Нийслэлийн соёл, урлагийн байгууллагын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, соёлын

Үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэх төсөл боловсруулах суурь судалгаа²-ны тайлан²гаас бидний судалгааны онолын хэсэгт болон судалгааны дүгнэлтэд шууд эшлэн оруулсан учир нь дээрх судалгааны эх олонлог нь бидний судалгааны арга зүйд бүрэн нийцсэнд оршино.

Судалгааны түүвэр³

Хүснэгт №5

№	Дүүргүүд	Дүүргийн хүн ам		Түүвэр хэмжээ	Нийслэлийн соёлын ордны ажиллагчид		
		Тоо	Хувь		Нийт тоо	Судалгаанд оролцогчид	
						тоо	Хамрагдсан хувь
1	Баянгол	221,384	16.4	77	-	-	-
2	Сүхбаатар	138,047	10.2	41	-	-	-
3	Баянзүрх	336,932	25.0	112	16	15	93.8
4	Хан-Уул	169,726	12.6	46	21	8	38.1
5	Сонгинохайрхан	322,458	23.9	164	14	9	64.3
6	Чингэлтэй	159,051	11.8	44	7	4	57.1
	Төвийн дүүргүүд /6/	1,347,598	100	493	58	36	62.1
7	Багахангай	4,100	5.9	79	14	13	92.9
8	Багануур	28,787	41.2	77	33	27	81.8
9	Налайх	36,911	52.9	80	24	17	70.8
	Алслагдсан дүүргүүд /3/	69,798 1,417,396	100	236 720	71 129	57 93	80.3 72.1

I.3. Судалгааны асуулга боловсруулалт

Хэрэглэгчээс авах судалгааны асуулгыг төслийн хүрээнд давшүүлсэн зорилго, зорилтуудыг хангахаар тооцоолон дараах чиглэлүүдээр боловсруулсан болно.

Үүнд:

- ✓ Судалгааны анкет бөглөгч буюу респондентуудын ерөнхий мэдээлэл
- ✓ Соёлын төв, ордны үйлчилгээний чанар
- ✓ Соёлын төв, ордны үйлчилгээний хүртээмж

² Нийслэлийн соёл урлагийн газар, Бүтээлч үйлдвэрлэл, инновацийн төвөөс 2018 онд хийсэн судалгаа.

³ Нийслэлийн соёл урлагийн газар, Бүтээлч үйлдвэрлэл, инновацийн төвөөс 2018 онд хийсэн судалгаа.

- ✓ Соёлын төв, ордны үйлчилгээний талаарх сэтгэл ханамж
- ✓ Соёлын төв, соёлын ордны тохижилт зэрэг болно.

Асуулгыг⁴ Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн соёл судлалын секторын эрдэм шинжилгээний ажилтнууд хэлэлцэн баталлаа. Нийт 562 оролцогчийн 3934 асуулгын хуудас бүхий судалгааны үр дүнг SPSS 20 программ ашиглан боловсруулав.

II. Экспертүүдийн судалгаа

II.1. Судалгааны зорилго, зорилт, хамрах хүрээ

Соёлын төв, соёлын ордноос хүн амд хүргэх соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад нэн тэргүүнд шийдвэрлэвэл зохих асуудлуудыг тодорхойлох зорилгоор экспертүүдээс “Соёлын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах арга зам” сэдэвт судалгаа авсан болно. Харин хамрах хүрээ, түүвэрлэлтийн хувьд зарим нэг байдлаараа хэрэглэгчээс авах “Соёлын үйлчилгээний хүртээмжийн судалгаа”-наас арай өөр, онцлогтой юм. Тус экспертүүдийн судалгааг нийгэм эдийн засгийн бүсээр ангилан орон нутгийн хэмжээнд соёл урлагийн бодлогыг боловсруулагч, бодлогын хэрэгжилтийг зохицуулагч, хэрэгжүүлэгчдээс түүвэрлэн авсан болно.

II.2. Судалгааны хамрах хүрээ:

Хүснэгт №6

Бүс	Бүсээс сонгогдсон аймаг
Баруун бүс	Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс
Хангайн бүс	Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай
Зүүн бүс	Дорнод, Сүхбаатар, Хэнтий
Төвийн бүс	Төв аймаг, Дорноговь, Өмнөговь

II.3. Судалгааны асуулга боловсруулалт

Экспертүүдээс авах судалгааны асуулга нь нийт 28 асуулттай бөгөөд Үүнд:

- Судалгааны анкет бөглөгч буюу экспертүүдийн ерөнхий мэдээлэл
- Соёлын төв, ордны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга зам
- Соёлын төв, ордны санхүүжилтийн байдал, ажилтнуудын санаачилга, боловсролын төвшин, ур чадвар, тулгамдаж буй асуудлууд, баримтлах хэм хэмжээ, жишиг стандартын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох бүлэг асуудлуудыг хамарсан болно.

Экспертүүдээс авах судалгааны асуулгыг⁵ Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн соёл судлалын секторын ажилтнууд хэлэлцэн баталлаа.

⁴ Хэрэглэгчээс авах социологийн судалгааны асуулгыг “Соёлын үйлчилгээний хүртээмж судалгаа”-ны төслийн тайлангийн хавсралтанд хавсаргасан болно.

⁵ Асуулгыг “Соёлын үйлчилгээний хүртээмж судалгаа”-ны төслийн тайлангийн хавсралтанд хавсаргалаа.

Б/ ЧАНАРЫН СУДАЛГАА.

I.1. Чөлөөт ярилцлага

Чанарын судалгааны хүрээнд соёл урлагийн салбар, тэр дундаа соёлын төв, соёлын ордны хөгжил, бодлого, үйл ажиллагааны талаар хангалттай мэдлэг, мэдээлэлтэй төрийн захиргааны байгууллагын төлөөлөл, соёлын төв, ордны дарга, менежерийн дунд тусгай хөтөлбөрийн дагуу чөлөөт ярилцлага хийн анхдагч мэдээлэлийг цуглуулсан болно.

Ярилцлагыг

1. Соёлын төв, соёлын ордны өнөөгийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийн байдал
2. Соёлын төв, соёлын ордонд мөрдөгддөг үлгэрчилсэн дүрэм, стандартын хэрэгцээ, шаардлага
3. Соёлын төв, соёлын ордонд орон нутгийн онцлогийг харуулсан соёл, зан заншлын холбогдолтой соёлын үйл ажиллагаа зохион байгуулах боломж, нөхцөл
4. Соёлын ордон, соёлын төвийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга зам
5. Соёлын үйлчилгээний үр дүнг үнэлэх аргачлал, үйл ажиллагааг боловсронгуй болгоход анхаарах зүйл гэсэн чиглэлүүдээр зохион байгуулахаар төлөвлөсөн болно.

Чөлөөт ярилцлагын хамрах хүрээ

Хүснэгт №7

Бүс	Бүсээс сонгогдсон аймаг
Баруун бүс	Баян-Өлгий, Ховд, Увс
Хангайн бүс	Архангай, Баянхонгор,
Зүүн бүс	Дорнод, Сүхбаатар, Хэнтий
Төвийн бүс	Төв аймаг, Дорноговь, Говьсүмбэр

II.1 Контент анализ

“Соёлын үйлчилгээний хүртээмжийн судалгаа”-г авах явцдаа сонгогдсон, тухайн нийгэм эдийн засгийн бүсэд хамаарах аймгуудын орон нутгийн соёлын байгууллагын удирдах болон мэргэжлийн ажилтнуудыг оролцуулсан уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж соёлын төвийн үйл ажиллагаа, үйлчилгээний өнөөгийн байдал, хүртээмж, чанарыг сайжруулах зэрэг олон талт тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцсэн ба тус зөвлөгөөний протокол-тэмдэглэл хөтөлж эрдэм шинжилгээний эх хэрэглэгдэхүүн бэлдсэнээс тус судалгаанд ашиглагдах шинэ сэтгэлгээ, оновчтой санал, бодит тохиолдол /кейс/-ыг контент анализ болгон ашиглахаар төлөвлөсөн болно.

III.1 Судалгааны харьцуулалт

Соёл урлагийн салбарын бодлого, төлөвлөлт, хөгжил, өнөөгийн байдал, менежмент, тулгамдсан асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга зам зэргийн талаар сүүлийн жилүүдэд олон талаас нь судалсан захиалгат судалгаа, тухайлбал нийтдээ 10 хийгдсэн байна.

Эдгээр судалгаа нь орон нутгийн хүн амд соёл, урлагаар үйлчлэх нийгмийн чиг үүрэг бүхий соёлын төв, соёлын ордонтой хамааралтай асуудлуудыг бүхэлд нь болон хэсэгчилсэн байдлаар судалжээ. Эдгээр судалгааны материалыг харьцуулан судалж, шаардлагатай дүгнэлт саналыг эш татан ашигласан болно. Тухайлбал: Соёлын үйлчилгээ-хүний хөгжилд, Соёл урлагийн салбарын хөгжил, Хүн амд хүргэх соёл урлагийн үйлчилгээний тулгамдсан асуудлууд, Монголын соёлын үйлдвэрлэл, соёл, урлагийн хувьсал, өөрчлөлт зэрэг судалгаануудад дурдагдсан соёл урлагийн байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагааны хүртээмж, чанар, тулгамдаж буй асуудлуудтай холбоотой санал зөвлөмж, дүгнэлтийг бид судалгаандаа харьцуулан ашигласан болно.

В/ СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД АШИГЛАГДСАН НЭР ТОМЪЁО, ОЙЛГОЛТ, ҮЗЭЛ ХАНДЛАГА, УХАГДАХУУНЫ ТУХАЙД.

1. Үйлчилгээ. Үйлчилгээ түүний мөн чанарыг тодорхойлохыг оролдсон 10 гаруй тодорхойлолт байдаг. Тухайлбал:

- Үйлчилгээ нь бодит бус шинж чанартай бөгөөд үйлчлүүлэгч, эсвэл тэдний эзэмшилд байгаа өмч хөрөнгөтэй харьцдаг, өмчлөлийн шилжилтийг бий болгодоггүй үйл ажиллагаа юм.
- Үйлчилгээ нь орц, нөөц хоёрын нэгдэл, орц+нөөц-ийг бүтээгдэхүүн болгон хувиргах ноццлийн хувиргалт бөгөөд үйлчилгээний үйлдвэрлэл нь бодит бүтээгдэхүүнтэй ойр, эсвэл огт холбоогүй байдаг гэх мэт.

Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангах бодит бүтээгдэхүүн, эсвэл үйл ажиллагааг бүхэлд нь бүтээгдэхүүнд тооцдог тул бүтээгдэхүүн ба үйлчилгээ нь бүтээгдэхүүний дэд категориуд болно. Судлаач Kotter P бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар 5 ялгаатай ойлголт байна гэж үзжээ. Үүнд:

- Цэвэр бүтээгдэхүүн - уран зураг, хивс, хөөрөг, ном гэх мэт
- Бодит бүтээгдэхүүн үйлчилгээтэй хавсарсан- компьютер
- Гибрид буюу саармаг- бодит бүтээгдэхүүн ба үйлчилгээ тэнцүү оролцдог рестораны үйлчилгээ, номын үзэсгэлэн худалдаа
- Туслах бүтээгдэхүүн ба үйлчилгээтэй хавсарсан гол үйлчилгээ- номын сангийн үйлчилгээ, музейн үемэр, үзэсгэлэн тайлбарлах, агаарын тээврийн нэгдүгээр зэргийн аялал
- Цэвэр үйлчилгээ- хүүхэд асрах, сурталчилгаа гэх мэт.

Үйлчилгээг мөн эх үүсвэрээр нь **техник технологид, хүнд** үндэслэгдсэн, ердийн ажиллах хүч шаардсан, мэргэжилтэй ажилчин шаардсан, тодорхой мэргэжил ур чадвар шаардсан үйлчилгээ гэх мэтээр ангилах нь ч бий. Ер нь **“үйлчилгээ”** гэдэг нь үйлдвэрлэлийн эцсийн үр дүн нь материаллаг зүйлс болон байгууламж бус, харин үйлдвэрлэгдсэн даруйдаа хэрэглэгдэж, худалдан авагч, үйлчлүүлэгчийн хүсэл сонирхол, хэрэгцээг ханган биет бус хэлбэрээр илрэх, үйлчлүүлэгчийн тохь тух, зугаа цэнгэл, цаг хугацааг хэмнэсэн түргэн шуурхай чанартай, сэтгэл ханамж, эрүүл мэнд зэрэг үнэт зүйлсийг буй болгодог эдийн засгийн үйл ажиллагаа юм. Аливаа үйлчилгээ дараах онцлог шинж чанарыг агуулна.

2. Үйлчилгээний шинж чанарууд.

Хүснэгт. №8

Үйлчилгээний шинж	Удирдлагад анхаарах зүйл
Үл мэдрэгдэх шинжтэй	Бодитой биш: Үйл ажиллагаа ба туршлага нөлөөлнө. Загварчлах боломж багатай: Худалдан авагчид эрсдэл өндөртэй. Урьдчилан үзүүлэх боломж бага: Ялгаварлахад бэрхшээлтэй. Патентлах боломж бага: Оролтын саад багатай.
Эх үүсвэрээсээ салшгүй шинжтэй	Худалдан авагч үйлдвэрлэлд оролцдог. Найрсаг харилцаа бий болгох. Бусад үйлчлүүлэгчид нөлөөлдөг. Хяналтын асуудлууд чухлаар тавигддаг. Үйлчилгээний орчин бизнесийн ялгааг бий болгох Ажилчдын хоорондын харилцаа нөлөөлдөг.

	Хувь, хүмүүсийн хоорондын эелдэг харилцааг хэвшүүлэх
Чанар нь нэгэн хэвийн бус шинжтэй	Стандарчлах боломж бага: Хүмүүсийн идэвхи оролцоо нөлөөлдөг. Чанарт хяналт тавихад хүндрэлтэй. Орчин нэгэн хэвийн биш тул.
Хадгалагдахгүй шинжтэй	Хадгалж болдоггүй: Бодит биш шинжтэй учраас. Эрэлт бөөгнөрөлийн бэрхшээл. Бүтээмж багасдаг. Үйлчилгээний зардал тооцох хүндрэлтэй: Үнийн асуудлыг тооцоход хүндрэлтэй.
Эзэмшигддэггүй шинжтэй	Үйлчлүүлэгч үйлчилгээг эзэмшдэггүй: Үйлчилгээ үйлчлүүлэгчээс ангид учраас.

3. Бүтээгдэхүүн үйлчилгээний хоорондох ялгаатай шинж чанарууд.

Хүснэгт. №9

Бүтээгдэхүүн	Үйлчилгээ	Үр дүнгийн хамаарлууд
Мэдрэгдэх	Үл мэдрэгдэх	Үйлчилгээг бүртгэж дансалж болохгүй; Үйлчилгээг патентлах боломжгүй; Үйлчилгээг хялбархан илэрхийлэх боломжгүй; Үнэ бүрдүүлэлт нь ярвигтай;

Стандартчилагдсан	Чанар нь олон төрлийн	Үйлчилгээний нийлүүлэлт, худалдан авагчдын сэтгэл
-------------------	-----------------------	---

		Ханамж нь ажиллагсдын үйл ажиллагаанаас шалтгаална. Энд үйлчилгээг үзүүлж буй өрсөлдөгчид юуг төлөвлөсөн, идэвхижүүлсэн талаархи мэдээлэл найдваргүй.
Үйлдвэрлэл нь хэрэглээнээс тусдаа	Үйлдвэрлэл хэрэглээ хоёр нэг зэрэг	Үйлчилгээнд худалдан авагчид оролцох ба үйл ажиллагаанд нь нөлөөлнө. Худалдан авагчид нэг нэгэндээ нөлөөлнө. Ажиллагсад үйлчилгээний үр дүнд нөлөөлнө. Өөрөө удирдах ёс чухал байж болно. Их хэмжээний үйлдвэрлэл явуулахад бэрхшээлтэй.
Хадгалагддаг	Хадгалагддаггүй	Үйлчилгээний эрэлт нийлүүлэлтийг давхцуулахад хүндрэлтэй. Үйлчилгээг дахин худалдах болон дахин эргүүлж өөрчилж болдоггүй.

4. **Соёлын байгууллага ба салбарын ангиллын тухайд**. Монголд өнөөдөр үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААН, байгууллагыг ангилж төрөлжүүлэн статистикийн мэдээлэл гаргасан байдаг боловч соёл урлагийн үйлчилгээ эрхлэгч байгууллагыг “бусад үйлчилгээ” гэх хэсэгт оруулан бүрхэгдүүлсэн байна. Үүнийг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт. №10

Салбар	2005	2006	2007	2008	2009
Бүгд	2254 7	3081 7	3210 5	36498	36877
Барилга	574	1059	1233	1313	1064
Худалдаа	8247	1092 4	1142 9	15031	14691
Зочид буудал, зоогийн газар	908	1367	1366	1376	1371
Тээвэр	541	937	896	1025	1045

Санхүүгийн ажиллагаа	755	891	957	774	1069
Үл хөдлөх хөрөнгө, түрээс	1494	2241	2596	2728	2895
Төрийн удирдлага БХ, НД	1306	1312	1477	1514	1536
Боловсрол	1740	1877	2005	2005	2047
Эрүүл мэнд	1662	2022	2230	2216	2275
Бусад үйлчилгээ	2194	4148	3644	4126	4224
Эзлэх хувь	86.1	86.8	86.6	87.9	88.2

Энэ нь Монголын нийгэм эдийн засгийн хөгжилд соёл урлагийн үйлчилгээний оруулах хувь нэмэр, эзлэх байр суурь, орон зайг тооцон гаргах аргачлал, соёлын эдийн засгийн шинжлэх ухааны судалгаа манай оронд хараахан хөгжөөгүй байгаатай шууд холбоотой гэж үзэж байна.

5. **Соёл урлагийн үйлчилгээний онцлог.** Онолын хувьд соёл урлагийн үйлчилгээ нь дараах доорх мөн чанарыг агуулдагаараа бусад төрлийн үйлчилгээнээс ялгарна.

- Материаллаг биш оюуны баялагийн үйлдвэрлэл бөгөөд үйлдвэрлэгч, хэрэглэгчийн аль аль нь хоёулаа гол үүрэг гүйцэтгэдэг, гэхдээ захиалагчийн чиг үүргийг гүйцэтгэж буй хэрэглэгч нь “үйлчилгээ” бүтээгдэх явцад идэвхитэй оролцдоогоороо ахуйн салбарын үйлчилгээнээс ялгарна.
- Соёл урлагийн үйлчилгээ нь хэрэглэгч-бие хүнд хүчтэй нөлөө үзүүлж, түүний оюун санааг өөрчлөх чадвартай.
- Орон зай-цаг хугацааны хүчин зүйлтэй шууд холбоотой нь соёлын үйлчилгээний өөр нэг өвөрмөц тал юм. Өөрөөр хэлбэл, тодорхой цаг хугацаанд, орон зайд соёлын “бүтээгдэхүүн” үйлдвэрлэгдэх ба хэрэглэгддэг.

6. **Нийгэм- соёлын үйлчилгээний онцлог, бүтээгдэх үе шат.**

- Үйлдвэрлэгдэж буй “үр нөлөө, үр ашиг” нь материаллаг бус чанартай.
- Үйлчилгээний явцад хэрэглэгч нь идэвхитэй оролцоно.
- Үйлчилгээний үр ашиг хэрэглэгч болох бие хүний төлөвшилд нөлөөлнө.
- Соёлын үйлчилгээний хэрэгцээ нь орон зай-цаг хугацааны хүрээнд явагдана.

Соёлын үнэт зүйлс, баялаг, үйлчилгээг үйлдвэрлэх тасралтгүй үйл явц болох бүтээн-туурвих үйл ажиллагаа гурван үе шатыг дамжин хэрэгждэг. Үүнд:

1. Бүтээн туурвих
2. Түгээн дэлгэрүүлэх
3. Эзэмших

Эдгээр үе шатууд нь материаллаг үйлдвэрлэл, солилцоо (худалдах, худалдан авах), хэрэглээ гэсэн үе шатуудтай адилтган ойлгож байна. Соёлын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох соёлын үнэт зүйлс буюу үйлчилгээ нь бүтээгдэх бүтээгч хэрэглэгчийн арилжааны “зүйл” болох буюу "бүтээгдэхүүн"-ий шинж чанарыг агуулдаг.

Аливаа үйлчилгээ үл мэдрэгдэх шинж чанартай (амталж, үнэрлэж, сонсож, харах боломжгүй) байдаг байхад соёл урлагийн зарим үйлчилгээ сонсож, харах, хүртэж мэдрэхэд чиглэгдсэн байдаг. Энэ шинж чанар нь зах зээл дээр үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч хоёрын хооронд үйлчилгээний үр дүнг ямар нэг байдлаар урьдчилан мэдсэн, үйлчлүүлэгчийн итгэлийг олж авсан таних тэмдэг, имиштэй болоход нөлөөлдөг.

Харин соёл урлагийн зарим үйлчилгээ нь эх үүсвэрээсээ салангид байж болох талтай. Уран бүтээлчийн бүтээлийг түүнийг байхгүйд үзэж харж, уншиж болдог учир соёл урлагийн үйлчилгээг түүний эх үүсвэр болох уран бүтээлчээс салангид авч үзэх боломжтой ийм тохиолдолд үйлчлүүлэгч, үйлчлэгч хоёулаа үйлчилгээний гарцад нөлөөлөхгүй байж болох юм.

Мөн соёл урлагийн зарим үйлчилгээ бусад үйлчилгээний адил нэгэн хэвийн чанартай байж чадахгүй. Гадаад, дотоод хүчин зүйлс, ялангуяа үйлчлэгч, үйлчлүүлэгчийн байдлаас шалтгаалан үйлчилгээний чанар янз бүр байна. Нэг талаас үйлчлэгчийн авьяас, ур чадвар, сэтгэл санааны байдал, нөгөө талаас үйлчлүүлэгчтэй холбоотой бие махбодийн онцлог, сэтгэл санааны байдлаас шалтгаалан үйлчилгээний чанар янз бүрийн төвшинд гүйцэтгэгдэх нөхцөл бүрддэг байна.

7. Соёл урлагийн үйлчилгээ нь нийгмийн болон хувь хүний эрэлт хэрэгцээгээр тодорхойлогддог онцлог шинж чанар бүхий **нийгмийн үйлчилгээ** юм. Нийгэм, эдийн засгийн харилцаанд хүн өөрийн бүх талын хэрэгцээг хангах идэвхитэй үйл ажиллагаа явуулж, улмаар өөрийгөө болоод өөрт хамааралтай бүхнээ хөгжүүлж байдаг. Хүн өөртөө хэрэгтэй зүйлээ таньж мэдээд идэвхитэй байдалд татагдан орохыг хэрэгцээ гэж үзвэл энэ нь хүний орших, хөгжихүйн үндэс болно. Хүний материаллаг болон оюуны хэрэгцээн дээр суурилан нийгмийн хэрэгцээ үүсч, улмаар нийгмийн мөн чанарыг илэрхийлэн, нийгэм хийгээд хувь хүний хөгжилд гол үүрэг гүйцэтгэнэ. Нийгмийн хэрэгцээ нь мэдлэг чадвар эзэмших, нийгмийн харилцаанд орох, эрүүл аюулгүй аж төрөх, соёлын хэрэгцээгээ хангах, өөрийгөө илэрхийлэх зэргээр илэрнэ.

Соёл урлагийн үйлчилгээ хувь хүний хэрэгцээгээр хязгаарлагдахгүй, нийт нийгмийн болон үндэсний эрх ашгийг хөндсөн хэрэгцээгээр тодорхойлогддог учираас зайлшгүй төрийн зохицуулалт, дэмжлэгтэй байна. Энэ онцлог шинж чанарыг шинжлэх ухааны үндэслэлтэй танин мэдэж байж иргэдэд хүргэх соёл урлагийн үйлчилгээг сайжруулах,

боловсронгуй болгох, орон нутгийн бодлого төлөвлөлтөндөө тусгах, түүнийг хэрэгжүүлэх боломжтой юм.

8. **Нийгмийн үйлчилгээний зорилго ба хэрэгцээ**. Хэрэгцээ нь “хязгааргүй” шинж чанартай ч нийгмийн болон хувь хүний нийтлэг хэрэгцээг хангахад нийгмийн үйлчилгээний зорилго оршдог. Иймээс соёл урлагийн үйлчилгээний зорилгыг ерөнхий утгаар нь **хүний хөгжлийн боломжийг өөрийнх нь сонирхол, таашаалд нийцүүлэн нэмэгдүүлэх** гэсэн талаас нь авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

Нийгмийн үйлчилгээ, ялангуяа соёл урлагийн үйлчилгээ түүхэн тодорхой үеүдэд шинэчлэгдэж байсан ба энэ нь улс орны хөгжлийн чиг хандлагаар илэрхийлэгддэг. Манай оронд 1990 оноос өмнө нийгмийн хэрэгцээ, шаардлагыг түлхүү анхаарч байсны үр дүнд соёл, урлагийн бодлого нь иргэдэд тэгш, боломжоороо үнэ төлбөргүй үйлчилгээг хүргэх, өв тэгш иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэгдэж байв.

9. **Соёл урлагийн үйлчилгээний хоёрдмол шинж чанар**. Соёл урлагийн үйлчилгээ нь нийгмийн үйлчилгээний нэг хэлбэр болохын хувьд **хувь хүн болон нийгмийн нийтлэг соёлын хэрэгцээг хангах, нийгмийн сайн сайхан аж байдлын төлөө хүн ам руу чиглэсэн төрийн зохицуулалттай, мэргэжлийн үйлчилгээ** гэж тодорхойлж болно.

10. **Соёл урлагийн үйлчилгээнд нөлөөлөгч хүчин зүйлс**. Монголын соёл урлагийн үйлчилгээний хөгжилд өнөөдөр хүн ам зүйн, нийгэм-эдийн засгийн, улс төрийн дараах өөрчлөлтүүд нөлөөлж байна гэж үзэж байна.

Хүснэгт. №11

Хүн ам зүйн өөрчлөлт	<ul style="list-style-type: none"> • Хүн амын зарим давхаргын амьдралын боломж, нөхцөл сайжирснаар чөлөөт цагийг зохион байгуулах шинэ эрэлт үүсч байна. • Хот хөдөөгийн болон гадаад руу явах дотоод гадаад шилжилт хөдөлгөөн соёлын эрэлтийн агуулгыг тодорхойлж байна. • Гэр бүлийн гишүүд бүгдээрээ ажил эрхлэх бололцоотой болсноор амьдралын төвшин сайжирч байна.
Нийгмийн өөрчлөлт	<ul style="list-style-type: none"> • Амралт чөлөөт цагийн сонголт улам бүр ухаалаг, туршлагатай болж байна.

	<ul style="list-style-type: none"> • Өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэхийг хүсэгчид, энэ чиглэлийн сургалтад хамрагдагчдын хүрээ өргөжиж байна.
Эдийн засгийн өөрчлөлт	<ul style="list-style-type: none"> • Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн хирээр үйлчилгээний эрэлт улам бүр глобалчлагдаж энэ нь улам бүр шинэ технологийн эрэлт хэрэгцээг бий болгож байна. Эдийн засагт төрөлжилт буй болсноор зар сурталчилгаа, электрон худалдаа болон маркетингийн судалгаа, менежментээр мэргэшсэн тусгай үйлчилгээний мэргэжилтнүүд нийгэм-эдийн засгийн бүх салбарт шаардагдах болсон байна.
Улс төр болон хууль зүйн өөрчлөлт	<ul style="list-style-type: none"> • Төрийн үүргийг гэрээний үндсэн дээр бусад субъектууд гүйцэтгэх, түншлэлийн зарчмаар хамтран ажиллах эрх зүйн орчин бүрдсэн. • Санхүүжилтийн олон эх үүсвэрийг ашиглах боломжтой. • Төрөөс хараат бусаар хуулинд нийцсэн үйл ажиллагаа явуулах боломжтой болсон. • Мэдээлэл солилцох, харилцаа холбоо тогтоох, дотооддоо төдийгүй гадаадад хамтран ажиллах боломж бүрдсэн.

11. Амралт зугаа цэнгэл (Eng. Recreation). Хөгжөөж, баясгаж, сэргээж, урамшуулдаг баяр, амралт зугаа цэнгэлийн үйл ажиллагаа гэж тодорхойлогддог. Үүнд мөрийтэй тоглоом болон хөгжөөнт тоглоомууд багтдаг хэдий ч спортын ангилалд хамрагдах биеийн тамирын чийрэгжүүлэх үйл ажиллагааг амралт зугаа цэнгэлд тооцдоггүй байна.

12. Музей (Eng. Museum). Нийгмийн хөгжилд үр нөлөө үзүүлэх, олон нийтэд нээлттэй, байнгын үйл ажиллагаатай, хүнийг гэгээрүүлэх, оюуны хэрэгцээг нь хангах зорилгоор хүн түүний амьдрах орчинтой холбоотой гэрч болох зүйлийг цуглуулах, хадгалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх, сэргээн засварлах, сурталчлах үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус соёлын байгууллага. (MNS 5634: 2006)

Монгол нутаг дахь хүний амьдралын түүх, соёл, урлаг, ёс заншил, байгаль орчны тухай бодит баримт материалуудыг цуглуулан хадгалж, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх, сурталчлах таниулах үйл ажиллагааг байнга явуулах үүрэг бүхий ашгийн төлөө бус соёлын байгууллага. (Улс аймгийн чанартай музейн дүрэм, 1997)

Музей нь хүн төрөлхтөн болон хүрээлэн буй орчин дахь биет болон биет болон биет бус өвийг сургалт, боловсрол, судлал, зугаа цэнгэлд зориулан бүрдүүлж, хадгалж, хамгаалж, судалж, харилцаа холбоонд оруулж, дэглэж байдаг ашгийн бус, олон нийтэд нээлттэй, нийгмийн хөгжилд үйлчлэх, байнгын институт юм. (ICOM, 2007)

13. Номын сан (Eng. Library) Уншигчид тодорхой хугацаанд ашиглуулах зориулалттай сан хөмрөг бүхий мэдээлэл, соёл, боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, нэгжийг хэлнэ. (Номын сангийн тухай хууль, 2014)

14. **Соёлын ажилтан** (Eng. Cultural employee). Бүх төрлийн уран бүтээлийг бүтээн туурвих, соёлын үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэх, хадгалан хамгаалах, сэргээн засварлах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд дагнан эрхэлж байгаа иргэнийг хэлнэ. (“Соёлын тухай” Монгол улсын хууль. 1996 он. 1.3.4)

15. **Соёлын байгууллага** (Eng. Cultural organization). “Соёлын тухай” Монгол улсын хуулийн дагуу соёлын үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж хамаарна.;

1. Соёлын байгууллага нь өмчийн хэлбэрээс үл хамааран улс болон орон нутгийн чанартай гэсэн ангилалтай байна.
2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж харгалзахгүйгээр бүх нийтэд соёл, урлагаар үйлчлэх зорилго бүхий төрийн өмчийн байгууллага нь мэргэжлийн соёл, урлагийн төв байгууллагад тооцогдоно.
3. Хэд хэдэн аймгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх үүрэг бүхий бүс нутгийн соёлын байгууллага байгуулж болно.
4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн болон бүс нутгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх зорилго бүхий байгууллага нь орон нутгийн соёлын байгууллагад хамаарна. (“Соёлын тухай” Монгол улсын хууль. 1996 он. 1.3.3; 3.6.1-4)

16. **Соёлын бүтээгдэхүүн** (Eng. Cultural goods). Ном, сэтгүүл, мультимедиа бүтээгдэхүүн, програм хангамж, дуу бичлэг, кино, видео, аудио-видео хөтөлбөр, гар урлал болон хувцас загвар зэрэг шинэ санаа, бэлгэ тэмдэг, амьдралын арга барил зэргийг дамжуулах хэрэглэгчийн бүтээгдэхүүн гэж тодорхойлдог.

17. **Соёлын олон төрөл зүйл** (Eng. Cultural Diversity). Олон төрлийн соёлын бүлгүүд ба ард түмнийг илэрхийлдэг олон арга хэлбэрүүдтэй хамаатай. Эдгээр соёлын илэрхийлэл нь үеэс үед дамжин бүлэг ба ард түмний дунд дамжин уламжлагдаж ирсэн. Соёлын олон талт байдал нь зөвхөн соёлын өвийг дамжуулах, илэрхийлэх, баяжуулах олон төрлийн аргаар үүсэн бий болдоггүй, харин ямар арга хэрэгсэл, технологи хэрэглэж байсан эсэхээс үл хамааран, урлагийн бүтээл, үйлдвэрлэл, тараан түгээлт, дамжуулалт, баяр хөөр таашаал авах зэрэг янз бүрийн хэлбэрээр гарч ирдэг.

18. **Соёлын ордон** (*Eng. Cultural Center of District*). Дүүргийн соёлын ордон /цаашид Соёлын ордон гэх/ дүүргийн хүн амд соёл урлагаар үйлчлэх, иргэдийн оюуны эрэлт хэрэгцээг хангах, авъяас билгээ нээн хөгжүүлэхэд нь идэвхтэй туслах үүрэг бүхий орон нутгийн төрийн өмчийн соёлын байгууллага мөн. (“Дүүргийн соёлын ордны үлгэрчилсэн дүрэм” БСШУ-ны сайдын 2011. №83 тушаалын хоёрдугаар хавсралт. 1.1)

19. **Соёлын оролцоо** (*Eng. Cultural participation*). Тодорхой соёлтой холбоотой байж болох өдөр тутмын амьдралын үйл ажиллагаа болон урлагт оролцох оролцоо юм. Энэ нь “соёлын мэдрэмж, үнэ цэнэ, зан үйл дэх үндэстэн ястны ялгаа нь зөвхөн уран сайхны ба мэдээллийг эрхэмлэх сонголтоор бус мөн амьдралын өдөр тутмын хэмнэлээр илрэн гарч ирдэг арга, мөн нийгмийн анги ба хүйс зэрэг нийгмийн чухал ач холбогдолтой онцлог шинжтэй холбоотой байх арга”-тай хамаатай юм.

20. **Соёлын төв** (*Eng. Cultural Center of Soum*). Сумын соёлын төв нь тухайн сумын хүн амд соёл, урлагийн үйлчилгээ хүргэх зорилго бүхий төрийн өмчийн орон нутгийн байгууллага юм. Соёлын төвийн бүтцэд номын сан, уншлагын газар, орон нутаг сурталчлах танхим, баг, хорооны соёлын төв, клуб, соёлын үйлчилгээний бусад нэгж хамаарна. Хуулийн этгээдийн эрхтэй бөгөөд зохих журмын дагуу хийлгэж батлуулсан тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, байгууллагын бэлгэдэлтэй байна. Монгол улсын төрөөс баримтлах соёлын бодлого, холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон тухайн сумын Засаг даргын удирдлагад ажиллана. (“Сумын соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм” БСШУ-ны сайдын 2011 оны 83 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт 1.1-4)

21. **Соёлын үйл ажиллагаа** (*Eng. Cultural activities*). Соёлын үйл ажиллагаанд соёлын үнэт зүйлийг бүтээх, эзэмших, ашиглах, хадгалж хамгаалах, судлах, түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой дараахь үйл ажиллагаа хамаарна:

- a) Уран зохиол, хөгжим, дүрслэх урлаг, театр, цирк, киноны урлаг, уран барилга, дизайн зэрэг урлагийн бүх төрлийн бүтээл туурвих, нийтийн хүртээл болгох;
- b) Соёлын үнэт зүйлийг бүтээх, хадгалж хамгаалах, нийтийн хүртээл болгоход чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;
- c) Монгол үндэстэн болон угсаатан, ястны хэл, аялгуу, аман болон бичгийн соёлыг хадгалж хамгаалах, сэргээн хөгжүүлэх;
- d) Иргэдийн соёлын ерөнхий төвшинг дээшлүүлэх, уран сайхан-гоо зүйн боловсрол, хүмүүжил олгох;
- e) Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр соёлын үйл ажиллагаа явуулах;
- f) Соёл судлалыг хөгжүүлэх;
- g) Соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх.

(“Соёлын тухай” Монгол улсын хууль. 1996. 1.3.1)

22. **ЮНЕСКО-гоос гаргасан “соёлын үйлчилгээ”-ний тухай тодорхойлолт.**

Соёлын хэрэгцээ, сонирхолыг хангахад чиглэгдсэн үйлчилгээг соёлын үйлчилгээ гэнэ. Тэд соёлын материаллаг бараа бүтээгдэхүүнийг төлөөлөхгүй боловч үйлдвэрлэх, түгээх үйл явцыг хөнгөвчилдөг. Жишээлбэл: соёлын үйлчилгээнд лицензийн үйл ажиллагаа, зохиогчийн эрхэд хамаарах бусад үйл ажиллагаа, урлагийн тоглолт, соёлын арга хэмжээг сурталчлах, соёлын мэдээллийн үйлчилгээ, ном, бичлэг, дурсгалын зүйлийг хадгалах үйлчилгээ (үүнд номын сан музей, баримтын сангууд) зэрэг багтана.

23. **Соёлын үйлчилгээ** (*Eng. Cultural services*). Соёлын ашиг сонирхол ба эрэлт хэрэгцээг хангах зорилготой. Тэд соёлын бодит бүтээгдэхүүнийг төлөөлөхгүй ч тэдгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба түгээлтийг хялбаршуулдаг. Жишээ нь: соёлын үйлчилгээнд тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа болон бусад зохиогчийн эрхтэй холбоотой үйлчилгээ, аудиовизуал түгээх үйл ажиллагаа, урлагийн тоглолт, соёлын үйл явдлууд болон соёлын мэдээллийн үйлчилгээний сурталчилгаа, ном, бичлэг, эд өлгийн зүйлсийг хадгалан хамгаалах үйл ажиллагаа (номын сан, баримт бичгийн архивын төв, музей) зэрэг багтана.

24. **Спорт болон биеийн тамирын чийрэгжилт** (*Eng. Sports and Physical recreation*).

Спорт, биеийн тамирын дасгал болон холбогдох үйлчилгээгээр хангаж, үзүүлэх ажлыг эрхлэн явуулдаг хувь хүн ба компаниуд багтана. Спорт, биеийн бялдрын чийрэгжилттэй холбоотой дасгалжуулах, сургах үйлчилгээ мөн багтана. Түүнчлэн спорт, биеийн бялдрын чийрэгжилттэй холбоотой бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг бизнесийн нэгжүүд багтдаг.

25. **Стандарт** (*Eng. Standard*). Тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг стандарт гэнэ. /Монгол улсын хууль. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай. 2017 он./

26. **Стандартчилал** (*Eng. Standardization*). Бүтээгдэхүүн, үйлчилгээний харилцан орлуулалт, мэдээлэл, техник, хэмжилт, сорилтын нэгдмэл, нийцтэй, аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтээр, дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагаа /Монгол улсын хууль. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай. 2017 он./

27. **Урлагийн тоглолт ба баяр наадам** (*Eng. Performing Arts and Celebration*). Орон нутгийн буюу албан бус шинжтэй мэргэжлийн болон сайн дурын урлагийн тоглолтууд болох театр, бүжиг, дуурь, хүүхэлдэйн жүжиг болон соёлын тэмдэглэлт баяр наадмын ажиллагааг (фестивал, үзэсгэлэн яармаг, наадам) хамарна.

28. **Үйлчилгээний чанар.** Үйлчилгээний талаарх хэрэглэгчийн хүлээлт ба бодит байдлын харьцааг илэрхийлсэн ойлголт юм. Өндөр чадвартай бизнесийн үйлчилгээ нь хэрэгцээнд нийцэхийн сацуу өрсөлдөх чадвартай байдаг. Үйлчилгээний чанар гэдэг бол өрсөлдөх чадварын нэг чухал үзүүлэлт юм.

29. **Үнэлгээ** (Eng. *Estimation, evaluation, appraisal, or. Оценивание, гер. Bewertung*). Байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж өгсөн үнэлэлтийг хэлнэ. (МУЗГ-ын тогтоолын хавсралт. 2017. №89. 2.1.2)

30. **Хяналт-шинжилгээ** (Eng. *Monitoring*). Байгууллагын үйл ажиллагаа болон бодлогын зорилт, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагаа. (МУЗГ-ын тогтоолын хавсралт. 2017. №89. 2.1.1)

31. **Хэрэглэгчийн үйлчилгээ.** Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хэрэглэгчийн хүлээлтийг хангаж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлэхэд зориулагдсан бүлэг үйл ажиллагаа.

32. **Хэрэглэгчийн үнэлгээ** (Eng. *User rating*). Захиргааны байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн дүнг хэлнэ. (МУЗГ-ын тогтоолын хавсралт. 2017. №89. 2.1.6)

33. **Чанар.** Тодорхойлоход нилээд түвэгтэй ойлголт бөгөөд судлаачид чанарыг тодорхойлох талаар олон санааг дэвшүүлсэн. Тухайлбал: Чанарыг хэрэглээнд бүх талаас нийцтэй байх гэдэг утгаар нь “хэрэглэгчийн эрэлтийг хангах” хэмээн судлаач Ju-gun (1982) үзсэн бөгөөд хийсэн судалгаанууд нь үйлчилгээний чанарын бодит байдал болон хэрэглэгчийн илүү субъектив ойлголт хоёрын хоорондын ялгааг тодорхойлох оролдлогыг хийсэн бол судлаач Crosby “хэрэглэгчийн шаардлагад нийцэх байдал” хэмээн (1984) тодорхойлсон байна. Эрдэмтэн Groncoos (1984) үйлчилгээний чанарын “техникийн” болон “ажил үүргийн” хүчин зүйлүүд гэсэн хоёр чухал бүрэлдэхүүнийг тодорхойлсон бөгөөд эдгээр нь үйлчилгээний чанарыг үнэлэх чухал хүчин зүйл гэж үзжээ. Учир нь үйлчилгээний явцад хэрэглэгч үйлдвэрлэгчийн шууд харилцаа явагдаж байдаг тул хэрэглэгчид өөрсдөө техникийн чанарт нөлөөлдөг байна.

34. **Үйлчилгээний чанар.** Өрсөлдөх чадварын нэг чухал үзүүлэлт юм. Үйлчилгээний чанар гэдэг нь үйлчилгээний талаарх хэрэглэгчийн хүлээлт ба бодит байдлын харьцааг илэрхийлсэн ойлголт юм. Өндөр чадвартай бизнесийн үйлчилгээ нь хэрэгцээнд нийцэхийн сацуу өрсөлдөх чадвартай байж чаддаг. (Hong Qin, 2009)

35. **Шалгуур үзүүлэлт** (*Eng. Criteria, Criterion*). Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг хэлнэ. (МУЗГ-ын тогтоолын хавсралт. 2017. №89. 2.1.7)

36. **ISO**. Олон улсын Стандартчлалын байгууллага нь дэлхийн 160 гаруй орны гишүүнчлэлээс бүрдсэн, стандарт боловсруулагч, түгээгч дэлхийн хамгийн том байгууллага юм. ОУСБ нь оролцогч талуудын (НҮБ түүний дэд байгууллага, WHO, WTO, IEC гэх мэт) хүсэлт хэрэгцээнд үндэслэн дэлхийн хөгжилд чухал шаардлагатай байгаа стандартуудыг боловсруулан гаргадаг. Тус байгууллага нь 1947 онд Швейцарь улсад байгуулагдсан.

ХОЁР. СУДАЛГААНЫ ҮР ДҮН, НЭГТГЭЛ.

I. Хэрэглэгчээс авсан социологийн судалгаа

Судалгааны арга зүйд заасны дагуу соёлын төвөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагааг үнэлж дүгнэх 441 респондентуудыг Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Төв аймгуудаас сонгон социологийн судалгаанд хамруулсан ба эдгээр нь эх олонлогийн 41,3% -д хүрсэн нь итгэх түвшин өндөр, судалгааны алдааны хязгаар бага байгааг нотолж байгаа бөгөөд судалгааны үр дүн бодит байдалд нийцэж байна гэсэн үг юм.

Судалгаанд хамрагдсан респондентууд

Хүснэгт№12

Бүс	Бүсээс сонгогдсон аймаг	Судалгаанд оролцсон респондентууд
Баруун бүс	Баян-Өлгий, Говь-Алтай, Увс	100
Хангайн бүс	Архангай, Баянхонгор, Өвөрхангай	141
Зүүн бүс	Дорнод, Сүхбаатар, Хэнтий	120
Төвийн бүс	Төв аймаг	50
		411

Судалгаанд оролцогсад эх олонлогийн 41, 3 % хүрсэн байна.

Харин Улаанбаатарын бүс, дүүргүүдийн хувьд бидний тооцоолсон эх олонлогийн 93%-иас “Соёлын үйлчилгээний хүртээмж” хэрэглэгчийн үнэлгээний судалгааг авсан байна.

Судалгаанд хамрагдсан респондентууд

Хүснэгт№13

Дүүрэг	Судалгаанд оролцсон респондентууд
Баянгол	34
Баянзүрх	2
Сонгинохайрхан	25
Сүхбаатар	30
Хан-Уул	30
Чингэлтэй	30
	151

Мөн судалгааны хүрээнд дэвшүүлсэн зорилго, зорилгод нийцэх зарим асуудлуудыг “Нийслэлийн соёл, урлагийн байгууллагын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, соёлын үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэх төсөл боловсруулах суурь судалгаа”-ны

тайлан⁶-гай танилцан дээрх судалгааны зарим эх хэрэглэгдэхүүнийг тус судалгааны санал дүгнэлтэнд авч ашигласан болно.

Судалгааны асуулга боловсруулалт.

“Соёлын үйлчилгээний хүртээмж” хэрэглэгчийн үнэлгээний судалгааг дараах чиглэлүүдээр боловсруулсан болно.

Үүнд:

- ✓ Судалгааны анкет бөглөгч буюу респондентуудын ерөнхий мэдээлэл
- ✓ Соёлын төв, ордны үйлчилгээний чанар
- ✓ Соёлын төв, ордны үйлчилгээний хүртээмж
- ✓ Соёлын төв, ордны үйлчилгээний талаарх сэтгэл ханамж
- ✓ Соёлын төв, соёлын ордны тохижилт зэрэг болно.

Асуулгыг⁷ Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн соёл судлалын секторын эрдэм шинжилгээний ажилтнууд хэлэлцэн баталлаа. Нийт 562 оролцогчийн 3934 асуулгын хуудас бүхий судалгааны үр дүнг SPSS 20 программ ашиглан боловсруулав.

Судалгааны асуулгыг бүлэгт хуваасан байдал

Хүснэгт. №14

	Тайлангийн бүтэц	№	Судалгааны асуултууд
I.	Респондентын ерөнхий мэдээлэл	1	Оршин суугаа газар
		2	Нас
		3	Хүйс
		4	Боловсрол
		5	Эрхэлдэг ажил, алба
		6	Сарын орлого
II.	Соёлын ордон, соёлын төвийн үйлчилгээний чанар	7	Соёлын үйлчилгээ гэдгийг хэрхэн ойлгодог вэ?
		8	Соёлын төвийн ажилтны мэргэжлийн ур чадварыг та хэрхэн дүгнэж байна вэ?
		9	Та Соёлын төв, ордноор үйлчлүүлэхээс татгалздаг бол, шалтгаан нь юу вэ?
		10	Таны оршин суугаа газар нутаг дээрх Соёлын төв, соёлын ордноос сүүлийн 3 жилд явуулж буй үйлчилгээний чанарт үнэлгээ өгнө үү?
III.	Соёлын үйлчилгээний хүртээмж	11	Соёлын төвийн талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?
		12	Та соёл урлагийн байгууллагаар ямар давтамжтай үйлчлүүлдэг вэ?
		13	Та сард хэдэн төгрөгийг үзвэр үйлчилгээнд зарцуулдаг вэ?

⁶ Нийслэлийн соёл урлагийн газар, Бүтээлч үйлдвэрлэл, инновацийн төвөөс 2018 онд хийсэн судалгаа.

⁷ Хэрэглэгчээс авах социологийн судалгааны асуулгыг “Соёлын үйлчилгээний хүртээмж судалгаа”-ны төслийн тайлангийн хавсралтанд хавсаргасан болно.

		14	Та амралт, чөлөөт цагаа ихэвчлэн хаана өнгөрүүлдэг вэ?
IV.	Соёлын төв, соёлын ордны үйлчилгээний талаарх сэтгэл ханамж	15	Төрөөс хэрэгжүүлж буй дараах хөтөлбөр танай Соёлын төвд хэрхэн хэрэгждэг талаар үнэлнэ үү?
		16	Соёлын төв, соёлын ордны ямар үйлчилгээнд Та хамрагдах дуртай вэ?
V.	Соёлын төв, соёлын ордны тохижилт	17	Та орон нутгийнхаа Соёлын төв, соёлын ордны тохижилтын талаар үнэлгээ өгнө үү?
		18	Та хэрэглэгчийн хувьд Соёлын төв, соёлын ордны тохижилтын талаар санал, хүсэлтээ илэрхийлж байсан уу?
		19	Соёлын төв, соёлын ордны дэргэдэх номын сангийн дотоод тохижилтын талаар та юу хэлэх вэ ?
		20	Соёлын төв, соёлын ордны орон нутаг судлах танхимын дотоод тохижилтын талаар та юу хэлэх вэ?
		21	Соёлын төв, соёлын ордны бүжгийн заалны дотоод тохижилтын талаар та юу хэлэх вэ ?
		22	Соёлын төв, соёлын ордны сургалт, дугуйлан явуулах өрөө тасалгааны хүртээмжийн байдалд үнэлгээ өгнө үү
		23	Та соёлын байгууллагын орчны эрүүл ахуйн нөхцлийг үнэлнэ үү?

II.1. I.Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэл

1.Хамрагдсан байдал. /Аймгуудаар/


Хүснэгт №.15

№	Аймаг	Тоо	Хувь
1	Архангай	40	7.1
2	Хэнтий	50	8.9
3	Төв	50	8.9
4	Говь-Алтай	6	1.1
5	Увс	64	11.4
6	Баян-Өлгий	30	5.3
7	Өвөрхангай	44	7.8
8	Дорнод	25	4.4
9	Сүхбаатар	45	8.0
10	Баянхонгор	57	10.1
11	Улаанбаатар	151	27
	Нийт	562	100

“Соёлын үйлчилгээний хүртээмж” хэрэглэгчийн үнэлгээний энэхүү судалгаанд нийт 562 хүн оролцсоноос 27% нь Улаанбаатар хотоос, 11.4% нь Увс аймгаас, 10.1% нь

Баянхонгор аймгаас, 8.9% нь Төв аймгаас, 8.9% нь Хэнтий аймгаас, 8% нь Сүхбаатар аймгаас, 7.8% нь Өвөрхангай аймгаас, 7.1% Архангай аймгаас, 5.3% нь Баян-Өлгий аймгаас, 4.4% нь Дорнод аймгаас, 1.1% нь Говь-Алтай аймгаас тус тус хамрагдсан байна.

Бүдүүвч №.1




2.Насны бүлгээр.

Хүснэгт №.16

№	Нас	Тоо	Хувь
1	18-29	146	26
2	30-39	143	25.4
3	40-49	153	27.2
4	50-69	91	16.2
5	60-аас дээш	29	5.2
	Нийт	562	100

Судалгаанд оролцогсдыг насны бүлгээр нь ангилбал 18-29 насны хүмүүс 26% (146), 30-39 насны хүмүүс 25.4% (143), 40-49 насны хүмүүс 27.2% (153), 50-69 насны хүмүүс 16.2% (91), 60-аас дээш насны хүмүүс 5.2% (29) тус тус хамрагджээ. Үүнээс 40-49 насны хүмүүс хамгийн олон тоотой хамрагдсан байна.

Бүдүүвч №.2 .




3.Хүйсээр.

Хүснэгт №.17

№	Хүйс	Тоо	Хувь
1	Эрэгтэй	232	41.3
2	Эмэгтэй	330	58.7
	Нийт	562	100

Судалгаанд оролцогсдыг хүйсээр ангилбал эрэгтэй 41,3%, эмэгтэй 58.7% байна. Хүйсийн хувьд эмэгтэйчүүд харьцангуй олон хамрагджээ.

Бүдүүвч№.3




4.Боловсролын түвшингээр.

Хүснэгт№.18

№	Боловсрол	Тоо	Хувь
1	Дээд	247	44
2	Тусгай дунд	107	19
3	Бүрэн дунд	145	25.8
4	Бүрэн бус дунд	41	7.3
5	Бага	14	2.5
6	Боловсрол эзэмшээгүй	5	0.9
	Хариулсан	559	99.5
	Хариулаагүй	3	0.5
	Нийт	562	100


Боловсролын түвшингээр нь ангилбал дээд 44% (247), тусгай дунд 19% (107), бүрэн дунд 25.8% (145), бүрэн бус дунд 7.3% (41), бага 2.5% (14), боловсрол эзэмшээгүй 0.9% (5) байна. Респондентуудын 44% нь дээд боловсролтой байгаа нь энэ категорийн хүмүүс орон нутгийн соёл урлагийн үйлчилгээний өнөөгийн байдлыг ямар нэг хэмжээгээр илүү сонирхож байгаа, мөн тэдгээр нь дээрх үйлчилгээнд үнэлэлт дүгнэлт өгөх чадамжтай хүмүүс тус судалгаанд голчлон оролцсоныг харуулж байна.



5. Эрхэлдэг алба, ажлаар

№	Эрхэлж буй ажил, алба	Тоо	Хувь
1	Төрийн алба	219	39
2	Хувийн хэвшил	130	23.1
3	Гэрийн ажилтай	14	2.5
4	ТББ	9	1.6
5	Тэтгэвэрт	52	9.3
6	Ажилгүй	35	6.2
7	Малчин	54	9.6
8	Оюутан	34	6
9	Бусад	13	2.3
	Хариулсан	560	96.6
	Хариулаагүй	2	0.4
	Нийт	562	100

Судалгаанд оролцогсдыг эрхэлсэн алба, ажлаар нь ангилбал төрийн албанд 39% (219), хувийн хэвшилд 23.1% (130), гэрийн ажилтай 2.5% (14), ТББ-д ажилладаг 1.6% (9), тэтгэвэрт 9.3% (52), ажилгүй 6.2% (35), малчин 9.6% (54), оюутан 6% (34), бусад 2.3% (13) оролцсон байна.




6. Респондентуудын сарын орлогын байдлаар.

Хүснэгт №.20

№	Таны сарын орлого	Тоо	Хувь
1	300.0 мянган төгрөгнөөс доош	138	24.6
2	300,0-500,0 мянган төгрөгний орлоготой	185	32.9
3	500,0-900,0 мянган төгрөгний орлоготой	185	32.9
4	900,0-1 сая 500,0 мянган төгрөгний орлоготой	17	3
5	1 сая 500,0 мянган төгрөгнөөс дээш	13	2.3
	Хариулсан	538	95.7
	Хариулаагүй	24	4.3
	Нийт	562	100

Судалгаанд оролцогсдыг сарын орлогын байдлаар нь ангилбал 300.0 мянган төгрөгнөөс доош 24.6% (138), 300,0-500,0 мянган төгрөгний орлоготой 32.9% (185), 500,0-900,0 мянган төгрөгний орлоготой 32.9% (185), 900,0-1 сая 500,0 мянган төгрөгний орлоготой 3% (17), 1 сая 500,0 мянган төгрөгнөөс дээш 2.3% (13) тус тус байна.

Бүдүүвч №. 6



II.1.II. Соёлын ордон, соёлын төвийн үйлчилгээний чанар

7. Та соёлын үйлчилгээ гэдгийг хэрхэн ойлгодог вэ?


Хүснэгт №.21

№	Соёлын үйлчилгээ	Тоо	Хувь
1	Эдийн засгийн үйл ажиллагаа	18	2
2	Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа	385	41.8
3	Урлагийн тоглолт	119	12.9
4	Үзвэр	84	9.1
5	Чөлөөт цагийн үйл ажиллагаа	111	12.1
6	Авьяасаа хөгжүүлэх үйл ажиллагаа	147	16
7	Бүтээн туурвих үйл ажиллагаа	57	6.2
	Хариулсан	541	96.3
	Хариулаагүй	21	3.7
	Нийт	562	100

Судалгаанд оролцогсдын 2% (18) нь эдийн засгийн үйл ажиллагаа, 41.8% (385) нь соён гэгээрүүлэх, 12.9% (119) нь урлагийн тоглолт, 9.1% (84) нь үзвэр, 12.1% (111) нь

чөлөөт цагийн үйл ажиллагаа, 16% (147) авьяасаа хөгжүүлэх, 6.2% (57) бүтээн туурвих гэж хариулсан байна. Үүнээс харахад судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь соёлын үйлчилгээ гэдгийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, урлагийн тоглолт, чөлөөт цагийн үйл ажиллагаа гэж дүгнэжээ.

Бүдүүвч №.7




8. Соёлын төвийн ажилтны мэргэжлийн ур чадварыг та хэрхэн дүгнэж байна вэ?

Хүснэгт №.22

№	Эрхэлж буй ажил	Сайн		Дунд		Тааруу		Хэлж мэдэхгүй байна		Хариулаагүй		Тоо	Хувь
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь		
1.	Соёлын төвийн эрхлэгч	171	30.4	245	43.6	68	12.1	59	10.5	19	3.4	562	100
2.	Номын санч	191	34	235	41.8	70	12.5	49	8.7	17	3	562	100
3.	Соёлын өвийн ажилтан	99	17.6	205	36.5	109	19.4	72	12.8	77	13.8	562	100
4.	Бүжгийн багш	176	31.3	197	35.1	92	16.4	67	11.9	30	5.3	562	100
5.	Хөгжмийн багш	165	29.4	220	39.1	88	15.7	60	10.7	29	5.1	562	100
6.	Бусад	54	9.6	142	25.3	38	6.8	52	9.4	275	48.9	562	100

Судалгаанд оролцогсод соёлын төвийн эрхлэгчийн ур чадварыг үнэлэхдээ 30.4% (171) нь сайн, 43.6% (245) нь дунд, 12.1% (68) нь тааруу, 10.5% (59) нь хэлж мэдэхгүй гэж хариулжээ. Номын санчийн ур чадварыг үнэлэхдээ 34% (191) нь сайн, 41.8% (235) нь дунд, 12.5% (70) нь тааруу, 8.7% (49) хэлж мэдэхгүй байна гэж хариулжээ. Соёлын өвийн ажилтаны ур чадварыг үнэлэхдээ 17.6% (99) нь сайн, 36.5% (205) нь дунд, 19.4% (109) нь тааруу, 12.8% (72) хэлж мэдэхгүй байна гэж хариулжээ. Бүжгийн багшийн ур чадварыг үнэлэхдээ 31.3% (176) нь сайн, 35.1% (197) нь дунд, 16.4% (92) нь тааруу, 11.9% (67) хэлж мэдэхгүй байна гэж хариулжээ. Хөгжмийн багшийн ур чадварыг үнэлэхдээ 29.4% (176) нь сайн, 39.1% (220) нь дунд, 15.7% (88) нь тааруу, 10.7% (60) хэлж мэдэхгүй байна гэж хариулжээ. Бусад гэсэн сонголтыг үнэлэхдээ 9.6% (54) нь сайн, 25.3% (142) нь дунд, 6.8% (38) нь тааруу, 9.4% (53) хэлж мэдэхгүй байна гэж хариулжээ. Судалгаанд оролцогчид соёлын төвийн эрхлэгч, номын санч, соёлын өвийн ажилтан, бүжгийн багш, хөгжмийн багш тус бүрийн мэргэжлийн ур чадварыг дунд гэсэн үнэлгээг хамгийн их өгсөн байна. Үүнээс харахад соёлын төвд ажиллаж буй мэргэжилтнүүд ур чадвараа дээшлүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.




9. Таны Соёлын төв, соёлын ордноор үйлчлүүлэхээс татгалздаг шалтгаан юу вэ?

Хүснэгт№.23

№	Соёлын төв, ордноор үйлчлүүлэхээс татгалздаг шалтгаан	Тоо	Хувь
1	Мэдээлэл авах боломжгүй	160	13.9
2	Үйлчилгээ нь хоцрогдсон	68	5.8
3	Үйлчилгээний нэр төрөл хэт цөөн	129	11
Судалгаанд оролцогсдын 54% (114) нь бүрэн санал нийлнэ, 37% (78) нь зарим талаар санал нийлнэ, 3.8% (8) нь санал нийлэхгүй, 5.2% (11) нь мэдэхгүй байна гэж хариулжээ.

Бүдүүвч№53



29. Асуулт: Соёлын төв, ордны улсын стандарт боловсруулахад зайлшгүй тусгах ямар зүйл байна вэ?


Хүснэгт№68

Улсын стандарт боловсруулахад зайлшгүй тусгах зүйл	Тоо	Хувь
Зориулалтын байрны стандарт	146	43.6
Техник, тоног төхөөрөмжийн стандарт	101	30.0
Хувцас, жижиг хэрэглэлийн стандарт	50	14.9

Үйл ажиллагааны тайлан бичилтийн стандарт	37	11.0
Хариулсан	210	99.5
Хариулаагүй	1	0.5
Нийт	211	100.0

Судалгаанд оролцгсдын 43.6% (146) нь зориулалтын байрны стандарт, 30% (101) нь техник, тоног төхөөрөмжийн стандарт, 14.9% (50) нь хувцас, жижиг хэрэглэлийн стандарт, 11% (37) нь үйл ажиллагааны тайлан бичилтийн стандарт гэж хариулжээ.

Бүдүүвч №54



Б/ ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН, НЭГТГЭЛ.

1. Чөлөөт ярилцлага

Чанарын судалгааны хүрээнд соёл урлагийн салбар, тэр дундаа соёлын төв, соёлын ордны хөгжил, бодлого, үйл ажиллагааны талаар хангалттай мэдлэг, мэдээлэлтэй төрийн захиргааны байгууллагын төлөөлөл, соёлын төв, ордны дарга, менежер нийт 52 хүн хамруулсан чөлөөт ярилцлагыг хийж анхдагч мэдээлэлийг цуглууллаа.

Ярилцлагад уригдан оролцогсдыг 5-10 хүнтэй 5 групп болгож, ярилцлага тус бүрд дунджаар 90 минут зарцууллаа.

Чөлөөт ярилцлагыг батлагдсан арга зүйн дагуу дараах сэдвүүдээр зохион байгуулав.

Үүнд:

- Соёлын төв, соёлын ордны өнөөгийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийн байдал
- Соёлын төв, соёлын ордонд мөрдөгддөг үлгэрчилсэн дүрэм, стандартын хэрэгцээ, шаардлага
- Соёлын төв, соёлын ордонд орон нутгийн онцлогийг харуулсан соёл, зан заншлын холбогдолтой соёлын үйл ажиллагаа зохион байгуулах боломж, нөхцөл
- Соёлын ордон, соёлын төвийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга зам
- Соёлын үйлчилгээний үр дүнг үнэлэх аргачлал, үйл ажиллагааг боловсронгуй болгоход анхаарах зүйл

Чөлөөт ярилцлагад оролцогсод

Хүснэгт №69

Бүс	Бүсээс сонгогдсон аймаг	Ярилцлагад оролцогсод
Баруун бүс	Баян-Өлгий, Ховд, Увс	8
Хангайн бүс	Архангай, Баянхонгор,	7
Зүүн бүс	Дорнод, Сүхбаатар, Хэнтий	12
Төвийн бүс	Төв аймаг, Дорноговь, Говьсүмбэр	15
Улаанбаатарын бүс		10
Нийт		52

Чанарын судалгааны хүрээнд төв, зүүн, баруун, хойд, өмнөд бүсийн ажилтнуудтай чөлөөт ярилцлага хийсэн. Нийслэлд нэг удаа, дөрвөн бүсэд тус бүр нэг, нийт таван удаагийн чөлөөт ярилцлага хийж, 52 соёлын ажилтныг хамруулсан. Чөлөөт ярилцлагад оролцогчдын боловсрол, ажлын туршлага, мэргэжлийг үндсэн шалгуур болгон авч үзлээ. Тэдний 85.7% нь салбартаа 3-аас дээш ажилласан байна. Ярилцлагын мэдээлэл дэх нэгж утга, үнэлгээ, гаргаж буй саналын давтамжийг нэгтгэж үзэхэд судалгааны хүрээнд дэвшүүлсэн таамаглалыг нотлох чухал асуудлыг хөндсөн байна.

Чөлөөт ярилцлагын нэгтгэл

Нэг. Соёлын төв, соёлын ордны үйл ажиллагааны чанар, хүртээмжийн байдал:

Соёлын төв, ордон өнөөгийн нөхцөл, боломжинд тулгуурлан ажиллаж, урлаг соёлын ажлыг таслахгүй явуулж байгаа хэдий ч үйл ажиллагааны чанар, хүртээмж нь хангалтгүй байгааг нийт оролцогчид хэлсэн байна. Үүнд төсөв санхүү, эрх зүйн орчин, хүний нөөцийн бодлого гэсэн хүчин зүйлс нөлөөлж байгааг дурджээ. Гэхдээ соёлын байгууллагууд өөрсдийн хүч, нөөц боломжийг эрэлхийлж ажилладаг.

Хүний нөөцийн хамгийн том бэрхшээл бол салбарын ажилтнуудын цалин, урамшууллын асуудал. Ажиллагчид мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд тогтмол хамрагдах нөхцөл бололцоо хангагдаагүй нь байгууллагын хийгээд салбарын хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Энэ саналыг залуу, дунд үеийн ажилтнуудын 90 гаруй хувь нь дурдсан байна. Соёлын ажилтнуудын аттестатчлалаар зэрэг дэв тогтоож, цалин урамшууллын системийг тодорхой болгох шаардлагатайг онцолжээ.

Үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд мэргэжлийн, ур чадвартай боловсон хүчнээр хангах, орон тоог нэмэгдүүлэх шаардлагатайг нэн тулгамдсан асуудлын нэг гэж тэмдэглэсэн. Тухайлбал, үйлчилгээний ажилтан, биеийн тамирын арга зүйч, ОНСТ-ын ажилтны орон тоог нэн тэрүүнд нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг тодорхой болгох хэрэгтэй. Мөн тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийг засварлах, шинэ ном худалдаж авах, ОНСТ-ыг тохижуулах төсөв

Keyc №: 1

Манайх уурхай дагасан онцлогтой. Зориулалтын байртай. Орон тоо хомсдолтой. Орон нутгийн хүн амын тоонд харьцуулвал 5-аас илүү байх ёстой. 6 хүн 10 мянган хүнд үйлчилж байна. Хэцүү. таван сумтай тэнцүү хүн амтай гэсэн үг. Өөрсдийн боломжоор л хурч ажилладаг. Соёлын төвийн эрхлэгч. Эмэгтэй. Хэнтий аймаг.

хүрэлцээгүйгээс, хөрөнгө оруулалт дутмагаас төлөвлөсөн үйл ажиллагааг явуулах боломжгүй болох тохиолдол их бий. Эдгээр бодит саад бэрхшээл нь үйл ажиллагааны чанар, хүртээмжид шууд нөлөөлж байгаа юм. Гэхдээ ихэнх оролцогч соёлын төв жил бүр хэрэглэгчдийн хүсэж буй хэрэгцээ, сэтгэл ханамжийг судалж үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Хоёр. Соёлын төв /ордон/-д мөрдөгддөг үлгэрчилсэн дүрэм, стандартын шаардлага хангаж буй эсэх:

Энэ асуудлын хүрээнд одоо мөрдөгдөж буй дүрэм журам бодит амьдралаас хол байгааг шүүмжлэхийн зэрэгцээ үйл ажиллагааг сайжруулахад бодит хувь нэмэр үзүүлэх стандартын хэрэгцээ чухал болохыг тэмдэглэжээ.

Соёлын төвүүдийн орчны болон үйл ажиллагааны стандарт байхгүйгээс шалтгаалан хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн шалгуур үзүүлэлт ч тодорхой бус байна. Соёлын төвийн үлгэрчилсэн дүрмийг зарим байгууллага өөрсдийн нөхцөлдөө тохируулан хийж мөрдлөг болгодог. Энэ нь үлгэрчилсэн дүрмийг сайжруулж боловсронгуй болгох, бодит нийтлэг байдалтай уялдсан шалгуур, зарчмыг тусгасан байхыг шаардаж буй хэрэг юм.

Жишээлбэл: соёлын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг яаралтай шинэчлэх хэрэгтэй байна. Монгол улсын “Соёлын тухай хууль”-д заасан соёлын үнэт зүйлийг бүтээх, эзэмших, ашиглах, хадгалж хамгаалах, судлах түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг чанартай явуулах стандартууд үгүйлэгдэж байна гэж нийт оролцогчдын 96 хувь нь үзжээ.

Сүүлийн үед шинээр соёлын төвүүд баригдаж байгаа боловч зориулалтын барилгад тавигдах стандарт тодорхой биш байгааг баримттай хэлсэн юм. Жишээлбэл, нэгэн сумын соёлын төв 1961 онд иргэд өөрсдөө барьсан чулуун барилга. Энэ нь 3 удаа их завсарт ороод, 1990 онд шатаж байсан. 2009 онд мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр актлагдсан байна. Ийм барилгад үйл ажиллагаа явуулахад бол мэдээж яагаад ч стандартын шаардлага хангахгүй гэж ярьсан байна.

Тус салбарын хоорондын уялдаа холбоо муутай дүрэм журмуудыг цэгцэлж, цөөн тооны оновчтой, бодит асуудлыг шийдэх, боловсронгуй стандарт боловсруулж мөрдвөл зарим гацаа, бэрхшээлийг богино хугацаанд засаж залруулахад чухал гэж үзсэн. Энэ нь соёлын байгууллагын үйл ажиллагааны технологийг сайжруулж, хэрэглэгчдийн хүлээлтийг хангахад тус дөхөм үзүүлэх бололцоотойг илтгэж байна.

Нийслэлийн оролцогчдоос соёлын байгууллагын ажилтнууд болон салбарын хэмжээнд төр засгийн бодлого, эрх зүйн шинэчлэлийг таниулан сурталчлахдаа Хилийн

Keyc №.2

Бид хуучин 100-р тушаал, үлгэрчилсэн дүрмийн дагуу ажиллахыг зорьж ирсэн. Гэхдээ энэ стандарт бидний хийх ажилд яагаад ч нөхцөлд зохицохгүй байгаа. Хэрэв шинэчлэвэл ажилтнуудын мэдлэг мэргэжил дээшилнэ. Үнэлэмж ч дээшилнэ. Энэ эртнээс шинэчлэгдэх ёстой байсан. Энэ ажлын анхан шатны ажил эхэлж буйд баяртай байна. Тайланг дур зоргоороо бичдэг. Үүнийг жигдлэх хэрэгтэй.

Соёлын төвийн эрхлэгч.

Эмэгтэй.

Дорнод аймаг.

цэргийн анги, Төмөр замын өртөөнүүд дээр ажиллаж буй соёлын төв, ордны ажиллагчдыг хамруулж байх зэргийг дурджээ.

Гурав. Орон нутгийн онцлогийг харуулсан соёл, зан заншлын холбогдолтой соёлын үйл ажиллагаа зохион байгуулах боломж, нөхцөл:

Орон нутгийн удирдлага нь тухайн орон нутгийн онцлогт тулгуурлан соёл урлаг, соёлын өвийг хадгалж хамгаалах чиглэлийн хөтөлбөрийг ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэх талаар зарим аймаг санаачилгатай ажиллаж байна. Орон нутгийн соёлын төвийн эрхлэгч нарын 96 хувь нь орон нутаг судлах танхимаараа дамжуулан соёлын өвийн онцлогийг харуулсан үйл ажиллагааг явуулахыг хичээдэг.

Харин нийт оролцогчид нийслэл болон орон нутгийн оролцогчид соёлын биет болон биет бус өвийн бүртгэл мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах боломж маш сул гэж үзэж байна.

Орон нутгийн өв соёлын агуулгыг илэрхийлсэн урлаг, соёлын үйл ажиллагааг соёлын байгууллагууд бүтээлчээр эрэлхийлэн ажиллаж байгаа тухай олон баримтыг судалгаанд оролцогчид дурдсан байна. Тухайлбал, тухайн орон нутагт буй угсаатнуудын ёс заншил, язгуур урлаг, өв соёлыг сурталчлах, орон нутгаас гаралтай алдартнуудын ой тэмдэглэх, ардын авъяастны бэсрэг наадам, ерөөлч магтаалчдын уралдаан, орон нутгийн соёлыг өвлүүлэх сургалт зохион байгуулах, жуулчдад зориулсан хөтөлбөр зэрэг олон ажлуудыг дурдсан нь дэвшилт тал болж байна.

Харин Улаанбаатар хотын оролцогч дүүргийн авъяастнуудын тоглолтыг ардын урлагийн шинжтэй болгож байна гэсэн юм. Энэ асуултын хүрээнд нийт оролцогчид орон нутагт соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулах, соёлын олон төрөл зүйлийг хамгаалах арга зам болохыг ойлгож буй нь маш чухал байв.

Судалгааны явцад 3.8 хувь нь нутгийн брэнд гаргах, орон нутгийн соёлын байгууллагын ажлыг аялал жуулчлалтай холбох чиглэлээр үйл ажиллагааг эрчимжүүлэхийн ач холбогдлыг онцлон дурдсан байв.

Дөрөв. Соёлын төв, ордны үйлчилгээний чанар, хүртээмжийг боловсронгуй болгоход нэн тэргүүний шаардлагатай зүйлс:

Судалгаанд оролцогчдын санаа бодлоо илэрхийлсэн байдлаас үзэхэд, бүхэлдээ нийтлэг, ижил төсөөтний бэрхшээлүүд давтагдаж байгаа юм.

Үүнд дараах хэдэн зүйл анхаарал татаж байна.

1. Соёлын төв, ордны барилга байгууламж, гадаад дотоод тохижилт, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах. Чанарын шаардлага хангасан орон байр дутагдалтай байна.
2. Төсөв, хөрөнгө оруулалт, мөн үндэсний хөтөлбөрүүд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх талаар дорвитой арга хэмжээ авах шаардлагатайг бүгд нэгэн дуугаар хэлсэн байна. Ярилцлагад оролцогчдын 30-аад хувь

Кейс №3

Үйлчлүүлэгчид маань юуг шаардаж байна вэ гэхээр орчин нөхцөлийг шаардаж байна. Тав тух, дэвшилтэт технологи шаарддаг. 2-рт бид нар бүх арга хэмжээг явуулаад байхад орчин нөхцөлөө голоод ирэхгүй байх талтай. Тиймээс чанар хүртээмж тиймхэн байна гэж үзэж байна.

*Соёлын төвийн эрхлэгч.
Эрэгтэй.
Төв аймаг.*

Кейс №4

Үйлчлүүлэгчид маань ихэнх нь социализмын үеийн ахмад хүмүүс л байдаг. Залуучууд бол үндсэндээ ирэхгүй.

*Соёлын төвийн эрхлэгч.
Эрэгтэй.
Нийслэлийн Чингэлтэй дүүрэг.*

нь соёл, урлагийн байгууллага орлогын төлөвлөгөө биелэхгүй байгаа нэг том шалтгаан нь үзэгчийг бэлтгээгүйтэй болон нийт хүмүүсийн боловсролтой ихээхэн холбоотой гэсэн юм.

3. Одоо мөрдөгдөж буй эрх зүйн орчны хүрээнд соёлын төв, ордны үйл ажиллагааг үнэлэх аргачлал, шалгуурыг боловсронгуй болгох хэрэгтэй. Нийт оролцогчдын 73% нь үйл ажиллагааг шударгаар үнэлэхийн тулд үйлчлүүлэгчдээс хөндлөнгийн үнэлгээг авч хэвшихийн давуу тал, ач холбогдлыг онцолж байлаа.

Тав. Соёлын үйлчилгээний үр дүнг үнэлэх аргачлал, үйл ажиллагааг боловсронгуй болгоход анхаарах асуудал:

Судалгаанд оролцогчид ажлын үр дүнг аймаг, орон нутгийн БСУГ-ууд харилцан адилгүй дүгнэж байгааг тэмдэглээд, энэ үнэлгээний аргачлал, шалгуурыг боловсронгуй болгох ажлыг цаг алдалгүй хийх хэрэгтэйг онцлон тэмдэглэж байна. Жил бүр нээлттэй зарлан мэргэжлийн ТББ-уудыг шалгаруулж, соёлын төв, соёлын ордны хэрэглэгчийн үнэлгээг хийлгэх нь оновчтой хувилбар гэж үзжээ. Орон нутгийн Засаг даргын тамгын газраас хэрэглэгчийн үнэлгээний судалгаа авдаг, түүнээс гадна үйлчлүүлэгчид, дугуйлангийн суралцагчдын эцэг эхээс сэтгэл ханамжийн судалгаа авч ажилдаа тусгаж байгаа нь нийтлэг болсон.

Кейс №5

Соёлын төвийн үнэлэх аргачлал утгагүй. Нэг итгэлцүүр тавиад бидний сайхан ажлууд унах тохиолдол байсан. Сүүлд аймгаас тодорхой хэмжээний хөтөлбөрүүдийг заагласан учир төлөвлөлт, тайлангаа хийж дүгнэхэд ач холбогдолтой болсон. Соёл урлагийн газрын статистик мэдээг бөглөдөг. Одоо соёлын байгууллага ямар байхыг харуулсан аргачлалтай болох нь зөв.

*Соёлын төвийн эрхлэгч.
Эрэгтэй.
Дорнод аймаг.*

Үнэлгээний аргачлал тодорхойгүй шагнал, үр дүнгийн урамшууллын шатлал болон шалгуур тодорхойгүй байна. Жишээ нь, нэг итгэлцүүрийн хэмжилтээр чанартай ажлууд унах тохиолдол байдаг.

Соёлын ажилтныг үнэлэх аргачлал бол бодитой биш санагддаг. Тоон үзүүлэлт байдаг. Сумын иргэдийн хурал ард иргэдтэй нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулаад иргэдээс санал аваад, эргээд цаашаа явуулаад үнэлвэл зүгээр юм.

Цаашид соёлын байгууллага ямар байхыг харуулсан аргачлалтай болох нь зөв гэж хариулжээ. Үнэлгээний аргачлалыг сайжруулах нь ажилтнуудын мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх хөшүүрэг болох төдийгүй иргэдийн хүлээлт, үнэлэмж ч дээшилнэ гэж үзэж байна.

Кейс №6

Хүн амд Угийн бичгийн сургалт хэдэн хүн хамрагдсан, явагддаг уу гэж асуугаад хэдэн тоо авдаг. Энэ бол буруу дутагдалтай. Бодит байдал дээр тийм биш байдаг.

*Соёлын төвийн эрхлэгч.
Эмэгтэй.
Хэнтий аймаг.*

II. Контент анализ:

“Соёлын үйлчилгээний хүртээмжийн судалгаа” захиалгат төслийн судалгааны хүрээнд бүсээс сонгогдсон аймгуудад хөдөө орон нутгийн хэмжээнд бодлого

боловсруулж, шийдвэр гаргадаг нутгийн захиргааны байгууллагынхан, тухайлбал засаг дарга, иргэдийн хурлын төлөөлөгчид, соёл урлагийн ажилтнууд, уран бүтээлчид, соёл урлаг хариуцсан төрийн захиргааны байгууллагын ажилтнууд, арга зүйч мэргэжилтнүүд, соёл урлагийн мэргэжлийн багш, ардын авъяастнууд, уран сайханчид, сонирхогчид зэрэг соёл урлагийн үйл ажиллагаанд идэвхтэй нийт 345 хүн оролцсон бүсчилсэн уулзалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа. Тухайлбал:

Хүснэгт№70

Бүс	Бүсээс сонгогдсон аймаг	Оролцогсод
Баруун бүс	Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс	67
Хангайн бүс	Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай	73
Зүүн бүс	Дорнод, Сүхбаатар, Хэнтий	45
Төвийн бүс	Төв аймаг, Дорноговь, Өмнөговь	160
		345

Контентийн тоо:

Хүснэгт№71


	Тоо	Хувь
	105	51
	103	49
Нийт	208	100

Контентийн ангилал

Хүснэгт№72

№	К. агуулгаар	Эерэг	Сөрөг	Нийт	Эрэмбэ
1	Соёлын төвийн барилга	1	24	25	10
2	Үйлчилгээний чанар, хүртээмж	17	24	42	8
3	Техник хэрэгсэл	-	43	43	7
4	Үнэлгээ	10	52	62	3
5	Хүний нөөц, мэргэжил дээшлүүлэх	2	79	81	1
6	СБӨ,СББӨ-ийн хадгалалт, хамгаалалт	17	35	52	5

7	Санхүүжилт	1	54	55	4
8	Нийгмийн халамж, хамгаалал	-	29	29	9
9	Явуулын үйлчилгээ	2	9	11	13
10	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн	2	14	16	11
11	Гадаад харилцаа	2		2	15
12	Номын сангийн үйлчилгээ	3	45	48	6
13	Сургалт, дугуйлан	4	8	12	12
14	Орон нутгийн дэмжлэг	-	4	4	14
15	Стандарт	-	66	66	2
16	Эрх зүйн орчин	-	4	4	14
Нийт:		61	490	551	



Уулзалт зөвлөлгөөнд оролцсон нийт 345 хүмүүсээс 42 нь бидэнтэй санал бодлоо солилцсоныг контент анализийн аргаар хураангуйлж нэгтгэн, нийт 208 контентыг жагсааж авсан болно.

Дээрх контентуудыг эрэмбэлвэл: Соёлын төв, ордонд хамгийн их эрэлттэй, шаардлагатай байгаа нь **1-рт, хүний нөөц, мэргэжил дээшлүүлэх (79) тухай асуудал хөндөгдөж байна.** Үүнд олон шалтгаан байна. Шинээр төгссөн мэргэжилтэн орон нутагт очиж ажиллах орчин, нөхцөл, цалин хөлс, нийгмийн хангамж муу, ажиллах техник хэрэгсэл хоцрогдсон гэх мэт олон шалтгаан байгаа нь харагдаж байна.

Мэргэжил дээшлүүлэхэд санхүүгийн байдал хүндрэлтэй, олон хоногоор сургалтанд явбал цалин мөнгө хасуулах, Аймгийн удирдах дээд байгууллагуудаас ажил тасалсанд тооцох, хичээлийн дундуур төрөл бүрийн урлагийн үзлэг, тоглолтын хуваарь

гарч ирэх зэрэг сөрөг хандлага их байдаг. Орон нутгийн соёлын төвд ихэвчлэн мэргэжлийн бус хүн зонхилон ажиллаж байгаа нь өөрөө мэргэжил дээшлүүлэх байнгын эрэлтийг бий болгож, чанаргүй мэргэжилтэн ажлын байнгын орон тоон дээр ажиллахад хүргэж байна.

Мөн хоёр гурав хоногоор явагдах түр сургалтууд үр өгөөж муутай байна. Соёл урлагийн салбар нь авъяастай, мэргэшсэн хүн байхыг шаарддаг өвөрмөц онцлогтой салбар юм. Сургалтанд ихэвчлэн соёлын төв, ордны ажилтнуудаас илүү эрхлэгч явах нь элбэг, тэдгээр сургалтанд суусан хүмүүс ажлын байрандаа очоод өөр бусдад мэдээлэл өгөх нь ховор зэрэг алдаа дутагдал нийтлэг байна.

Сүүлийн үед зарим мэргэжлийн сургуулиудаас зайны сургалтыг буй болгосон боловч энэ нь номын санч, музейн ажилтан сурах гэх мэт мэргэжлээр сургах боломж бололцоотой боловч, хөгжмийн багш, бүжгийн багш гэх мэт заавал биеэр суралцах хэрэгцээ шаардлагатай мэргэжлүүдэд тохиромжгүй хэлбэр юм. Эерэг үйл ажиллагаатай хоёр соёлын төв байгаа нь хоёулаа мэргэжлийн боловсон хүчинтэй газрууд байна.

2-рт стандартын асуудал эрэмбэлэгдэж байна. Орон нутгийн соёлын байгууллагад Соёлын төвд стандарт шаардлагатай байна. Учир нь одоогийн өөрчлөлт, шинэчлэлт хөрсөндөө бууж өгөхгүй байгаа талаар оролцогчид саналаа хэлсэн олон контент тэмдэглэгдсэн байна. Орон нутгийн соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн сонгууль, Төрийн албаны хуулийн өөрчлөлт гэх зэрэг нийгэм улс төрийн нөхцөл байдал их нөлөөлж байна гэсэн нь соёл урлагийн, тэр дундаа хүнийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг үйл ажиллагаа улс төрөөс ангид байх ёстойг илтгэж байна.

Соёлын ажилтан хүн нэг талаас төрийн албан хаагч боловч нөгөө талаасаа нийт төрийн албан хаагчдаас цалин хангамж, нийгмийн хамгаалал зэрэг бүхий л талаараа доогуур байгаа нь тухайн салбарын боловсон хүчнийг тогтвор суурьшилгүй ажиллахад шууд нөлөөлж байна. Орон нутгийн соёлын байгууллагынхан авъяастай, чадвартай багш нараа ерөнхий боловсролын сургууль /цаашид ЕБС гэх/, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв /цаашид МСҮТ гэх/-д алддаг тухай контент их байна.

Соёлын төвүүдийн үйл ажиллагааны үнэлгээний үзүүлэлт байдаг, гэвч зарим талаар нийцдэггүй тул үнэлгээ доогуур гардаг. Мөн яамнаас хэрэгжүүлдэг хөтөлбөрүүд ямар ч судалгаагүй гардаг тул манай орон нутагт байхгүй юмыг шаарддаг. Байхгүй учраас үнэлгээ авдаггүй гэхчлэн үнэлгээний талаар саналаа хэлсэн байна.

Хөдөө орон нутагт байгаа ихэнх сумын соёлын төв стандартын шаардлагад нийцдэггүй. Сүүлийн үед соёлын төвтэй болсон хэд хэдэн сум байна. Эдгээрээс зарим

нэг сумын соёлын төвийн барилга нь спорт заал мэт хийц, загвар, шийдэлтэй. Цууриа дарагчгүй, нэгдүгээр давхартаа спортын заалтай тул ямарваа урлаг, соёлын үйл ажиллагаандаа заал, тайзаа засах шаардлага байнга гардаг байна.

ОНС танхим байхгүй, өдийг хүртэл соёлын төв нь амбаар мэт газарт толгой хорогдож яваа /Баян-Өлгий аймаг Сагсай сум/ гэх мэт нэн тэргүүнд төрөөс анхааралдаа авч, монгол хүний оршин тогтнохуйн дархлаа болсон соёл урлагаа дэмжих шаардлагатай байна. Тиймээс цаашид шинээр барих соёлын төв, ордны барилгын зураг төсөл гаргахдаа соёлын ажилтны санал авах, мэргэжлийн театр, чуулга, соёлын төвийн үйл ажиллагааны чиглэлд тохирсон зураг төсөл хийх шаардлагатай.

3-рт, санхүүжилт нь аливаа үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын гол хөшүүрэг байдаг. Орон нутгийн соёлын байгууллага сумын төвийн оршин суугчид, багт очиж үйлчлэх үүрэгтэй байдаг. Гэвч явуулын үйлчилгээ явуулахад санхүүгийн бэрхшээл тулгамдсан асуудал болдог. Тиймээс хүний машинд дайгдаж тоглолт хийдэг зэрэг нь төсвийн хуваарилалт, санхүүтэй салшгүй холбоотой. Соёлын төвийн тоног төхөөрөмжийн чанар, хүртээмж шаардлага хангахгүй байна. Баруун бүсийн соёлын ажилтнуудтай уулзах үед тэд “тендер гэдэг зүйлийг болиулах арга байна уу? Учир нь, бид арайхийж их үнэтэй хөгжим, техник хэрэгсэл авдаг. Дараа нь хотод очоод хөгжмийн дэлгүүр ороод үзэхэд бидний авсан үнээс 40-50 хямд байж байх юм. Тэгээд ч бид үзэж авдаггүй учир 1 жил болохгүй эвдэрч байна. Ингээд биднийг үнэтэй хөгжим эвдсэн, өөрсдөө засуул гэдэг, ингэхлээр тендерийн зарчим маань хэр шударга явагддаг юм бол хэмээн үзэхэд хүргэж байна” хэмээсэн билээ.

Хүний нөөц, мэргэжлийн боловсон хүчинтэй байх, ажлын байрандаа засвар хийх, камержуулах, номын сан, ОНС танхимээ тохижуулах, компьютертой болох зэрэг ихийг хийж бүтээх хүсэл тэмүүлэл нь бүгд санхүүжилт, хөрөнгө оруулалт гэсэн чөдөртэй байдаг. Соёл урлагийн ажилчид өөрсдөө нийгмийн манлайлагчид тиймээс ч тэд санхүүжилт байвал ханцуй шамлан орж эх орныхоо сайн сайхны төлөө хөдлөх дайчин хүмүүс. Соёл урлагийн үйлчилгээний хүрэлцээ хүртээмж, хангамж, үнэлгээний гол зүйл нь санхүүжилттэй холбогдож байна.

Үнэлгээ (4)-өөр эрэмбэлэгдэж байна. Үнэлгээний талаар судалгаанд оролцогчдын ихэнх нь сөрөг дүнтэй байв. Учир нь үнэлгээний жишиг загвар байдаг боловч энэ нь хөрсөндөө буудаггүй. Тухайлбал, “Сонгодог урлаг” хөтөлбөр хөдөө орон нутагт хэрэгжүүлэх боломжгүй бөгөөтөл түүний үр дүнг хэрхэн үнэлэх билээ?

Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа нь сайн хэрэг боловч хаана, хэнд хэзээ, хэрхэн, яаж гэдэг нь хамгийн чухал юм. Үнэлгээнд тооноос чанар хамгийн эрхэм чухал юм.

Номын сангийн үйлчилгээ эрэмбэ (5), үүнээс эерэг 5, сөрөг 40. Аймгийн номын сангийн үйлчилгээ боломжийн. Харин сумын номын сан 2017 оныг хүртэл жилийн 65,000 төгрөгний ном худалдан авах маш бага санхүүжилттэй байсан. 2017, 2018 онд бодлогоор жил тус бүр 1 сая төгрөгний санхүүжилттэй болж, номын баяжилт хийгдсэн байна. Зарим сумдад номын сангийн зориулалтын байргүй, мэргэжлийн номын санчгүй байдал одоог хүртэл байна. Энэ нь мэргэжлийн боловсон хүчин нийгмийн хангамж, цалин, орон байрны тохижилт зэрэгтэй холбоотойгоор мэргэжлийн боловсон хүчин орон нутагт үчихгүй байгаатай холбоотой юм. Мөн намын шугамаар мэргэжлийн бус хүмүүс халаа сэлгээ болж орж ирдэг.

Зарим газар явуулын номын сангийн үйлчилгээ багуудад явж үйлчилдэг нь хэвээр байна. Сүүлийн үед ер нь соёлын төвийн үйлчилгээний чанар хүртээмж, соёл, чөлөөт цагийн үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлт нь даяаршин буй өнөөгийн нийгмийн технологийн хөгжилтэй салшгүй холбоотой.

Завтай цагаар ямар нэгэн уран зохиол, шүлгийн номыг шимтэн унших биш гар утсаараа хамаатан садан, үр хүүхэдтэйгээ чатлах, хошин шог үзэх, facebook дахь хэрэгтэй хэрэггүй мэт хаа хамаагүй дүрс бичлэг сонирхох зэрэг соёл чөлөөт цагийн өнөөгийн хандлага эрс өөрчлөгдсөн нь номын сангийн өнөөгийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой. Мөн зарим оюунлаг гэр бүл номын хямдралтай худалдаа, үзэсгэлэнгээс цуврал, комиксоор ном худалдан авч хувиараа номын баяжилттай болсон.

Техник хэрэгсэл эрэмбээр (6)-д, сөрөг 43. Энэ нь тоног төхөөрөмж хуучин, өөрийн гэсэн авто машин байхгүй тул хөдөө явж үйлчлэхэд эрсдэлтэй. Зарим газар шинэ соёлын төв баригдсан боловч техник хэрэгсэл дутагдалтай хэвээр, хуучин ширээ сандал зэрэг тавилга нь шинэ барилгадаа гологддог. Техник хэрэгсэл сайн байхад хөрөнгө оруулалт, санхүүжүүлэлт, төсөл хөтөлбөр хамгийн чухал юм.

СББӨ-ийн хадгалалт, хамгаалалт эрэмбээр (7)-д, эерэг 17, сөрөг 35 хүн контентэд хамрагджээ. Үүнээс үзэхэд бусад контентыг бодвол эрс өөр. Эерэг хандлагатай. Сөрөгт соёлын биет бус өвийн өвлөн тээгч ховор болж байна. Сүүлийн үед СББӨ-өө судлах сурталчлах ажилд бодлогоор түлхүү анхаардаг болсон.

Нийгмийн халамж, хамгаалалт эрэмбээр (8), 29 контент тэмдэглэгдсэн. Мэргэжлийн боловсон хүчин төдийгүй соёлын төвд ажиллаж байгаа ямар ч түвшний ажилтны хамгийн чухал зүйлийн нэг нь нийгмийн халамж, хамгаалалт юм. Гэвч орон тоо

цөөн, нэг хүн 2 хүний ажил байнга давхар хийдэг зэрэг нь хуулиараа өөрөө нийгмийн халамж хамгааллын асуудлыг тодорхой хэмжээнд зөрчиж байгаа хэрэг юм.

Шинээр төгсөж ирсэн мэргэжилтэнд орон гэр, ажлын орчин хамгийн чухалд тавигдаж, үүнийг дагаад нийгмийн халамжийн бодлого дутагддаг байна.

Машин тоног төхөөрөмжгүй гээд хүний унаанд явж ажил хийх, давхар ажиллах, илүү цагаар ажиллах зэрэгт цалин, урамшуулал чухал мэт боловч хүний амь насыг хамгаалж байдаг нийгмийн халамж үйлчилгээ хамгийн чухал юм.

III. Судалгааны харьцуулалт:

Соёлын төв /соёлын ордон/-ы үйлчилгээний хүртээмж болон бидний судалгааны объектуудын талаар хэсэгчлэн болон тусгайлсан байдлаар дараах судалгаануудад хөндөгдөн судлагдаж байсныг дараах хүснэгтүүдээр харуулж байна.

Хүснэгт №.73

№	Судалгааны нэр	Хамарсан хүрээ	Судалгааны үр дүн
1	Зах зээл ба соёл урлаг /1998-2000/		“Монголын төрөөс баримтлах соёлын бодлогын шинжлэх ухааны үндэс”, “Маркетингийн онол, түүнийг монголын соёл урлагт хэрэглэх арга зам”, “Соёлын менежментийн үндэс, түүнийг монголын нөхцөлд хэрэглэх нь”, “Зах зээлийн нөхцөл дэх театрын урлаг” зэрэг сургалт судалгаанд зориулсан гарын авлага зөвлөмж боловсруулсан байна. Эдгээр бүтээлд соёл урлагийн менежмент маркетингийн онол, соёл урлагийн байгууллагуудын удирдлага, бүтэц зохион байгуулалтын тулгамдсан асуудлыг судлан бичжээ.
2	Монголын соёл урлагийн салбарын менежментийг боловсронгуй болгох үндсэн асуудал /2001/	Төв, Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгуудын нийт 13 суманд ажиллаж, 270 хүнээс мэдээлэл цуглуулжээ.	Орон нутгийн соёл урлагийн байгууллагын удирдлагын бүтэц, үйл ажиллагааны агуулга, хэлбэрийн уялдаа холбоо, тэдгээрийн дотоод зохион байгуулалтад задлан шинжилгээ хийх <ul style="list-style-type: none">• Соёл урлагийн менежерүүдийн ур чадварын төвшинг тодорхойлох

			<ul style="list-style-type: none"> • Хөдөөгийн соёл урлагийн боловсон хүчний хэрэгцээ, материаллаг бааз, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, түүний хангалтын судалгаа гаргах • Хүн амын соёл урлагийн үйлчилгээний эрэлт хэрэгцээг судлах <p>Соёл-урлагийн байгууллагын хөгжил, байршлын ерөнхий схемийг бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан судалж, өнөөгийн дүр зургийг гаргахад холбоотой материал бүрдүүлэх</p>
3	Соёлын бодлого, соёл урлагийн байгууллагын санхүүжилт /2003/	Увс, Баян-Өлгий аймгийн 10 орчим сум, Улаанбаатар хотын 4 дүүргийн 559 хүн, 219 урлагийн ажилтныг оролцуулсан.	<ul style="list-style-type: none"> • Монголын соёл урлагийг хөгжүүлэх төрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх талаар явуулж буй үйл ажиллагаанд дүгнэлт хийх • Соёл урлагийн хөгжлийн эрх зүйн орчин, санхүүжилтийн байдлыг судлах • Дээрхи чиглэлээр олон нийтийн санаа бодлыг судлах
4	Соёлын үйлчилгээ-хүний хөгжилд /2007/	21 аймаг, 126 сум, нийслэлийн 9 дүүргийн соёл урлагийн байгууллагууд, нийт 4406 респондентууд хамрагдсан.	<ul style="list-style-type: none"> • Хүн амын соёл урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдлыг судлах <p>Соёл урлагийн үйлчилгээний хүний хөгжилд үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох</p>
	Соёл урлагийн салбарын хөгжил /2008-2009/	Төв, Өмнөговь, Баян-Өлгий, Хөвсгөл, Сүхбаатар аймгууд	Монголын төрөөс соёлын талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагааны үндэс

5		болон Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй, Налайх дүүргийн нийгэм-хүн ам зүй, нийгэм-мэргэжлийн янз бүрийн бүлгийн төлөөлүүлэн 1781 хүнийг хамруулсан.	болох соёл урлагийн мастер төлөвлөгөө /2009-2021/-г боловсруулах ажилд шаардагдах мэдээллийг бүрдүүлэх, тус салбарын хөгжлийн хандлагыг тодорхойлох
6	Хүн амд хүргэх соёл урлагийн үйлчилгээний тулгамдсан асуудлууд /2010/ Соёл урлаг судлалын хүрээлэн хүрээлэнгийн гүйцэтгэсэн БСШУЯ-ны захиалгат төсөл	Орон нутгийн дөрвөн бүсээс сонгогдсон Завхан, Увс, Өвөрхангай, Баянхонгор, Сүхбаатар, Хэнтий, Дундговь, Өмнөговь зэрэг 8 аймгаас социологийн судалгааг 680 респондентуудаас авсан. Мөн эксперт мэргэжилтнүүдийн дунд	Тус шинжилгээ, судалгааны үр дүнд хөдөө, орон нутгийн хүн амд хүргэх соёл урлагийн үйлчилгээнд тулгамдаж буй нийт 41 асуудлуудыг дөрвөн чиглэлээр гаргаж дүгнэсэн байна. Үүнд: 1.Шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа дутмаг,орон нутагт соёл урлагийн үйлчилгээ хүргэх тогтолцоо оновчтой биш, түүнд ажиллагсдын эрх зүйн мэдлэг дутмаг талаар – 14 багц асуудал 2. Хүний нөөц, мэргэжлийн боловсон хүчин дутмаг, боловсон хүчин бэлтгэх мэргэжлийн сургалтын чанарыг сайжруулах, соёлын ажилтнуудын нийгмийн хамгааллын асуудал зэргийг хөндсөн-10 багц асуудал

		чөлөөт ярилцлага хийсэн байна.	<p>3. Орон нутгийн соёл, урлагийн байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, соёлын маркетинг, менежментийг хөгжүүлсний үндсэн дээр ажлын уялдаа холбоог нь сайжруулах талаар- 6 багц асуудал</p> <p>4. Орон нутгийн соёл, урлагийн байгууллагын санхүүжилт, эдийн засгийн хүчин чадлыг дээшлүүлэх талаар- 11 багц асуудал</p>
7	“Монголын соёлын үйлдвэрлэл, соёл, урлагийн хувьсал, өөрчлөлт (1911-2011 он)” /2011-2013/	Нийслэлийн 6 дүүрэг, Увс, Өмнөговь, Хэнтий, Орхон аймгийн 4500 гаруй хүнээс социологийн судалгаа авч, соёл, урлагийн байгууллагуудаас нийгэмд үзүүлж буй соёлын үйлчилгээний чанар, үр өгөөж, хэрэглэгчдийн сэтгэл ханамж, хандлагыг тодорхойлон, урьд өмнө хийгдсэн судалгаа, салбарын нэгдсэн үнэлгээнд нэгдсэн дүгнэлт хийж, холбогдох	<p>Энэхүү судалгааны ажлын үр дүнд Монгол Улсын төр, засгаас соёл, урлагийн талаар баримталсан бодлого, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг Олноо өргөгдсөн Монгол улсын үеийн болон БНМАУ-ын, Монгол Улсын үеийн тогтоол, тушаал, шийдвэр, үндэсний хөтөлбөр, зарлиг, захирамж зэрэг эрхзүйн баримт бичигт тулгуурлан судалж үнэлэлт, дүгнэлт өгчээ.</p> <p>Монгол улсын зарим аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа соёлын үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага, уран бүтээлчдийн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэн, бүртгэлд хамрагдсан байгууллагын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн орчин, үйл ажиллагааны бодит байдлыг судалж үнэлэлт дүгнэлт өгсөн нь цаашид энэ үйл явцыг төрийн</p>

		саналуудыг дэвшүүлсэн байна.	бодлогоор хэрхэн зохицуулах арга замыг тодорхойлоход ач холбогдолтой болжээ.
8	Соёлын төвийн жишиг загвар /2015/		Олдоогүй болно.
9	Соёл урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал хэтийн төлөв /2018/		Олдоогүй болно.
10	Нийслэлийн соёл урлагийн байгууллагын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, соёлын үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэх төсөл боловсруулах суурь судалгаа /2018/	Судалгаанд түүврийн аргачлалын дагуу нийслэлийн 9 дүүргийн 720 иргэн, нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй 7 соёлын ордны 93 ажиллагсдыг хамруулсан.	Нийслэлийн дүүргийн соёлын ордуудын нөхцөл байдлын шинжилгээ хийсний үндсэн дээр соёлын ордуудын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд баримтлах бодлого, стратегийг тодорхойлж, тогтвортой хөгжлийг хангах талаар зөвлөмжийг санал болгосон.

Монголын соёл, урлагийн салбарын орчинд 1998-2018 оны хооронд томоохон 8 төсөл хэрэгжсний бидэнд олдсон буюу 6 төслийн судалгааг агуулгаар нь нэгтгэж үзвэл:

- Зах зээлийн нөхцөл дэх монголын соёл, урлагийн салбарын менежмент, маркетингийн удирдлагыг боловсронгуй болгох асуудал, санхүүжилт
- Соёл, урлагийн мастер төлөвлөгөө боловсруулахад шаардагдах мэдээлэл, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх суурь судалгаа

- Хүн амын соёл, урлагийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ, үйлчилгээний чанар хүртээмж, тулгамдсан асуудал зэргийг хандсан байна.

Тухайлбал, хүн амд хүргэх соёл урлагийн үйлчилгээний тулгамдсан асуудлууд /2010/ төслийн хүрээнд соёл урлагийн салбарт тулгамдаж буй 41 асуудлыг дэвшүүлсэн байна. Бидний хэрэгжүүлсэн “соёлын үйлчилгээний хүртээмжийн судалгаа” төслийн хүрээнд дээрх асуудлууд ч хөндөгдөж байна.

Судалгааны хүрээнд хийсэн контент анализаас харвал, үнэлгээ, стандарт, сургалтын хөтөлбөр, орчин, явуулын үйлчилгээ, төсөл хөтөлбөр, гадаад харилцаа зэрэг 16 тулгамдаж буй асуудлууд байна. Мөн “нийслэлийн соёл урлагийн байгууллагын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, соёлын үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэх төсөл боловсруулах суурь судалгаа” /2018/ -ны төслийн хүрээнд нийслэлийн дүүргийн соёлын орднуудын нөхцөл байдлын шинжилгээ хийсний үндсэн дээр соёлын орднуудын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд баримтлах бодлого, стратегийг тодорхойлж, тогтвортой хөгжлийг хангах талаар зөвлөмжийг санал болгосон байна.

Бидэнд олдсон зарим нэг төслүүдийн материалтай танилцахад : судалгааг өргөн хүрээнд хийж хангалттай материал бүрдүүлсэн, тулгамдсан асуудлуудыг гаргаж тодорхой санал, зөвлөмжүүдийг дэвшүүлэн тавьсан байна. Гэвч зарим материал олдохгүй байгаа нь төслийн үр дүн судалгааны эргэлтэнд орохгүй байх, салбарын хэмжээний дараачийн судалгааны залгамж холбоонд сөргөөр нөлөөлөх тал байхыг үгүйсгэхгүй юм.

Судалгааны төсөл бүр дээр давхцан гарч буй зарим нэг тулгамдсан асуудлууд шийдвэрлэгдэхгүй байгааг бид дараах байдлаар авч үзэж байна. Үүнд:

- Соёлын үйлчилгээний төрөл зүйлүүд салбарын ангиллаар эрүүл мэндийн яам, нийгмийн хамгааллын яам, байгаль орчин аялал жуулчлалын яам гэх мэтчилэн 10 гаруй салбарт сарнин тархсан
- Улсаас соёл урлагийг дэмжих санхүүгийн дэмжлэг дутмаг
- Боловсон хүчний дутагдал, ур чадвар /соёлын боловсрол эзэмшсэн байдал/
- Орчин /соёлын төв, номын сан, онст/
- Нүүдэл шилжилт хөдөлгөөний улмаас орон нутгийн хүн амын тоо багассан
- Орон нутгийн засаг захиргааны хариуцлагагүй байдал /үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг төсөвтөө тусгадаггүй/
- Сүүлийн үед тус салбарын хүрээнд төсөл хэлбэрээр санхүүжилт өгч судалгаа хийж байгаа сайн тал байгаа хэдий ч сэдэв давхцах асуудал сүүлийн үед ажиглагдаж байгаа нь салбарын судалгааны стратегийн чиглэлийг тодорхой болгох шаардлага байгааг харуулж байна.
- Түүнчлэн төслийн санал, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх эдийн засгийн тооцоолол, эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх асуудлууд удаашралтай байдгаас төслийн ач холбогдол, уялдаа алдагдсаар байх магадлалтай хэмээн үзэж байна. Дээрх шалтгаан судалгааны үр дүнг хэрэгжүүлэх боломж хомсдох байдлыг буй болгосон байж болох талтай.

Судалгааны харьцуулалтаас үзвэл, соёлын төв бол хүн амд соёлын үйлчилгээг хүргэх, сургах, мэдээлэл түгээх, судлах, СБӨ болон СББӨ-ийг хадгалан хамгаалах, өвлөн уламжлуулах зэрэг үйл ажиллагааны чиглэл нь олон нийтийг “соён гэгээрүүлэх” чиглэлд хандаж байна.

Иймд “соёлын төв, соёлын ордон”-ы статусыг тодорхой болгож, үйл ажиллагаа, үйлчилгээг нь стандартчилах нь чухал юм хэмээн үзэж байна.

ГУРАВ. СОЁЛЫН ТӨВ, ОРДНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

III.1. Соёлын төв, соёлын ордны үйлчилгээний өнөөгийн байдал

Үзэгч, хэрэглэгчийн үйлчилгээ гэдэг нь хэрэглэгчид худалдан авалт хийхийн өмнөх, худалдан авалт хийх үед болон худалдан авалт хийсний дараа үзүүлж буй үйлчилгээний нөхцөл юм. Эдийн засагт үйлчилгээг биет бус хөрөнгө гэж үздэг. Мөн хэрэглэгчийн үйлчилгээ гэдэг нь бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хэрэглэгчийн хүлээлтийг хангаж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлэхэд зориулагдсан үйл ажиллагааны цогцыг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Аливаа байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалт, орлогын түвшинд хэрэглэгчид үзүүлж буй үйлчилгээний чанар чухал үүрэг гүйцэтгэдэг. Манай улсын “Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ хийх, үнэлэх журам” /2008/-д чанарын үзүүлэлтүүдийг баталсан⁹ болно.

Үйлчилгээний чанар гэдэг нь үйлчилгээний талаарх хэрэглэгчийн хүлээлт ба бодит байдлын харьцааг илэрхийлсэн ойлголт юм. Өндөр чадвартай бизнесийн үйлчилгээ нь хэрэгцээнд нийцэхийн сацуу өрсөлдөх чадвартай байж чаддаг. Үйлчилгээний чанар гэдэг бол өрсөлдөх чадварын нэг чухал үзүүлэлт юм.

Чанар бол цөөн үгээр тодорхойлоход нилээд төвөгтэй ойлголт бөгөөд судлаачид чанарыг тодорхойлох талаар олон санааг дэвшүүлсэн. Тухайлбал:

- Чанарыг хэрэглээнд бүх талаас нийцтэй байх гэдэг утгаар нь “хэрэглэгчийн эрэлтийг хангах”, үйлчилгээний чанарын бодит байдал болон хэрэглэгчийн субъектив ойлголт хоёрын хоорондын ялгааг тодорхойлох судалгаанууд хийгдсэн байна. Үйлчилгээний чанарын “техникийн” болон “ажил үүргийн” хүчин

Keyc №7

“Соёлын төвүүдийг үнэлэх үлгэрчилсэн юм байхгүй. Статистик үр дүнд үндэслээд үнэлээд байгаа. Гэвч тооноос наана чанар гэж чухал зүйл байна. Иргэд бас үнэлэх, ганц засаг дарга үнэлэх биш. Шинэ аргачлал боловсруулах нь зөв гэж үзэж байна. Зохион байгуулж байгаа арга хэмжээний чанар хүртээмжийг авч үзэх нь чухал. Үүнийг үнэлэх шалгуур алга. Соёлын төвийн эрхлэгч. Эмэгтэй. Өвөрхангай.”

зүйлүүд гэсэн хоёр чухал бүрэлдэхүүн байх бөгөөд эдгээр нь үйлчилгээний чанарыг үнэлэх чухал хүчин зүйл. Учир нь үйлчилгээний явцад хэрэглэгч үйлдвэрлэгчийн шууд

⁹ Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ хийх, үнэлэх журам. <http://nsug.ub.gov.mn/wp-content/uploads/2018/05/>. 2019.10.28.

харилцаа явагдаж байдаг тул хэрэглэгчид өөрсдөө техникийн чанарт нөлөөлдөг. Жишээ нь, бид номын санд үйлчлүүлэгч болон ном худалдаж аваад унших замаар номын сан бүрдүүлэхийг ялгаж нарийвчилсан тоон мэдээ гаргах хэрэгтэй болжээ. Ийнхүү орчин үед бүтээгдэхүүнээс гадна үйл ажиллагаа, удирдлагын тогтолцоо, үйлчилгээнд ихээхэн анхаарал хандуулж, үйлчилгээний чанарыг үнэлэх туршигдсан олон загварууд ашиглан өөрийн салбар, байгууллагад тохирохыг хэрэглэж, цаашид үйлчилгээгээ сайжруулах стратегиа боловсруулж байна. Дээрх гадаад орны загвар, туршлагаас харахад манай орны

Кейс№9

“Соёлын үйл ажиллагааг үнэлэхдээ стандарт, маягтын дагуу үнэлж авч болно. Театр, том урлагийн байгууллагын жишгээр биднийг үнэлээд байдаг. Хөтөлбөрүүд байна. Хөрсөн дээрээ болохоор аймгийн соёлын газрууд Соёлын төвүүдээсээ анхны мэдээллээ бүрдүүлдэг. Гэтэл бидний ажлыг үнэлэхдээ ганц Засаг дарга үнэлдэг. Мэдээллийн цахимаар үнэлэмжээ авах хэрэгтэй.

*Соёлын төвийн эрхлэгч.
Эмэгтэй. Чингис хаан хот.”*

Кейс№8

“Номын сан талаасаа яриад явья. Үйлчилгээ бол хэвийн явагдаж байгаа. Манай үйлчлүүлэгчдийн 70, 80% нь сургуулийн хүүхдүүд. Учир нь иргэдэд номын сангаар ирээд заалаар үйлчлүүлэх зав муу. Гэрээр олгохоор насанд хүрэгчид их үйлчлүүлдэг. Нэг хэсэг ном уншихаа байсан гэдэг бол одоо харин унших нь сэргэсэн. Номын сангаар үйлчлүүлж уншихаас гадна ихэнх боломжийн амьдралтай иргэд дэлгүүрээс номоо худалдан аваад уншиж байна. Тэгэхээр тоон мэдээнд алдаа орж байна. Хувиараа худалдан авч байгаа уншигчид уншигчдын тоонд орохгүй үлдэнэ. Гэртээ хобби болгоод ном уншдаг, цуглуулдаг хүмүүс их болсон.

*Соёлын төвийн эрхлэгч.
Өвөрхангай. Эмэгтэй.”*

хувьд соёл, урлагийн байгууллагуудын ажлын байрны тав тухтай орчин, нөхцөл, материаллаг бааз, хөгжим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, орчны тохижилтыг сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг судлах, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.

Жинхэнэ үйлчлүүлэгч төвтэй байгууллага бол хамгийн үнэ цэнэтэй зүйлсээ үйлчлүүлэгчдээ гэж авч үздэг бөгөөд тэдний сэтгэл ханамжийг чухалчилдаг байна. Иймд манай соёлын байгууллагууд үйлчилгээний төвд хэрэглэгчийг тавьж, тэдний сэтгэл ханамжийг чухалчлах зайлшгүй хэрэгцээ үүсч байгааг анхаарах хэрэгтэй болж байна.

Театр чуулга, соёлын төв, ордууд зөвхөн туурвиж буй уран бүтээл, урын сан, үзвэрийн талд илүү анхаарч, ашиг орлогоо нэмэгдүүлэхэд хүчээ тавиад, тухайн байгууллагад үйлчлүүлж буй үзэгчдийн тав тух, хүсэл сонирхол, хүлээлтийг хангах, сайхан амрааж, тохь тухтай үйлчилгээг үзүүлэх замаар хүний хөгжилд сайнаар нөлөөлөх

талд муу анхаарч байгаа дутагдалтай байдал харагдаж байна. Цаашид үйлчлүүлэгч төвтэй байхын тулд:

- Үйлчлүүлэгч хамгийн үнэ цэнэ, байр суурийг эзлэхийг,
- Үйлчлүүлэгчийг бүхнээс илүүд тавихыг,
- Байгууллагын хүн бүр үйлчлүүлэгчид үйлчлэх ёстой гэдгээ ойлгодог байхыг хэлнэ.

Өнөөдөр манай соёлын байгууллагууд үйлчлүүлэгч төвтэй соёлыг төлөвшүүлэхэд дараах гурван асуудлыг чухалчлан авч үзэх хэрэгтэй. Үүнд, **аюулгүй байдал, цэвэр цэмцгэр байдал, хяналт**¹⁰. Соёлын төвд үйлчлүүлэгчийн орж ирэх тэр цаг үеэс эхлээд түүнийг гарах мөч хүртлэх хугацаанд танай ажиллагчид үйлчилгээний чанараар дамжуулан мартагдашгүй дурсамж үлдээх явдал юм.

Үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд үйлчлүүлэгч төвтэй соёлыг төлөвшүүлэхэд дан ганц үйлчилгээний ажилчид биш тасалбар түгээгч, жижүүр, харуул, соёлын ажилтан, дарга, менежер зэрэг бүх ажиллагчдын үйлчлүүлэгчийг угтан авч буй хэвшил, инээмсэглэл, нүдний харц зэргээр үйлчлүүлэгчиддээ тааламжтай байдлыг үүсгэх нь чухал юм.

Кейс №10

“Соёлын үйлчилгээний чанарыг дээшлүүлэхийн тулд дотроо ажиллаж байгаа соёлын ажилтан нараа чадавхжуулах, мэдээллээр хангаж байх. Сургуулийн багш нарыг үе үе дуудаад сургалтанд хамруулдаг. Түүн шиг ажилтан нараа хамруулмаар байна. Иргэдийг соён гэгээрүүлэхийн тулд ажилтан нараа цэнэглэх нь зүйтэй юм. Соёлын төвийн эрхлэгч. Эмэгтэй. Дорноговь”

Соёлын төвийн үйлчлүүлэгчид бол өөрийн дотоод сэтгэл зүйн үнэлгээгээр байгууллагад тусалдаг хамтрагч тул тэдэнд үйлчлүүлэгчдийн зөвлөгөө өгөх төв, үнэлгээний систем, хэрэглэгчид рүү чиглэсэн арга хэмжээ зэрэгт хандах боломжийг олгох хэрэгтэй.

Соёлын төв, соёлын ордны үйл ажиллагаа, үйлчилгээний өнөөгийн байдал.

Хүн амд соёлын үйлчилгээ үзүүлэх зорилгоор Монгол Улсын 21 аймаг, нийслэлд 345 соёлын төв, 364 номын сан, 45 музей ажиллаж байна.¹¹ Соёлын төвүүдэд 2385 ажиллагсад байна. Мөн томоохон үйлдвэр, Төмөр замын өртөө, Хилийн цэргийн ангийн дэргэд соёлын ордон, соёлын төв ажилладаг. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 83 дугаар тушаалаар нийслэлийн хүн амын соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор дүүрэг бүхэнд соёлын ордон байгуулахаар

¹⁰ <https://wenku.baidu.com/>


¹¹ http://1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L20_2. 2019.11.07.

шийдвэрлэж, дүүргийн соёлын ордны үлгэрчилсэн дүрмийг баталсан. Гэвч соёлын төв, соёлын ордны бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, санхүүжилтэд олон тулгамдсан асуудал байна.

Соёлын төв, ордны үйл ажиллагааг хэвийн явуулж, үйлчилгээг сайжруулахад санхүүжилт олон эх үүсвэртэй байх нь үр өгөөжтэй гэдгийг мэргэжилтнүүд анхааруулж байна.


Таны бодлоор соёлын төв, соёлын ордны санхүүжилтийн аль эх үүсвэр илүү чухал вэ?

Бүдүүвч №.56



Соёлын төв, ордон батлагдсан төсвөөс гадуурх үйл ажиллагаанаас олсон орлогыг хэрхэн нэмэгдүүлж буй нь үйлчилгээний хүртээмжийн байдлыг илэрхийлэх нэг үзүүлэлт гэж болох юм. Мэргэжилтнүүдийн 48% нь дөнгөж 10 хүртэл хувийг нэмэгдүүлж байна гэсэн байна. Харин респондентуудын 18% нь 10-20%-ийг бүрдүүлэх боломжтой гэж тооцсон байна.

Соёлын төв, ордны батлагдсан төсвийн өөрийн орлогыг нэмэгдүүлж чадаж байна уу?




Монгол улсын Соёлын тухай хуульд "соёлын ажилтан" гэж бүх төрлийн уран бүтээлийг бүтээн туурвих, соёлын үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэх, хадгалан хамгаалах, сэргээн засварлах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд дагнан эрхэлж байгаа иргэнийг хэлнэ" гэж тодорхойлсон байдаг.

Сүүлийн үед соёл, урлагийн байгууллагууд хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалт, хөгжлийн бодлого боловсруулан хэрэгжүүлж, суралцагч байгууллага болох, цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэвшүүлэх талаар анхаарч буй боловч хангалттай үр дүнд хүрч чадахгүй байна.

Соёлын үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай тулгамдсан асуудлуудыг эрэмбэлбэл: 1-рт, мэргэжлийн боловсон хүчин (73%), 2-рт, төсөв хөрөнгө (66.8%), 3-рт, тоног төхөөрөмж (51.2%), 5-рт, Зориулалтын байр (33.6%) гэсэн судалгааны дүгнэлт гарсан байна.

Мэргэжилтэн шинжээчдээс авсан судалгаанд соёлын ажилтны эзэмшсэн байх ёстой мэдлэг урлагийн боловсрол, ёс зүйн боловсрол, удирдахуйн ухааны мэдлэгийг чухал гэж үзсэн байгаа нь цаашид соёлын ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулж, сэдэв агуулгыг өргөжүүлэх шаардлагатай болжээ. Байгууллагын соёлыг сайжруулахад оновчтой хөтөлбөртэй сургалт өгөөжтэй байдаг.


Таны бодлоор соёлын ажилтан ямар мэдлэг, ур чадвар эзэмшсэн байх ёстой вэ?



Мөн манай улсад соёлын салбарын боловсон хүчин бэлтгэдэг сургуулиудын боловсролын чанарыг ерөнхийд нь ямар түвшинд байдаг гэж үздэг болохыг тодруулахад олонх нь буюу 52.9% нь дунд зэрэг гэж хариулсан байна. Энэ судалгааны анкетаар тодруулах шаардлагатай гэж үзсэн ерөнхий асуулт юм.

Манай улсад соёлын салбарын боловсон хүчин бэлтгэж байгаа боловсролын чанар ямар түвшинд байна вэ?

Бүдүүвч №59




Экспертийн асуулганд соёл урлагийн бодлого тодорхойлох, шийдвэр гаргагч, үйлчилгээ хүргэгч субъектууд хамрагдсан. Эдгээр респондентуудын 6-21 жил буюу 72.8% нь ажил амьдралын туршлагатай хүмүүс байгааг тухайн ажил, албан тушаал дээр 1-5 жил ажиллагсад 26%-ийг эзэлж байгаатай харьцуулж үзээд дараах дүгнэлтийг хийж болох юм.

Үүнд: соёл, урлагийн үйлчилгээний салбарт ажиллаж байгаа хүмүүс мэргэжлийн бус, тогтвор суурьшилгүй, улс төрийн томилгоогоор өөрчлөгддөг, өөр салбарын хүмүүс тэтгэвэрт гарах дөхөхөөрөө соёл, урлагийн салбарт орж ажилладаг буюу соёл урлагийн ажлыг хэн ч хийж болдог гэсэн үнэлэмж ач холбогдлыг нь алдуулж байна гэсэн таамаглалд хүргэж байна.

Үүнтэй уялдуулан хөдөө орон нутагт соёл, урлагийн чиглэлээр ажиллаж буй хүмүүсийн тогтвор суурьшил, нийгмийн хамгаалал, мэргэжлийн ур чадвар, үүнд орон нутгийн шийдвэр гаргагчдын хандах хандлага зэргийг тусгайлан судлах хэрэгцээ шаардлага байгааг анхаарах цаг болжээ. Тус салбарын ажилтнуудын чадавхийг үнэлж, зэрэглэлтэй болгож цалингийн нэмэгдэл олгохын тулд харьяа яамнаас аттестатчлалын журам боловсруулахыг экспертийн судалгаанд оролцогчдын олонх нь дэмжиж байна.

Соёлын төв, ордны ажилтны аттестатчлал шаардлагатай гэж үзэж байна уу?

Бүдүүвч №.60



“Соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт зорилтот бүлэгт хүрч чадаж байна уу?” гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 40.4% нь “Салбарын дарга, албан тушаалтнууд ихэвчлэн хамрагддаг” гэж хариулснаас үзэхэд, соёлын ажилтнууд сургалтад хамрагдах байдал хангалтгүй байна. Тэдний 14.% нь соёлын төвийн мэргэжилтнүүд хамрагдаж байна гэж хариулсан байгаа тул цаашид сургалт зохион байгуулагчид анхаарах асуудал мөн.

Соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт зорилтот бүлэгт хүрч чадаж байна уу? /хариултын тоо/

Бүдүүвч №.61



Судалгаанд оролцогчдын 24.6% нь сүүлийн таван жилд дотоод, гадаадад мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаагүй байна. 40.2% нь 1-2 удаа дотоодын, 6.6% нь гадаадын сургалтад хамрагджээ. 15.6% нь 3-5 удаа дотоодын, 6-аас дээш удаа буюу жил тутамд дөнгөж 3.3% нь хамрагдсан байна.

Бидний явуулсан экспертийн судалгааны үр дүнгээс харахад соёлын төв, соёлын ордонд ажилладаг ажилтан албан хаагч нар ихэвчлэн хоёр хүний ажлыг нэг хүн хийдэг. Олон жил ажилласан хүмүүс нь ажлын туршлагаар ажиллаж байна. Зарим мэргэжлийн бус хүмүүст мэргэжилтэй болох, сургалтанд суух, хандлагаа өөрчлөх зайлшгүй шаардлага байна.

Монгол улсын Соёлын тухай хуулийн 15.2-т “Улсын болон бүс нутгийн чанартай соёлын байгууллагын даргыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн соёлын байгууллагын дарга, захирлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга, сум, дүүргийн соёлын байгууллагын дарга, захирлыг аймаг, нийслэлийн соёлын байгууллагын дарга, захиралтай зөвшилцөн сум, дүүргийн Засаг дарга тус тус томилж, чөлөөлнө” гэж заасан. Практик дээр зарим соёлын төв, ордны удирдлагаар мэргэжлийн бус хүн томилогдох явдал их байгаа нөхцөлд мэргэжил дээшлүүлэх сургалтад аль болох тогтвор суурьшилтай ажиллах үндсэн орон тооны соёлын ажилтныг хамруулж байх хэрэгтэй юм.

Энэ салбарын хүний нөөцийн бодлого, хөтөлбөрийг шат дараатай хэрэгжүүлж, орон нутаг соёлын ажилтан, уран бүтээлчийг захиалгаар бэлтгэх хэрэгцээ шаардлага үүссэн байна.

Соёлын төв, ордны үйл ажиллагааны орлого, төрөл хэлбэрийг нэмэгдүүлэх нэг арга зам нь соёл, урлагийн захиалгат үйлчилгээний саналыг хүлээж авч хэрэгжүүлэх юм. Танай орон нутгийн соёлын төв, соёлын ордон иргэд, байгууллагын захиалгат үйлчилгээ

явуулж байна уу? гэсэн асуултад судалгаанд оролцогчид урлагийн тоглолт (55.9%), цэнгээнт үдэшлэг (53.5%), тэмдэглэлт өдөр (45.9%), хурал семинарын (41.7%) үйлчилгээг нэмэлт захиалгат үйлчилгээг голлон явуулдаг гэж хариулжээ. Мөн заримдаа үзэсгэлэн, хөдөлмөрийн алдар тэмдэглэх, сургалт, ой тэмдэглэх үйлчилгээг үзүүлэх нь нийтлэг байна.

Танай орон нутгийн соёлын төв, соёлын ордон иргэд, байгууллагын захиалгат үйлчилгээ явуулж байна уу?/хариултын тоо/

Хүснэгт №.74

	Үйлчилгээний төрөл		Тогтмол	Заримдаа	Огт үгүй
1	Сургалт	Албан	51	114	8
		Албан бус	38	96	12
2	Урлагийн тоглолт		118	80	2
3	Хурал, семинар		88	97	7
4	Төгсөлтийн баяр		55	97	28
5	Хөдөлмөрийн алдар тэмдэглэх		52	109	21
6	Тэмдэглэлт өдөр		96	66	15
7	Үзэсгэлэн		47	119	14
8	Насны ой тэмдэглэх		18	84	59
9	Ургийн баяр		20	112	41
10	Хурим		20	57	79
11	Түүхэн үйл явдлын ой тэмдэглэх		71	93	12
12	Цэнгээнт үдэшлэг		113	57	14


Мэргэжилтэн шинжээчдээс *Орон нутагт соёлын үйлдвэрлэл, үйлчилгээг хослуулан явуулах шинэлэг хувилбарыг санал болгоно уу?* гэсэн нээлттэй асуултад олонх нь язгуур урлагийн төрөл зүйл, гар урлал, аялал жуулчлал, угсаатны өв соёл, баярыг уламжлуулах ажлуудыг уялдаатай зохион байгуулахыг онцлон нэрлэжээ. Жишээ нь, Дорнод аймгийн соёл, урлагийн салбарыг дэмжих хөтөлбөр /2018-2021/-т Соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах, баяжуулан хөгжүүлэхэд соёлын байгууллага нь төр, олон нийтийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах зорилтын хүрээнд “Угсаатны урлаг соёлын “Алтан дөрөө”, “Алтаргана”, “Хатагин”, “Баргажин”, “Тоонот нютаг”, “Эв

модны наадам” зэрэг томоохон арга хэмжээг олон улсын аялал жуулчлалтай холбож хөгжүүлнэ” гэж зорилт тавин ажиллаж байна.¹²

Соёлын төв, ордон нь иргэдийн санаачилга, эрэлт хэрэгцээнд тулгуурласан орон нутгийн соёлын бодлого, хөтөлбөрт нийцсэн үйл ажиллагааг явуулах нь зүйтэй гэж мэргэжилтнүүд үзэж байна.

Танай соёлын ордон, төвөөс зохион байгуулдаг үйл ажиллагаа ямар зорилго, чиглэлтэй байвал зохистой вэ?

Бүдүүвч №62




Бид энд 2016 онд Эрдэнэт үйлдвэрийн цех, салбар хэлтсүүдийн ажилчдын төлөөлөл болгон 262 ажилчдаас “Уурхайчин” соёлын ордноос зохион байгуулдаг чөлөөт цагт зориулсан соёлын үйлчилгээний өнөөгийн байдлын судалгааны тайлангаас үзэхэд хувь хүний хөгжилд зориулсан соёлын ажил, гэр бүлд зориулсан чөлөөт цагийн үйлчилгээ, хүүхдэд зориулсан чөлөөт цагийн үйлчилгээний эрэлт, хүлээлт байна.

ГОК-ийн Соёлын ордноос дараах соёлын үйлчилгээнүүдээс аль чиглэлийг түлхүү зохион байгуулаасай гэж хүсч байна?

Бүдүүвч №63

¹² Дорнод аймгийн соёл, урлагийн салбарыг дэмжих хөтөлбөр /2018-2021/.




Танай орон нутгийн онцлогийг тусгасан соёлын үйлдвэрлэл, үйлчилгээг хослуулан явуулах бололцоо хэр зэрэг бүрдсэн бэ? гэсэн асуултад салбарын мэргэжилтнүүдийн 55.3% нь боломжийн, 35.9% нь хангалтгүй, 9.2% нь хангалттай гэж хариулсан.

Иргэдэд соёлын талаарх бодлого, эрх зүйг сурталчлан таниулах ажил дутмаг байдгаас хэрэглээгээ тодорхойлж мэдэхгүй, оролцоо идэвх сул байж болно. Орон нутгийн соёлын төв иргэдэд соёлын талаар төрөөс баримтлах бодлого, хууль, дүрэм, журмыг сурталчлах талаар ямар ажил зохиож байна вэ? гэсэн асуултад дараах байдлаар хариулжээ.


Танай орон нутгийн соёлын төв иргэдэд соёлын талаар төрөөс баримтлах бодлого, хууль, дүрэм, журмыг сурталчлах талаар ямар ажил зохиож байна вэ?

Бүдүүвч №.64



Доорх асуулгын хариулт нь соёлын төв, ордны үйлчилгээ, үйл ажиллагаанд стандарт, чанарын удирдлагын асуудлууд тулгамдаж буйг бас дахин баталсан юм.


Соёлын төв, ордны улсын стандартад зайлшгүй тусгах ямар зүйл байна вэ?



Соёлын салбарт болон төрийн захиргаанд соёлын салбарыг хариуцан ажилладаг, соёлын төвийн ажилтнууд, энэ байгууллагын үйл ажиллагааг мэддэг экспертүүдийн судалгаанаас харахад 91% нь стандарт хэрэгтэй гэдэгтэй санал нийлнэ, зарим талаар санал нийлнэ гэж хариулсан бөгөөд өнөөдөр соёлын төвийн үйлчилгээ, үйл ажиллагаанд чанарын удирдлага, тэр тусмаа стандарт, стандартчилалын асуудал тун чухал байна гэсэн дүгнэлт гарч байна. Ялангуяа санал асуулгад оролцогсдын 69.5% зориулалтын байрны стандарт, 48.1% тоног төхөөрөмжийн стандарт, 23.8% хувцас, жижиг хэрэглэлийн, 17.6% үйл ажиллагааны тайлан бичилтийн стандарт шаардлагатай гэж үзжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ” хэмээн нутгийн удирдлагын үндсэн зарчмыг тодорхойлсон. Мөн Соёлын тухай хуулийн 12-р зүйлд “Соёлын удирдлагын тогтолцоо нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн болон соёлын байгууллагын удирдлагаас бүрдэнэ” гэж заасан.

Танай орон нутгийн удирдлага соёлын төвийн үйл ажиллагааг сайжруулах талаар хэр зэрэг санаачилгатай ажилладаг вэ?



Соёл, урлагийн салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулахад статистик тоон үзүүлэлтийн дүн шинжилгээ нэн чухал. ҮСГ-аас соёлын статистикийн үндсэн үзүүлэлтэд Урлаг, соёлын байгууллагын үзүүлэлт, Музейн үзүүлэлт, Номын сангийн үзүүлэлт, Киноны үзүүлэлт, Соёлын үйлчилгээ, Соёл, урлагийн салбарын ажиллагсад, Соёл урлагийн салбарын тоног төхөөрөмжийн судалгаа, Соёл, урлагийн салбарын зардал, сургуулийн номын сангийн тайлан гэх мэт нийт 419 үзүүлэлт ашигладаг байна.

ЮНЕСКО-гийн “Соёлын статистикийн хүрээ-2009” зөвлөмж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам. “Соёл, урлагийн салбарын статистикийн мэдээллийг боловсруулах зөвлөмж” /2003/, “ҮСГ-аас баталсан Соёлын статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал” /2013/ зэргийг удирдамж болгон соёл, урлагийн салбарын статистикийг гаргаж байна. Энэ статистикийг улам нарийвчлалтай гаргахын тулд үзүүлэлтүүдийг бодитой, зөв томъёолох шаардлага буй.

Соёл, урлагийн байгууллагын статистикийн үндсэн үзүүлэлтүүд

Хүснэгт №.75

№	Үйл ажиллагаа	Үндсэн үзүүлэлтүүд
1	Кино, үзвэр	<ul style="list-style-type: none"> • Кино үзвэрийн цэгийн тоо • Суудлын тоо • Кино гаргалт • Үзэгчдийн тоо • Ажиллагчид • Нийт орлого

2	Тогог төхөөрөмжийн судалгаа	<ul style="list-style-type: none"> • Театр, чуулга, соёлын төв, • Музейн • Номын сан • Кино
3	Соёлын төв	<ul style="list-style-type: none"> • Соёлын төвийн тоо • Зохион байгуулсан арга хэмжээ • Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдагсад • Суудлын тоо • Ажиллагчид
4	Мэргэжлийн урлагийн байгууллага	<ul style="list-style-type: none"> • Шинэ уран бүтээлийн тоо • Тоглолтын тоо • Үзэгчдийн тоо • Нийт орлого • Суудлын тоо
5	Музей	<ul style="list-style-type: none"> • Музейн үзмэрийн тоо • Үзэгчдийн тоо
6	Номын сан	<ul style="list-style-type: none"> • Суудлын тоо • Уншигчдын тоо • Шинээр авсан номын тоо • Номын фондын тоо • Фондоос хасагдсан номын тоо

Эх сурвалж: <file:///D:/Soyolin%20uilchilgee%20anket/>

Соёлын төв, ордны үйлчилгээг чанаржуулж, иргэдийн соёлын эрэлт хэрэгцээ ба оролцоонд тулгуурласан соёл, урлагийн олон талт үйл ажиллагааг хүн амд хүргэхийн тулд соёлын салбарын хүний нөөцийг чадавхижуулах нь чухал байгааг манай судалгаа харуулж байна. Иймд соёл, урлагийн салбарын өнөөгийн бодит байдал ба хэтийн зорилгыг уялдуулсан үнэлгээний журам, стандарт нэн шаардлагатай болжээ.

Ш.2. Соёлын төв, соёлын ордноос зохион байгуулагддаг сургалтын үйл ажиллагаа

Соёлын төв, соёлын ордны сургалтанд холбогдох заалтууд дараах дүрэм журам, бодлогын баримт бичигт туссан байна. БСШУ-ы сайдын 2011 оны “Сумын соёлын

төвийн үлгэрчилсэн дүрэм” батлах тухай 83 дугаар тушаалын 1.7-д “Соёлын төвийн номын санч-мэдээллийн ажилтан, дуу хөгжим, бүжгийн багш, музей (орон нутаг сурталчлах танхим)-н ажилтныг сумын Засаг даргын Тамгын газартай зөвшилцөн Соёлын төвийн эрхлэгч томилж, чөлөөлнө” гэж заасан. Эндээс үзвэл дуу хөгжим, бүжгийн багш сургалт зохион байгуулах үүрэгтэй.

Мөн “Соёлын төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг”-г ...иргэдийн танин мэдэхүй, боловсрол, соёл, авъяас чадварын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулна; ...Иргэд, ардын авъяастны хэрэгцээ, сонирхолд түшиглэн **сургалт**, семинар зохион байгуулах; Байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, ардын авъяастныг түшиглэн үндэсний уламжлалт болон хүүхдэд зориулсан урлаг, сонгодог урлагийг сурталчлан дэлгэрүүлэх, хадгалж хамгаалах чиглэлээр **сургалт явуулж**, хамтлаг, хэсэг зохион байгуулан хүн амын соёлын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ” гэж заасан.

Боловсролын эрх зүйн талаас “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)”-ын 3.14-д “Насан туршийн боловсролын үйлчилгээний төрөл, хэлбэр, сургалтын байгууллагыг өргөжүүлэн бэхжүүлнэ”¹³ гэж заасан буй.

Соёлын төв, ордны сургалт нь дугуйлангийн зарчмаар явдаг, янз бүрийн насны суралцагчид хамрагддаг, эрэлт хэрэгцээнд тулгуурладаг онцлогтой.

Сургалтын технологи, арга зүй гэдэг нь сургалтын зорилго, агуулга, үйл явц, арга, хэлбэрийг илэрхийлдэг ойлголт. Өнөө үед сургалтыг “нийгмийн болон хувь хүний (суралцагчийн) эрэлт хэрэгцээг хангах зорилго бүхий багш, суралцагчдын хамтын бүтээлч үйл ажиллагаа”¹⁴ хэмээн үзэх болсон. “Сургалтын технологи нь өөрийн зорилго, зориулалт, агуулга, арга хэлбэр, үнэлгээ, шалгуур бүхий иж бүрэн, өвөрмөц тогтолцоот ухагдахуун”¹⁵ юм.

Нөгөө талаар “Сургалтын технологи бол **бүтээлч, уян хатан, олон хувилбар** бүхий өвөрмөц үзэгдэл”¹⁶ хэмээн үзэх болсон. Энэ нь нийгмийн үнэлэмжийн нөлөөгөөр ч өөрчлөгдөж байдаг.

Соёлын төвийн сургалтын арга зүй нь суралцагчийн идэвхтэй, багийн сургалтын аргад тулгуурлаж, тэдний авъяасыг хөгжүүлэх технологийн давуу талуудыг хэрэглэвэл

¹³ Багшийн хөгжил. Баримтын эмхэтгэл. УБ.,2018. 209-р тал.

¹⁴ Ичинхорлоо Ш. Сургалтын онол, хэрэглээ. УБ.,2013. 7-р тал

¹⁵ Сургалтын технологи, үзэл баримтлал, онол арга зүйн зарим асуудал. Ред. Пүрэв О., Содномваанчиг Г. УБ.,2001.

¹⁶ Ичинхорлоо Ш. Сургалтын онол, хэрэглээ. УБ.,2013 69-р тал

илүү үр дүнтэй болно. Авьяас хөгжүүлэх сургалт нь суралцагч, оролцогч төвтэй илүү бүтээлч, хамтын шинжтэй байдгаараа онцлог юм.

Судалгааны ажлын хүрээнд Нийслэлийн Хан-Уул дүүргийн Соёлын ордны үйл ажиллагаатай танилцсан. Тус Соёлын ордон нь нийт 7 багштай бөгөөд 2019 онд хэрэглэгчдэд нийт 18 төрлийн төлбөртэй сургалт санал болгосон байна. СУИС-ийн мэргэжлийн тэнхимийн багш нараас зөвлөгөө авч сургалтын хөтөлбөрөө уян хатан байдлаар сар, улирал, жилээр боловсруулж ирсэн. Мөн ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр сургалт явагддаг байна. Цаашид мэргэших суралцагчдад зориулан нарийвчилсан хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж ажилладаг.

Төслийн судалгааны хүрээнд Хан-Уул дүүргийн Соёлын ордны сургалтуудаас 2018-2019 оны хичээлийн жилийн “Авьяас хөгжүүлэх морин хуур” хөгжмийн сургалтын төлөвлөгөөг сонгож, агуулгын шинжилгээ хийж үзлээ /Хавсралт 1/. Үүний тулд хөтөлбөрийн зорилго, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээг авч үзсэн болно.

Тус сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөөнд бүлэг сэдэв, цаг, хичээл тус бүрийн сэдэв, хугацаа, гол зорилго, хичээлийн хэрэглэгдэхүүн, бие дааж хийх ажлын агуулга зэргийг тусгасан байна. Тухайлбал, **бүлэг сэдэв** нь “Морин хуур хөгжмийн бүтэц, зохион байгуулалт, барил, тавил, суулт, ноотны анхан шат, гамм, Монгол ардын дуу заах”; “Гамм, дасгал, Монгол ардын дуу, жижиг хэлбэрийн зохиол, Гурвал, дөрвөлөөр хамсран хөгжимдөх, ноот унших дадал эзэмшүүлэх”; “Чуулга, найрал хөгжим хөгжимдөх мөн ноот унших дадал эзэмшүүлэх” гэж бүлэглэсэн боловч цагийн хувьд харилцан адилгүй.

Агуулгын хувьд удиртгал, онолын анхан шатны мэдлэг, баруун зүүн гарын барил, дасгал, бататгал гэсэн нэгж хичээлүүдээс бүрдэж байгаа юм. Онол, дасгалыг зэрэгцүүлж заана, хүүхэд багшаас хэт хамаарахгүй өөрөө хөгжих боломжийг олгохыг хичээнэ.

Технологи, арга зүй, үнэлгээний аргачлал.

Соёлын төвийн суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэхэд дараах аргачлал илүү жишиг дөхөм байж болох юм. Үнэлгээг явцын ба үр дүнгийн гэж ангилна. Юуны өмнө суралцагчдыг ямар үзүүлэлтээр хэрхэн яаж үнэлэх аргачлалаа тайлбарлаж танилцуулах нь чухал. Үүнд:

- Сургалт /Оролцоо, нэгж бүлэг сэдэв, хөндлөнгийн үнэлгээ, хичээлийн бэлтгэл, сурах бичиг, дэвтэртэй эсэх, гэрийн даалгавар/
- Сахилга бат /Танхимын болон танхимын бус сургалтын үеийн сахилга, хариуцлага, төлөвшил, харилцааны соёл/
- Цаг ашиглалт /Хичээлээс хоцрох, таслах, хичээлээс гадуур ажилд оролцох оролцоо, цаг хугацааг тооцож болох даалгаврын биелэлтүүд/

- Үүрэг даалгаврын биелэлт /Багшийн өгсөн үүрэг даалгаврыг хийж гүйцэтгэх байдал/

- Соёлжилт¹⁷ /Урлагийн хувцсаа өмсөж хэвшсэн байдал, биеэ авч явах байдал/.

Суралцагчдын авъяасаа нээн илрүүлэх, хөгжүүлэх, цаашид гүнзгийрүүлэн суралцах боломжийг бүрдүүлэхэд сургалтын үнэлгээний зарчим нэлээд нөлөөлнө. Өнөө үед сургалтын үр дүнг мэдлэг, ур чадвар, хандлагад гарсан бодит ахиц дэвшил, чанарын өөрчлөлтөөр үнэлэх болсон.¹⁸ Иймээс, үнэлэх объект, шалгуур, үзүүлэлтээс бүрдсэн үнэлгээний аргачлал бий болгож мөрдөх нь ач холбогдолтой. Жишээ нь, хөгжмийн сургалтын үр дүнгийн үнэлгээ нь судлагдахууны агуулгын хүрээнд дараах 4 түвшин, тодорхой шалгууртай байж болох юм. Шалгуурт суурилсан үнэлгээ нь суралцагчийн амжилтын түвшинг хүрэх үр дүнтэй харьцуулан үнэлэхэд чиглэнэ. Ерөнхийдөө авъяас хөгжүүлэх сургалтын явцын үнэлгээ (Formative) нь дүн тавихад чиглэхгүй, үр дүнгийн үнэлгээ (Summative) нь хэр зэрэг сурсан, ямар түвшинд хүрсэн гэдгийг тогтооход чиглэж буй учир дүн тавьж болох юм. “Үнэлгээ гэдэг нь дүн тавих биш, харин ямар дүн тавих үндэслэлийг гаргахад чиглэсэн үйл ажиллагаа”¹⁹ гэж үзэх болсон байна.

Соёлын төв, соёлын ордны хөгжмийн сургалтын үр дүнгийн үнэлгээний түвшин, шалгуур.

Хүснэгт №76

Түвшин	Тоон ба чанарын Үнэлгээ	Үнэлгээний түвшний шалгуур
I	60-100 ABCD	<ul style="list-style-type: none"> • Хөгжмийн бүтэц, зохион байгуулалт • Хөгжмийн барил, тавил, суулт • Ноот унших дадал эзэмшсэн байх • Хөгжим сонсож сурах
II	60-100 ABCD	<ul style="list-style-type: none"> • Гамм дасгал унших • Эзэмшсэн чадвар дээрээ тулгуурлаж Монгол ардын дуу тоглох

¹⁷ Жигмэд Ё. Сурагч нэг бүрийн манлайллыг бодитой дүгнэх нь. –Зөвлөх багшийн арга зүй, түршлага. УБ.,2019. 92 –р тал.

¹⁸ Ичинхорлоо Ш. Сургалтын онол, хэрэглээ. УБ.,2013. 20-р тал

¹⁹ Багшийн хөгжил. УБ.,2019. 46-р тал.

III	60-100 ABCD	<ul style="list-style-type: none"> • Эзэмшсэн чадвар дээрээ тулгуурлаж жижиг хэлбэрийн зохиол тоглох • Гурвал, дөрвөлөөр хамсран хөгжимдөх
IV	60-100 ABCD	<ul style="list-style-type: none"> • Чуулга, найрал хөгжим хөгжимдөх • Ноот унших

Соёлын төв, ордны бүжгийн сургалтын үр дүнгийн үнэлгээний түвшин, шалгуур.

Хүснэгт №77

Түвшин	Тоон ба чанарын Үнэлгээ	Үнэлгээний түвшний шалгуур
I	60-100 ABCD	<ul style="list-style-type: none"> • Гарын байрлал ба хаялага, цацлага • Мөрний цохилт, дугтралт • Цээж биеэр хийх хөдөлгөөн • Хөлийн зогсолт • Биелгээний суултууд
II	60-100 ABCD	<ul style="list-style-type: none"> • Жижиг үсрэлт, эргэлтүүд • Бүжгийн хөдөлгөөн болон намбууд эзэмшиж, 3-4 намба болон тайзны монгол бүжиг сурсан байна.
III	60-100 ABCD	<ul style="list-style-type: none"> • Сонгодог бүжиг • Монгол бүжиг • Цэнгээнт бүжиг • Язгуур бий биелгээ • Олон үндэстний бүжгийн элементүүдийг эзэмшсэн байна.

Мөн 2018 онд шинэчилсэн ЕБС-ийн сурагчдын үнэлгээний найман шатлалт хувилбарыг ч хэрэгжүүлж болох юм.

ЕБС-ийн сургалтын үнэлгээний шатлал

Хүснэгт №78

Түвшин	Хувь
I	0-29
II	30-39

III	40-49
IV	50-59
V	60-69
VI	70-79
VII	80-89
VIII	90-100

Тайлан тоглолт, уралдаан тэмцээнд байр эзэлсэн байдлаар үнэлж байна. Энэ нь багш нар, эцэг эхчүүдийн зүгээс суралцагчийг үнэлэх боломжтойгоос гадна суралцагч өөрийгөө ямар түвшинд байгааг ойлгож өөрийгөө дүгнэх нөхцөлийг бүрдүүлдэг ач холбогдолтой.

Үр дүнгийн дүнтэй, дүнгүй аль нэг үнэлгээ нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг шинжлэх, ахиц амжилтыг тодорхой харах, хүрсэн бодит түвшнийг тогтоох, суралцагчийн авъяасыг хөгжүүлэхэд ямар дэмжлэг хэрэгтэйг илрүүлэх, цаашдын үйл ажиллагаагаа төлөвлөх сайжруулах боломжтой болно.

Ер нь сурагчдын бүтээлээр үнэлэх арга нь суралцагч өөрийгөө үнэлэх, суралцагчийг бусад нь үнэлэх, багш сурагчдаа үнэлэх маш том боломжийг олгодог. Бүтээл хийх явцад суралцагчдад бие даах, бүтээх, хамтран ажиллах, шинийг сэдэх, эрэл хайгуул хийх, өөрөөр сэтгэх, өөртөө итгэх итгэл үнэмшил төрдөг.

Бүжгийн сургалтаар суралцагч өөрсдийн чадамжаасаа шалтгаалан 1-3 бүжиг сурсан байна. Дугуйлангийн багш суралцагчийн тайлан тоглолтыг хийж эцэг, эхчүүдэд танилцуулна.

Сургалтанд хамрагдах нас: Бүжгийн сургалтанд 7-14 нас, “Дуу, хөгжим”-ийн сургалтанд нас харгалзахгүй.

Үнэлгээний шалгуур үзүүлэлт нь сурагчийн эзэмших урлагийн талаарх мэдлэг, ахиц дэвшил, чадвар, хандлага, төлөвшлийн түвшинг бодитой тодорхойлоход тус дөхөм үзүүлнэ. Соёлын төв, ордны сургалт нь нэгдсэн загвартай журнал, хувийн хэрэг хөтлөлтийн программыг бий болгох шаардлагатай.

Өнөөдөр практик дээр авъяас хөгжүүлэх сургалтыг тайлан тоглолтоор үнэлж сертификат олгох арга түгээмэл хэрэглэгдэж байна. Үүний давуу тал нь нээлттэй байдлаар үзэгчдээр үнэлүүлэх, суралцагчийн урам зоригийг мохоохгүй байх зэрэг сэтгэлзүйн талын ач холбогдолтой. Мөн сул тал нь урлагийн боловсрол, онолын мэдлэгийг тодорхой үнэлэх бололцоо дутмаг байдаг. Суралцагчийн оюун ухаан, зөв

хүмүүжил төлөвшлийг үнэлэхийн тулд үр дүнгийн үнэлгээ чухал. Цаашид соёлын төв, ордны сургалтын үнэлгээний системийг өөрчилснөөр олон улсын чиг хандлагад нийцсэн, олон талын давуу чанарыг бий болгох бололцоотой. Өөрөөр хэлбэл, сургалтын ямар хөтөлбөрийг хэрэгжүүлбэл илүү ач холбогдолтой вэ, багшийн зүгээс суралцагчидтай хэрхэн харьцах вэ гэдэг нь тодорхой болно.

Сургалтын үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт эрх зүйн хүрээнд тодорхой бус байна. Жишээ нь, 2008 оны “Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлэх журам”-д “Иргэдэд үзүүлсэн урлаг, соёлын үйлчилгээний хүртээмж, чанар, үр дүн” гэж ерөнхий заасныг нарийвчлах шаардлагатай байна.

Урлагийн боловсрол олгох сургалтын үр дүн нь суралцагчийн сэтгэл, оюун ухаан, зөв хүмүүжил төлөвшил юм. Иймд Соёлын төв, ордны сургалтыг үнэлэх шалгуурын **ерөнхий зарчмыг** дараах байдлаар томъёолж болно. Үүнд:

1. Дугуйлангийн сургалтын зорилго, зорилт, үр дүнг үнэлэх боломжийг агуулсан байх.
2. Дугуйлангийн сургалтын агуулгад туссан мэдлэг, ур чадварыг үнэлэх.
3. Урлагийн боловсролоор дамжуулан эзэмшиж буй хүмүүжил, хувийн соёлын түвшинг тодорхойлох.

Түүнчлэн сургалт бол багш, суралцагчийн харилцаа учир 2018 онд батлагдсан “Багшийн хөгжлийг дэмжих тухай” хуульд “Багшийн ажлын гүйцэтгэл гэж суралцагчдын хөгжил, хүмүүжил, төлөвшил, хандлага, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан бусад чиг үүргийн хүрээнд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгээр илэрхийлэгдэх үр дүнг хэлнэ” гэж заасан байна. Иймээс Соёлын төв, ордны багш нарын ур чадварын ахиц, амжилт, өөрчлөлтийг үнэлж, чанарын үнэлгээ хийж хэвших шаардлагатай байна. Энэ нь тэдний зэрэг дэв, цалин, урамшууллыг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг хангах хөшүүрэг болно. Нөгөө талаас багш нар сурган хүмүүжүүлэх ухааны мэдлэг, заах арга зүйн сургалтад хамрагдах, энэ чиглэлийн ном зохиолыг уншиж өөрийгөө хөгжүүлэх тал дээр ихээхэн анхаарах хэрэгтэй. Жишээ нь, Өвөрхангай аймгийн БСУГ-аас Соёлын төвийн эрхлэгч нарын үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхдээ дугуйланг “хүрэлцээ далайц, чанар үр дүн, тогтмолжсон байдал” гэсэн 3 үзүүлэлтээр үнэлсэн байна.²⁰ Энэ бол Соёлын төв дээрх дугуйлангийн зохион байгуулалтыг үнэлж буй боловч, шалгуур нь тодорхой бус.

²⁰ Өвөрхангай аймгийн БСУГ-аас Соёлын төвийн эрхлэгчтэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэсэн илтгэх хуудас. 2017 он.

Сургалтын арга зүй: Сургалтанд орчин үеийн идэвхтэй сургалтын аргуудыг ашиглахаас гадна уламжлалт сургалтын түгээмэл аргыг ч ашиглах хэрэгтэй. Жишээ нь, хөгжмийн зохиолыг сонсгохын өмнө тухайн зохиолын агуулгад тохирсон тайлбар өгөх буюу тодорхой нэр томъёог мэдүүлж, хөгжмийн зохиолчийн тухай ярилцана. Хөгжмийн зохиолчийн алдар гавъяа, ямар дууны хөгжим, гоцлол, бүжгийн жүжиг бичсэн гэдгийг товч танилцуулна.²¹

Бүжгийн сургалтын арга зүй: Хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон бүжиг нь агуулгын хувьд харагдах байдлаараа өвөрмөц, өнгөлөг, цовоо сэргэлэн харагддаг бол мэргэжлийн уран бүтээлчид, насанд хүрэгчдэд зориулан дэглэн найруулсан бүжиг нь илүү нарийн элементүүдтэй байдаг. Хүнд элементтэй мэргэжлийн бүжгийн агуулгыг гүйцэд харуулахыг дугуйлангийн багш хүүхдээс шахаж болохгүй бөгөөд их хүч зарцуулж ажилласнаас хүүхэд бэртэж гэмтэж болзошгүй. Иймд хүүхдийн ирээдүйг зөв төлөвлөн харж, бүжгийн хөдөлгөөн, агуулгыг нас биеийн онцлогт тохируулан дэглэх, найруулах, хөрвүүлэн зааж сургах нь чухал. Бүжгийн хөдөлгөөнөөс гадна дотоод сэтгэлийн илэрлүүдийг бүжгийн хөдөлгөөнтэй холбон нүд, сэтгэл, зүрхний тольтоор уялдуулан илэрхийлэх арга зүйг ашиглах нь зохимжтой.

Сургалтын төлөвлөгөө: Сургалтын төлөвлөгөө нь ямар түвшний суралцагч ямар хичээлийг, хэдэн цаг судлахыг тогтооно. Сургалтын төлөвлөгөөг хичээлийн жил, хагас жил, сараар, долоо хоногоор төлөвлөж болно.

Сургалтын хөтөлбөр: Энэ нь заавал үзэх (тоглох зохиол) судлагдахуун, сонгон судлах (өөрийн сурахыг хүсч байгаа зохиол) судлагдахуунтай боловсруулагдсан байвал зохино. Сонгон судлах судлагдахуун нь суралцагчийн 100 хувь хэрэгцээ сонирхолд тулгуурлана. Жишээ нь, *бүжгийн сургалтын хөтөлбөрийн агуулга:*

1-р анги: Эхлэн суралцагчдад бүжгийн анхан шатны дасгалуудыг зөв, шинжлэх ухааны үндэслэлтэй заах, их биеийн тавилтыг зөв тавих, тэнцвэрийг зөв олох, хөл гарын байрлал, жижиг үсрэлтүүд, тойрон бүжгүүдийг хөгжмийн хэмнэлд тохируулан хийлгэж сурсан байна.

Монгол бүжгийн гол суурь тавилтаар гар хөлийн байрлал, суултуудыг маш сайн зааж сургах ёстой. Үүнд:

- ✓ Гарын байрлал ба хаялага, цацлага
- Гарын үндсэн байрлал
- Бэлтгэл байрлал

²¹ Аюуш С. Соёл гэгээрлийн ажил чөлөөт цаг. УБ., 1988. 121-р тал.

- Гарын хурууны онцлог (мэндийн гар, баярын гар, дээдлэх гар)
- Гарын хаялагууд (гарыг дэлгэж хаях хаялага, гараар царваж хаях хаялага)
- ✓ Мөрний цохилт, дугтралт
 - Мөрний хөдөлгөөнүүд (дугтрах, солбиж дугтрах, нухлах, солбиж нухлах, солбих цохилго)
- ✓ Цээж биеэр хийх хөдөлгөөн
- ✓ Хөлийн зогсолт ба биелгээний суултууд
 - Явган суудал, тахимаар сөг суудал, цомцойх суудал, сөхрөх суудал, мушгиа суудал, завилгаа суудал, лянхуа суудал.

2-р анги: 1-р ангид үзсэн дасгалуудыг хүндрүүлэн үзнэ. Дасгалын хөгжмийн темпээ ахиулна, жижиг үсрэлтүүд, эргэлтүүд, бүжгийн хөдөлгөөнүүд болон намбуудаас эзэмшсэн байна. Үүнд 3-4 намба болон тайзны монгол бүжгүүдээс сурсан байна.

Сонгоны анги: Сонгодог бүжиг, монгол бүжиг, тайзны монгол бүжгүүдийг 1-2 ангийн программын шаардлага хангасан суралцагчдыг сонгон суралцуулж, цаашид цэнгээнт бүжиг, орчин үе болон олон ардын бүжгүүдийн элементүүдээс заана. Бүжгүүдийг гүнзгийрүүлэн хүндрүүлж үзнэ. Мөн бүжгүүдийг бүжиглэх дадал чадварыг эзэмшүүлнэ. Сургалтын явцад багш үндэстэн угсаатнуудын угсаа гарал, түүх, газар зүйн байрлал, амьдралы нөхцөл, зан үйл, ёс заншилтай танилцуулж тэдгээр нь бүжгийн үүсэл хөгжилд хэрхэн нөлөөлсөн тухай тодорхой, үнэн зөв мэдээллийг өгөх шаардлагатай.²²

Сургалтын хэрэглэгдэхүүн: Сургалтанд хэрэглэгдэх сурах бичгийн чанарыг сайжруулж, шинэлэг агуулгаар боловсруулж, заавал ашиглах ном, сурах бичгийн жагсаалтыг баталж гаргах хэрэгтэй юм. Үүнд салбарын эрдэмтэн судлаачид анхаарал хандуулж, сэтгэл судлал, заах арга, боловсрол судлалын мэргэжилтэн зөвлөхүүдтэй хамтран ажиллах шаардлагатай болжээ. Цаашид:

1. Одоо хэрэглэж байгаа сурах бичгийг судалгаанд үндэслэн сайжруулах багийг сонгон шалгаруулах ажилуулах.
2. Сурах бичгийг мэдээлэл харилцаа холбооны төрөл бүрийн хэрэгслээр ашиглах боломжтой болгох. Түүнчлэн сургалтанд ашиглах техник тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэг, хувцас хэрэглэлийн хангалт нь сургалтын чанарт нөлөөлөх нь эргэлзээгүй учир санхүүжилтийг нэмэгдүүлэх нь зайлшгүй болж байна.

Хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон бүжгүүдийг зааж сургах шаардлагатай бөгөөд сургалтанд зориулан тохижуулсан танхим ч чухал нөлөөтэй. Иймд бүжгийн

²² Түүл Т. Ардын тайзны бүжиг. УБ.,2012. 6-7-р тал

сургалтын танхимын стандарт, түүний тохижилт дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- Таазны тавигдах шаардлага
- Шалны гадаргууд тавигдах шаардлага
- Агааржуулалтын системд тавигдах шаардлага
- Нэг суралцагчид ноогдох талбайн хэмжээ
- Гэрэлтүүлэгт тавигдах шаардлага
- Ханын толинд тавигдах шаардлага
- Тулгуур модонд тавигдах шаардлага
- Хөгжим, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага гэх мэт.

Дугуйлангийн багш нь сургалтын хэрэглэгдэхүүнийг цаг ямагт анхаарч, түүнийг ариглаж хамгаалах, хөгжүүлэх үүрэг хүлээдэг. Сургалтын бусад хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж дутмаг, өрөө, танхимын хүртээмж, гадаад дотоод тохижилт муу байдлаас үүдэн сургалтын чанарт сөрөг нөлөө үзүүлж байна.

Сургалтын зохион байгуулалт: Сургалтын эхэнд суралцагчдын дунд ахлагчийг сонгох, хөгжим, бусад хэрэглэгдэхүүнийг хуваарилах, сургалтын зорилго, хичээлийн ерөнхий төлөвлөгөө, цаг, сургалтын үр дүн, ач холбогдол, үнэлгээ зэргийг ойлгуулах шаардлагатай. Суралцах хугацааг уян хатан зохион байгуулж болно. Жишээ нь, бүжгийн сургалтанд бүжгийн урлагийн зайлшгүй суралцах мэдлэг чадварыг 2 жилийн хугацаанд олгодог байна. Цаашид үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй, авъяастай суралцагчдыг сонгоны ангид дэвшүүлэн суралцуулж болно.

Өнөө үед албан бус боловсролын хэлбэрээр дугуйлангийн танхимын бус сургалтын арга зүйг боловсруулах шаардлага тулгарч байна. Соёлын төвүүдэд зориулсан дугуйлангийн сургалтын технологи, арга зүйн удирдамж, гарын авлага гаргаж, багш, суралцагчийн үнэлгээний журам боловсруулах хэрэгтэй байна.

Соёлын төв, ордны сургалтын үнэлгээ нь соёлын төвөөс суралцагчийг үнэлэх, багш нарыг үнэлэх гэсэн цогц үнэлгээ бөгөөд эдгээрийг зохицуулах журмуудыг нарийвчлан боловсруулж хэвшүүлэх шаардлагатай юм.

Ш.3. Соёлын төв, соёлын ордны үйлчилгээний чанар, хүртээмж,

Соёлын үндсэн үүрэг нь танин мэдүүлэх, соён гэгээрүүлэх, энэрэн нигүүлсэх шинж чанарыг хүнд төлөвшүүлэх, улмаар нийгмийн үнэт зүйлсийн системийг эрэмбэлэн

зохицуулах замаар үндэстэн оршин тогтох суурь нөхцлийг бүрүүлэхэд чиглэдэг. Тийм ч учраас үндэсний соёлыг улсын хил хязгаарын “зөөлөн манаач” гэж нэрлэх нь бий.²³

Соёлын хүртээмж нь үндэсний соёл, урлагийг ард түмэнд хүртээмжтэй хүргэж, түгээн дэлгэрүүлж, уламжлуулан, үйлдвэрлэл, инновацийн бүтээгдэхүүн болгож, язгуур дархлааг бий болгогч амин чухал үйл ажиллагаа юм.

Монгол улс аль ч нийгмийн үед соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийн талаар төрийн бодлогын түвшинд авч үзэж, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, олон нийтэд соёлын хүртээмж хүртээмжтэй байх талаар байнга анхаарч ирсэн байдаг. Соёлын төв, соёлын ордон нь ард түмэнд соёлыг хүртээмжтэй хүргэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. 1921 оноос хойш олон шатны сургууль, номын сан, музей, мэргэжлийн урлагийн байгууллага, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл зэрэг оюуны соёлыг түгээн дэлгэрүүлэх үүрэг, зорилго бүхий байгууллагуудын бүхэл бүтэн тогтолцоо бүрэлдсэн.²⁴ Манай улсад төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн урлагийн байгууллага (театр, чуулга, цирк, филормани) 35, музей 43, нийтийн номын сан 380, сумын соёлын төв, ордон 343, кино үзвэрийн байгууллага 30 нийт 831²⁵ соёлын байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Соёлын төв нь клубын үйл ажиллагааны агуулга хэлбэрийг улам боловсронгуй болгож, материаллаг бааз, тухайн нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх үйлчилгээний хүрээ, хүртээмжийг өргөжүүлэх зорилгоор байгуулсан соёлын үндсэн нэгж байгууллага. Харин *соёлын ордон* нь тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тоо, үйлдвэрлэлийн төвлөрөлд нийцүүлэн байгуулсан соёлын төвийн томсгосон хэлбэрийн байгууллага²⁶ юм. Хувийн хэвшлийн музей, цирк, кино театр, үзвэрийн танхим, гар урлалын үйлдвэрүүд, хэвлэлийн үйлдвэр, номын худалдаа, монгол ахуй соёлыг үйл ажиллагааны гол чиглэлээ болгосон амралтын газар зэрэг нь соёл, чөлөөт цагийн үйл ажиллагаанд өөр өөрийн чиглэлээр хувь нэмрээ оруулж байдаг.

Хүн амын соёлын үйлчилгээнд хамрагдаж байгаа байдал нь эрс өөөрчлөгдсөн байна. Үүнд телевизийн сувгууд, хотжилт, гар утасны хэрэглээ зэрэг нь нөлөөлж байна.


Соёлын төвийн талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?

²³ Долгорсүрэн Ж. Соёлын бодлого соёл, урлагийн салбарын хувьчлал. УБ., 2010. 10-р тал

²⁴ Монгол улсын түүх. V боть. УБ., 2004, 367-р тал


²⁵ Эрхэмтөгс Ж. Монгол улсад соёлын бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх арга зам. Бизнесийн удирдлагын докторын зэрэг горилсон бүтээл. Удирд: Оюунцэцэг Л. УБ., 2016. 54-р тал.

²⁶ Жаргалсайхан Ц. Соёлын төв, соёлын ордны ажилтан нарт тусламж. УБ., 2016. 50-р тал.



Мэдээллийн хурдацтай хөгжлийн эрин үед амьдарч байгаа өнөөгийн хүмүүсийн мэдээлэл авах цар хүрээ нь харьцангуй өргөн болсон. Үүнтэй уялдуулаад үзэхэд энэхүү судалгааны асуултанд 22.9% хувь нь найз нөхөд, мэдээллийн самбар (19.6%), гэр бүл (14.2%), телевиз (13%), нүүр ном (8.5%), хамаатан садан (7%), FM радио (4.2%) өөр эх сурвалжаас (0.8%) гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын олонх нь найз нөхдийн харилцаанаас, соёлын төвийн мэдээллийн самбараас ихэвчлэн мэдээлэл авдаг гэж хариулжээ.

Та соёл, урлагийн байгууллагаар ямар давтамжтай үйлчлүүлдэг вэ?



Соёлын төвөөр үйлчлүүлдэг хугацааны байдлыг долоо хоногт нэг удаа гэж судалгаанд оролцогчдын 37% нь хариулсан бол долоо хоногт хоёр удаа гэж 3.9%, жилд хоёр удаа гэж 17.9% нь хариулжээ. Жилд хоёр удаа соёлын төв, ордноос үйлчилгээ авдаг гэсэн нь иргэдийн соёлын үйлчилгээнд хамрагдаж байгаа байдал хангалтгүйг харуулж байна. Гурван удаа гэж 1.06% нь хариулсан нь хүмүүс соёл, чөлөөт цагаа соёлын төв, ордноор үйлчлүүлж үр дүнтэй өнгөрүүлдэг нь эрс багассаныг харуулж байна. Энэ нь телевизийн олон суваг, интернет орчин бий болж, нүүр номоор мэдээлэл авах болсонтой холбоотой. Нөгөө талаар ойр орчны төдийгүй дэлхий ертөнцийн сонин сайхан, чанартай тоглолт, уран сайхны үйл ажиллагааг өөрийн гар утасны тусламжтайгаар үзэх боломж бүх аймаг, суманд амьдарч байгаа малчид, ард иргэдэд нээлттэй болжээ. Хонь малаа хариулахдаа, ажлаа хийж байхдаа, гэрээсээ найз нөхөд, хамаатан садантайгаа гар утсаар яриад соёл, урлагийн салбарын үйлчилгээний талаар мэдээлэл авах боломжтой болсон зэрэг нь бидний судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Социализмын үед соёлын төвөөр үйлчлүүлэгчдийн тоо өндөр хувьтай байсныг дараах ярилцлагад өгүүлж байна.

Үйлчлүүлэгчид үзвэр үйлчилгээнд хэдэн төгрөгийг зарцуулж байна вэ гэдэг бол хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшингөөс хамаарна.


Кейс №11

1982 оноос өмнө бүүр тооцчихсон. 1 хүн 15 үзвэр үздэг. Одоо кино, концерт, янз бүрийн юм байна. Тэгтэл, эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн орнууд гэж. Тэр орнуудынх 15 байхад манайх гурваар ахисан байсан гэж... тэр чинь тухайн үеийн амжилт шүү дээ. Манай Сумъяа сайд бол үүнийг бичсэн юм”.

*Соёл судлаач.
Эрэгтэй.*

Та сард хэдэн төгрөгийг үзвэр үйлчилгээнд зарцуулдаг вэ?

Бүдүүвч №69



Сард 1000-9000 төгрөг үзвэр үйлчилгээнд зарцуулдаг гэж 31%, 10.000-19.000 төгрөг гэж 24.5%, 20000-29000 гэж 19.40% нь хариулсан нь соёлын төв, ордноор үйлчлүүлэгчдийн амьдралын нөхцөл байдал, сарын орлоготой шууд холбоотой. Харин мөнгө зарцуулдаггүй гэж 13.2% нь хариулжээ. Орон нутагт зундаа хүн ам цөөнтэй, намар хүүхдийн хичээл эхлэхээр сумдад амьдарч байгаа иргэдийн тоо нэмэгддэг. Энэ нь монголчуудын нүүдэлчин малчин ахуй, улирал, амралтын үед хүмүүс мал аж ахуйгаа эрхэлдэгтэй салшгүй холбоотой. Тус судалгаанд оролцогчдын 13% нь мөнгө зарцуулдаггүй гэж хариулсан нь хүмүүсийн үнэгүй бэлэнчлэх сэтгэлгээ, мөн ойр төрлийн уран бүтээлчдийнхээ тоглолтыг үзэж байгаа гэдгээр үнэгүй үзэх боломж

Кейс №12


...Соёлын төвийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж байгаа соёлын төвийн идэвх сайн байгаад санаачлага сайн байх юм бол үйл ажиллагаа хүмүүстээ очиж наалддаг. Манай соёлын төв бол ерөөсөө төлөвлөсөн ажилтай байдаг. Төлөвлөгөөний дагуу ажлыг цогцоор үзэгчдэд хүргэж чаддаг учраас манайд чанар хүртээмж хамгийн сайн байдаг. Ганц онцлог юм хэлэхэд зохион байгуулагдаж байгаа үзвэрийн билет захиалга 3 хоногийн өмнө дуусдаг. Үүдэн дээр билет зарах, овоорох асуудал байхгүй. Тоглолт яг цагтаа эхэлдэг. Хөдөөний соёлын төвүүдээр үйлчлүүлж байгаа урлагийн бригадууд хэлж байна. 1-2 цагийн дараа үзэгчид нь ирэх юм гэж байна. Манайх бол цаад талын хугацаа 10-аас 20 минут хүлээгээд түүнээс цааш хүн цуварч ирнэ гэсэн ойлголт байхгүй. Энэ бол чанар хүртээмж сайн байгаагийн илрэл.

Соёлын төвийн эрхлэгч. Эрэгтэй. Дорноговь аймаг.

таардаг зарим шалтгаан бий. Хэдийгээр үнэгүй үзэж байгаа хүмүүс байгаа боловч энэ нь соёлын төв, ордны үйл ажиллагааны үр дүн, мөнгөн орлогод сөргөөр нөлөөлсөн гэх үндэсгүй юм. Энэ тухай манай ярилцлагад орсон мэргэжилтэн ийнхүү ярьжээ.

Та амралт, чөлөөт цагаа ихэвчлэн хаана өнгөрүүлдэг вэ?

Бүдүүвч №70




Зах зээлийн үед зөвхөн соёлын байгууллага төдийгүй бусад бизнес байгууллага, хувь хүмүүс ч чөлөөт цагийн төрөл бүрийн үйл ажиллагаа зохион явуулдаг болсон нь гол төлөв эдийн засгийн ашиг сонирхолтой холбоотой юм. *Та амралт, чөлөөт цагаа ихэвчлэн хаана өнгөрүүлдэг вэ?* гэсэн асуултанд судалгаанд оролцогчийн 23.1% гэртээ гэж, соёлын төвд гэж 23.1%, спорт зааланд гэж 15.7%, сургалтын төвд гэж 13.6% хариулсан байгаагаас үзэхэд, хүмүүсийн гэр бүлсэг, гэр бүлдээ чөлөөт цагаа зарцуулдаг байдал их, соёлын төвд очиж чөлөөт цагаа өнгөрүүлэх нь нийтлэг байна. Эрүүл мэнд, спортыг эрхэмлэгчид спорт зааланд чөлөөт цагаа өнгөрөөдөг болжээ.

2016 онд Эрдэнэт үйлдвэрийн цех, салбар хэлтсүүдийн ажилчдын төлөөлөл болгон 262 ажилчдаас “Уурхайчин” соёлын ордноос зохион байгуулдаг чөлөөт цагт зориулсан соёлын үйлчилгээний өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээний мэдээлэлд уламжлалт зан заншил, эрүүл аж төрөх ёс, харилцааны соёлын төрлийг хамгийн их хэрэгтэй гэж үзсэн байна.

Дараах соёлын төрлүүдээс аль нь танд хамгийн их хэрэгтэй вэ? /3-ыг сонгоно уу/

Бүдүүвч №71




Эх сурвалж: Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн харъяа “Уурхайчин” соёлын ордны хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа. СУИС ТУС. 2016.

Мэдлэг чадвараа дээшлүүлэхийг хүсэгчид оюуны хөрөнгө оруулалтыг өөртөө хийж сургалтын төвд чөлөөт цагаа өнгөрүүлж байна. Энэ нь сүүлийн үед хүмүүс төрөл бүрийн сургалтыг сонирхдог болсонтой холбоотой. Жишээлбэл, олон үндэстний хоол, үндэсний хувцас, наамал урлал, цаасан урлал, зүү ороох оёдол, мод тарих, ногоо тарих зэргийг сурснаар гэртээ эдийн засгийн үр ашиг авч ирж, соёл, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэхэд чиглэгдэж байгаагаараа онцлог юм. Хувь хүний эдгээр сонирхолтой сургалтууд өрхийн аж ахуй эрхэлж эдийн засгаа сайжруулахад нөлөөлж байна. Тухайлбал, Эрдэнэт үйлдвэрийн “Уурхайчин” Соёлын орон хэрэглэгчдэд зориулсан чөлөөт цагийн клубууд ажиллуулдаг байна.

ГОК-ийн соёлын ордонд ажилладаг чөлөөт цагийн клубуудээс аль нь илүү өгөөжтэй вэ?

Бүдүүвч №72



Эх сурвалж: Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн харъяа “Уурхайчин” соёлын ордны хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа. СУИС ТУС. 2016.

Тус соёлын ордноос зохион байгуулдаг соёл, чөлөөт цагийн үйл ажиллагаанд нийт оролцогчдын 40% нь өөрийн сонирхлоор, мөн нөгөө 40% нь ажлын хамт олонтойгоо цагаа өнгөрүүлэх зорилгоор оролцдог хэмээн хариулсан нь нийт ажилчдын дунд энэ төрлийн үйл ажиллагаанд оролцох, хамрагдах сонирхол, эрэлт хэрэгцээ өндөр байдгийг харуулж байна. Мөн нийт оролцогчдын 34% нь цаг зав байдаггүй, 26% нь ар гэрийн асуудал, 27% нь миний сонирхолд нийцдэггүй шалтгааны улмаас үйл ажиллагаанд оролцдоггүй хэмээн хариулжээ. Харин 40% нь өөрийн сонирхлоор, 40% нь ажлын хамт олонтойгоо цагаа өнгөрүүлэх зорилгоор оролцдог хэмээн хариулсан нь нийт ажилчдын дунд энэ төрлийн үйл ажиллагаанд оролцох, хамрагдах сонирхол, эрэлт хэрэгцээ өндөр байдгийг харуулж байна.²⁷


Мөн соёл, чөлөөт цагийн үйл ажиллагааны хэлбэр ямар үр өгөөжтэй байвал оролцох вэ? гэсэн асуултанд талаас илүү хувь нь эрүүл мэндэд ашиг тустай, 20 гаруй хувь нь танин мэдэхүйн боловсрол олгох үр өгөөжтэй байвал оролцоно хэмээн хариулсан нь ажлын хэлбэр агуулгадаа тусгах зүйл юм.

Тиймээс соёлын төвүүд байнга зохион байгуулдаг ажлынхаа арга, хэлбэр, агуулгаа шинэчлэх хэрэгцээ шаардлага байгааг анхаарах нь зүйтэй.

Чөлөөт цагт зориулсан үйл ажиллагаанд таны оролцоо

Бүдүүвч №73

²⁷ Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн харъяа “Уурхайчин” соёлын ордны хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа. СУИС ТУС. 2016.




Эх сурвалж: Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн харъяа “Уурхайчин” соёлын ордны хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа. СУИС ТУС. 2016.

Мөн сумын хүн амын тоо, орон нутгийн газарзүйн байршил, тухайн сум орон нутагт явуулж байгаа үйлдвэр, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн газар бас соёлын төвд нөлөөлж соёл, чөлөөт цагаа өнгөрүүлэх хандлага өөр өөр байна.

Таны чөлөөт цагт зориулсан үйл ажиллагаа танд ямар үр өгөөжтэй байвал та оролцох вэ?

Бүдүүвч №74





Эх сурвалж: Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн харъяа “Уурхайчин” соёлын ордны хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа. СУИС ТУС. 2016.

Сүүлийн жилүүдэд кино үзвэрийн үйл ажиллагаа өргөжиж, үзэгчдийн эрэлт нэмэгдэж байгааг дараах зургаас харж болно.

Кино үзвэрийн байгууллагын үйл ажиллагаа /2016-2018/

Бүдүүвч №75

Үзүүлэлт	Суудлын тоо	Кино цэгийн тоо	Кино гаргалт	Үзэгчид		Нийт орлого		Ажилчдын тоо		
				нийт	үүнээс хүүхэд	нийт	үзвэрийн	Нийт	Үүнээс эмэгтэй	
	2018	23,143	69	304	37,676	31,307	31,221	11,382	51	23
	2017	14,433	66	998	32,352	300	32,294	31,976	31	-
	2016	11,214	49	927	49,865	755	43,456		31	
	2018	7,990	20	15,595	4,462,993	1,298,138	3,949,542	4,016,602	837	524
	2017	7,938	16	72,763	1,222,419	-	18,553,697	7,428,885	515	330
	2016	5,574	6	51,290	1,040,137		15,374,097	6,713,714	398	282
Улсын дүн	2018	31,133	89	15,899	4,500,669	1,329,445	3,980,763	4,027,984	888	547
	2017	22,371	82	73,761	1,254,771	300	18,585,991	7,460,861	546	330
	2016	16,788	55	52,217	1,090,002	755	15,417,553	6,713,714	429	282

Эх сурвалж: <http://culture.gov.mn/p/r4?id=9>. 2019.11.07.

Ихэнх сумын соёлын төвийн байрны стандарт, хүн амын тоо, боловсон хүчний

Кейс №13

...Манай ажилчид соёлын төвийн чанар хүртээмжийг сайн байлгахын тулд хичээж ажилладаг. Манай соёлын төв 1961 онд баригдсан. Манай сумын иргэд өөрсдийн гараар барьсан чулуун барилга. 3 удаа их завсарт орсон. 1990 онд шатсан. Ер нь бол стандартын шаардлага хангахгүй. 2009 онд мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр актлагдсан. Ийм барилгад үйл ажиллагаа явуулахад бол мэдээж яагаад ч стандартын шаардлага хангахгүй

Соёлын төвийн эрхлэгч. Эрэгтэй.

асуудал зэрэг нь үйл ажиллагааны хүртээмжид нөлөөлж байгаа байдал ч байна. Сүүлийн үед шинэ барилга барьж байгаа нь сайн тал боловч өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий стандартын дагуу соёлын төв, ордныг барихдаа хамгийн гол анхаарах зүйл бол зориулалт гэдгийг гол болгох нь чухал юм.

Кейс№14

...Манай Соёлын төвийн хувьд шинээр баригдсан. Заал нь спорт заал. Тиймээс тоглолт хийхэд жаахан цуурайтдаг. Хотод ойрхон учраас хүмүүс маань хот руу явж их юм үздэг. Гэхдээ номын санд байнга суудаг, сумынхаа төв, багаас тоглосон тоглолтыг үзэгчид идэвхтэй үздэг байгаа.

Соёлын төвийн эрхлэгч.

Эрэгтэй.

Баянхонгор.

Кейс№15

...Хөдөө орон нутагт боловсон хүчний асуудал хөндөгдөж байдаг. Сум орон нутгаасаа боловсон хүчин бэлтгэхэд төлбөрийн асуудал, нийгмийн баталгаа чухал байдаг. Үүн дээр асуудал байдаг. Боловсон хүчин муу байхад бидний бүтээгдэхүүний чанарт мэдээж нөлөөлнө. Гэвч бид өөрсдийн боломжийг 100 хувь дайчлан ажилладаг. Мөн соёл, урлагийн байгууллагын засварын ажлыг сургууль цэцэрлэг эмнэлэгийн дараад тавьдаг. Сумаас зохион байгуулж байгаа соёл олон нийтийн ажил сумын соёлын төвд явагддаг. Тэндээс бүх хүн, хүүхэд өв уламжлалаа авч үлддэг тул соёлыг төвийг сайн, чадамжтай, гоё өнгөтэй

Дээр өгүүлснээс үзэхэд соёлын төв, ордны стандарт бүхий зориулалтын байр маш чухал болохыг харуулж байна.

Музей, галерей, номын сан, кино театрын үйлчилгээ хангалтгүй байгаа нь нэгдүгээрт эдгээр нь хөдөө орон нутагт соёлын төв, ордны үйл ажиллагааны хүрээнд байдаг боловч номын санд мэргэжлийн номын санч дутмаг, музей буюу орон нутаг судлах танхимд нь

өөрийн гэсэн өрөө танхим байхгүй, үзмэр нь цөөхөн, баяжилт муу, зарим газар орон нутаг судлах танхимаа одоог хүртэл тохижуулаагүй зэрэгтэй салшгүй холбоотой. Хоёрдугаарт, эдгээр салбарт төр засгаас анхаарч бодлогын түвшинд авч үзэхгүй байгаа юм. Жишээлбэл, номын санчийг бол ном өгдөг хүн гэж ойлгохоос биш, ард түмнийг соён гэгээрүүлэх нөлөө бүхий мэргэжилтэн гэж ойлгох төр засаг, орон нутгийн

Кейс№16

Манайд бол номын сан, утга зохиолын дугуйлан хийдэг. Энэ жил баг руугаа хандсан ажил хийж байгаа. Гэр бүл хүүхдүүдийг хамруулдаг. Номын сангийн төлөөлөлтэй болсон. Богц аялуулаад багуудаар явуулдаг. Сард тэр баг тэг ажиллаа гэсэн тайлангаа гаргадаг ажил хийсэн. Ийм ажил өнгөрсөн жилээс хэвшиж байна. Мөн шатрын дугуйланг насанд хүрэгчдийн дунд явуулж байна. Манай соёлын төв нь шатрын дугуйлантай. Сургууль амарлаа гэхэд манайх бол нээлттэй байдгаараа бусад сумдуудаас ялгаатай байх. Шагай харвах, бөгцөлдөх зэрэг дугуйланг бусад дугуйлангуудтайгаа зэрэгцээд ажиллуулж байна. Номын сангийн ийм дугуйлангийн ажлыг манайх хийж байна.

Соёлын төвийн эрхлэгч. Эрэгтэй. Өвөрхангай.

удирдлага бараг байхгүй болжээ.

Хүний хөгжлийн гол тулгуур болсон соёл, чөлөөт цагийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэхийн тулд аймаг, орон нутаг дахь соёлын төвийн байр, байрны стандарт, ажиллах хүчин, тэдгээрийн мэргэжил, цалин хөлс, орон байрны асуудалд гол

анхаарлаа хандуулах шаардлага нэн тэргүүний тулгамдсан асуудал болоод байна. Мөн сүүлийн үед дэлхий нийтийн чиг хандлага, даяаршилтай холбоотойгоор хүмүүс гэрийн нөхцөлд соёл, чөлөөт цагаа өнгөрөөж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Үүнд техник, технологийн хөгжил нөлөөлж байна. Үзвэр үйлчилгээнд сар, жил, улирал, долоо хоногт зарцуулж байгаа мөнгөн дүнг харахад иргэдийн эдийн засгийн чадамжтай салшгүй холбоотой. Мөн хөдөө орон нутгаас иргэд хот руу олноор шилжин суурьшиж байгаа нь соёл, чөлөөт цагийн үйл ажиллагааны үр дүнд нөлөөлж байна. Хөдөө орон нутагт амьдарч, ажиллах хүн амын тоо цөөрч байгаа нь соёлын төв, соёлын ордноор үйлчлүүлэгчдийн тоо, орлогод нөлөөлж улмаар соёлын үйлчилгээний хүртээмж, чанарыг бууруулах магадлалтай юм.

Орон нутаг судлах танхимын үйлчилгээний хүртээмж:

Орон нутаг судлах танхимын (ОНСТ) үйлчилгээний хүртээмжийн өнөөгийн байдал ямар түвшинд байгаад шинжилгээ хийж үзлээ.

2007 оны 8 сарын 24-ний өдөр Австрийн Вена хотод хуралдсан Олон улсын музейн зөвлөлийн (ОУМЗ) 25 дахь удаагийн Ерөнхий чуулганаар музей нь “Гэгээрүүлэх, сургах, амрааж цэнгүүлэх зорилгоор хүн ба түүний орчны биет ба биет бус өвийг цуглуулж, хадгалж, судлан шинжилж, харилцан холбож, дэглэн үзүүлдэг ашгийн бус, байнгын үйл ажиллагаатай, нийгмийн хөгжилд үйлчлэх байгууллага юм”²⁸ гэж тодорхойлсон байдаг. Уламжлалт тодорхойлолттой харьцуулахад үзэгчдийг “амрааж цэнгүүлэх”, мөн “нийгмийн хөгжилд нөлөө” үзүүлэх байгууллага гэдгийг тодруулснаараа ялгаатай байгаа нь музей нь соёлын үйлчилгээнд ихээхэн анхаарал хандуулж байгааг хуруулж байна. Иймээс ОУМЗ-ийн тодорхойлолтоос авч үзэхэд ОНСТ-ч мөн энэ үүргийг өөртөө хүлээж баримтжуулалт, боловсрол-хүмүүжил, чөлөөт цаг-үйлчилгээний үүрэг бүхий музейн нийгэм соёлын үндсэн гурван чиг үүргийг тогтолцоогоор авч үзэн хэрэгжүүлэх шаардлагатай байгааг хэлэх нь зүйтэй.

²⁸ <https://icom.museum/en/activities/standards-guidelines/museum-definition/>

Монгол Улс 330 сумтайгаас Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2012-2013 оны улсын тооллогоор нийт 257 сумын ОНСТ-н сан хөмрөг тооллогод хамрагдсан байдаг ба 2018-2019 онд 265 сумын ОНСТ-н сан хөмрөг тоологдож урьдах тооллогоос хойш даруй 8 суманд ОНСТ нэмэгдсэн байгаагаас үзэхэд сумдын ард иргэдийн хүсэл

Кейс №17


Орон нутгийг судлах музейн 80% мэргэжлийн бус, эрхлэгч нарын 47% нь мэргэжлийн бус гэж өнгөрсөн жилийн бидний судалгаагаар гарсан. Ажлын байранд сургах, бодлогын түвшинд авч үзэх хэрэгтэй. Ийш тийш явуулж юм үзэж нүд тайлуулах, гадаадад бас явуулж туриллага солилцуулах асуудлыг эрчимтэй хийх хэрэгтэй. Жалга, жалгандаа байж болохгүй.

Соёлын төвийн эрхлэгч. Эрэгтэй. Баянхонгор.”

сонирхол, хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Монгол Улсын сумын тоо, сумдын ОНСТ-н тооны харьцуулалт

Бүдүүвч №76



Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл (2018), Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын тооллого(2018-2019).

“Соёлын үйлчилгээний хүртээмж” социологийн судалгааны хүрээнд “Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс, музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага–MNS 5634:2006” музейн стандартын долдугаар зүйл “Музейд тавигдах нийтлэг шаардлага” заалтын хэрэгжилтэд шинжилгээ хийх шаардлагатай гэж үзээд стандартын 7.1.Музейн байгууллагад тавигдах шаардлага заалтын 7.1.9-д Сумдад орон нутаг судлах танхим ажиллана гэсэн үндэслэлийг баримтлав.

Юуны түрүүн музейд тавигдах нийтлэг шаардлагыг хангаж байгаа эсэхэд анхаарал хандуулахад доорхи байдал харагдлаа (Хүснэгт 5., Зураг 33).


Соёлын төв, соёлын ордны орон нутаг судлах танхимын дотоод тохижилт

Хүснэгт №79

	Тохижилтын зүйлс	Маш сайн	Сайн	Дунд зэрэг	Муу	Маш муу
		5	4	3	2	1
1.	Үзмэр дэглэлт	16	102	141	47	20
2.	Гэрэл	46	128	173	79	28
3.	Дулаан	55	133	172	59	35
4.	Агааржуулалт	12	48	87	75	41
5.	Компьютер, тоног төхөөрөмж	31	132	132	76	69
6.	Хадгалалт, хамгаалалт	49	100	167	85	37

Дээрх судалгаанаас үзмэр дэглэлт дунд зэрэг 141, гэрэл 172, дулаан 172, агааржуулалт 87, компьютер тоног төхөөрөмж 132, хадгалалт хамгаалалт 167 хэрэглэгч хариулсан байгаа нь бусад үзүүлэлтээс хамгийн өндөр байна. Үүнийг зургаар харуулая.

Соёлын төв, ордны орон нутаг судлах танхимын дотоод тохижилт



Бүдүүвч №77

Судалгаанаас харахад “дунд зэрэг” гэсэн үнэлгээний үзүүлэлт 6 асуулгад бүгд ижил байгаа явдал нь сумдын Соёлын төвд байрлах ОНСТ-ын дотоод тохижилтыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна. Харин тусдаа байртай ОНСТ-ын хувьд социологийн судалгаанд оруулаагүй тул дүгнэлт хийх боломжгүй байна.

Соёлын үйлчилгээ үзүүлэх таатай орчин бүрдүүлэхэд соёлын байгууллагын орчны эрүүл ахуйн асуудал чухлаар тавигдана. Агаарын бохирдол, хүн амын нягтаршил зэргээс үүдэлтэй орчны эрүүл ахуй хүний эрүүл мэндэд хортой нөлөөлөх болсон талаар эрдэмтдийн судалгаанд өгүүлсэн байдаг.

Та Соёлын байгууллагын орчны эрүүл ахуйн нөхцлийг үнэлнэ үү?

Хүснэгт №80


	Танхим	Сайн	Дунд	Муу	Хариулж мэдэхгүй
		4	3	2	1
1.	Үзвэрийн танхим	225	199	82	32
2.	Номын сан	232	222	67	14
3.	Орон нутаг судлах танхим	155	141	152	34
4.	Сургалтын танхим	172	184	135	35

ОНСТ-ын орчны эрүүл ахуйн нөхцөл байдлыг үнэлэхэд 152 хэрэглэгч “муу” гэсэн үзүүлэлтээр дүгнэсэн байгаа нь үзвэрийн танхим, номын сан, сургалтын танхимтай харьцуулахад хангалтгүй байгаа нь харагдлаа.

ОНСТ нь тухайн орон нутгийн ард иргэдийн соёл, байгалийн өвийг олж илрүүлэх, сан хөмрөгийг олон нийтийн харилцаанд оруулахаас гадна ОНСТ-р дамжуулан ард иргэдийн эдийн засгийн амьжиргааг дээшлүүлэх хөшүүрэг болох боломжтой.

Та соёлын үйлчилгээ гэдгийг хэрхэн ойлгодог вэ?


Бүдүүвч №78



Судалгаанд нийт 541 хэрэглэгч хамрагдсанаас 41.5%-нь соёлын үйлчилгээг соён гэгээрүүлэх үйлчилгээ гэсэн байхад зөвхөн 2%-нь эдийн засгийн үйл ажиллагаа гэж үзжээ. Тэгвэл соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээнд ОНСТ-ын үйлчилгээг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж байгааг дурдах нь зүйтэй. Иймээс цаашид ОНСТ-ыг эдийн засгийн үйл ажиллагаанд татан оролцуулах, соёлын өвд суурилсан бүтээлч үйлдвэрлэл бий болгох боломжийг судлах шаардлагатай байна.

Үйлдвэрлэлийн IV хувьсгалтай золгож байгаа XXI зуунд дижитал технологи хурдацтай хөгжин түүний тусламжтайгаар амралт чөлөөт цагаа өнгөрөөх, соёлын үйлчилгээг хүртэх арга, хэлбэр өөрчлөгдөн орон зайн хязгаар үгүй мэдээллийг хүлээн авч байгаа технологийн эринд улс, аймгийн музей, сумдын ОНСТ үйлчлүүлэгчтэй байх нь нэн тэргүүний асуудал болоод байна.

Та амралт, чөлөөт цагаа ихэвчлэн хаана өнгөрүүлдэг вэ?



Хэрэглэгчдийн амралт, чөлөөт цагаа өнгөөрөөж байгаа байдлыг эрэмбэлвэл хамгийн их буюу 23.1%-нь гэртээ, 16%-нь соёлын төвд, 15.7%-нь спорт зааланд гэсэн бол хамгийн бага буюу 2.8%-нь номын санд, зөвхөн 1.4%-нь музей галерейд чөлөөт цагаа өнгөрүүлж байна. Үүнээс үзэхэд ОНСТ-н үйлчилгээний хүртээмж “хангалтгүй” гэж дүгнэж болох ч нөгөөтэйгүүр үйлчилгээ явуулах таатай орчин бүрдүүлэх стандарт

Кейс №18

...Үлгэрчилсэн дүрэм учир дутагдалтай. Музейн ажилтанг хоёр салгаад, бүртгэл мэдээлэл тусдаа, музейн ажилтан үзмэрээ хариуцмаар байна. Бүртгэл нь өвөө хариуцах, үл хөдлөх бүртгэлээ хиймээр. Соёлын байгууллагуудын нярав, нягтлан ажлын байрыг нэмээд орон тоо тодорхой байх хэрэгтэй. Соёлын байгууллага чинь үйлчилгээний ажилтантай байх нь зөв. Үйлчилгээний стандартуудыг сайжруулах. Хэрэглэгдэхүүн техник технологийн нэр өөрчилж, жагсаалтыг шинэчилмээр байна. Хөгжмийн программ шинээр олгож өгмөөр байна. Дуу хөгжмийн багш маш олон ажил зэрэг хийдэг. Ажлын байрны тодорхойлолт шинэчлэх хэрэгтэй. Цөөн ажилтан маш их давхар ажил хийдэг.

Соёлын төвийн эрхлэгч. Эрэгтэй. Өвөрхангай.

үгүйлэгдэж байгааг харуулж байна.

Цаашид ОНСТ-ын үйлчилгээний чанарын үнэлгээг тодорхойлох тусгайлсан социологийн судалгаа хийж хэт ирээдүйд хэрэгжүүлэх бодлогын төлөвлөлтийн менежментийг тодорхойлох нь зүйтэй гэж үзлээ. Үүнтэй холбоотой одоо мөрдөгдөж байгаа “Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс, музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага–MNS 5634:2006” (Музейн стандарт)-нь шаардлага хангаж байгаа эсэхийг тодруулах Монгол Улсын хот, аймгийн чанартай музейн стандартын хэрэгжилтэд социологийн судалгааг явуулах шаардлагатай байгааг харууллаа.

Соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд нэн тэргүүнд шийдвэрлэвэл зохих ямар асуудал байна вэ? /хариултын тоогоор/

Бүдүүвч №80



Судалгааны дүнгээс үзэхэд Соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд нэн тэргүүнд шийдвэрлэвэл зохих асуудлын тоонд төсөв, соёлын ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, соёлын салбарын бодлогын хэрэгжилтийг сайжруулах асуудлыг онцолжээ.

Хэрэглэгчид соёл, чөлөөт цагийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун бус байгаа нь хэд хэдэн асуулгаас тодорхой байна. Энэ нь соёлын төв, соёлын ордууд оногдсон үүргээ хангалттай сайн гүйцэтгэхэд учирч буй бэрхшээлүүдийг шийдвэрлэж чадахгүй байна. Нөгөө талаар энэ салбарын ажилтнуудын ажлыг үнэлэх, урамшуулах тогтолцоо байхгүйтэй холбоотой юм.

Номын сангийн үйлчилгээний хүртээмж:

Амьдралын хэрэгцээ шаардлага, орчин нөхцөл, ажлын байр зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан хотжилт улам бүр эрчимтэй явагдаж байна. Хот суурин газрын амьдралын боломжууд, ажлын байрны хүрэлцээ хангамж, интернэт, тав тухтай байдал нь илүү тааламжтай тул иргэд сумаас аймаг, аймгаас нийслэл рүү олноороо шилжиж байгаа нь нөгөө талдаа сум, орон нутаг эзгүйрч үлдэх нөхцөл юм.

Үндэсний статистикийн хорооны мэдээнд дурдсанаар 2018 оны байдлаар нийт хүн амын 68% хот суурин газарт, 32% нь хөдөө амьдарч байна гэсэн тоо бий²⁹. Энэ 32% нь 1,040,509 хүн бөгөөд эдгээрийг 300 суманд хуваавал нэг суманд дунджаар 3,500 хүн оршин сууж байна гэсэн үг.

Өнгөрсөн 20-р зууны турш боловсрол нь хүний эрх гэж хүлээн зөвшөөрөгдсөн байдаг бөгөөд хувь хүний боловсрол, сургалт нь хүн өөрөө хөгжих, баталгаатай амьдралд хүргэх зам гэж үздэг. Түүнчлэн боловсролын ерөнхий түвшин өндөр байх нь хөдөлмөр эрхлэлт болон эдийн засгийн өсөлтийн урьдач нөхцөл болдог³⁰.

Сумын иргэдийн хувьд хүн амын нягтаршил, тооноос шалтгаалаад мэдлэг боловсролоо дээшлүүлэх, мэргэжил, ур чадвараа дээшлүүлэхийн тулд аймаг, нийслэл явж ямар нэг сургалтад хамрагдаж байна.

Орон нутагтаа мэргэжил, боловсролоо дээшлүүлэх нэг боломж нь насан туршийн боловсрол бөгөөд үүнийг дэмжих хамгийн тохиромжтой газар нь нийтийн номын сан гэж олон улсад үздэг.

Насан туршийн боловсрол гэдэгт бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухаан, амьдрах

²⁹ <http://1212.mn>

³⁰ https://www.ifla.org/node/1025?fbclid=IwAR1k_j1KQNN3s...

ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагааг³¹ хэлдэг. Үүнд бичиг үсэгт тайлагдахаас гадна өөр бусад мэргэжлийн боловсрол эзэмших, мэдлэг чадвараа дээшлүүлхийг ч хамруулан ойлгож болно.

Иймээс тэрхүү олон чиглэлээр суралцах, мэдлэгээ дээшлүүлэхийг хүссэн сумын иргэдэд соёлын төвийн номын сангийн зүгээс өөрийн сан хөмрөг болон байр талбайг ашиглуулах, интернэт, компьютер, зарим шаардлагатай хэрэгслээр хангах замаар дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлага өндөр байна.

Насан туршдаа суралцах нийгэмд албан болон албан бус гэдгээс үл хамааран нийтийн номын сан нь дэлхий нийтийн мэдлэг, мэдээллийг орон нутгийн иргэдэд холбох гол зангилаа болдог. Иймд нийтийн номын сан нь ирээдүйд насан туршийн боловсролын тогтолцоог хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил нь мэдээллийн өргөн сүлжээг бий болгох үндэс суурийг тавьсан бөгөөд орон нутгийн жижиг номын сан хүртэл уншигч хэрэглэгчдэд дэлхий дахины мэдээллийн эх сурвалжтай холбох боломжийг олгодог.

Нийтийн номын сангууд нь мэдээлэл хайх болон мэдээллийн эх сурвалжид үнэлгээ өгөх сургалт, зөвлөгөөг санал болгодог. Тиймээс нийтийн номын сан зайлшгүй шаардлагатай гэж үздэг.

Бүхий л нийтийн номын сангийн нэгэн адил сумын соёлын төвийн номын сан нь сумын иргэдийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Сумын иргэдийн хөгжил нь номын санд хадгалагдаж байгаа мэдээллийн эх сурвалжууд, түүний дотор үнэ төлбөргүй ашиглах интернэт, суралцах, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх орон зай, өрхийн үйлдвэрлэл, жижиг бизнес эрхлэхтэй холбоотой лавлагааны асуулт зэрэг нь иргэдэд тодорхой мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй ашиг тусыг өгдөг. Нийтийн номын сангаас хүртэх ашгийг тодорхой мөнгөн дүнгээр шууд илэрхийлэх боломжгүй ч түүнд зарцуулсан нэг төгрөг тутмаас 5 төгрөгний ашиг нийгэмд эргэж ордог гэсэн судалгаа бий.³²

Сүүлийн жилүүдэд нийтийн номын сангаар ирэгсдийн тоо буурч байгаа нь соёлын төвийн номын сангийн зүгээс иргэдийн насан туршийн боловсролд дэмжлэг үзүүлэн ажиллах нөхцлийг бүрдүүлж өгч байна.

Нийтийн номын сангуудын сүүлийн 5 жилийн тайланд хийсэн судалгаагаар зохион байгуулж буй ажлын нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдсэн боловч номын санд ирэгсдийн тоо буурсан үзүүлэлт байна.

³¹ <https://www.legalinfo.mn/law/details/9020?lawid=9020>

³² <http://www.ala.org/tools/research/librariesmatter/category/return-investment-roi?page=1>

Тайлангийн мэдээнд дүн шинжилгээ хийхдээ баруун, зүүн, төв, хангайн бүсээс тус бүр нэг аймгийг санамсаргүй түүврийн аргаар сонгосон. Үүнд дараах аймгууд сонгогдсон болно. Үүнд: Баруун бүс - Говь-Алтай, Зүүн бүс - Хэнтий, Төвийн бүс - Говьсүмбэр, Хангайн бүс - Орхон

Үйлчилгээний нэр төрөл:

Тухайн жил хэдэн төрлийн үйлчилгээ үзүүлэв гэдгийг номын сангуудын тайланд дурдсан ажлуудын нэрийг тоолох замаар бүрдүүлсэн болно. Хүснэгтэд байгаа мэдээллийг харахад бүх аймаг үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх бодлого барьжээ гэж харагдахаар байна.

Хүснэгт №81

	2012	2013	2014	2015	2016
Говь-Алтай	14	18	17	20	16
Хэнтий	19	12	17	16	21
Говьсүмбэр	14	14	19	20	20
Орхон	16	18	19	16	19
	63	62	72	72	76

Бүдүүвч №.81



Ном олголт.


Дээрх хугацаанд аймгийн нийтийн номын сангуудын үйлчилгээний төрөл нэмэгдсэн ч ном олголтын тоо буурсан үзүүлэлтэй байна.

Хүснэгт №.82

	2012	2013	2014	2015	2016
--	------	------	------	------	------

Говь-Алтай	40000	25002	21424	28013	42500
Хэнтий	36480	32171	37141	37691	31928
Говьсүмбэр	16119	16119	11240	20100	15789
Орхон	133592	143223	136232	136778	121116
Нийт олголт	226191	216515	206037	222582	211333

Бүдүүвч №82




Уншигчдын ирц.

Үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн ч ирцийн тоо буурсан үзүүлэлттэй гарчээ.

Хүснэгт №83

	2012	2013	2014	2015	2016
Говь-Алтай	20000	16201	12838	14012	14036
Хэнтий	15883	13664	16015	14369	20402
Говьсүмбэр	15053	15053	7954	13700	23154
Орхон	63225	69132	61296	66766	35674
Нийт ирц	114161	114050	98103	108847	93266

Бүдүүвч №.83



Иймд тухайн сумын иргэдийнхээ сонирхол, хэрэгцээг судалсны үндсэн дээр тэдний хэрэгцээнд тулгуурласан ажил зохион байгуулах нь илүү үр дүнтэй байх цаг үед бид амьдарч байна.

Иргэдийнхээ насан туршдаа сурч, боловсрох, мэдлэг чадвараа дээшлүүлэх үндсэн хэрэгцээг сумын нийтийн номын сан соргогоор мэдэрч ажиллах нь өнөө цагт илүү үр дүнтэй байж болох нэг гарц гэж үзэж болно.

Номын сангийн олон улсын холбооны зүгээс насан туршийн боловсролд нийтийн номын сангууд дэмжлэг үзүүлэхдээ дараах зүйлсийг анхаарах хэрэгтэйг зөвлөсөн байдаг. Үүнд:

1. Иргэд одоогийн ажил дээрх мэдлэг боловсролоо дээшлүүлэхээс гадна цаашдын боловсрол эзэмшихдээ гийтийн номын санг ашиглах
2. Нийтийн номын сан болон орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг дэмжих.
3. Иргэдийн мэдээлэл авах, үг хэлэх эрх чөлөөг дээшлүүлэхэд нийтийн номын сангийн үүргийг нэмэгдүүлэх
4. Насанд хүрэгчид болон тусгай хэрэгцээт бүлгүүдэд тохируулсан сургалтын арга болон стратегийг хөгжүүлэх. Жнь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, хүйсийн тэгш байдал гэх мэт.
5. Номын санчдыг мэдээлэл харилцаа холбооны технологи, сурган хүмүүжүүлэх арга, мэдээлэл хайх ур чадварт илүү мэргэшүүлэх
6. Орон нутгийн иргэдийн соёлын өвийг хадгалах, олон нийтэд таниулах, түгээн дэлгэрүүлэх ажил. Жнь: аман зохиол, нутгийн аялага гэх мэт.
7. Нийтийн номын сан, эрдэм шинжилгээний номын сан, сургуулийн номын сан болон тусгай номын сангуудын хооронд цахим сүлжээ бий болгох
8. Боловсролын болон бусад байгууллагуудтай нийтийн номын сангийн харилцах харилцаа холбоог нэмэгдүүлэх
9. Номын санд мэдээлэл харилцаа холбооны технологийг ашиглах замаар насан туршийн боловсролыг дэмжих.

10. Сан хөмрөгийн зохистой харьцаа. Жишээ нь. Сонин, ном, цахим материал гэх мэт.

11. Номын санг уншлагын танхим, ажлын байр мэтээр давхар ашиглах боломжийг бүрдүүлэх. Жишээ нь: Номын сангийн дотоод тохижилт нь сурч боловсроход илүү тохиромжтойгоор тоноглогдож, зохион байгуулагдсан байх.³³

Насан туршийн боловсролд нийтийн номын сангийн оролцооны талаар ИФЛА-гаас гаргасан зөвлөмж болон өнөөгийн нөхцөл, боломжид тулгуурлан соёлын төвийн номын сангийн зүгээс нэн түрүүн хэрэгжүүлэх шаардлагатай ажил үйлчилгээний саналыг энд танилцуулж байна.

Сумын иргэдийн насан туршийн боловсролд СТНС оролцох боломжууд:

- Сумын соёлын өвийг хадгалж хамгаалах
 - Ургийн бичиг хөтлөх сургалт³⁴
 - Ардын аман зохиолын сан үүсгэх, нутгийн домог, түүхээр мэдээллийн сан үүсгэх
- Төрийн бодлого, түүний хэрэгжилтийн баримт бичгээр хангах
 - Хууль, засгийн газрын бодлого
 - Аймаг, сумын ЗДТГ мөрийн хөтөлбөр, хэрэгжилт
 - Мэргэжлийн байгууллагуудын шийдвэр, зөвлөмж
- Интернэтээр дамжуулан сурах бичиг, гарын авлагаар хангах. econtent.mn
- Номын санд хичээл, сургалтаа давтах танхим, интернэтээр хангах
- Зарим хичээл зохион байгуулах - Хайлт хийх, мэдээлэл олох гэх мэт.
- Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран түр сургалтуудыг зохион байгуулах
- Номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа ном, хэвлэлийн бүтээгдэхүүнийг ашиглуулах

Насан туршийн боловсролд нийтийн номын сангийн оролцоог нэмэгдүүлсэнээр ирээдүйд олон иргэд орон нутагтаа сурч, өөрийн боловсрол, мэдлэг чадвараа дээшлүүлсэнээр тэдний амьдралын чанар тодорхой шатаар ахих болно.

Африкийн Малави улсад нэгэн өсвөр насны хүү сургууль завсардсаны дараагаар орон нутгийнхаа нийтийн номын санд байсан ном, гарын авлагуудыг судалсны үндсэн

³³ https://www.ifla.org/node/1025?fbclid=IwAR1k_j1KQNN3....

³⁴ Зарим ажил нь хэрэгжиж байгаа

дээр тосгоноо цахилгаантай болгосон түүх³⁵ 2019 онд интернэтэд шуугиан тарьсан бөгөөд насан туршийн боловсролд соёлын төвийн номын сангийн гүйцэтгэх үүрэг асар их гэдгийг батлах нотолгоо юм.

Соёлын төв, соёлын ордны үйлчилгээний талаарх сэтгэл ханамж:

Энэ хэсэгт соёлын төв, ордны үйлчилгээний талаарх сэтгэл ханамж, үнэлгээний судалгаагаар тухайн байгууллагын шинэчлэл, өөрчлөлт хийж болох, нэр томъёоны зохистой хэрэглээний тухай санал болгож байна. Өнөө үед соёлын үйлчилгээний үнэлгээ хувьсан өөрчлөгдөж буйг СУСХ-ээс явуулсан судалгаа мөн хавсралт хүснэгтээр жишээлэн харуулж байна.


Төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны удирдлагаас төв, орон нутгийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны чанар, үр нөлөөг үнэлж, зохих арга хэмжээ авч ирсэн нь ойлгомжтой юм. Харин улс орны нийгмийн амьдралын бүхий л салбар ардчилал, зах зээлийн харилцаанд эргэлт буцалтгүй шилжин орж, нэгэнт хуучин арга механизмаар ажиллах боломжгүй болсон билээ. Иймээс шат шатны байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх, тэдгээрт хяналт шинжилгээ хийх ажилд зарим шинэчлэл хийх нь зохистой болж байна.

Үзэгчийн үнэлгээ нь соёлын байгууллагын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хөрөнгө төсөв, санхүүжүүлэгчийн эрэлт хэрэгцээг ханган ажиллах бат тулгуур, ажлыг сайжруулах ач холбогдолтой. Зарим тохиолдолд соёлын байгууллагын уламжлалт сэтгэлгээтэй удирдлагад үзэгчийн үнэлгээ, судалгааны үр дүн шүүмж, зөрчилтэй, хүлээн зөвшөөрөмгүй санагдаж болох ч судалгаанд үндэслэн хэрэгжүүлсэн арга хэмжээ, байгууллагын хөгжил дэвшил, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зэрэг үр өгөөж ихтэйг ойлгох хэрэгтэй.

Та соёлын үйлчилгээ гэдгийг хэрхэн ойлгодог вэ?

Бүдүүвч №.84


³⁵ https://urbanintellectuals.com/malawian-teen-taught-build-windmill-junk-brought-power-village-learned-library-books/?fbclid=IwAR0tDRZNNK3DnTYVvzsR2wptvjElfvi5OLhL_ZISwggK67drvVPabriX10



Соёлын төв, соёлын ордны үйлчилгээг үзэгч, хэрэглэгчид нь соён гэгээрүүлэх 40%, авьяасаа хөгжүүлэх 15%, урлагийн тоглолт 12.9%, чөлөөт цагийн үйл ажиллагаа 12.1%, үзвэр 9.1%, бүтээн туурвих 6.2%, эдийн засгийн үйл ажиллагаа гэж 2%-иар тус бүр ойлгодог байна. Үүнээс үзэхэд соёлын төв, ордон нь нутгийн хүн ардыг соён гэгээрүүлэх, өөрсдийн оролцоотой, авьяас, ур чадвараа хөгжүүлэх чухал объект мөн хэвээр боловч эдийн засгийн боломж нөөц болохыг үйлчлүүлэгчид хараахан таниагүй байна.

Соёлын төвийн ажилтны мэргэжлийн ур чадварыг та хэрхэн дүгнэж байна вэ?

Бүдүүвч №85



Судалгаанд оролцогчид соёлын төв, ордны номын санчийг 34%, бүжгийн багшийг 31.3%, соёлын төвийн эрхлэгчийг 30.2%, хөгжмийн багшийг 29.3%, соёлын өвийн ажилтныг 17.6%, бусад үйлчлэгч, техникч зэргийг 9.6%-иар тус бүр сайн ур чадвартай гэжээ. Харин номын санчийг 54.4%, бүжгийн багшийг 51.3%, соёлын төвийн эрхлэгчийг 61.3%, хөгжмийн багшийг 68.4%, соёлын өвийн ажилтныг 53.7%, бусад үйлчлэгч, техникч зэргийг 32%-иар тус бүр мэргэжлийн ур чадвар дунд, тааруу гэсэн үнэлгээний дүнгээс харахад өнөөгийн хэрэглэгчийн соён гэгээрэл, авъяас билгээ хөгжүүлэх зэрэг хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна. Хэлж мэдэхгүй гэж 8.7-12.8% хүртэл хариулсан.

Тэгвэл соёлын төвийн ажилтан эл байдлыг дараах ярилцлагад тодорхой өгүүлжээ.


Кейс №19

Соёлын төвийн үйл ажиллагааг иргэдэд хүргэхэд үнэхээр боловсон хүчний хангалт маш муу байгаа. Өвөрхангайн хэмжээнд бүжгийн багш, эрхлэгч, хөгжмийн багш, номын санч, үйлчлэгч гэсэн таван орон тоотой ажилладаг. Орон нутгийн судлах танхимын ажилтан байхгүй. Үүнээс үүдээд соёлын өвийн ажилтны үүргийг соёлын төвийн эрхлэгч давхар хариуцаж явдаг. Соёлын төвийн эрхлэгч орон нутгийн бүхий л соёлын бодлогыг хэрэгжүүлдэг. Үүний хувьд үнэхээр цаг зав нь гардаггүй, ажлын чанар хүртээмжид нөлөөлдөг..., боловсролын салбартай харьцуулахад цалин бага...

Соёлын төвийн эрхлэгч. Эмэгтэй.

Оршин суугаа газрын Соёлын төв, ордноос сүүлийн 3 жилд явуулж буй дараах үйлчилгээний чанарт үнэлгээ өгнө үү?


Бүдүүвч №86



Судалгаанд оролцогчид өөрсдийн оршин суугаа газрын соёлын төв, ордны сүүлийн гурван жилд тэмдэглэлт баяр, наадмын ажиллагаанд 50%, урлаг спортын наадам 63.4%, номын сангийн уншлага 56.6%, нүүдлийн соёлын үйлчилгээ 39%, дугуйлан 46%, түүх соёлын дурсгалт зүйл (ТСДЗ)-ийг хамгаалах сурталчилгаа 40%-иар маш сайн, сайн чанартай гэжээ. Тэмдэглэлт баяр, наадмын ажиллагаанд 30.7%, урлаг спортын наадам 30.4%, номын сангийн уншлага 35.1%, нүүдлийн соёлын үйлчилгээ 36.3%, дугуйлан 46%, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах сурталчилгаа 51.7%-иар тус бүр дунд, муу, маш муу чанартай гэжээ.

Оршин суугаа газрын Соёлын төв, ордноос сүүлийн 3 жилд явуулж буй дараах үйлчилгээний чанарт үнэлгээ өгнө үү?


Бүдүүвч №.87



Хүүхэд өсвөр үеийнхний дунд зохиох ажил 52.4%, бүжиг цэнгүүн 58.6%, үзэсгэлэн худалдаа 41.5%, чөлөөт цагийн ажил 35.6%, захиалгат үйл ажиллагаа 36.2%, аялан тоглолт 48.8%, сайн дурын нэгдэл, клубын ажил 30.7%-иар маш сайн, сайн чанартай гэжээ. Мөн хүүхэд өсвөр үеийнхний дунд зохиох ажил 40.3%, бүжиг цэнгүүн 34.4%, үзэсгэлэн худалдаа 47.5%, чөлөөт цагийн ажил 48%, захиалгат үйл ажиллагаа 48%, аялан тоглолт 37.6%, сайн дурын нэгдэл, клубын ажил 59%-иар дунд, муу, маш муу чанартай гэж үнэлсэн.

Оршин суугаа газрын Соёлын төв, ордноос сүүлийн 3 жилд явуулж буй дараах үйлчилгээний чанарт үнэлгээ өгнө үү?

Бүдүүвч №88




Судалгаанд оролцогчид төрийн бодлого, шийдвэрийн мэдээлэл 39%, урлагийн боловсрол олгох ажил 41.1%, албан бус сургалт 38,5%, нийгмийн түншлэлийн хүрээн дэх ажил 40.5%, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ажил 27.2%, ахмад настанд зориулсан ажил 19.4%-иар маш сайн, сайн чанартай гэжээ.

Мөн төрийн бодлого, шийдвэрийн мэдээлэл 48.7%, урлагийн боловсрол олгох ажил 49.1%, албан бус сургалт 47.1%, нийгмийн түншлэлийн хүрээн дэх ажил 49%, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ажил 62,5%, ахмад настанд зориулсан ажил 44.1%-иар тус бүр дунд, муу, маш муу чанартай гэж үнэлсэн.

Оршин суугаа газрын соёлын төв, ордноос сүүлийн 3 жилд явуулж буй дараах үйлчилгээний чанарт үнэлгээ өгнө үү?

Бүдүүвч №.89




Соёлын төв, ордны ажилд дээрхийг нэмэлт үйлчилгээ болгож, чанарыг үнэлүүлсэн юм. Үүнд хонжворт сугалаа 14.7%, аялал зугаалга 13.3%, караоке 18,2%, кофе шоп 13%, фитнес клуб 14.1%-иар маш сайн, сайн чанартай гэжээ. Мөн хонжворт сугалаа 52%, аялал зугаалга 51.4%, караоке 48.1%, кофе шоп 49.7%, фитнес клуб 51.8%-иар дунд, муу, маш муу гэж үнэлсэн. Оролцогчдын 33.4-37.8% хариулаагүй. Судалгааны

дүнгээс харахад соёлын төв, ордонд эдгээр төрлийн үйл ажиллагаа цөөн зохион байгуулдаг, ажлын төрөл, үйчилгээ болж хэвшээгүй байна.

Соёлын төв, ордонд Сонгодог урлаг-III 31.4%, Монгол уран бүтээл үндэсний хөтөлбөр 29.3%, Соёлын үйлдвэрлэл үндэсний хөтөлбөр 36.8%, Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр 2-р үе 35.6% тус бүр маш сайн, сайн чанартай хэрэгждэг. Сонгодог урлаг-III 55.4%, Монгол уран бүтээл үндэсний хөтөлбөр 47.7%, Соёлын үйлдвэрлэл үндэсний хөтөлбөр 46.1%, Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр 2-р үе 47.2%-иар тус бүр дунд, муу, маш муу чанартай хэрэгжиж байгаа гэжээ. Судалгаанд оролцогчдын 4.4-15.4% хэлж мэдэхгүй, 5.2-23.1% хариулаагүй. Үүнээс үзэхэд соёлын төв, ордонд нэг талаас төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилт, танин мэдүүлэх ажил дунд тааруу, хангалтгүй, нөгөө талаас төрөөс авч хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээний агуулгыг ард иргэдийн урлаг, байгаль ахуй, газар зүй, амьдралын хэв маягтай уялдуулах шаардлага харагдаж байна.

Төрөөс хэрэгжүүлж буй дараах хөтөлбөр соёлын төвд хэрхэн хэрэгждэг талаар үнэлнэ үү?

Бүдүүвч №90



Кейс №20

Соёлын байгууллагын үйл ажиллагаа явж байна. Чанар хүртээмж сайнгүй, янз бүрийн шалтгаантай. 1. Манай орчин, нөхцөл хангалтгүй. Барилга байшин муу. Эрхлэгчийн, хувцасны, заал гэсэн өрөөнүүдтэй. Суугаад ажиллах боломж хэцүү. 2. Санхүүжилт маш бага.

Соёлын төвийн эрхлэгч.
Эмэгтэй. Чингис хаан хот

Соёлын төв, соёлын ордны үйл ажиллагааны үнэлгээнд тухайн улсын баримталж буй стандарт, дүрэм журам, эрхзүй мөн ард иргэдийн оролцоо шалгуур үзүүлэлт болдог байна. Үнэлгээний аргачлалыг үнэлгээг хийх газар тодорхойлох, ингэхдээ захиалгат, гэрээт, дотоод, гадаад, хэсэгчилсэн, нэгдсэн, шат дараалсан гээд арга хэлбэр, агуулга өргөн, цаг хугацаа, төсөв мөнгө, хүн хүч шаардах хэдий ч эцсийн үр дүн тутамд

Кейс №21

Соёлын төвийн төрийн албан хэргийн стандарт, архив, мэдээ зэрэгт чиглэл чиглэлээр авдаг аргачлал гэж бий. Соёлын ажилтны нарийн стандарт алга байна уу даа гэж би боддог. 4, 5 хэсэг байх юм уу. Хөдөөд хүргэж үйлчилж байгаа үйлчилгээ, хөдөлмөр хамгаалал, биет ба биет бус өвийг хэрхэн хэрэгжүүлж байна. Орон нутгийг судлах танхим, музейг үзүүлэлтэнд оруулж өгөх. Дорноговь аймгийн хувьд жилдээ 2 удаа СТ-ийн үйл ажиллагааг дүгнэдэг томоохон арга хэмжээ бий. Үндсэн үйл ажиллагааг 16 үзүүлэлтээр гаргасан байна лээ. Сумын мэргэжилтнээ дүгнээд явж байхдаа үүнийг би зөв гэж бодож байна.

Соёлын төвийн эрхлэгч. Эрэгтэй. Дорноговь

сайжруулалт хийх нь зохистой.

Соёлын төв, ордны үйлчлүүлэгч, хэрэглэгчид соёлын төв, ордныг соён гэгээрүүлэх, авьяасаа хөгжүүлэх, урлагийн тоглолтын үйлчилгээ үзүүлдэг гэж ойлгодог, бүтээн туурвих эдийн засгийн боломжит газар гэж харахан үзэхгүй байна.

Судалгаанд оролцогчид соёлын төв, ордны ажилтнуудыг орон нутгийн баяр, наадам, урлаг спортын наадам, номын сан, нүүдлийн соёлын үйлчилгээ, дугуйлангийн үйл ажиллагааг тогтмол сайн, харин түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах сурталчилгаа, төрийн бодлого, шийдвэрийн мэдээлэл, урлагийн боловсрол олгох, нийгмийн түншлэл, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настай иргэдэд зориулсан ажлыг тааруу муу зохион байгуулдаг гэжээ. Мөн номын санчийг сайн, хөгжим, бүжгийн багш, эрхлэгч, соёлын өвийн ажилтныг дунд тааруу мэргэжлийн ур чадвартай гэж үнэлж байна.

Ш. 4. Үйлчилгээний орчин

Соёлын хөгжлийг хангах, соёл, урлагийн үйлчилгээг иргэдэд ойртуулан, тэгш хүртээмжтэй хүргэх, урлагийн бүх төрөл, түүний дотор үндэсний уламжлалт урлаг, ёс заншил, түүх, соёлын дурсгалт зүйл, утга соёлын өвийг дээдлэн, үр удам хойч үедээ өвлүүлэх, соёлыг өргөн утгаар ойлгож, түүнийг нийгэм, эдийн засгийн бусад салбартай нягт холбоход соёлын байгууллага тэр дундаа сум, орон нутгийн соёлын төвийн үүрэг маш их юм.


“Соёл нь дотоод, гадаад ертөнц болон бусад соёлын хүрээлэн байгаа орчинтой харьцсаны үр дүнд байнга өөрчлөгдөж байдаг тогтолцоо”³⁶ бөгөөд даяаршлын соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зарим орон нутгийн соёлын бүтээгдэхүүн, үйл ажиллагааны хэлбэрт хөнөөл учруулж байгааг ЮНЕСКО тэмдэглэсэн байдаг. Тухайлбал: “Телевизийн болон техник технологийн гарвалтай дүрст бүтээгдэхүүн нь уламжлалт урлаг, уран сайхны тоглолтын орон зайг шахаж байна. Эндээс “соёлын төрөл зүйл бүхэн их эмзэг”³⁷ гэдгийг харж болох бөгөөд манай улсад төдийгүй бусад үндэстэн бүхэнд үндэснийхээ уламжлал, үнэт зүйл, ёс суртахуун, зан үйл, өвөрмөц онцлогоо хадгалан үлдэх, нийгмийн шинэчлэлтэй зохицон хөгжүүлэхтэй холбоотой асуудалд анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлага үүсээд байгаа юм.

³⁶ЮНЕСКО-гийн дэлхий дахины тайлан илтгэл. Соёлын төрөл зүйл соёл хоорондын харилцааг тэтгэхүй 2005. 4-р тал

³⁷ ЮНЕСКО-гийн дэлхий дахины тайлан илтгэл. Соёлын төрөл зүйл соёл хоорондын харилцааг тэтгэхүй 2005. 13-р тал

Та орон нутгийнхаа Соёлын төв,соёлын ордны гадаад орчны тохижилтын талаар үнэлгээ өгнө үү?

Бүдүүвч №91




Судалгаанд оролцогчид орон нутгийнхаа соёлын төв, ордны барилгын өнгө үзэмж 55.6% (313), барилгын загвар хийц 46.3% (261), мэдээллийн самбар 55.1% (310), хаягжилт 48.6% (274), авто зогсоол 39.6% (222), хашаа 35.1% (198), цэцэрлэгжүүлэлт 35.3% (199), бие засах газар 12.6%-иар тус бүр маш сайн, сайн чанар, үзэмжтэй гэжээ. Соёлын төв, ордны барилгын өнгө үзэмж 38.3% (216), барилгын загвар хийц 47.6% (268), мэдээллийн самбар 38.8% (219), хаягжилт 42.8% (241), авто зогсоол 52.6% (295), хашаа 51.3% (306), цэцэрлэгжүүлэлт 35.3% (199), бие засах газар 12.6% (236)-иар тус бүр дунд, муу, маш муу чанартай, үзэмжгүй гэжээ.

Судалгаанаас үзэхэд соёлын төв, ордны барилгажилт бүрэн, загвар хийцэд сэтгэл нийцтэй боловч, авто зогсоол, мэдээллийн самбар, хашаа цэцэрлэгжүүлэлт нь төдийлэн сайнгүй, ариун цэвэр сахих асуудал тун хангалтгүй байна.

Та орон нутгийнхаа Соёлын төв, соёлын ордны дотоод орчны тохижилтын талаар үнэлгээ өгнө үү?

Бүдүүвч №92




Судалгаанд оролцогчид орон нутгийнхаа Соёлын төв, ордны тайз 57%, сандал ширээ 53.1%, гэрэлтүүлэг 54.8%, дулаан 48.5%, дуу дүрсийн тоног төхөөрөмж 52.6%, акустик 35%, агааржуулалт 31.8%, камержуулалт 26%, өлгүүр 16%-иар тус бүр маш сайн, сайн чанартай гэжээ.

Судалгаанд оролцогчид соёлын төв, ордны тайз, сандал ширээ, гэрэлтүүлэг, дулаанд эерэг сэтгэгдэлтэй, агааржуулалт, камержуулалтад хангалтгүй муу үнэлж, сэтгэл дундуур байна. Мөн судалгаанд оролцогчид соёлын төв, ордны өлгүүрт 51.3%-иар үнэлгээ өгөөгүй явдал бол хувцас өлгөх цэг, үйлчилгээ байхгүй байж болох талтайг анхаарах нь зүйтэй.

Соёлын төв,ордны гадаад, дотоод орчны тохижилт


Бүдүүвч №93



Судалгаанд оролцогчдоос соёлын байгууллагын гадаад болон дотоод орчны тохижилт, өрөөний хүрэлцээ, тав тухтай байдалд өгсөн үнэлгээний 48% маш сайн, сайн, 52% дунд болон муу, маш муу үнэлгээ өгсөн байна.

Соёлын төв, ордны сургалт, дугуйлан явуулах өрөө тасалгааны хүртээмжийн байдалд үнэлгээ өгнө үү

Бүдүүвч №.94




“Соёлын үйлчилгээний хүртээмж” төслийн хүрээнд хийсэн социологийн судалгааны “Соёлын төв, ордны тохижилтын талаар санал хүсэлтээ илэрхийлж байсан уу” гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 25.1% нь нэг удаа, 11.4% нь 2 удаа, 8.4% нь 3-аас дээш удаа санал хүсэлтээ илэрхийлсэн, харин 50.5% нь огт үгүй, 8.2% нь мэдэхгүй гэж хариулснаас үзэхэд нийт оролцогчдын 41.3% нь ямар нэгэн байдлаар санал хүсэлтээ илэрхийлж байсан нь харагдаж байна.

Кейс №22

Аймгийн номын сан гайгүй. Хөдөө орон нутгийн номын сан бүр хаягдсан. Байр орчны хувьд стандарт гэдэг юмыг ярихын ч хэрэг байхгүй. Жижигхэн өрөөнд бүх номоо давхарлаад өрчихсөн. Хүн нь номын сан дотроо суучихсан байх жишээтэй. Уншигч суух ширээ сандалгүй газар ч байна. Нар салхины хамгаалалт байхгүй.

Соёлын төв, ордны тохижилтын талаар санал хүсэлтээ илэрхийлсэн байдал

Бүдүүвч №95




Судалгаанд оролцогчид соёлын төв, ордны дэргэдэх номын сангийн дотоод тохижилтыг маш сайн 14.8%, сайн 40.2%, дунд зэрэг 27.8%, муу гэж 17.2% нь үзсэн

байна. Үүнээс нийт судалгаанд оролцогчдын 56.9% нь каталогийн шүүгээ, 64.4% нь номын тавиур, 56.6% нь ширээ, сандал ерөнхийдөө сайн хэмээн үнэлсэн бол 15.7% нь гэрэлтүүлэг, 15.2% нь дулаан хангамж, 14.2% нь шинэ ном мэдээлэх буланг ерөнхийдөө муу гэж үнэлсэн байна. Харин судалгаанд оролцогчдын 14.7% нь компьютер, тоног төхөөрөмж, 14.7% нь агааржуулалт маш муу гэж үнэлжээ.

Соёлын төв, ордны дэргэдэх номын сангийн дотоод тохижилтыг үнэлсэн байдал


Бүдүүвч №96



Судалгаанаас үзэхэд соёлын төв, ордны дотоод тохижилт дунд зэрэг гэсэн үзүүлэлттэй гарч байгаа бөгөөд байгууллагын орчинд үйлчлүүлэгчдийн зүгээс сэтгэл хангалуун бус байна гэсэн дүгнэлтийг өгч байна. Мөн үзмэр дэглэлт, агааржуулалт, дулаан хангамж, компьютер, тоног төхөөрөмжийг сайжруулах, шинэчлэх шаардлагатай юм.

Соёлын төв, ордны дэргэдэх орон нутаг судлах танхимын дотоод тохижилтыг үнэлсэн байдал

Бүдүүвч №97




Судалгаанд оролцогчдоос соёлын төв, ордны дэргэдэх орон нутаг судлах танхимын дотоод тохижилтын талаар асуухад 8.3% нь маш сайн, 26.7% нь сайн, 36.7% нь дунд зэрэг, 18.3% нь муу, 10% нь маш муу гэж үнэлсэн байна. Үүнээс судалгаанд оролцогчдын 43.2% нь үзмэр дэглэлт, 38.1% нь хадгалалт хамгаалалт, 38.1% нь гэрэлтүүлэг дунд зэрэг, 28.5% нь агааржуулалт муу, 15.7% нь компьютер, тоног төхөөрөмж маш муу гэж үзжээ.

Ярилцлагын судалгаанд шинэ соёлын төвүүд баригдаж байгаа боловч техник, тоног төхөөрөмж байхгүй, хуучин, ширээ сандал гологдож буй асуудлыг хөндөж байгаагаас үзэхэд соёлын төвийн орчны стандарт, тохижилт, тоног төхөөрөмжийн асуудлыг ч цогцоор нь авч үзэх шаардлагатай харагдаж байна.

Соёлын төв, ордны бүжгийн заалны дотоод тохижилт

Бүдүүвч №98



Судалгаанд оролцогчдоос соёлын төвийн дэргэдэх бүжгийн дугуйлангийн танхимын дотоод тохижилтонд маш сайн, сайн үнэлгээг 40%, дунд, муу, маш муу

Кейс №23

Одоо бусад газар, бүх л багш нарт нөүтбүүк байгаа байх. Манайханд бол тэр чинь зүүдэнд ч байхгүй. Газар тариалан эрхэлдэг хүнд хүрз хэрэгтэй байдаг шиг бидэнд бол тоног төхөөрөмж маш хэрэгтэй байна. Би бүр яаманд хандаж хэлмээр байна. Монголд байгаа бүх Соёлын төвүүддээ нэг нэг компьютер, тоног төхөөрөмж, хөгжим техникээр нь хангаж өгөөчээ. Бид нар чинь бараг гуйлга гуйж байж, Их хурлын гишүүдийг бараг долоох шахаж байж жаахан юм авч байгаа. Одоо манай Ховдод нэг ч компьютергүй газар байна. Өөр газар очиж юмаа хийлгэдэг. Сургуульд өгч болоод байгаа юм чинь Соёлын төвүүдэд яагаад 2 нөүтбүүк албан ёсоор өгчихөж болдоггүй юм бэ? Ихэнхдээ хувийнхаа юмыг хэрэглэж байна. Сургууль, цэцэрлэгт май май гээд багш бүрт өгчихдөг. Ний нуугүй хэлэхэд соёл бол айлаар бодох юм бол хойд эцэгтэй дагавар хүүхэд шиг л явж байна шүү дээ.


Сумын соёлын төвийн эрхлэгч. Эмэгтэй. Увс

үнэлгээг 60% өгсөн байна.

Орон нутгийн соёлын төв, ордны үзвэрийн танхимд 40%, номын санд 41.2%, сургалтын танхимд 30.6%, ОНС танхимд 27.5%-иар тус бүр эрүүл ахуйн нөхцөл сайн хангадаг үнэлгээ өгчээ. Соёлын төв, ордны үзвэрийн танхимд 50%, номын санд 51.5%, сургалтын танхимд 56.7%, ОНС танхимд 52%-иар тус бүр эрүүл ахуйн нөхцөл дунд, муу хангасан гэсэн. Соёлын байгууллагын эрүүл ахуйн нөхцлийн тухай асуултад оролцогчдын 38% маш сайн, сайн 62% хангалтгүй үнэлгээ өгсөн байна.

Та Соёлын байгууллагын орчны эрүүл ахуйн нөхцлийг үнэлнэ үү?

Бүдүүвч №99



Судалгааны үзүүлэлтийг нэгтгэн дүгнэхэд соёлын төв, ордны гадаад болон дотоод орчны тохижилт, эрүүл ахуйн орчинд өгсөн нийт үнэлгээний маш сайн, сайн

үнэлгээ 44.4% гарч байхад дунд, муу, маш муу үнэлгээ 55.6%-ийг эзэлж байгаа нь соёлын байгууллагын орчинд үйлчлүүлэгчдийн зүгээс сэтгэл хангалуун бус байна гэсэн дүгнэлтийг өгч байна.

Бүхэлдээ судалгаанд оролцогчид соёлын төв, ордны үзвэрийн танхим, номын санд эрүүл ахуй нөхцөл дунд, орон нутаг судлах танхим, сургалтын танхимд эрүүл ахуйн нөхцөл муу үнэлгээ өгч, сэтгэл дундуур байна.

Даяаршил, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хурдацтай хөгжлийн өнөө цагт сэтгэл татам орчин нөхцөл, нийгмийн амьдралын хэв жишиг болж хүн бүр л тохь тухтай, сэтгэл ханамжтай багц үйлчилгээ авахыг хүсч хэрэгцээ шаардлага нь улам бүр өссөөр байгаа юм.

Соёлын байгууллагын орчны тохижилт тав тухын талаар маш сайн, сайн үнэлгээ 44.4% гарч байхад дунд, муу, маш муу үнэлгээ 55.6%-ийг эзэлж байгаа нь соёлын байгууллагын орчинд үйлчлүүлэгчдийн зүгээс сэтгэл хангалуун бус байна гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дэлхий дахины соёл, урлагийн мэдээлэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр секундын төдийд тархаж, түүнийг хүлээн авч буй мэдээлэлтэй, өндөр боловсролтой үзэгч, хэрэглэгчдэд үйлчлэх зорилго бүхий өнөөгийн соёлын байгууллагын орчин, нөхцөл, үйл ажиллагаа, үйлчилгээний чанар орчин үеийн шаардлагыг хангахуйц байх ёстой нь судалгаанаас харагдаж байгаа юм.

ДӨРӨВ. СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЙЛЧИЛГЭЭГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ.

БСШУСЯ-ны захиалгаар хэрэгжүүлсэн “Соёлын үйлчилгээний хүртээмжийн судалгаа” –ны хүрээнд соёл, урлагийн салбарын үйл ажиллагааны үнэлгээний асуудлыг эрх зүйн орчин, хэрэгжилтийн судалгаа, гадаад орны ижил төстэй байгууллагуудын туршлагын түвшинд тухайлан авч үзлээ.

Судалгаанаас үзэхэд соёл, урлагийн салбарын хяналт- шинжилгээ үнэлгээний хоорондын уялдаа сул, хэрэгжилтийг хянахад хүндрэлтэй, санхүүгийн эх үүсвэр нь тусгагдаагүй зэрэг асуудлууд байсаар байна.

Төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны удирдлагаас төв, орон нутгийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны чанар, үр нөлөөг үнэлж, зохих арга хэмжээ авч ирсэн нь ойлгомжтой юм. Харин улс орны нийгмийн амьдралын бүхий л салбар ардчилал, зах зээлийн харилцаанд эргэлт буцалтгүй шилжин орж, нэгэнт хуучин арга механизмаар ажиллах боломжгүй болсон билээ. Иймээс шат шатны байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх, тэдгээрт хяналт шинжилгээ хийх ажилд зарим шинэчлэл хийх нь зохистой болж байна.

Бид “Соёлын үйлчилгээний хүртээмж” төслийн хүрээнд мэдээлэл цуглуулж, шинжилгээ хийх, томилолтоор гадаад, дотоодын улс орнуудын туршлагаас суралцан ажиллаж, дотооддоо уулзалт ярилцлага, сургалт семинар зохион байгуулах ажлуудад оролцож ирлээ.

Ямарваа үнэлгээний хувилбар, агуулга, маягтыг тухайн чиглэлд баримталдаг стандарт, дүрэм, эрх зүйг эх хэрэглэгдэхүүн, шалгуур үзүүлэлт болгон зохиодог байна³⁸. Үнэлгээний судалгаа нь янз бүрийн арга хэлбэр, утга агуулгаар цуглуулсан мэдээллээр сан үүсгэж, сангаа эмхэтгэн цэгцэлж, бичвэрт буулган өгөгдөл болгож, өгөгдлийг синтизлэх, тайлан тайлбарласнаар тухайн сэдвийн давуу тал, учир дутагдал, ач холбогдол бүхий дүгнэлтэд хүрдэг байна. Дүгнэлтийн дараагаар тус сэдэв чиглэл эсхүл байгууллагад хандсан цогц шат дараалал, санал бүхий сайжруулах санал зөвлөмж гардаг.

Соёлын үйлчилгээний байгууллага, мэргэжилтний ярилцлага, анкет, ажиглалт судалгааны үр дүнгээс өмнө төслийн багийн гишүүдийн дунд тулгамдаж байсан нэр томъёоны асуудлыг дурдах нь зүйтэй байна. Төслийн хүрээний нэг ойлголт бол “Үнэлгээ” юм. Энэхүү ойлголтыг нэг адил язгуур бүхий үгээр илэрхийлэх зарим ойлголттой зэрэгцүүлэн харьцангуй түгээмэл хэрэглэдэг орос, англи, герман хэлэнд буулгаж үзвэл дараах дүр зураг үзэгдэж байна:

1. Үнэлгээ-оценивание - *evaluation -Bewertung*
2. Үнэлэлт-оценка - *assessment -Auswertung*
3. Үнэлэмж-ценность-value-Wert

Өрнөдийн улс орнуудын байдлыг ажиглахуул үндсэндээ эдийн засаг болон нийгмийн бусад салбарын харилцааг оптимизацижуулах, хэрэглэгчдийн эрэлт болон сэдэл, маркетинг, технологийн ашиглалт, стратегийн төлөвлөлт, төрийн болон хувийн хэвшлийн бүтцийн талаас, тэрчлэн хүн амын зүгээс тавих хяналт болон үнэлгээ гэх мэт параметруудээс шууд хамаарах өрсөлдөх чадвар, үр ашигтай байдал зэргийг соёлын салбар дахь үйлчилгээнд хэрэгжүүлэх салшгүй бүрэлдэхүүн хэсэг болгож байна.

Жишээ нь, Сьюзан Бош “*Нийгмийн хөгжлийн үүднээс урлаг, соёлын салбар дахь төслийг үнэлэх үнэлгээ нь маш чухал, нарийн төвөгтэй ажил юм. Санхүүжүүлэгчид үндсэндээ нийгэмд илүү өргөн хүрээтэй, урт хугацаанд тогтвортой үр нөлөөлөл үзүүлэх байдлыг тусгаж чадсан тоогоор илэрхийлэх "хэмжигдэхүйц үр дүн"-гийн тухай санаагаа нотлохыг шаарддаг. Үүнээс гадна төслийн үр дүн, үр нөлөө, тогтвортой байдлыг нотлох нь соёлын бодлогыг дэмжих, цаашид санхүүжилт олгоход зайлшгүй шаардана*”³⁹ гэж тэмдэглэсэн байна.

³⁸ Gregory J.Cize, Amy A Germuth, Audra E Kosh, Lorrie A Schmid, 2016

³⁹ Susanne Bosh, 2004.

татсан: 2019.09 <https://www.boell.de/en/educulture/education-culture-evaluation-criteria-How-to-measure-art-and-culture-projects-14370.html>

Иймд соёл, урлагийн салбарын бодлого, төлөвлөлтийг боловсруулахдаа Үр дүнд суурилсан удирдлагын хүрээнд төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг улам боловсронгуй болгох шаардлагатай байна.

Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ бол гол шалгуур үзүүлэлтүүдийн тухай мэдээлэл цуглуулах, шинжлэх, мөн бодит үр дүнг хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж, тухайн төсөл, хөтөлбөр, бодлого хэр сайн хэрэгжиж байгааг хэмжих үргэлжилсэн үйл явц юм. Энэ бол шалгуур үзүүлэлтүүдийг ашиглах замаар тусгай, урьдчилан тодорхойлсон зорилгод хүрэх явцын баримтыг судлан ашиглаж, богино, дунд ба урт хугацааны тодорхой үр дүнд чиглэсэн ахиц, өөрчлөлтийг хэмжих үргэлжилсэн үйл явц юм мөн. Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ ажилтнууд ба шийдвэр гаргагчдыг ахиц өөрчлөлтийн талаар санал, мэдээллээр хангах бөгөөд тэд гаргах шийдвэрээ сайжруулахын тулд уг мэдээллийг янз бүрийн аргаар ашиглаж болдог.

Үр дүнд суурилсан үнэлгээ бол төлөвлөсөн, одоо үргэлжилж байгаа, эсвэл дууссан, үйл ажиллагааны уялдаа холбоо, үр ашиг, үр дүн, үр нөлөө, ба тогтвортой байдлын үнэлгээ юм. Үүний зорилго нь найдвартай, мэдээллээр хангах, авсан сургамжийг хүлээн авагч орны шийдвэр гаргах үйл явцад тусгах явдал юм. Үнэлгээ нь үйл ажиллагааг өргөн хүрээтэй авч үзэж, зорилго ба тодорхой үр дүнд хүрэхэд гарсан дэвшил уг үйл ажиллагаанаас болсон уу, эсвэл хяналт-шинжилгээний тогтолцооны өөрчлөлт нь өөр тайлбартай юу гэдгийг тодорхойлно. Үнэлгээний асуултад дараах асуултуудыг оруулж болно:

- Зорилтот түвшин ба бий болсон үр дагавар хоорондоо хамааралтай юу?
- Тэдгээрийг хэр үр дүнтэй, үр ашигтай биелүүлсэн бэ?
- Тухайн үйл ажиллагаанаас болж урьдчилан хараагүй ямар үр нөлөө гарсан бэ?
- Тухайн үйл ажиллагаанд тусгай эрэлт хэрэгцээг хангах хамгийн зардал хэмнэлттэй, тогтвортой стратегийг баримталсан уу?⁴⁰

Үнэлгээний тухайд

Үнэлгээний тухай олонхи тодорхойлолтод үнэлэх зүйлийнхээ үнэ цэнэ, эсвэл үнэлэмжийг судлан тодорхойлох ойлголтыг агуулсан байдаг. Үнэлгээ нь ямар нэг урьдаас төлөвлөсөн, одоо үргэлжилж байгаа эсвэл хийж дууссан үйл ажиллагаа,

⁴⁰ Үр дүнд хүрэх зам. Дэлхийн банк. УБ., 2011

бодлого, хөтөлбөрийн үнэ цэнэ, ач холбогдлыг аль болохоор системтэй бодитой тодорхойлох үйл явц юм.

Үнэлгээг хэрэгжилтийн явцын үнэлгээ (formative evaluation) , нэгтгэн дүгнэх үнэлгээ (summative evaluation) , урьдчилсан үнэлгээ (prospective evaluation) гэж ангилна.

Хэрэгжилтийн явцын үнэлгээ нь тухайн хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлэх арга замыг авч үздэг. Энэ нь төлөвлөсөн ажил бодит ажлын гүйцэтгэлтэй нийцэж байгаа эсэхийг шалгаж, хэрэгжилтийн үр дагаврыг тооцдог. Үнэлгээний энэ хэлбэрийг хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийдэг учраас заримдаа үйл явцын үнэлгээ гэж нэрлэдэг.

Нэгтгэн дүгнэх үнэлгээг гол төлөв үр дагавар, үр нөлөөний үнэлгээ гэж нэрлэдэг бөгөөд тухайн үйл ажиллагааны төгсгөлд хийж, хүлээсэн үр дүн ямаар хэмжээнд хэрэгжсэнийг тодорхойлно. Энэхүү үнэлгээ нь үр нөлөөний үнэлгээ, зардал – үр ашгийн судалгаа, хагас туршилт, тодорхой нөхцөл байдлын судалгааг багтаана.

Урьдчилсан үнэлгээ нь тухайн хөтөлбөр, бодлогын гарч болзошгүй үр дүнг үнэлдэг. Урьдчилсан үнэлгээ буюу баримтын өмнөх үнэлгээ нь хөтөлбөрийн онол баримтлалыг шинэчлэх, эсвэл үнэлэх, төсөөлөл зураглалыг судлах, тогтоох зэрэг үнэлгээг багтаана. Үнэлгээ нь харилцан адилгүй 4 зорилготой.

Ёс зүйн зорилго: бодлого, хөтөлбөр хэрхэн хэрэгжсэн, ямар үр дүнд хүрсэн талаар удирдах албан тушаалтан болон иргэдэд мэдээлэх ингэснээр хариуцлагын тогтолцоог сайжруулах, мэдээллийг сайжруулах зэрэг зорилтууд хамрана,

Удирдлагын зорилго: хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн санхүүгийн болон хүний нөөцийг илүү зохистой хуваарилах, хөтөлбөрийн удирдлагыг сайжруулах, түүнээс гарах үр ашгийг нэмэгдүүлэх,

Шийдвэр гаргах зорилго: бодлого хөтөлбөрийг үргэлжлүүлэх, дуусгах, эсвэл өөрчлөх шийдвэр гаргах замыг тодорхойлох,

Сонирхолтой болгох зорилго: оролцогсдод үйл ажиллагааг нь ойлгуулах, тавьж буй зорилгыг нь тодорхой болгох талаар сонирхолтой болгох.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ гэж юу вэ? Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь бодлого төлөвлөлтийн мөчлөгийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Төлөвлөлтийн мөчлөгийн эхний гурван бүрэлдэхүүн нь төлөвлөлт, төсөвлөлт, болон хэрэгжилт бөгөөд дөрөв, тав дахь бүрэлдэхүүн хэсэг нь хяналт-шинжилгээ, үнэлгээ юм.

Хяналт-шинжилгээ гэж хөгжлийн зорилгод хүрэхэд гарч байгаа ахиц дэвшил, хуваарилсан хөрөнгийн ашиглалтын явцыг тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хянаж, системтэй мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийж, бодлогын

хэрэгжилтийн талаар удирдлага болон гол оролцогч талуудад тасралтгүй мэдээллэх байнга, тасралтгүй явагдаж байдаг дотоод үйл ажиллагаа юм.

1. Дотоод үнэлгээ: Тухайн байгууллагын доторх хүмүүсийн хийж буй үнэлгээ
2. Хөндлөнгийн үнэлгээ: Тухайн байгууллагын бус гадны байгууллагын хүмүүсийн хийж буй үнэлгээ
3. Хамтын оролцооны үнэлгээ буюу 3 дахь арга нь хамтран оролцогч болон сонирхогч талуудын төлөөлөлтэй хамтран ажиллаж, үнэлгээг төлөвлөж, гүйцэтгэх, тайлбарлах, тодорхойлох үндсэн дээр хийгдэж буй үнэлгээний нэг хэлбэр

Хяналт шинжилгээ, үнэлгээний аль аль нь хэрэгжилтийг хэмжиж, үнэлдэг боловч харилцан адилгүй аргаар, өөр өөр цаг хугацаанд хийгддэг онцлогтой.

Хяналт шинжилгээ ба үнэлгээг харьцуулах нь

Хүснэгт №84

Хяналт шинжилгээ	Үнэлгээ	
<ul style="list-style-type: none"> - Тогтмол хийгдэж үргэлжилж байдаг - Дотоод үйл ажиллагаа - Удирдлагын хариуцах чиг үүрэг - Хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулахын тулд эргэх мэдээллийн холбоо тогтмол хийдэг 	<ul style="list-style-type: none"> - Үе үе хийгддэг, цаг хугацааны хязгаартай - Дотоод, хөндлөнгийн эсвэл хамтын оролцоот үйл ажиллагаа - Үнэлгээний ажилтнууд болон удирдлагын хамт хүлээх хариуцлага - Тодорхой хугацаанд эргэх мэдээллийн холбоо хийдэг 	-

Үнэлгээ гэж хэрэгжиж байгаа болон хэрэгжиж дууссан бодлого, хөтөлбөр, төсөл, түүний дотор тэдгээрийн боловсруулалт, хэрэгжилт, үр дүнг системтэй, бодитой үнэлэх үйл явц юм. Үнэлгээний зорилго нь төсөл, хөтөлбөрт тавьсан зорилгодоо хүрсэн эсэх,

хэрэгжилтийн үр дүн болон үр ашигтай байдал, нөлөө, цаашид бие даан хэрэгжих боломжтой эсэхийг тодорхойлоход оршино.

Товчоор хэлбэл хяналт-шинжилгээ нь хөтөлбөр, төслийн хэрэгжилт нь төлөвлөлтийн дагуу явж байна уу гэдгийг шалгахад тусалдаг бол үнэлгээ нь үйл ажиллагааг хэрэгжүүлснээр үр дүнд хүрсэн эсэхийг тодорхойлох үүрэгтэй “үр дүнг тооцох” шинжилгээ юм.

Шалгуур үзүүлэлт

Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтээр төлөвлөсөн үйл ажиллагаанд цаг хугацааны явцад гарч буй аливаа өөрчлөлт, ахиц дэвшлийг хэмждэг. Хүссэн зорилгодоо хүрэхийн тулд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны (эсвэл өөр шалтгааны улмаас) үр нөлөөг харуулахын тулд янз бүрийн түвшин хэвтээ (газар зүйн байршлаар) болон босоо (үйл ажиллагааны доод түвшнээс яам хүртэлх) тэнхлэгт үзүүлэлтүүдийг ашиглана. Иймд хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог үр дүнтэй, найдвартай байлгах үүднээс зохистой үзүүлэлтүүдийг тодорхойлох нь чухал байдаг. Оролцогч талуудын зөвшилцлийн үр дүнд шалгуур үзүүлэлтийг сонгох хэрэгтэй ба ингэж тодорхойлоогүй тохиолдолд зарим оролцогчийн хувьд биелэгдээгүй шалгуур үзүүлэлтүүдийг нуух шууд бус шалтаг болдог. Шалгуур үзүүлэлт нь хүссэн үр дүнтэй аль болохоор ижил төстэй байх нь зүйтэй бөгөөд зорилтот түвшний тусгал байх хэрэгтэй гэж судлаачид үзсэн байна. Амжилт эсвэл ахисан түвшинг үнэлэх үүднээс шалгуур үзүүлэлт нь зорилтот түвшинг тусгахаас гадна бодлого (үйл ажиллагаа, орц)-ын үр дүнтэй байдлыг мэдээлж, сайжруулах арга замыг санал болгох ач холбогдолтой юм.

Үүнээс гадна үзүүлэлт нь SMART эсвэл CREAM байх хэрэгтэй. Дээр дурьдсанчлан, хүмүүст өгсөн үйлчилгээ, хөрөнгө, нөөцтэй холбоотой үзүүлэлтийг хүйсээр ангилсан байдлаар гаргасан байх ёстой хэмээн үзсэн байдаг.

Smart шинжилгээ

Хүснэгт №85

S	Тодорхой – хүссэн үр дүнд хүрэхийн төлөө	C	Тодорхой
M	Хэмжихүйц – хэмжиж болохуйц үр дүн, үр дагавар	R	Ач холбогдолтой
A	Биелүүлэхүйц – бодитой байх	E	Үр ашигтай
R	Ач холбогдолтой - тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн	A	Зохистой

Т	Цаг хугацаатай – төслийн хугацаанд хэрэгжүүлж болох	М	Хяналт тавихуйц
----------	---	----------	-----------------

ЮНЕСКО-с эрхлэн гаргасан “ Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай 2005 оны конвенцын үндсэн баримт бичгүүд” –д зааснаар үйл ажиллагаа, төсөл хэрэгжүүлэхэд гарах хүндрэл бэрхшээлүүдийг танин тогтоох, тогтвортой хэрэгжих нөхцөлийг ханган ажиллахад хүрэлцэхүйц хэмжээний санхүүгийн болон хүний нөөцөд тулгуурлан эрсдэлд суурилсан төслийг хянан шинжлэх тогтолцоог бүрдүүлнэ. Энэхүү хяналт шинжилгээний тогтолцоо нь урт болон богино хугацааны зорилгууд нь тодорхой байх, хэмжигдэхүйц байх, хүрэх боломжтой байх, бодитой байх, хугацаатай байх гэсэн үзүүлэлтүүдэд суурилан таван жил тутамд хөндлөнгийн хяналт оруулж, үнэлгээ хийнэ гэж заажээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо нь зорилгодоо хүрэхийн тулд тогтмол хугацааны болон жилийн биелэлтийг хэмжихээр шалгуур үзүүлэлт бүрийн хувьд тогтоосон зорилтот түвшин (өсөн нэмэгдэх)-ийг тогтоохыг шаардана. Иймд тогтмол хугацааны болон жилийн бодит гүйцэтгэлийг зорилтот түвшинтэй харьцуулан ахиц, дэвшлийг хэмжинэ. Энэ арга барил нь шалгуур үзүүлэлт бүрийн хувьд жилийн зорилтот түвшинг бодитой тогтоохыг шаардана. Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлж өгснөөр ажлын аль ч түвшинд үйлчилгээг цаг тухайд нь үзүүлэх зэргээр орц, гарцыг тодорхойлоход том асуудал гардаггүй.

Үйл ажиллагааны амжилтыг хэмжихээр сонгож авах шалгуур үзүүлэлтийн тоо нь "Хэдэн шалгуур үзүүлэлт зорилтод хүрэх амжилтыг хангалттай тусгах вэ?" гэсэн асуултад тулгуурласан байна. Ерөнхийдөө тогтсон дүрмээр бол аль түвшинд хамгийн багаар тооцоход 2-3-аас ихгүй шалгуур үзүүлэлттэй хэрэгтэй. Үйл ажиллагааны түвшинд шалгуур үзүүлэлт нь зайлшгүй бус бол нэг байх ёстой.

Үнэлгээг хийх үе шат -1: Төлөвлөлт

Хүснэгт №86

Хяналт-шинжилгээ (Бодит гарцыг төлөвлөсөнтэй харьцуулна)	Үнэлгээ (Үр дагавар, үр нөлөөг хэмжинэ)
- Зорилго, зорилтын биелэлтийг үнэлэх, хяналт-шинжилгээ хийх аргыг тодорхойлох - Хугацааны хүрээг тогтоох,	-Үнэлгээний зорилгыг тодорхойлох (нийгмийн хөгжил, хяналт-шинжилгээ, зохицуулалт, уялдаа холбоо, хариуцлага, ил тод байдлыг хангах,

<ul style="list-style-type: none"> - Мэдээллийг олж авах төлөвлөлт, төсөвлөлт, - Мэдээллийн чиглэлийн ажилтны чиг, үүргийг тодорхойлж, чиг үүргээ биелүүлэхийг шийдвэрлэх, - Хяналт-шинжилгээ хийх ахицын үзүүлэлтийг боловсруулах (гарцад илүү анхаарч, ихэнхдээ тоон үзүүлэлт) 	<p>мэдлэг буй болгох түүнийг хуваалцах, удирдлага, зохион байгуулалтын дэмжлэгийг сайжруулах, оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжих),</p> <ul style="list-style-type: none"> -Шаардлагатай мэдээлэл, эх сурвалжийн сонголтыг тодорхойлох, - Судалгааны хүрээг тодорхойлох, -Түүврийг тогтоох, - Үнэлгээний багийг сонгох, -Судалгааны логик хүрээг тодорхойлох, - Зорилго, зорилтод тулгуурлан биелэлтийн үзүүлэлтийг боловсруулах, - Мэдээлэл цуглуулах давтамж, хугацааг тодорхойлох, -Үнэлгээний төсвийг тооцох (цалин, томилолт, зөвлөхийн зардал, тээвэр, холбоо, хэвлэлт, олшруулах, бусад зардал).
---	--

Үнэлгээг хийх үе шат - 2: Бэлтгэл

Хүснэгт №.87

<p style="text-align: center;">Хяналт-шинжилгээ (Бодит гарцыг төлөвлөсөнтэй харьцуулна)</p>	<p style="text-align: center;">Үнэлгээ (Үр дагавар, үр нөлөөг хэмжинэ)</p>
<ul style="list-style-type: none"> -Мэдээлэл цуглуулах маягт, шалгалт, -Хяналт-шинжилгээ хийх ажилтныг сургах, - Хяналт-шинжилгээний тогтолцооны талаар ажилтанд мэдээлэх, -Үйл ажиллагааны заавар боловсруулах, -Оролцогчдыг оролцуулан техникийн ажлын даалгаврыг бэлтгэх. 	<ul style="list-style-type: none"> -Үнэлгээний төрөл (урьдчилсан, хэрэгжилтийн явцын, төгсгөлийн, төслийн, үр дагаврын, нөлөөллийн, сэдэвчилсэн, үйл ажиллагааны дарааллын, мета үнэлгээ) –ийг сонгох -Мэдээлэл цуглуулах хэрэгслийг зохиох (судалгааны маягт, ярилцлагын удирдамж,

-Үнэлгээний төрөл (урьдчилса	асуулгын хуудас, шалгах хуудас, баримт бичиг, судалгаа, ажиглалт, фокус групп, жишээ судалгаа), -Мэдээлэл цуглуулах хэрэгслийг урьдчилан турших, сайжруулах, -Түүврийг хэрхэн сонгохоо шийдэх, -Бэлтгэл үнэлгээ, үнэлгээний багийн үүргийг тодорхойлох, -Үнэлгээний ажилтныг сургах, -Холбогдох бэлэн баримт бичгийг цуглуулах, бүртгэх
------------------------------	--

Үнэлгээг хийх үе шат -3: Мэдээлэл цуглуулах

Хүснэгт №.88

Хяналт-шинжилгээ (Бодит гарцыг төлөвлөсөнтэй харьцуулна)	Үнэлгээ (Үр дагавар, үр нөлөөг хэмжинэ)
-Тохиролцсон мэдээллийг тогтмол хугацаанд газар дээр очих болон байнгын хяналт-шинжилгээ цуглуулах, -Системийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, -Хяналт-шинжилгээний мэдээллийн бааз байгуулах.	-Газар дээрх үнэлгээ зохион байгуулах, -Оролцогч талын оролцоог хангах, -Байгаа мэдээлэл(төлөвлөгөө, тайланг, санал)-ийг цуглуулах, судлах, -Үнэлгээний объектыг сонгох (өрхийг сонгох), -Ярилцлага авах (ажиглалт), -Мэдээллийн боловсруулалтыг эхлэх.

Үнэлгээг хийх үе шат -4: Шинжилгээ, дахин хянах

Хүснэгт №89

Хяналт-шинжилгээ (Бодит гарцыг төлөвлөсөнтэй харьцуулна)	Үнэлгээ (Үр дагавар, үр нөлөөг хэмжинэ)
-Цуглуулсан мэдээллийг тохиролцсон	-Мэдээллийг хүснэгт хэлбэрт оруулах,

<p>үзүүлэлттэй харьцуулах, зөрүүг тэмдэглэх, -Бусад асуудлыг тодорхойлох, -Аливаа асуудлын шалтгааныг хайх, арга хэмжээний хувилбарыг тодорхойлох.</p>	<p>-Үр дүнг хөрвүүлэх тайлбарлах, дүгнэлт хийх, -Зөвлөмж дээр тохиролцох, -Гол мэдээлэгч нартай шинжилгээг дахин хянах.</p>
--	---

Үнэлгээг хийх үе шат -5: Үр дүнг тайлагнах

Хүснэгт №.90

<p>Хяналт-шинжилгээ (Бодит гарцыг төлөвлөсөнтэй харьцуулна)</p>	<p>Үнэлгээ (Үр дагавар, үр нөлөөг хэмжинэ)</p>
<p>-Мэдээлэл, олдворыг баримтжуулах, -Удирдлага, хэрэгжүүлэгчид танилцуулах, -Нийт оролцогч талуудад улирлын нэгдсэн мэдээ болон хагас жилийн хэрэгжилтийн тайланг мэдээлэх.</p>	<p>-Мэдээллийг хүснэгт, графикт нэгтгэх, -Эцсийн тайлан бичих, -Үнэлгээний чанарын баталгаа гаргах</p>

Үнэлгээг хийх үе шат- 6: Үр дүнг ашиглах

Хүснэгт №91

<p>Хяналт-шинжилгээ (Бодит гарцыг төлөвлөсөнтэй харьцуулна)</p>	<p>Үнэлгээ (Үр дагавар, үр нөлөөг хэмжинэ)</p>
<p>-Удирдлага, хэрэгжилтийн бодлогыг сайжруулахад үр дүнг хэрэглэх.</p>	<p>-Тэргүүлэх чиглэлийн үнэлгээний үр дүнгээр тодорхойлох, -Тэргүүлэх арга хэмжээ өөрчлөлтийг төлөвлөх, -Үнэлгээний үр дүн, авсан сургамж, зөвлөмжийг олон нийтэд нээлттэй болгох веб хуудастай болох, байршуулах,</p>

	-Оролцогч талуудын хурлыг зохион байгуулах, шинжлэх ухааны сэтгүүл, ном, хэвлэл, хурал, зөвлөлгөөний үеэр тараах.
--	---

Монгол Улсад аливаа бодлогыг төлөвлөхдөө тогтвортой хөгжлийн зарчмыг баримтлан **үр дүнд суурилсан удирдлагын загварыг** баримталж байна. Үр дүнд суурилсан удирдлагын загвараар төлөвлөлтийг хэрэгжүүлэх нь тогтвортой хөгжилд хүрэх өргөн боломжийг олгох бөгөөд нийгмийн хөгжлийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулна хэмээн үздэг байна.

Үр дүнд суурилсан удирдлага нь төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн “Бодлогын мөчлөг” гэсэн загварт нийтлэг суурилдаг.⁴¹

Бодлогын мөчлөгийн загвар

Бүдүүвч №100

**Хэрэгжүүлэх, хяналт
шинжилгээ, үнэлгээ хийх**

**Шаардлага, үндэслэл
дэвшүүлэх**

⁴¹ Төлөвлөлт, хяналт- шинжилгээ, үнэлгээний гарын авлага . УБ., 2016



Төлөвлөлт

Төлөвлөлт нь үндэсний, бүс нутгийн, орон нутгийн болон салбарын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчлан зураглах үйл явц юм. Өөрөөр хэлбэл, Засгийн газар бодлогын зорилгоо тодорхойлж, түүнд хүрэх (бодлогод суурилан) стратегиа боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээгээ тогтоох, шаардлагатай нөөцийг төсөвлөх, хуваарилах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл явцыг тус тус нарийвчлан төлөвлөх шаардлагатай. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь тухайн бодлого төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна уу, хүссэн үр дүндээ хүрч байна уу, залруулга, засвар, тодотгол хэрэгтэй байгаа эсэхийг тодорхойлох үүрэг гүйцэтгэдэг.

Үр дүнд суурилсан төлөвлөлтийн нийтлэг сэдэв бол нийгэмд хүргэхээр зорьсон үйлчилгээг үр дүнтэй, үр ашигтай хүргэх явдал юм. Ингэхийн тулд хөтөлбөр, дэд хөтөлбөр бүрийн нөлөөг тооцож, биелэлтэнд суурилан хөрөнгийг хуваарилахыг шаарддаг байна.

Төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хоорондын харилцааны тайлбарыг дараах хүснэгтэд харуулав.

**Төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ,
үнэлгээний хоорондын харилцааны тайлбар**

Хүснэгт № 92

Төлөвлөлт	Төсөвлөлт	Хэрэгжүүлэлт	Хяналт - шинжилгээ	Үнэлгээ
Хүрэх үр дүнгүүдийн уялдааг тодорхойлох	Үр дүнд суурилсан төсөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх	Төлөвлөлтийн үр дүнтэй институцийн тэргүүлэх асуудлыг зэрэгцүүлэх	Төлөвлөлтөөс гарсан шалгуур үзүүлэлтүүд	Үнэлгээний аргачлалыг боловсруулах
Үр дүнгийн түвшин бүрт зорилтот түвшинг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг тодорхойлох	Төлөвлөлтийн үр дүнд суурилан төсөвлөх	Төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэхэд бодлого, хүн хүч, үйл ажиллагааг чиглүүлэх	Байгууллагуудын хүлээх хариуцлагыг тодорхойлох	Байгууллагуудын хүлээх хариуцлагыг тодорхойлох
Тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болох, ач холбогдолтой, цаг хугацаатай зарчмыг баримтална	Төсөв нь төлөвлөлттэй уялдан дунд хугацаанд төлөвлөгдөн байх	Үйлчилгээ үзүүлэх стандартуудыг боловсруулах	Мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргачлалыг тодорхой болгох	Мэдээллийг түгээх аргачлалыг тодорхойлох
	Төсвийн гүйцэтгэлийг хянах тайлагнах аргачлалыг боловсруулах		Дүн шинжилгээ хийх тайлагнах аргачлалыг боловсруулах	Талуудын оролцоог хангах
Төлөвлөлтийн хүрээ нь үнэлгээний	Төсөв нь зорилтот түвшинг	Үр дүнг хянахад бүтээгдэхүүн нь хэмжигдэхүйц	Хяналт – шинжилгээний үйл ажиллагаа нь	Үнэлгээ нь хүрсэн үр дүнг үнэлж, цаашид

мэдээлэл болон тэргүүлэх асуудлыг төлөвлөлтөнд авч үздэг	төлөвлөхтэй зэрэг хийгдэх ба эцсийн бүтээгдэхүүнийг тодорхойлдог	явцын шалгуур үзүүлэлтийг төсөвтэй уялдуулсан байна	бүтээгдэхүүн болон үнэлгээний мэдээллийг сайжруулдаг	дараагийн төлөвлөлтийн үйл ажиллагааг мэдээллээр хангадаг
---	--	---	--	---

Судлаачдын үзэж байгаагаар бодлогын үр дүнтэй байдалд системтэй үнэлгээ хийхийг бодлого боловсруулах үйл явцад суулгаж өгөх шаардлагатай бөгөөд үүний тулд 1. үнэлгээний зорилтыг эхнээсээ нарийвчлан тодорхойлох 2. амжилтын шалгуурыг тодорхойлох гэжээ.

Үнэлгээний өргөн хүрээтэй 7 хэлбэр байдгаас манай орны соёл урлагийн байгууллагуудад хэрэглэж буй үнэлгээний стратеги нь үйл явцын хэрэгжилтийн үнэлгээ юм.

Эрх зүйн орчин

Үнэлгээний стратеги

Бүдүүвч №101



Үнэлгээ – үйлчилгээний чанар

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх ач холбогдол нь үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагаатай шууд холбогдох бөгөөд үйлчилгээг өндөр чанартай хүргэж, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээд түвшинд байлгах нь соёл, урлагийн салбарт тулгарч буй чухал асуудлуудын нэг юм.

Үйлчилгээний чанар

Үйлчилгээний чанар гэдэг нь “үйлчилгээний талаарх хэрэглэгчийн хүлээлт ба бодит байдлын харьцааг илэрхийлсэн ойлголт юм”⁴². Үйлчилгээний чанарыг тодорхойлон үнэлэх асуудал нь 1. чанарын түвшинг хэмжих 2. Үнэлгээнд үндэслэн үйлчилгээг сайжруулсанаар байгууллагыг өндөр амжилтанд хүргэх чухал ач холбогдолтой байдаг.

Үйлчилгээний чанар нь үйл ажиллагааны тогтвортой байдал, өсөлт, хөрөнгө босгох, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, үйлчлүүлэгчээ алдахгүй байх, ашигтай ажиллах зэрэг олон хүчин зүйлд хүчтэй нөлөөлж байгаа учраас сүүлийн 20-иод жилд судлаач, менежерүүдийн анхаарлыг зүй ёсоор татах болсон байна. Үйлчилгээг чанарын үзүүлэлтэнд суурилан удирдан чиглүүлэх үйл ажиллагааг үйлчилгээний чанарын удирдлага гэж томъёолон авч үздэг бөгөөд үйлчилгээний байгууллага зорилгодоо хүрэхийн тулд үйл ажиллагаагаа төлөвлөх, зохицуулах, хянах, байнга сайжруулах үйл явцуудын нэгдлийг хэлнэ.

Үйлчилгээний чанарын удирдлага нь чанарын бодлого, зорилтыг тодорхойлдог байгууллагын дээд удирдлага, тогтолцоо (систем), үйлчилгээний удирдлагын тогтолцоо гэсэн ойлголтуудтай холбоотой⁴³. Үйлчилгээний чанарын удирдлага нь үйлчилгээний чанарын төлөвлөлт, үйлчилгээний чанарын хангалт (зохион байгуулалт), үйлчилгээний чанарын хяналт, үйлчилгээний чанарыг байнга сайжруулах гэсэн задаргаатай байна.

Бүдүүвч №102

⁴² Я. Отгонсүрэн Маркетингийн удирдлага. УБ., 2012

⁴³ Т.Сосорбарам. Чанарын нэгдсэн удирдлага. УБ., 2009)



Үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоо

Үйлчилгээний чанарыг хэмжих асуудлаар судлаачид үйлчилгээний чанарт тулгарч буй асуудлыг илрүүлэх, түүнийг арилгах арга замыг тодорхойлон сайжруулалтыг үнэлэх үйлчилгээний чанарын арга замуудыг санал болгодог бол зарим судлаачид үйлчилгээний чанарт тулгарч болох асуудлуудыг анхааруулах замаар чанарын судалгааг байгууллагууд ашиглахыг зөвлөдөг байна. Эрдэмтэн Zeithaml, Berry болон Parasuraman нар 1985 үйлчилгээний зөрүүний загварыг хэмжих Service Gap Model гэсэн нэртэй загварыг үндэслэн гаргасан байна. Энэ загвар нь байгууллагын үйлчилгээний чанарт асуудал үүсгэж болох 5-н зөрүүг тодорхойлоод загварыг чанарын асуудлын эх сурвалжид анализ хийх, асуудлыг шийдвэрлэх, үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд асуудалд хялбар аргаар анализ хийх боломжийг олгодог. 1988 онд тэд олон төрлийн үйлчилгээг судалсан чанарын өгөгдөл дээр үндэслэн үйлчилгээний чанарын 10 хэмжүүрийг тодорхойлсон ба үүнийгээ цааш нь нарийвчлан судалсаны үндсэн дээр GAP загвар дээр суурилан үндсэн 5 хэмжүүр, 22 нэгж үзүүлэлт бүхий SERVQUAL загварыг гаргасан байна. Үндсэн 5 хэмжүүрүүд нь тухайн салбарын онцлогоос хамаарч шаардлагатай үзүүлэлтүүдийг шинээр нэмж, хасч болдог.

Үндсэн 5 хэмжүүр үзүүлэлтүүд:

- Reliability буюу найдвартай байдал: Санал болгож буй үйлчилгээгээ зохих ёсоор гүйцэтгэх

- Assurance буюу баталгаатай байдал: Ажиллагсдын мэдлэг ур чадвар, өрсөлдөхүйц байдал багтсан

- Responsiveness буюу хариу үйлдэл: Үйлчлүүлэгчиддээ туслах чин эрмэлзлэл

- Empathy буюу бусдыг ойлгох байдал: Хялбар байдал, харилцаа холбоо, хэрэглэгчээ ойлгох

- Tangible буюу хүртэгдэх байдал: Ашиглаж буй техник хэрэгсэл

Энэхүү загвар нь хэрэглэгчийн хэмжүүр үзүүлэлт тус бүрээс ямар түвшний гүйцэтгэл хүлээж байгааг судалж дараа нь гүйцэтгэлийг ямар түвшинд хүлээн авч байгааг судалдаг тул үйлчилгээний чанарын үндсэн агуулгыг бүрэн илэрхийлдэг гэж үздэг байна. Тус загвараар үйлчилгээний чанарыг үнэлснээр байгууллагын үйлчилгээний талаарх өргөн мэдээллийг авах боломж бүрддэг бөгөөд бодитоор хүлээж авсан үйлчилгээний сэтгэгдэл нь таамаглаж буй үйлчилгээний хүслээс илүү байвал тухайн байгууллага үйлчлүүлэгчдийн сэтгэлд нийцсэн үйлчилгээг үзүүлж чадаж байгааг харуулна.

SERVPERF загвар Судлаач Кронин, Тайлор нар шинэ загвар боловсруулсан нь үйлчилгээний ханамжийг зөвхөн гүйцэтгэлд тулгуурлан хэмжих явдал байв. Уг загварыг SERVPERF хэмээн нэрлэдэг бөгөөд хандлага дээр суурилсан чанарыг хэмжих загвар юм. Энэ загвар нь үйлчилгээний чанарын хэмжигдэхүүн болон нарийвчилсан схем, үүнийхээ үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж хэрхэн холбогдож байгаа, худалдан авах сонирхлыг судалсан байдаг бөгөөд үйлчилгээний чанарыг сайн мэдэх үйлчлүүлэгчийн бодлыг тодорхойлж, бодлыг онооны өөрчлөлтөөр тооцон харьцуулсан байдаг.

Үйлчилгээний чанарыг үнэлэх SERVQUAL загварыг дэлхийн оронд хэрэглэж байгаагийн нэг жишээ бол ОХУ-ын Соёлын яам нь 2005 оноос хойш холбооны гүйцэтгэх удирдлагууд болон соёлын салбар дахь төрийн байгууллагуудын чанар, хүртээмжийн байдалд иргэдийн сэтгэл ханамжид мониторинг тогтмол хийсээр ирлээ.

Соёл, урлагийн байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээний чанарыг хэрэглэгчдийн санал хүсэлтээр үнэлэх нь менежментийн оновчтой шийдвэр гаргахад чухал нөлөөтэй бөгөөд нийт хүн амын амьдралын чанарт нөлөөлөх чухал хүчин үзүүлэлтүүдийн нэг юм.

Түүнчлэн үйлчилгээний чанарыг хэрэглэгчдийн санал хүсэлтээр үнэлэх нь соёлын байгууллагуудын ажлыг сайжруулах менежментийн оновчтой шийдвэрийг цаг тухайд нь гаргах үндсэн суурь болох төдийгүй ажилтнуудын ёс суртахууны болон материаллаг урамшууллын арга хэлбэрүүдийг тасралтгүй, зорилтот түвшинд

сайжруулахад түлхэц болж, соён гэгээрүүлэх ажлын чанарыг сайжруулах өрсөлдөөн, сэдэл төрлийг бий болгох боломжийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой хэмээн бид үзэж байна.

Хяналт- шинжилгээ, үнэлгээний эрх зүйн орчин

Бид соёл, урлагийн салбарын хүрээнд гарч байсан хяналт- шинжилгээ үнэлгээний эрх зүй, хэрэгжүүлэлтийн орчныг судлан авч үзлээ.

Засгийн газрын 1999 оны 6 дугаар сарын 11 –ний өдрийн 142 дугаар тогтоолоор Гэгээрлийн яамны бүтцэд өөрчлөлт орон “ Соёл, урлагийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн төслийн баг” татан буугдаж соёл, урлагийн 5 мэргэжилтэн яамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газар, Мэдээлэл, хяналт – шинжилгээ, үнэлгээний газарт ажиллах болсон.

Түүнчлэн яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай Засгийн газрын 2000 оны

8 дугаар сарын 23-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор БСШУЯ нь эдийн засаг, хяналт – шинжилгээ, үнэлгээний газар зэрэг 5 газартай ажиллах болсон байна.

Засгийн газрын 2017 оны 267 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “БСШУСЯ-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”⁴⁴ –ийн 3.3.10.-т хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлон заасан байна.

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт болон яамны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, боловсролын хяналтыг хяналт-шинжилгээ, тандалт, судалгааны хэлбэрээр хэрэгжүүлж салбарын бодлогыг үр дүнтэй болгох, салбарын болон яамны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд үйл ажиллагаанд олон улсын чанарын удирдлагын (ISO9001:2015 стандарт) тогтолцоог нэвтрүүлэх, баримтжуулсан журмуудыг хэрэгжүүлэх, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлнэ гэжээ.

⁴⁴ info@legalinfo.mn

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, салбарын байгууллага, аж ахуйн нэгж байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яамд, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд байна хэмээн заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-н баримт бичгийн 5.4. энэ бодлогын 5.2-т заасан урт, дунд, богино хугацааны стратегийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон иргэний нийгмийн холбогдох байгууллагууд хамтран хяналт, шинжилгээ- үнэлгээ хийж, цаашдын хөгжлийн зорилтыг тодорхойлж байх болно гэжээ.

Соёл, урлагийн салбарт хэрэгжиж байсан болон одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хяналт- шинжилгээ, үнэлгээний эрх зүйг баримт бичгүүдийг 2000 оны байдлаар авч үзвэл;

- Сумдын соёлын төвийн үйл ажиллагаанд түвшин тогтооход баримтлах шалгуур үзүүлэлт /Төрийн нарийн бичгийн дарга Б. Мишигжав/ 2002 он
- Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ хийх, үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтүүд батлах тухай /БСШУ- ны сайдын 429 дүгээр тушаалын хавсралт/ 2003 он
- Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ хийх, үнэлэх журмыг батлах тухай /БСШУ- ны сайдын 154 дүгээр тушаал/ 2008 он

2002 оны “Сумдын соёлын төвийн үйл ажиллагаанд түвшин тогтооход баримтлах шалгуур үзүүлэлт” нь 1. Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын төвийн соёлын үйл ажиллагаанд тогтоох шалгуур үзүүлэлт /10 шалгуур үзүүлэлттэй/ 2. Сумдын соёлын төвийн үйл ажиллагаанд түвшин тогтооход баримтлах шалгуур үзүүлэлт /13шалгуур үзүүлэлттэй/ байжээ.

2008 оны БСШУ- ны сайдын 154 дүгээр тушаалаар батлагдсан “Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ хийх, үнэлэх журам”-ын хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлал нь тоон болон чанарын гэсэн хоёр хэлбэрээр тайлагнан хэрэгжиж байна. Уг журам нь нийтлэг үндэслэл, номын сангийн үйл ажиллагааг үнэлэх тоон шалгуур үзүүлэлтүүд, дүгнэх аргачлал, театр (Чуулга)-ын үйл ажиллагааг үнэлэх шалгуур тоон үзүүлэлтүүд, дүгнэх аргачлал, үнэлгээ өгөх, урамшуулал гэсэн хэсгүүдээс бүрдсэн байна.

Энэ журмын Номын сангийн үйл ажиллагааг үнэлэх тоон шалгуур үзүүлэлтүүд, дүгнэх аргачлалд

Дүгнэх аргачлал

Хүснэгт №.93

д/д	Үзүүлэлтүүд	Дүгнэх аргачлал	
1	Мэргэжилтэй ажилтны хангалтын индекс	$A_1 = \frac{a_1}{a_2}$	a_1 – мэргэжлийн номын санчдын тоо a_2 - Нийт номын санчдын тоо
2	Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдалтын индекс	$A_2 = \frac{a_3}{a_2}$	a_3 -Тухайн онд улсын чанартай мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан номын санчдын тоо
3	Төсвийн зарцуулалтын индекс	$A_3 = \frac{a_4}{a_5}$	a_4 –төсвийн гүйцэтгэлийн хэмжээ a_5 - Батлагдсан төсвийн хэмжээ
4	Өөрийн үйл ажиллагааны орлогын индекс	$A_4 = \frac{a_6}{a_7}$	a_6 - Өөрийн үйл ажиллагааны орлого a_7 –өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө
5	Сэргээн засварласан номын индекс	$A_5 = \frac{a_8}{a_9}$	a_8 – Сэргээн засварласан номын тоо a_9 - Сэргээн засварлахаар төлөвлөсөн номын тоо
6	Номын фондын ашиглалтын индекс	$A_6 = \frac{a_{10}}{a_{11}}$	a_{10} –олгосон номын тоо /давхардсан/ a_{11} – Фондонд байгаа номын тоо

7	Номын үзэсгэлэн гаргалт	$A_7 = \frac{a_{12}}{a_{13}}$	a_{12} - Номын үзэсгэлэнгийн тоо a_{13} - Төлөвлөсөн номын үзэсгэлэнгийн тоо
8	Ном, хэвлэлийн сурталчилгааны индекс	$A_8 = \frac{a_{14} + a_{15} + a_{16}}{a_{17}}$	a_{14} - FM, радио болон телевизээр сурталчилсан тоо a_{15} - Сонин, сэтгүүл, бусад хэвлэлээр сурталчилсан тоо a_{16} - Веб сайтаар сурталчилсан тоо a_{17} - Ном, хэвлэлийг сурталчилхаар төлөвлөсөн тоо

Судалгааны хүрээнд зарим аймгийн номын сангийн захиралуудтай хийсэн ярилцлагаас үзэхэд энэхүү тоон аргаар гаргах тайлан нь өсөх динамик хандлагыг түлхүү баримталдаг байна. Өссөн үзүүлэлтээр ажлыг дүгнэх нь сайн талтай ч нөгөө талаасаа тайлангийн үзүүлэлт хөөсрөх буюу бодит бус гарах магадлалыг бий болгох талтайг анхааруулж байлаа. Одоогийн байдлаар тоон тайланд дүн шинжилгээ хийх, дүгнэлтийг цаашдын үйл ажиллагааны төлөвлөлт, төсөвт тусгах байдал дутмаг хийгдэж байгаа нь ажиглагдлаа. Түүнчлэн дүгнэх аргачлалын үзүүлэлтэнд орчин үеийн номын сангийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй нэр томъёог оруулах хэрэгтэйг онцолж байв.

Тав. Чанарын үзүүлэлтүүд / бүх соёл, урлагийн байгууллагад ижил байна/

Дүгнэх аргачлал

Хүснэгт №94

д/д	Чанарын үзүүлэлтүүд	Тавигдах шаардлага
1	Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын ур чадвар	Байгууллагын удирдлагын арга барил, ур чадварыг дээшлүүлэх, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн

2	Ажилчдын ажлын хариуцлага сахилга, дэг журам, өөрийн үйл ажиллагаа	Байгууллагын ажилчдын ажлын хариуцлага, сахилгыг дээшлүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх талаар авсан арга хэмжээ, үр дүн
3	Байгууллагын дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ	Байгууллагын удирдлагын арга барил, түүнийг хөгжүүлэх талаар хийсэн ажил, байгууллагын болон уран бүтээлийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ түүний мөрөөр авсан арга хэмжээ, үр дүн
4	Статистик мэдээний чанар, байгууллага, иргэдийг мэдээллээр ханга үйл ажиллагаа, сурталчилгаа	Статистик мэдээллийн чанарыг сайжруулах, байгууллага, иргэдийг мэдээллээр хангах, түүний үр дүнг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж байгаа байдал
5	Байгууллагын хүний нөөцийн хангамж, ашиглалт	Байгууллагыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах хэтийн зорилт, судалгаа, төлөвлөлт, хүний нөөцийн ашиглалт хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, ахиц өөрчлөлт
6	Иргэдэд үзүүлсэн урлаг, соёлын үйлчилгээний хүртээмж, чаар, үр дүн	Иргэдэд үзүүлсэн соёл урлагийн үйлчилгээний хүртээмж, зохион байгуулалт, чанар, үр дүн
7	Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар хийсэн ажил, үр дүн	Ажилчдын ажиллах нөхцөл, ахуй амьдралыг дээшлүүлэх, орлого, цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар санаачлан зохион байгуулж байгаа арга хэмжээ, үр дүн
8	Байгууллагын орчин хангамж, үйлчилгээ	Ажлын өрөө тасалгааны тохижилт, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсгийн хангамж, ашиглалтыг дээшлүүлэх талаар авсан арга хэмжээ, үр дүн
9	Байгууллагын санхүүгийн чадавхи	Байгууллагын төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх,

		өөрийн үйл ажиллагааны орлого, хандив, тусламж, түүний зарцуулалт, тайлагналт, өр авлагын барагдуулалт, хэмнэлт, төсвийн бус орлого, хөрөнгө оруулалтын хэмжээ
10	Үндэсний хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилт, үр дүн	Хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх талаар хийсэн ажил, хэрэгжилтийн явцад хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээ, оруулсан хөрөнгө, санхүүжилтийн үр ашиг
11	Мэдээллийн дотоод сүлжээ, удирдлага мэдээллийн сангийн бүрдэлт, вэб үйлчилгээ	Байгууллагын удирдлагын мэдээллийн санг бүрдүүлэх, түүнийг өргөтгөх талаар хийсэн ажил интернет ашиглалт, веб сайтын үйлчилгээ
12	Уран бүтээл, фонд үзмэрийн хадгалалт хамгаалалт	Архивын стандартын хэрэгжилт, дижитал /видео, аудио, фото/ хэлбэрээр дүрсжүүлсэн байдал

Одоогийн нөхцөлд аймаг, хотын соёлын байгууллагууд аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан үйл ажиллагаагаа чанарын аргаар дүгнүүлдэг бол сум, орон нутгийн соёлын төвүүд аймгийн БСУГ, сумын засаг даргатай гэрээ байгуулан ажлаа чанарын аргаар тайлагнан дүгнүүлж байна.

“Соёлын үйлчилгээний хүртээмж” төслийн хүрээнд “Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ хийх, үнэлэх журам”-ын хэрэгжилтийн байдалд судалгаа хийх явцад зарим заалтыг дахин хянаж боловсронгуй болгох шаардлага бидэнд ажиглагдлаа. Жишээ нь тус журмын долоодугаарт ;

“ Урамшуулал

Соёл, урлагийн байгууллагын жилийн үйл ажиллагаа, үр дүнд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүнг үндэслэн музей, театр, чуулга, номын сан бүрээр байр эзлүүлж урамшуулна.” хэмээн заасан нь соёл урлагийн салбарын нийт ажиллагсдын 30 гаруй хувийг бүрдүүлдэг сумдын соёлын төвүүд үйл ажиллагаагаа чанарын аргаар дүгнүүлдэг ч урамшууллын тогтолцоо нь тодорхойгүй байна.

Бид аймгуудын БСУГ- с сумдын соёлын төвүүдийн үйл ажиллагааг дүгнэж буй чанарын үнэлгээний хэлбэр үзүүлэлтийг гурван хэсгээр судлан нэгтгэж харьцуулалт хийлээ.

Соёлын төвүүдийн үйл ажиллагааг дүгнэж буй хэлбэр

Хүснэгт №95

Аймаг	Дүгнэх хэлбэр	Үзүүлэлт	Оноо
Архангай	-	-	-
Баянхонгор	Хүснэгт, оноо	6 хэсэг 79 үзүүлэлт	100
Баян –Өлгий	Хүснэгт, оноо	4	100
Говь-Алтай	Хүснэгт, оноо	15	100
Дархан – Уул	-	-	-
Дорнод	Хүснэгт, оноо	5 хэсэг 40 үзүүлэлт	100
Дорноговь	Хүснэгт, оноо	18	90
Дундговь	Тоон	14	
Завхан	Тоон болон чанарын	12	100
Орхон	Хүснэгт, оноо	3	100
Өвөрхангай	Хүснэгт, оноо	20	40
Өмнөговь	Хүснэгт, оноо	6	50
Сэлэнгэ	Хүснэгт, оноо	13	68
Сүхбаатар	Хүснэгт, оноо	12	100
Төв	Хүснэгт, оноо	6 хэсэг 22 үзүүлэлт	30
Увс	Хүснэгт, оноо	28	100
Хэнтий	Хүснэгт, оноо	16	100
Ховд	Хүснэгт, оноо	36	74
Хөвсгөл	Хүснэгт, оноо	10	20

Судалгаанд ирүүлсэн аймгуудын БСУГ-н чанарын үнэлгээнд баримталдаг нийтлэг үзүүлэлтүүдээс дурдвал:

- Хөтөлбөрүүдийн хэрэгжилт
- Авъяас чадварыг хөгжүүлэх дугуйлангийн үйл ажиллагаа
- Номын сангийн болон ОНСТ үйл ажиллагаа
- Байгууллагын бодлого төлөвлөлт
- Хүний нөөцийн чадавхижуулалт
- Захиалгат үйлчилгээ
- Нийтлэг үйлчилгээ

- Материаллаг орчны тохижилт
- Орлогын төлөвлөгөө
- Үүрэг даалгаврын биелэлт
- Ажилтны хариуцлага, ёс зүй гэсэн хэсгүүдээс бүрдэж байв.

Судалгаанаас үзэхэд аймгийн БСУГ – с сумдын соёлын төвүүдийн үйл ажиллагааны чанарын үзүүлэлтийг дүгнэх хэлбэр үзүүлэлт, онооны хэсгүүд харилцан адилгүй байна.

Дүгнэх хэлбэрийг харахад бүх аймгууд хүснэгтийн аргаар онооны дарааллыг баримталсан бол шалгуур үзүүлэлтийн тухайд зарим аймгуудад тодорхой бус (Архангай, Дархан-Уул), дунджаар 20 гаруй шалгуур үзүүлэлтийг баримтлан 87 хүртэлх дундаж баллыг баримтлан дүгнэжээ.

Чанарын үнэлгээний оноо нь 20-100 хооронд хэлбэлзэж байгаа нь “ Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ хийх, үнэлэх журам”-ын

- 9. ... чанарын үнэлгээний нийлбэр оноо хамгийн ихдээ 24 байна гэсэн заалт хэрэгжихгүй байгааг харуулж байна.

Соёл, урлагийн салбарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээний аргачлал тодорхой бус одоогийн байдал нь ажиллагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх шаардлагатайн дээр орчны болон үйл ажиллагааны наад захын стандарт байхгүй хүндрэлтэй нөхцөлтэй шууд холбоотой хэмээн үзэж байна.

Сүүлийн 3 жилд явуулж буй үйлчилгээний чанар

Хүснэгт №96


№	Үйлчилгээний төрөл	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу	Нийт
1	Аялан тоглолтууд	51	244	144	44	24	507
2	Бүжиг-цэнгүүний үйлчилгээ	62	268	146	31	16	523
3	Урлаг спортын наадам	107	250	1270	32	13	1672
4	Төрийн бодлого шийдвэрийн мэдээлэл	50	169	181	86	18	504
5	Тэмдэглэлт баяр, наадмын үйл ажиллагаа	152	129	132	10	32	455

6	Нүүдлийн соёлын үйлчилгээ	76	143	163	10	32	424
7	Үзэсгэлэн худалдаа	57	177	168	79	20	501
8	Захиалгат үйл ажиллагаа	52	152	180	75	15	474
9	Дугуйлан	73	186	170	62	27	518
10	Сургалтууд /албан ба албан бус/	35	182	194	69	14	494
11	Чөлөөт цагийн ажил	55	178	207	48	14	502
12	Номын сангийн уншлага, үйлчилгээ	93	237	129	40	23	522
13	Түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, сурталчилах ажлууд	73	151	167	82	41	514
14	Урлагийн боловсрол олгох ажил	46	186	184	60	33	509
15	Хүүхэд, өсвөр үеийнхний дунд зохиох ажил	70	224	147	53	27	521
16	Нийгмийн түншлэлийн хүрээн дэх ажил үйлчилгээ	34	194	174	74	28	504
17	Сайн дурын нэгдэл, клубийн үйл ажиллагаа	57	116	203	94	35	505
18	Ахмад настны дунд зохиох ажил	22	87	139	87	22	357
19	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйл ажиллагаа	27	126	197	110	45	505
Нийт		1192	3399	4295	1146	479	10511

Судалгаанд оролцогчдоос соёлын байгууллагын сүүлийн 3 жилд зохион явуулж буй үйлчилгээний чанарт маш сайн - 1192 хариулт буюу 11.3%, сайн – 3399 хариулт буюу 32.3 %, дунд – 4295 хариулт буюу 40.8%, муу – 1146 хариулт буюу 10.9%, маш муу – 479 хариулт буюу 4.5% хариулт өгсөн байна. Нийт хариултын 43.6 % - ийг маш сайн,

сайн, 56.4% -ийг дунд муу, маш муу хариулт эзэлж байна . Үзүүлэлтийг доорх зурагт дэлгэрэнгүй харуулав.

Бүдүүвч №103



Гадаад орны туршлага

Төслийн даалгаврын хүрээнд соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны хяналт- шинжилгээ үнэлгээний аргачлалыг олон талт боловсронгуй болгох үүднээс хэрэглэгчийн үнэлгээ хийх эрх зүйн орчин болон уг үнэлгээг хэрэглэж буй гадны орны туршлагаас бид судалж үзлээ.

ОХУ-д соёл урлагийн байгууллагуудын ажлыг дүгнэхдээ “Хөндлөнгийн үнэлгээ” -г ашиглан тодорхой үр дүнд хүрч буй туршлага байна. Уг үнэлгээг ОХУ-ын Соёлын Яамны 2018 оны 599 тоот "Соёлын байгууллагуудын үйлчилгээ үзүүлэх нөхцлийн чанарыг үнэлэх ерөнхий шалгуурыг тодорхойлсон шалгуур үзүүлэлтийг батлах тухай" / Независимая оценка качества условий оказания услуг организациями культуры/ тушаалыг үндэслэн нэгдсэн загвар, арга зүйгээр ханган дүгнэж байна.

Хөндлөнгийн үнэлгээг ОХУ хэрэгжүүлснээр соёл, урлагийн байгууллагууд үнэлгээний нэгдсэн мэдээллийн платформтой болж үйл ажиллагааны төлөвлөлтийг хийхдээ уг үнэлгээг үндэслэдэг зэрэг ололттой талууд бий болжээ.

Соёлын төв, ордны үйлчилгээний чанарын үнэлгээний ерөнхий нөхцөл ⁴⁵

Хүснэгт. №97

№	Шалгуур үзүүлэлт	Хамгийн их утга	Үзүүлэлтийн ач холбогдол	Ач холбогдлыг харгалзсан үзүүлэлт
1.	Шалгуур1 "Соёлын байгууллагын нээлттэй, хүртээмжтэй байдал"			
1.1.	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл тавигдсан байдал, мэдээллийн жагсаалт, түүнд тавигдах шаардлага нь хууль эрх зүйн актуудаар тогтоогдсон эсэх - Байгууллагын мэдээллийн самбар дээрх мэдээлэл, - Байгууллагын албан ёсны вэбсайт дээрх мэдээлэл болон харилцаа холбооны бусад чиглэлийн мэдээлэл	100 оноо	30%	30 оноо
1.2.	Байгууллагын албан ёсны вэбсайт дээр			

⁴⁵ Приказ Министерства культуры РФ от 7 марта 2017 г. № 261 Независимая оценка качества условий оказания услуг организациями культуры

	<p>үйлчлүүлэгчтэй харилцах, санал хүсэлтийг хүлээн авах, харилцах аргууд байгаа эсэх, хэрхэн ажиллаж байгаа тухай.</p> <ul style="list-style-type: none"> - утас, - имэйл, -электрон үйлчилгээ (гомдол, саналыг ирүүлэх маягт; "байнга асуудаг асуултууд" үзүүлж буй үйлчилгээний талаар зөвлөгөө авах гэх мэт). - Үйлчлүүлэгчид үйлчилгээний чанарын талаар санал бодлоо илэрхийлэх боломж олгосон эсэх (иргэдээс санал авах асуулгын хуудас эсвэл түүнтэй холбосон линк байгаа эсэх) 	100 оноо	30%	30 оноо
1.3	Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийн нээлттэй байдал, бүрэн байдал, хүртээмжтэй байдалд сэтгэл ханамжтай үйлчлүүлэгчийн хувь хэмжээ, (судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчийн эзлэх хувь)	100 оноо	40%	40 оноо
Нийт			100%	100 оноо
2.	Шалгуур2 "Үйлчилгээний тав духтай нөхцөл байдлын" шалгуур "			
2.1.	<p>Үйлчилгээний таатай нөхцлийг бүрдүүлсэн байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Ая тухтай амрах талбайтай эсэх (хүлээлгийн); - Байгууллагын доторх байршлыг харуулсан схем, зураг, танилцуулгатай эсэх; - ундны усны боломжтой эсэх; - ариун цэврийн байгууламжийн хүртээмж, (ариун цэврийн өрөөний цэвэр байдал, 	100 оноо	50%	50 оноо

	саван, ус, ариун цэвэрийн цаас гэх мэт); - Байгууллагын байрны эрүүл ахуйн нөхцөл; - Захиалгын үйлчилгээ авах боломжтой эсэх, хүртээмжтэй эсэх /үйлчилгээ захиалах боломж (утсаар, интернет ашиглан байгууллагын албан ёсны вэбсайтаар, биечлэн очих гэх мэт)			
2.2.	Үйлчилгээг хүлээн авах хугацаа	Энэ үзүүлэлт нь соёлын байгууллагуудын үнэлгээнд хамаарахгүй.		
2.3.	Үйлчилгээний нөхцлийн ая тухтай байдалд сэтгэл ханамжтай үйлчлүүлэгчдийн эзлэх хувь (Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн нийт хувь%)	100 оноо	50%	50 оноо
Нийт			100%	100 оноо
3.	Шалгуур3 "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан үйлчилгээ хүртээмж"			
3.1.	- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжтэй байдлыг харгалзан байгууллагын гадна дотор талын орчныг тохижуулсан байх; - шатыг орлох налуу тавцан; - хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тээврийн хэрэгслийн тусгай зориулалтын зогсоол; - өргөн хаалгатай, гар хөшүүрэгтэй, цахилгаан шат; - сольж болох тэргэнцэр байгаа эсэх; - байгууллагад тусгайлан тоногдсон ариун цэврийн байгууламж байгаа эсэх	100 оноо	30%	30 оноо

3.2.	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш үйлчилгээг авах боломжтой нөхцөлийг бий болгох, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - сонсгол, харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан дуут болон харааны мэдээлэл; - брайл үсэг тэмдгээр бичсэн тэмдэг болон бусад бичвэр болон график мэдээллийг давхар хуулбарлах; - сонсголын (сонсгол, хараа) бэрхшээлтэй хүмүүст дохионы хэлний орчуулагчийн үйлчилгээгээр хангах боломж - Харааны бэрхшээлтэй хүмүүст үйлчилгээ үзүүлдэг эсэх “интернет”: - Ажилтнуудыг сургалтанд хамруулан, тэдэнд туслалцаа үзүүлэх боломжоор хангасан эсэх - Алсаас, гэрт нь үйлчилгээ үзүүлэх боломжтой эсэх 	100 баллов	40%	40 оноо
3.3.	<p>Үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэтгэл ханамжтай байдлын эзлэх хувь (судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчдээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх %)</p>	100 оноо	30%	30 оноо
Нийт			100%	100 оноо
4.	Шалгуур4 "Байгууллагын ажилтнуудын эелдэг байдал, ёс суртахуун"			
4.1.	<p>Байгууллагын ажилчдын харилцаа, эелдэг, уриалгахан байдал, анхан шатны холбоо тогтоох, үйлчилгээг хэрэглэгчдэд мэдээлэх байдал (үйлчилгээний ажилтнууд, кассчин гэх мэт) байгууллагатай шууд холбоо тогтоосон үйлчлүүлэгчийн эзлэх хувь</p>	100 оноо	40%	40 оноо

	(судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчдийн %).			
4.2.	Соёл, урлагийн ажилтан, мэргэжилтнүүдийн харилцааны соёл, эелдэг байдал үйлчдүүлэгчийн сэтгэл ханамжтай байдал (судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчдийн эзлэх %)	100 оноо	40%	40 оноо
4.3.	Алсын зайн хэлбэрийг ашиглахдаа (утсаар, и-мэйл, цахим үйлчилгээг ашиглан (цахим өргөдөл, гомдол, санал хүсэлт гаргах, үйлчилгээний хүсэлт гаргах, үзүүлж буй үйлчилгээний талаар зөвлөгөө авах гэх мэт) байгууллагын ажилтнуудын эелдэг байдал сэтгэл ханамжтай үйлчлүүлэгчдийн %) (судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчдийн %)	100 оноо	20%	20 оноо
Нийт			100%	100 оноо
5.	Шалгуур5 "Үйлчилгээний нөхцөлийн сэтгэл ханамж"			
5.1.	Энэхүү байгууллагыг хамаатан садан, найз нөхөддөө санал болгохыг хүсч буй үйлчлүүлэгчийн хувь хэмжээ (хэрэв байгууллага сонгох боломжтой бол үүнийг санал болгож болно) (Судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчид %)	100 оноо	30%	30 оноо
5.2.	Байгууллагын ажлын хуваарьт сэтгэл ханамжтай байгаа үйлчлүүлэгчийн хувь (Судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчид %)	100 оноо	20%	20 оноо
5.3.	Байгууллагын үйлчилгээ үзүүлэх нийтлэг	100 оноо	50%	50 оноо

	нөхцөл, шаардлагыг хангасан байдалд сэтгэл ханамжтай үйлчлүүлэгчийн эзлэх хувь (Судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчдийн %)		
Нийт		100%	100 оноо

Төслийн хүрээнд бид ОХУ-ын Улан – Үдэ хотын ДССДС-ийн дэргэдэх <Нийгэм, соёлын үйл ажиллагааны> тэнхимээс удирдан явуулсан соёл, урлагийн 13 байгууллагуудад хийсэн “Хөндлөнгийн үнэлгээ”- ний явц болон тайлангийн материалтай дэлгэрэнгүй танилцсан. Үнэлгээг дараах үзүүлэлтээр хийсэн байна.

- Соёлын байгууллагын мэдээллийн нөөцийн үнэлгээ
- Соёлын байгууллагын үйлчилгээний цагийн хуваарийн үнэлгээ
- Соёлын байгууллагын тохижилт орчин нөхцлийн үнэлгээ
- Соёлын байгууллагын тохижилт орчин нөхцлийн үнэлгээ
- Соёлын байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн үйл ажиллагааны үнэлгээ
- Соёлын байгууллагын ажиллагсдад өгсөн үнэлгээ
- Соёлын байгууллагын үйл ажиллагааны нэгдсэн үнэлгээ гэсэн үндсэн үзүүлэлтээр дүгнэн харьцуулалт хийж байна.⁴⁶

Хөндлөнгийн үнэлгээг ОХУ хэрэгжүүлснээр соёл, урлагийн байгууллагууд үнэлгээний нэгдсэн мэдээллийн платформтой болж үйл ажиллагааны төлөвлөлт болон төсөвлөлтийг хийхдээ уг үнэлгээг үндэслэдэг зэрэг ололттой талууд бий болсон байна. Түүнчлэн соёл, урлагийн байгууллагуудын удирдах ажилтнуудын ажлыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг ОХУ-д 2012 оноос /Показатели эффективности и критерии оценки деятельности руководителей муниципальных учреждений культурно-досугового типа /эхлэн мөрдлөг болгон ажиллаж байна.

Соёл, чөлөөт цагийн байгууллагуудын удирдлагын үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт⁴⁷

⁴⁶ Эх сурвалж: Деятельность учреждений культуры Республики Бурятия: сравнительный анализ-2018 Н.А.Затеева, С.П. Татарова

⁴⁷ Приложение N 2 к постановлению администрации города Тамбова от 7 ноября 2014 года N 9584

N п/п	Удирдлагын ажлын үр днг дүгнэх шалгуур үзүүлэлтүүд	Дүнгийн үзүүлэлт	Тооцох оноо	Тайлагнах хугацаа
1	2	3	4	5
1. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа				
1.1.	Соёл, чөлөөт цагийн үйл ажиллагаанд оролцогчдын тоон үзүүлэлтийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулсан байдал	100% биелэлт	10	Жил бүр
		85 - 99 хувийн биелэлт	5	
		85% -с доош биелэлт	0	
1.2.	Клуб, сайн дурын нэгдлийн үйл ажиллагаанд хамрагдагсдын тоон үзүүлэлтийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулсан байдал	Өссөн үзүүлэлт	5	Улирал тутам
		Тогтмол үзүүлэлт	3	
		Буурсан үзүүлэлт	0	
1.3.	Клуб, сайн дурын нэгдлийн үйл ажиллагаанд хамрагдагсдын тоон үзүүлэлтийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулсан байдал	Өссөн үзүүлэлт	5	Улирал тутам
		Тогтмол үзүүлэлт	3	

		Буурсан үзүүлэлт	0	
1.4.	Соёл, чөлөөт цагийн үйл ажиллагаанд оролцогчдын дундаж үзүүлэлтийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулсан байдал	Өссөн үзүүлэлт	10	Улирал тутам
		Тогтмол үзүүлэлт	5	
		Буурсан үзүүлэлт	0	
1.5.	Байгууллагын аюулгүй байдлын хангалт	Дутагдалгүй	5	Улирал тутам
		Хяналтын байгууллагуудын тавьсан шаардлагууд, ирүүлсэн заалтуудыг заасан хугацаанд биелүүлсэн	2	
		Удирдлагын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан тогтоосон хугацаанд биелүүлээгүй т хяналтын байгууллагын санал байгаа эсэх	- 2	
1.6.	Үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ	Байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдийн санал асуулгын эерэг үр	2	Жил бүр

		дүн (санал асуулга хэлбэрээр)		
		Дээд болон хяналтын байгууллагаас хийсэн шалгалтын үр дүнд үндэслэн үйлчилгээний талаар иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлууд байгаа	-2	
1.7.	Байгууллагын мэдээллийн нээлттэй байдлыг хангасан байдал	Холбооны портал дээр тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийн дагуу байгууллагын талаарх мэдээллийг байрлуулах, засвар үйлчилгээ хийх	5	Улирал тутам
		Биелүүлээгүй үзүүлэлт	0	
		Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг интернетийн эх сурвалж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байршуулах	5	Улирал тутам
		Биелүүлээгүй үзүүлэлт	0	
1.8.		Төлбөрт үйлчилгээний	3	Улирал тутам

	Иргэдийн дунд байгууллагын үйл ажиллагааг мэдээлэн таниулж сурталчилсан байдал	жагсаалт, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, үйлчилгээний чиглэлээр үйлчилж буй хууль тогтоомж, бусад мэдээллийн талаархи мэдээлэл бүхий стэнд байх.		
		Биелүүлээгүй үзүүлэлт	0	
		Албан ёсны интернетийн сайт, үйл ажиллагааны тасралтгүй байдал	5	Улирал тутам
		Биелүүлээгүй үзүүлэлт	0	
2. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа, сахилга бат				
2.1.	Сар, улирал, жилийн тайлан, санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, статистикийн тайланг цаг тухайд нь гаргаж өгөх, бусад мэдээлэл, тэдгээрийн чанар	Мэдээлэл, тайлан, статистикийн тайлан гаргах хугацаа, тогтоосон журам, хэлбэрийг дагаж мөрдөх	5	Улирал тутам
		Мэдээлэл, тайлан, статистикийн тайлан гаргах хугацаа, тогтоосон журам, хэлбэрийг зөрчсөн	-2	

2.2.	Даалгаврын хүрээнд төсвийн хөрөнгийг зорилтот, үр ашигтай зарцуулах	Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байдал	5	Жил бүр
		Биелэгдээгүй үзүүлэлт	0	
2.3.	Санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны үр нөлөө	Эрчим хүчний зохистой хэрэглээ (жилийн эхнээс нийт хуриимтлагдсан)	5	Жил бүр
		Биелэгдээгүй үзүүлэлт	0	
		с нарас-тающим итогом с начала года)	5	Жил бүр
		Биелүүлээгүй үзүүлэлт	0	
		Төлбөртэй болон бусад үйлчилгээнээс хөрөнгө, орлого төвлөрүүлэх үйл ажиллагааны динамик өсөлт (өмнөх жилтэй харьцуулахад)	5	Жил бүр
		Биелүүлээгүй үзүүлэлт	0	
3. Хүний нөөцийн талаарх үйл ажиллагаа				
3.1.	Байгууллагын ажиллагчдын мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх сургалт	Ажиллагчдын мэргэжил дээшлүүлэх хугацааг төлөвлөгөөнд тусган	10	Улирал тутам

		хэрэгжүүлсэн байдал з		
		Биелүүлээгүй үзүүлэлт	0	
3.2.	Тухайн байгууллагын тодорхой ангиллын ажиллагчдын цалинг дундаж цалинтай харьцуулсан харьцааны утга	1 ба түүнээс дээш харьцаа	10	Жил бүр
Шалгуур үзүүлэлтийн нийт онооны хамгийн их утга:			100	
Улирал тутам :				
I улирал			58	
II улирал			58	
III улирал			58	
IV улирал			100	

Дээрх журмын дагуу улирал тутам удирдах ажилтнуудын ажлыг дүгнэдэг бөгөөд тогтвортой болон онцгой амжилт гаргасан тохиолдолд урамшуулал олгох журмын дагуу шагнал урамшууллыг олгож байна.⁴⁸ / Положение о выплатах стимулирующего характера руководителям муниципальных учреждений культуры/.

Соёлын байгууллагын удирдах ажилтан нарт урамшуулал олгох журамд зааснаар үндсэн 2 төрлийн урамшууллын хэлбэр байна. Үүнд;

- Ажлын өндөр амжилт гаргасны төлөө сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг сар бүр олгох нөхцөл нь байгууллагын улирлын ажлын үр дүнг үнэлсэн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, байгууллагын дүрэмд заасан үндсэн зорилго, зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд удирдагчийн оруулсан хувь нэмэр, түүнчлэн хөдөлмөрийн гэрээнд заасан үүргийн биелэлтийг харгалзана
 - Ажлын үр дүнгийн урамшууллыг байгууллагын удирдлагуудад албан тушаалын цалингийн 25 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр сар бүр тогтоохдоо;
- Үйл ажиллагааны болон хөдөлмөрийн сахилга батыг дагаж мөрдөх;

⁴⁸ Приказ Министерства культуры РФ от 22 мая 2018 г. N765 <О внесении изменений в Положение о выплатах стимулирующего характера руководителям федеральных государственных учреждений, находящихся в ведении Министерства культуры Российской Федерации, утвержденное приказом Министерство культуры РФ от 16 сентября 2013 г. N1351 >

Ажлын гүйцэтгэлийн цаг хугацаа, чанарыг харгалзана гэжээ.

Түүнчлэн ажлын гүйцэтгэлийн үзүүлэлтээс шалтгаалан урамшуулал хасагдах болон олгогдохгүй байж болох бөгөөд дараах үзүүлэлтээс шалтгаална гэжээ. Үүнд;

- Хөдөлмөрийн сахилга бат зөрчсөн /хоцролт, ажлын байрыг орхих гэх мэт/;
- Хүндэтгэх шалтгаангүйгээр ажлын өдөр дөрвөн цаг дараалан таслах;
- Мэргэжлийн ёсзүйгүй байдал гаргах;
- Зайлшгүй шаардлагаас урган гарсан ажилд үндэслэлгүйгээр татгалзах.

Удирдах ажилтан нь ажлын гүйцэтгэлийн тайлангаа улирал тутам цаг хугацаандаа дүүргийн соёлын хэлтэст өгч байх хэрэгтэй бөгөөд дүгнэн шалгаруулахад дүүргээс томилогдсон комисс ажилладаг байна.

Комисс нь журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу 100 хүртэл оноогоор эрэмбэлэн дүгнэж шалгаруулалтыг хийдэг ба энэ оноо нь шагналт урамшууллын үндэс болдог байна.

Түүнчлэн соёлын байгууллагын удирдлагын улирал, жилийн ажлын үр дүн нь ажлын онцгой ач холбогдолтой, өндөр ур чадвар, хариуцлага, гүйцэтгэл шаардсан тохиолдолд нэг албан тушаалын цалингийн хэмжээ хүртэл урамшуулал тогтоон олгож болно хэмээн заажээ.

Соёл, урлагийн салбарт үйл ажиллагааны үнэлгээний чиглэлээр мөрдөгдөж буй бас нэгэн баримт бичиг бол

Соёлын салбарын байгууллага, ажилтантай үйл ажиллагааны үзүүлэлтийн тогтолцоог уялдуулах нь “Методические рекомендации по взаимоувязке системы отраслевых показателей эффективности деятельности в сфере культуры от федерального уровня до конкретного учреждения и работника”⁴⁹ удирдамжийг үндэслэн удирдлага, менежер, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан байна. Үүнд: нийтийн номын сан, музей, үзэсгэлэнгийн танхим, галерей, театрууд, соёлын болон чөлөөт цагийн хэлбэрийн байгууллагууд, соёл амралтын хүрээлэн, цирк, циркийн бүлгүүд, амьтны хүрээлэн, ботаникийн цэцэрлэг, концертын байгууллагууд, бие даасан хамтлагууд, кино үйлдвэрлэх, түрээслэх, өргөн нэвтрүүлэг, телевиз, архив.

Удирдамж нь удараах хэсгүүдээс бүрдэж байна.

I. Төрийн соёлын байгууллагуудын үйл ажиллагааны үзүүлэлтүүдийн тогтолцоог боловсруулах хэрэгцээ;

⁴⁹ Приложение к письму Минкультуры России от 05.08.2014 г. № 166-01-39/04-НМ

II. Салбарын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд тавигдах шаардлагууд;
III. Салбарын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн ололт амжилтыг хангах;
IV. Ажилтны цалинг түүний үйл ажиллагааг тодорхойлсон үзүүлэлтүүдтэй уялдуулах;

V. Холбооны түвшинд соёлын салбарын байгууллага, ажилтны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн харилцан хамаарал. Үүнд:

1. соёлын байгууллагын үйл ажиллагааны үзүүлэлт;
2. байгууллагын удирдлагын үйл ажиллагааны үзүүлэлт;
3. байгууллагын ажилчдын гүйцэтгэлийн үзүүлэлтүүд

Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар гаргасан байна. Жишээ нь:
Соёл, чөлөөт цагийн байгууллага

1) өмнөх жилтэй харьцуулахад соёл, чөлөөт цагийн үйл ажиллагаанд оролцогчдын тоо (хувь);

2) сайн дурын нэгдэл, клубын үйл ажиллагаанд хамрагдагсдын тоо (хувь);

3) соёл, чөлөөт цагийн үйл ажиллагааны тоо (нэгж)

4) хүүхэд, залуучуудын бүтээлч чадавхийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны нийт байгууллагын үйл ажиллагаанд эзлэх хувь (хувь);

5) соёл, чөлөөт цагаа өнгөрөөх үйл ажиллагаанд оролцсон хүмүүсийн дундаж хувь (хувь);

6) соёл, чөлөөт цагийн хэлбэрийн байгууллагуудын зохион байгуулдаг соёлын болон чөлөөт цагийн чөлөөт арга хэмжээнд оролцсон хүн амын эзлэх хувь (хувь);

6) бүтээлч үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн тоо, нийт хүүхдийн (хувь);

7) олон улсын, бүх Орос, бүс нутаг, бүс нутгийн уралдаан, фестивалийн шагналтнуудын тоо (хүмүүс) зэргийг хамруулсан байна.

ОХУ-ын Засгийн газраас баталсан / 2012 онд анх батлагдаад 2015 онд шинэчилсэн найруулга хийгдсэн/ Үйл ажиллагааны төлөвлөгөө ("Замын зураг") "Соёлын салбарын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн нийгмийн салбарын өөрчлөлтүүд" үйл ажиллагааны төлөвлөгөө /Замын зураг/⁵⁰-нд Соёлын салбарыг хөгжүүлэх зорилтот үзүүлэлт (үзүүлэлт) ба тэдгээрийн үр дүнг баталгаажуулах арга

⁵⁰ План мероприятий ("дорожная карта") "Изменения в отраслях социальной сферы, направленные на повышение эффективности сферы культуры"- УТВЕРЖДЕН распоряжением Правительства Российской Федерации от 28 декабря 2012 года N 2606-р(с изменениями на 28 апреля 2015 года)

хэмжээ /Целевые показатели (индикаторы) развития сферы культуры и меры, обеспечивающие их достижение/ гэсэн хэсэгт ОХУ-н соёл, урлагийн салбарт 2012 – 2018 онд олсон амжилтуудыг 19 салбар үзүүлэлтээр нэгтгэн дүгнэж гаргасан байна. Жишээ нь;

1) театр концертын үйл ажиллагаанд хамрагдагсдын тоо.

(хувь)

2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
3,1	3,2	3,3	3,5	3,8	4	4,2

2) Оросын номын сангийн нэгдсэн цахим каталог дахь ном зүйн бичлэгийн тоог нэмэгдүүлэх (хувь)

2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
1,7	1,8	1,9	2	2,1	2,2	2,3

3) соёлын өвийн объектуудын нийт тоонд ОХУ-ын (түүх, соёлын дурсгалт) нэгдсэн цахим бүртгэлд бүртгэгдсэн соёлын өвийн объектуудын эзлэх хувийг нэмэгдүүлэх

(хувь)

2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
27	30	35	40	46	50	52

6) соёл, чөлөөт цагийн үйл ажиллагаанд хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх

(хувь)

2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
6,5	6,6	6,7	6,8	7	7,1	7,2

7) соёлын үйлчилгээний чанараас ОХУ-ын иргэдийн авах сэтгэл ханамжийн түвшинг дээшлүүлэх.

(хувь)

2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
70	71	74	78	83	88	90

8) холбооны, бүс нутгийн болон орон нутгийн хамгаалалтын сайн нөхцөлд байгаа соёлын өвийн объектийн эзлэх хувийг нэмэгдүүлэх.

(хувь)

2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
30,5	31,24	32,01	32,79	33,59	34,41	35,25

17) бүтээлч үйл ажиллагаанд оролцогч хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх

(процентов)

2012 год	2013 год	2014 год	2015 год	2016 год	2017 год	2018 год
1	2	3	5	6	7	8
18)	соёлын	байгууллагаар	үйлчлүүлэгчдийн	тоог	нэмэгдүүлэх	

(процентов по отношению к 2012 году)

2012 год	2013 год	2014 год	2015 год	2016 год	2017 год	2018 год
-	5	10	15	20	25	30

19) соёлын байгууллагаас үзүүлэх нэмэлт үйлчилгээний тоог нэмэгдүүлэх:

(процентов по отношению к 2012 году)

2012 год	2013 год	2014 год	2015 год	2016 год	2017 год	2018 год
-	5	10	15	20	25	30

ОХУ-ын соёлын салбарт мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгүүд болон хэрэгжилтийн байдлаас үзэхэд / Об утверждении показателей, характеризующих общие критерии оценки качества оказания услуг организациями культуры , Показатели эффективности и критерии оценки деятельности руководителей муниципальных учреждений культурно- досугового типа, Положение о выплатах стимулирующего характера руководителям муниципальных учреждений культуры / 2014 оноос эхлэн салбарын соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний чанарыг дүгнэх нэгдсэн аргачлалтай бөгөөд Интернет платформд аль ч хотын байгууллагын үйлчилгээний талаар мэдээлэл авах боломжтой болсон байна.

ОХУ-ын Соёлын Яамнаас гарч буй эрх зүйн бодлогын баримт бичгүүд нь байгууллага үйл ажиллагаандаа хэрхэн хэрэглэх аргазүйн зөвлөмжийг дагалдуулан мэдээллийг ашиглах нээлттэй орчинд хэрэгжиж байна.

Байгууллагын үйл ажиллагааг хөндлөнгийн үнэлгээний аргаар дүгнэхээс гадна сайн менежер, удирдагч нарыг соёл, урлагийн салбарт амжилттай, шударга ажиллах эдийн засгийн хөшүүргийг бий болгон ажлын гүйцэтгэлийг дүгнэх үзүүлэлт болон шагналт цалин, урамшуулал олгох тушаалыг хот, дүүрэг, тосгоны хэмжээнд мөрдлөг болгон ажиллаж байгаа нь манай орны нөхцөлд анхаарч хэрэглүүштэй туршлага байна гэж бид үзлээ.

Түүнчлэн ОХУ-ын Засгийн газраас Соёл, урлагийн салбарыг хөгжүүлэх цогц бодлогын хүрээнд тодорхой төлөвлөгөө Замын зураглалыг баримталж байгаа нь хүрэх үр дүнгээ урьдчилан тооцоолж нөөцөө зөв зохистой хуваарилах, холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэх зэрэгт ач холбогдлоо өгсөөр байна.

БНХАУ-ын соёлын салбарт мөрдөгдөж буй стандартыг тоймлон авч үзэхэд хүн амын нягтралтай уялдуулан соёлын үйлчилгээний газруудыг үндсэн 3 түвшинд ангилан авч үзэж барилга байгууламж болон орчны тохижилтыг үүнд тохируулан зааж өгсөн байна.

Стандартын бүтцэд үнэлгээний үндсэн 4 шалгуур үзүүлэлтүүдийг 1000 оноонд хувааж тооцогдох жагсаалттайгаар тусгаж өгсөн байна. Үүнд;

- орчны тохижилт, нөхцөл -360 оноо
- хүний нөөц – 110 оноо
- нийтэд зориулсан үйлчилгээ – 430 оноо
- менежмент – 100 оноо

түүнчлэн 5 дах шалгуур үзүүлэлтийг сайжруулах 50 оноог нэмэлтээр тусгасан байна.

Орчны тохижилт болон менежментийн хэсэгт байгууллагын вэб сайтад тавигдах шаардлагыг нарийвчлан дижитал үйлчилгээний хэсэгт хамааруулан 1. Мэдээлэл түгээх 2. Үнэлгээ өгөх 3. Зөвөлгөө өгөх чиглэлээр ажиллах шаардлагатайг заажээ.

Стандартын үндсэн болон менежментийн хэсэгт үйлчлүүлэгчдээс авах сэтгэл ханамжийн судалгааг байгууллагын зүгээс заавар хийсэн байхаар тусган хамрагдах хүний тоог хүн амын нягтралаас шалтгаалан 200 – 300 байхаар тогтоосон байна.

Хөрш зэргэлдээ хоёр улсын туршлагаас үзэхэд соёл, урлагийн байгууллагууд үйлчилгээний болон орчны стандартыг мөрдлөг болгон ажилладаг тул хяналт-шинжилгээ, үнэлгээ нь стандарт норм нормативийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тогтоож үр дүнг шинжлэн дүгнэх, улмаар цаашид авах арга хэмжээг төлөвлөх, гүйцэтгэх зөвлөмжөөр хангахад чиглэгдэж байна.

Цаашид соёлын байгууллагын үйл ажиллагааны хяналт- шинжилгээ, үнэлгээний ач холбогдлыг нэмэгдүүлэх үүднээс зөвхөн удирдлагын зүгээс дотоод шинжилгээ үнэлгээ хийхээс гадна хэрэглэгчийн /үйлчлүүлэгчийн/ үнэлгээг ашиглах нь үнэлгээг бодитой болгох сайн талтай юм. Энэ нь хэрэгжих бүрэн боломжтой бөгөөд эрх зүйн орчны тухайд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралт “ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт – шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д :

- 9.7. Хэрэглэгчийн үнэлгээг гаргахдаа захиргааны байгууллагаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хөндлөнгийн байгууллагаар тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн насанд хүрсэн иргэдийн 5 хүртэлх хувийг хамруулан явуулсан санал асуулгын дүнг үндэслэн гаргана.

Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааг дүгнэх аргачлалыг цаашид боловсруулахдаа Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралт “ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт – шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д

2.1.2. “үнэлгээ” гэж байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж өгсөн үнэлэлтийг;

2.1.3. “үр дүнд суурилсан явцын үнэлгээ” гэж хяналт-шинжилгээний мэдээлэлд үндэслэн зорилтот түвшинд хүрч байгаа эсэхэд үнэлгээ хийх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхойлж, үр дүнг сайжруулах дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

2.1.4. “үр дүнд суурилсан эцсийн үнэлгээ” гэж бодлогын баримт бичиг хэрэгжиж дууссаны дараа хэрэгжилтийг үнэлж, үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхойлон цаашид тухайн чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлэх, эсхүл зогсоох талаар дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

2.1.5. “хөндлөнгийн үнэлгээ” гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, судлаач, үнэлгээчдийн хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг;

2.1.6. “хэрэглэгчийн үнэлгээ” гэж захиргааны байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн дүнг;

2.1.7. “шалгуур үзүүлэлт” гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг баримтлана гэсэн заалтуудыг үндэслэх нь шалгуур үзүүлэлтийг жигдлэн мөрдөх ач холбогдолтой хэмээн бид үзэж байна.

1980-аад оны сүүлч 1990-ээд оны эхэн үеэс Швед, Швейцарь, Норвеги, Австри, Герман, АНУ зэрэг олон оронд бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг төрийн хараат бус үнэлгээний системээр буюу хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үндэсний индексийг баримтлан тогтоож ирсэн байна.

Дүгнэж үзвэл, “Соёлын үйлчилгээний хүртээмж” төслийн хүрээнд үйл ажиллагааны үнэлгээ, үйлчилгээний чанарын асуудлаар нийт 345 соёлын ажилтан, 562 үйлчлүүлэгч, 211 бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, 52 хүнийг чөлөөт ярилцлагад хамруулан хийсэн судалгааны ажлын үр дүнгээс дараах дүгнэлтийг хийж байна.

- Соёл, урлагийн салбарт хийгдэж буй хяналт- шинжилгээ, үнэлгээний ач холбогдол, эргэж төлөвлөлт, төсөвлөлтөнд тусах гинжин холбоо сул,
- Аймгийн БСУГ-аас соёлын төвүүдийн үйл ажиллагааг үнэлэх нэгдсэн аргачлал байхгүй,
- Орон нутгийн соёлын төвүүдийн орчны болон үйл ажиллагааны стандарт байхгүйгээс шалтгаалан хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн шалгуур үзүүлэлт гарахад хүндрэлтэй,
- Судалгааны II хэсэгт 11 аймаг, хотын 18-60 гаруй насны 562 хүнийг хамруулсан хэрэглэгчийн үнэлгээний судалгааг: 1. Соёлын байгууллагын орчны тохижилт тав тухтай байдлаар авахад маш сайн, сайн үнэлгээ 44,4% гарч байхад дунд, муу, маш муу үнэлгээ 55,6%-ийг эзэлж байгаа нь соёлын байгууллагын орчинд үйлчлүүлэгчдийн зүгээс сэтгэл хангалуун бус байна,
- Судалгааны III хэсэгт үр дүнгээс үзэхэд:
 - олон талт үйлчилгээ, үйлчилгээний цагийн хуваарь, үйл ажиллагааны талаар мэдээлэл авах боломж багатай, тоног төхөөрөмж хоцрогдсон байдал нь соёлын байгууллагын үйлчилгээ авахаас татгалзах шалтгааны 67.9% -ийг эзэлж байна.
 - Соёлын байгууллагаас авсан сүүлийн 3 жилийн үйлчилгээний чанарт 43.6% - ийг маш сайн, сайн, 56.4% -ийг дунд муу, маш муу гэж дүгнэгдсэн.
 - Нэмэлт үйлчилгээний чанарын тухай асуултад нийт хариултын 23% -ийг маш сайн, сайн, 77% -ийг дунд, муу, маш муу хариулт эзэлсэн байна.
- Судалгааны IV хэсгийн үр дүнгээс үзэхэд:
 - судалгаанд оролцогч соёлын ажилтнуудын 89.7% нь иргэдийн санал санаачилга, эрэлт хэрэгцээг тусгасан, соёлын бодлого, хөтөлбөрт нийцсэн, бүс нутгийн онцлогийг тусгасан үйл ажиллагааны зорилго чиглэлтэй байх нь илүү зохистой гэж үзсэн байна.
 - түүнчлэн судалгаанд оролцогчдын 30.9% төсвийн орлогыг 10-40%-иар, 11.8% нь 40% -иас дээш , 39% нь 10 хүртэл хувиар нэмэгдүүлж чаддаг хэмээн хариулжээ.

- Соёлын төвд зохион байгуулагдаж буй үйл ажиллагааны 56.4% урлаг, уран сайхан, номын сангийн үйл ажиллагаа, 43.6%-ийг бусад үйл ажиллагааны чиглэл эзэлж байна.
- Судалгааны Ү хэсгийн үр дүнгээс үзэхэд соёлын ажилтнуудын зүгээс хүн хүч, материаллаг баазын хүчин чадлын бодит боломжинд тулгуурлан зүтгэл гарган ажиллаж байгаа хэдий ч тодорхой хүчин зүйлүүдээс шалтгаалан үйлчилгээг чанартай хүргэхэд хүндрэл гарч буйг:
 - мөрдөгдөж буй эрх зүйг орчны тухайд судалгаанд оролцогчид хангалттай бус, шаардлага хангахгүй байгаа тул үнэлэх аргачлал, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, үнэлгээний арга тодорхойгүй тул шагнал, үр дүнгийн урамшууллын шатлал тодорхойгүй,
 - үйл ажиллагааг шударгаар үнэлэхэд үйлчлүүлэгчдээс хөндлөнгийн үнэлгээг авах нь зөв,
 - орон нутгийн өв соёлын агуулгыг шингээн илэрхийлсэн үйл ажиллагааг соёлын байгууллагууд бүтээлчээр эрэлхийлэн ажиллаж байна,
 - соёлын үйл ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд санхүүгийн болон мэргэжлийн хүний нөөцийн хангалтын зэрэг асуудлууд хүндрэл учруулж байна гэж үзжээ.

ТАВ. СОЁЛЫН ТӨВ, СОЁЛЫН ОРДНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ СТАНДАРТЧИЛАХ НЬ: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

V.1.Соёлын төв, соёлын ордны үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, өнөөгийн байдал.

Дэлхий дахиныг хамарсан даяаршлын үйл явц, технологийн дэвшлийн тэсрэлтэт эрин үе⁵¹, аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал зэрэг нь улс орны нийгэм, эдийн засаг соёл, оюуны амьдралд эрс өөрчлөлт гарах шинэ нөхцөл байдлыг буй болгож байгаа бөгөөд Монгол улсын хувьд юуны өмнө дараах стратеги зорилтыг дэвшүүлэн тавьж байна.

1. Дэлхийн хөгжлийн хандлагатай хөл нийлүүлэн нийтлэг жишгээр хөгжих, аж төрөх

⁵¹ Exponential growth of technology and Mongolian higher education policy. Undram Chinbat. UB impulse. 2019.11.28

2. Үндэсний өвөрмөц онцлог, өв уламжлалаа хадгалан үлдэх

Өөрөөр хэлбэл, ондоошин ялгарахын хажуугаар бас зэрэгцэн хөгжих стратегийн зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга замыг нэн даруй олох шаардлагатай болоод байна.

Өндөр хөгжилтэй улс орны тэргүүлэх бодлогын шинжээчид, судлаачид соёлын бодлогод зайлшгүй тусгах ёстой гурван зүйл байдгийг цохон дурдаад дараах зүйлүүдийг хамгийн түрүүнд хийх шаардлагатай гэж үзсэн байдаг.

Үүнд:

- Соёлын үнэлэмж, зорилго, бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох
- Дээрх зорилгыг хэрэгжүүлэх зорилтууд, санаачлага, хөтөлбөрүүд, эдгээрийн санхүүжилт
- Нийгэм соёлын үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг үнэлэхэд шаардлагатай тогтоосон стандартууд зэргийг хамруулж үзсэн байна.

Монгол улс ч нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болох зорилтуудыг дэвшүүлсэн бөгөөд соёл, бүтээлч үйлдвэрлэлийн салбар, тэр дундаа *аймаг нийслэл, сум дүүргийн болон бүс нутгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх зорилго бүхий орон нутгийн соёлын байгууллага*⁵² болох соёлын төвүүдийн өмнө үйл ажиллагааны болон удирдлага зохион байгуулалтын эрс шинэчлэл, өөрчлөлтийг хийх шаардлага, тулгамдсан хэрэгцээг буй болгоод байна.

Иймээс цаг үетэйгээ хөл нийлүүлж алхахын тулд соёл урлагийн салбар, тэр тусмаа энэ салбарт ажиллаж байгаа хувь хүн, байгууллага бүр одоо байгаа нөхцөл байдалдаа дүн шинжилгээ хийн, эрс өөрчлөлт шинэчлэлт хийх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Өнөөдөр Монгол улсад төсвийн санхүүжилттай, төрийн мэдлийн, нийт 88007 суудал бүхий 345 соёлын төвд 2385 хүн ажиллаж хүн ам, иргэдэд соёл чөлөөт цагийн болон соён гэгээрүүлэх гэх зэрэг олон төрөл, чиглэлт ажил үйлчилгээг хүргэж байна.


Төрийн мэдлийн дээр дурдсан соёлын төвүүдээс гадна төрийн байгууллагын харьяаны, аж ахуйн нэгж байгууллагын, олон нийтийн болон гадаадын хүмүүнлигийн байгууллагын, төрийн бус байгууллагын, хувийн хэвшлийн гэх мэт олон тооны соёл, чөлөөт цагийн, соён гэгээрүүлэх ашгийн бус болон ашгийн “соёлын төв”-ийн хэв маяг бүхий байгууллагууд нийгэмд өнөөдөр ажиллаж байгаа ч бид “Соёлын үйлчилгээний

⁵²Монгол улсын “Соёлын тухай хууль” 1996 он. III бүлэг. IV заалт. Соёл, урлаг шинэ нөхцөлд-VIII.УБ., 2017 он. 9-р тал.

хүртээмж” судалгааны хүрээнд төсвийн санхүүжилттэй, төрийн мэдлийн соёлын төв, ордныг хамруулан стандартын асуудлыг дэвшүүлэн тавьж байна.

Өнөөдөр манай улсын урлаг, соёлын байгууллагууд Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Инновацийн тухай хууль гэх зэрэг хуулиуд, тухайн салбарын үйл ажиллагаанд хамаарах олон улсын гэрээ, ерөнхийлөгчийн зарлиг, засгийн газрын тогтоол, чиг үүргийн яамны тогтоол зэрэг эрх зүйн орчинд үйл ажиллагаагаа явуулж байгаа ч соёлын төв /ордон/-ийн хувьд хорь гаруй жил чиг үүргийн төрийн захиргааны төв байгууллагаас гарган баталсан эрх зүйн орчны хүрээнд ажиллаж ирлээ.

Эдгээрт 1997 оны Гэгээрлийн сайдын баталсан “Сумын соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм” , 2011 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны /цаашид БСШУ-ны гэх болно/ сайдын баталсан “Соёлын төв, ордны үлгэрчилсэн дүрэм” -ийг баримтлан ажиллаж ирсэн байна.



Эх сурвалж: БСШУСЯ-ны захиргааны статистик. 2018 он.

Дээрх үлгэрчилсэн дүрмүүдийн дагуу соёлын төв гэх байгууллагыг тодорхойлж түүний үйл ажиллагаа, үйлчилгээний чиг үүргийг дараах байдлаар баталсныг хүснэгтээр харуулж байна.

Сумын соёлын төв

Хүснэгт №99

<p>Гэгээрлийн сайдын баталсан №100 “Сумын соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм” 1997 он</p>	<p>БСШУ-ны сайдын баталсан №83 “Соёлын төв, ордны үлгэрчилсэн дүрэм” 2011 он</p>
<p>Соёлын төв нь тухайн сумын хүн амд соёл, урлагийн үйлчилгээ хүргэх зорилго бүхий төрийн өмчийн орон нутгийн байгууллага мөн.</p>	<p>Сумын соёлын төв нь төр, олон нийт, иргэдийн сайн дурын байгууллагаас хүн амын дунд соёл, хүмүүжил, чөлөөт цагийн ажил явуулах түшиц газар, хүмүүсийн өсөн нэмэгдэж буй оюуны болон соёл, чөлөөт цагийн эрэлт хэрэгцээг хангах, тэдэнд мэдлэг,</p>

	боловсрол, хүмүүжил олгох, авьяас билгээ нээн хөгжүүлэхэд нь идэвхтэй туслах үүрэг бүхий орон нутгийн соёлын байгууллага мөн.
--	---

Соёлын төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэл /чиг үүрэг/

Хүснэгт №100

1997 №100	2011 №83
<ol style="list-style-type: none"> 1. Цуврал лекц 2. Уулзалт 3. Үдэшлэг 4. Өдөрлөг 5. Наадам 6. Ярилцлага 7. Ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн зохион байгуулах 8. Соёл чөлөөт цагийн үйл ажиллагаа 9. Аман болон үзүүлэнт мэдээлэл 10. Үзэсгэлэн сурталчилгаа 11. Гоо зүй урлаг уран сайхны дугуйлан 12. Хамтлаг, сонирхогчдын нэгдэл хичээллүүлэх 13. Уран сайхны хамтлаг, ардын театр, чуулга авьяастнуудын хэсэг байгуулан ажиллуулах 14. Урлагийн үзлэг 15. Ардын авьяастнуудын бага наадам, театрчилсан тоглолт зохион байгуулах 16. Концерт, жүжиг найруулан тоглуулах 	<p>Орон нутгийн түүх, соёлын өв, түүнийг өвлөн уламжлагч, тээгч, хүн амын уламжлалт ёс заншил, зан үйл, байгаль,цаг уурын онцлогтой холбогдолтой Бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, байнга баяжуулан, иргэдийн танин мэдэхүй, боловсрол, соёл, авьяас чадварын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа /10 багц/</p> <p>Дэлхийн жагсаалтад бүртгэж тунхагласан өвийн төрөл зүйлийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулах талаар гарсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх /5 багц/</p> <p>Иргэд ардын авьяастны дунд өглөөлөг, өдөрлөг, үдэшлэг, цэнгээн, уулзалт, ярилцлага, яриа, лекц, мэдээлэл, нэвтрүүлэг, урлаг спортын тоглолт, наадам, үзлэг уралдаан, тэмцээн, номын яармаг, үзэсгэлэн худдалдаа, зөөврийн номын, соёлын явуулын үйлчилгээ, сургалт, семинар/ соёл-чөлөөт цагийн олон талт үйлчилгээ /23 багц/</p>

<p>17. Хөдөөгийн хүн амд соёл урлаг ахуйн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх</p> <p>18. Музей, орон нутаг сурталчлах танхим ажиллуулах</p> <p>19. Зан үйл алдрын , гэрлэх болон бусад ёслолын танхим ажиллуулах</p> <p>20. Танин мэдэхүйн аялал, зугаалга зохион байгуулах</p> <p>21. Төрөл бүрийн спортын уралдаан тэмцээн, үзүүлэх сургууль зохион байгуулах</p> <p>22. Орон нутгийн мэдээлэлийн төвийн үүрэг гүйцэтгэж, хэвлэл мэдээллийн сурталчилгаа хийх</p> <p>23. Номын үзэсгэлэн, уншигчдын бага хурал, семинар, зөвлөгөөн хийх, иргэдийг номтой нөхөрлүүлэх, нүүдлийн номын сан ажиллуулах</p> <p>24. Дүрс бичлэгийн үйлчилгээ зохион байгуулах</p> <p>25. Түүхт ой, тэмдэглэлт үйл явдал, ардын ёс заншил, зан үйл хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах</p> <p>26. Амралт чөлөөт цагаар үйлчлэх төрөл бүрийн үйлчилгээг зохион байгуулах</p>	<p>Үндэсний уламжлалт болон хүүхдэд зориулсан урлаг, сонгодог урлагийг сурталчлан дэлгэрүүлэх, хадгалж хамгаалах чиглэлээр сургалт явуулах, хамтлаг хэсэг зохион байгуулах, соёлын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх /8 багц/</p> <p>Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх / 3 багц/</p> <p>Жилд 2-с доошгүй удаа соёлын нүүдлийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх /2 багц/</p> <p>Соёлын төвийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэж цаашид авах арга хэмжээг тодорхойлох /4 багц/</p> <p style="text-align: center;">Нийт: /55 багц/</p>
---	---

1997 оны Соёлын төвийн үлгэрчилсэн дүрмийн дагуу 26 чиг үүрэгтэй байсан бол 2011 оны дүрмээр 55 багц үйл ажиллагаа, үйлчилгээг орон нутгийн соёлын төвүүд гүйцэтгэх чиг үүрэг хүлээжээ. Ихэнх соёлын төвүүд өнөөдөр эрхлэгч, дуу, хөгжмийн багш, номын санч, үйлчлэгч гэсэн таван орон тоотой ажиллаж байгаа бөгөөд алдаг оног заримд нь нярав, соёлын өвийн мэргэжилтэний орон тоо байгаа билээ. Тав, зургаахан, тэгэхдээ дор бүрнээ ажлын байрны тодорхойлолтоор чиглэлийн бүлэг ажил хариуцсан

ажилтнуудтай соёлын төвүүд хичнээн орон тоотой байж энэ 56 багц нийгмийн чиг үүргээ бүрэн дүүрэн гүйцэтгэж чадах бол, өнөөдөр энэ чиг үүргээ гүйцэтгэх чадамж байна уу гэдэг нь өөрөө тулгамдсан асуудал болоод байна.

Мөн чиг үүргээ гүйцэтгэхтэй холбоотой ур чадвар, мэргэжлийн мэдлэг, мэргэшил шаардсан арга зүй, менежментийн тулгамдсан асуудлуудаас гадна өдөр дутам хийж, бодож, боловсруулж, төлөвлөж, тайлагнаж байх шаардлагатай байгууллагын захиргааны ажил үнэхээр их цаг шаарддаг билээ.

Бидний хийсэн “Соёлын үйлчилгээний хүртээмж” судалгааны хүрээнд хэрэглэгчээс авсан “**Та соёлын үйлчилгээ гэдгийг хэрхэн ойлгодог вэ?**” гэсэн асуултанд хариулсан байдлаар соёлын төв /ордон/-оос зохион байгуулдаг үйлчилгээ, эдгээр байгууллагуудын нийгмийн чиг үүргийг үйлчлүүлэгчид хэрхэн ойлгож байгаа хандлагыг тодорхойлж болно.

Асуулт: Та соёлын үйлчилгээ гэдгийг хэрхэн ойлгодог вэ?


Хүснэгт №.101

№	Соёлын үйлчилгээ	Тоо	Хувь
1	Эдийн засгийн үйл ажиллагаа	18	2
2	Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа	385	41.8
3	Урлагийн тоглолт	119	12.9
4	Үзвэр	84	9.1
5	Чөлөөт цагийн үйл ажиллагаа	111	12.1
6	Авъяасаа хөгжүүлэх үйл ажиллагаа	147	16
7	Бүтээн туурвих үйл ажиллагаа	57	6.2
	Хариулсан	541	96.3
	Хариулаагүй	21	3.7
	Нийт	562	100

Судалгаанд оролцогсдын 2% (18) нь эдийн засгийн үйл ажиллагаа, 41.8% (385) нь соён гэгээрүүлэх, 12.9% (119) нь урлагийн тоглолт, 9.1% (84) нь үзвэр, 12.1% (111) нь чөлөөт цагийн үйл ажиллагаа, 16% (147) авъяасаа хөгжүүлэх, 6.2% (57) бүтээн туурвих гэж хариулсан байна.

Дээрх хүснэгтийг бүдүүвчээр харуулбал:

Бүдүүвч №.104



Өөрөөр хэлбэл: Соёлын төв /ордон/-ийн нийгмийн чиг үүргийг

1. Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа
2. Авьяас ур чадварыг хөгжүүлэх
3. Урлагийн тоглолт
4. Чөлөөт цаг зохион байгуулах
5. Үзвэр
6. Бүтээн туурвих үйл ажиллагааг дэмжих
7. Ашиг олох үйл ажиллагаа гэж эрэмбэлсэн олон нийтийн хүлээлт байгааг харуулж байна.

Үүнээс гадна дээрх соёлын байгууллагад нийгмийн чиг үүргээ гүйцэтгэхтэй холбоотой бүтээгдэхүүн үйлчилгээнээс гадна захиргааны болон менежментийн үйл ажиллагаа зэрэгцэн явагддаг бөгөөд энэ ажил доголдвол бүх ажил үйлчилгээнд нь шууд болон дамаар нөлөөлөх магадлал өндөр юм.

Соёлын төвд хийгдэх ёстой үйл ажиллагаа

Хүснэгт №102

Чиг үүргээ гүйцэтгэхтэй холбоотой зарим асуудлууд	Захиргааны үйл ажиллагаа
-“Соёлын зөвлөл”-ийн үйл ажиллагааг зохицуулах	-Орон тоо, ажлын байртай холбоотой -Бүтэц, удирдлага зохион байгуулалт -Баримт бичиг боловсруулах

-Соёлын төвийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, стратеги,	-Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх
-Бүс нутгийн онцлог бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээ	-Төлөвлөлт түүнийг баталгаажуулах
-Үйлчилгээний түвшин	-Тайлагнах, түүний үр дүнг тооцох
- Явуулын үйлчилгээ	-Үр ашгийг хэмжих
-Дугуйлангийн үйл ажиллагаа	-Хамт олныг идэвхижүүлэх
-Өдөрлөг, уншлага, үзэсгэлэн гаргах хөтөлбөр, арга зүй, аргачлал, сэдэвчилсэн төлөвлөгөө	-Статистик мэдээллийг гаргах, мэдээлэх
-Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага	-Хүний нөөцийг судлах, мэргэшүүлэх, ур чадвар, мэргэшил дээшлүүлэх тогтолцоо
-Музейн үзмэрийн хадгалалт хамгаалалтанд тавигдах шаардлага	-Ажилтнуудын ажлын хариуцлага, нийгмийн баталгаа
-Соёлын өвийг бүртгэлжүүлэх, хадгалах, хамгаалах гэх мэт	-Ажил, амралтын цагийг зохицуулах
	-Байгууллагын санхүүгийн чадавхи,
	-Төсөл хөтөлбөрийн санхүүжилт
	-Байгууллагын орчин, нөхцөл, хангамж бүрдүүлэх гэх мэт

Хэрэглэгчийн соёлын үйлчилгээ гэдэг ойлголт хандлага, хүлээлт ийм байхад мөн л дээрх судалгааны хүрээнд соёлын төв, ордноор үйлчлүүлэхээс яагаад татгалздаг шалтгааныг нээлттэй хариултыг бүлэглэн гаргаж судалсан юм.

Асуулт 9.Таны Соёлын төв, ордноор үйлчлүүлэхээс татгалздаг шалтгаан юу вэ?

Хүснэгт №103

Соёлын төв, ордонгоор үйлчлүүлэхээс татгалздаг шалтгаан			
1	Үйлчилгээ хоцрогдсон	67	5.8%
2	Үйлчилгээний нэр төрөл хэт цөөн	126	11%
3	Цагийн хуваарь тохирдоггүй	172	15%
4	Гадаад орчны тохижилт муу	61	5.3%
5	Дотоод орчны тав тух муу	85	7.4%
6	Тоног төхөөрөмж хоцрогдсон	112	9.8%
7	Үйлчилгээний зохион байгуулалт тааруу	96	8.4%
8	Олон талт үйлчилгээ байхгүй	209	18.2%
9	Үйлчилгээний ажилтны харилцааны соёл муу	59	5.1%

Дээрх хүснэгтийг бүдүүвчээр харуулбал:

Бүдүүвч №105



Дээрх судалгаанаас үндэслэн хэрэглэгчид соёлын төв, ордноор үйлчлүүлэхээс цааргалдаг шалтгааныг эрэмбэлвэл:

1. Олон талт үйлчилгээ байхгүй
2. Цагийн хуваарь тохирдоггүй
3. Үйлчилгээний нэр төрөл хэт цөөн
4. Тоног төхөөрөмж хоцрогдсон
5. Үйлчилгээний зохион байгуулалт тааруу
6. Дотоод орчны тав тух муу зэрэг шалтгаануудыг нэр заан дүгнэлт өгсөн байна.

Дээрх, зөвхөн чиг үүргийн болон хэрэглэгчийн гэсэн хоёрхон судалгаанаас өнгөц харахад цөөхөн ажилтантай, олон талт ажил үйлчилгээг гүйцэтгэх чиг үүрэг бүхий соёлын төвийн үйл ажиллагаанд тулгамдаад байгаа асуудлуудыг чанарын удирдлагын тогтолцооны үүднээс шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлан цогцоор нь шийдвэрлэх шаардлага зайлшгүй үүсч байна.

Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлэх журам⁵³, Сумдын хөгжлийн загвар⁵⁴, номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага⁵⁵, гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс, музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага⁵⁶ гэх зэрэг эрх зүйн актуудад соёлын төвийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг үнэлэх, тэдгээрийн хүчин чадал, барилга байгууламжид тавигдах суудлын тооны шаардлага зэргийг хэсэгчлэн чанарыг хэмжих, стандарчилах оролдлого хэсэгчлэн тусгагдаж байсан ч асуудлыг шинжлэх ухааны үүднээс судлах, цогцоор нь шийдвэрлэлгүй явж ирсэн нь асуудлыг улам бүр гүнзгийрүүлж, хүндрүүлж иржээ гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.

V.2.Стандартчилал, стандартын тухай ойлголт

Соёлын төв /ордон/-ийн үйл ажиллагаа, үйлчилгээний хүртээмж нь ирээдүйн чанарыг бий болгохоос эхлэн уялдаа, холбоо, зохист холбоо харилцааг хангаж, чанарын тохиролд тэнцүүлэн, баталгааг хангах, итгэл үзүүлэх зөв тогтолцооноос ихээхэн хамаарна.

Чанарын талаарх багц асуудлын голыг нь олох, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргад үндэслэнэ гэдэг нь чанарын удирдлагын “нэг зоосны хоёр тал болох” стандарт, стандартчиллын асуудлыг зайлшгүй дэвшүүлэх асуудлыг хөндөж байгаа юм.

Соёлын төв /ордон/-ийн үйл ажиллагаа, үйлчилгээний өмнө тавигдаж буй дараах асуудлууд нь:

- ✓ Асуудлын мөн чанар юу вэ?
- ✓ Яг юунд нь төвлөрөл, эрэмбэлэл байх,
- ✓ Чухам юунаас эхэлж дуусгах,
- ✓ Уялдаа холбоог нь яаж хангах вэ?
- ✓ Олон улсын түвшинд нийцсэн ажил үйлчилгээ, бүтээгдэхүүнийг яаж гаргах вэ?
- ✓ Адил төстэй байгууллагуудтай өрсөлдөх чадварыг яаж буй болгох вэ?

шууд стандартчилалтай шууд холбогдох, нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлууд болоод байна.

⁵³ Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлэх журам. БСШУ-ны сайдын тушаал.2008 он

⁵⁴ Сумдын хөгжлийн загвар. Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоол.

⁵⁵ Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага. MNS 5742:2007

⁵⁶ Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс, музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS:5634:2006

Соёлын төв / ордон/-ийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, менежментийн тогтолцооны чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлчилгээ үзүүлэгчдийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон тулгамдсан асуудлуудыг стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэл гэсэн эрх зүйн үндсийг тогтоосноор зохицуулах боломжтой болох юм.

Стандартчилал⁵⁷ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний харилцан орлуулалт, мэдээлэл, техник, хэмжилт, сорилтын нэгдмэл, нийцтэй, аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтээр, дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагаа бөгөөд тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичиг бол стандарт юм.

Харин “техникийн зохицуулалт гэдэг нь бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, стандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг эш татаж, эсхүл тэдгээрийн агуулгыг тусгаж эрх бүхий байгууллагаас баталсан заавал дагаж мөрдөх баримт бичиг”-ийг хэлдэг.

Бид цаашид бүтээгдэхүүн гэсэн ойлголтонд соёлын төв /ордон/-ийн үйл ажиллагаа, иргэдэд үзүүлэх үйлчилгээний үйл явцад бий болсон үр дүнг хамааруулан авч үзэж байна.

Үүнээс гадна соёлын төв /ордон/-ийн стандартчиллын асуудлын хүрээнд тохирлын үнэлгээ буюу бүтээгдэхүүн, ажилтны ур чадвар, менежментийн тогтолцоо нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг зайлшгүй судлан үзэх шаардлагатай юм.

Ер нь онолын үүднээс стандартчилах бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг дараах байдлаар объектынх нь хувьд ангилан үздэг байна.

Стандартчилал /standardization,стандартизация/-ын мөн чанар нь бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг үйлдвэрлэх, цэгцлэх, эргэлтэд оруулах, түүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн, олон удаа ашиглагдах зориулалт бүхий дүрэм, журам ойлголтыг буй болгох сайн дурын үйл ажиллагаа гэдгийг цохон тэмдэглэж байна.

Хүснэгт №104

⁵⁷ Монгол улсын хууль.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай. 2017 он

Стандартчилах объект		
Бүтээгдэхүүн (өргөн хэрэглээний бараа, үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл):	Үйлчилгээ (ахуйн, үйлдвэрлэлийн):	үйл явц /ажил/
1. Түүхий эд байгалийн түлш	1. Биет	1. Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн бие даасан үе шатанд явагддаг үйл явц; бүтээгдэхүүн;
2. Бүтээгдэхүүн материал	2. Биет бус /нийгэм, соёлын/	
3. Бэлэн бүтээгдэхүүн	Нэг цогц үйлчилгээний бие даасан хүрээнүүд : - нэр томъёо; - техникийн шаардлага; - үнэлгээний арга; - Үйлчилгээ үзүүлэх нэгжийн ангилал; - ажилтнуудад тавигдах шаардлага.	
Нэг цогц үйл ажиллагааны бие даасан хүрээнүүд : - нэр томъёо, тэмдэглэгээ; - параметр ба хэмжээ; - техникийн шаардлага; - хяналтын арга; - хүлээн авах журам; - хаяглах, савлах, тээвэрлэх, хадгалах.		2. Биет бус үйлдвэрлэлтэй холбоотой үйл явц (статистик, банк, хэвлэлийн
		3. Удирдлагын үйл явц
		4. Хэмжих үйл явц
		5. Нягтлан бодох бүртгэл, мэдээлэл боловсруулах үйл явц
		6. Харуул, хамгаалах үйлдлийн үйл явц буюу процесс (хүн, экологи, байгаль орчин г.м)

Соёлын төв /ордон/-ийн стандартчилалд хамрагдах ёстой буюу хамаарах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ, үйл явцад дараах зүйл орох боломжтой.

Тухайлбал: Аливаа үйл ажиллагаа, үйлчилгээний хүрээ тус бүрийн чиглэл бүрээр ангилсан бие даасан зүйлүүд буюу үүнд:

- ✓ Соёлын төв /ордон/-ийн байгууламжийн ангилал /аж ахуйн нэгжийн ангилал/
- ✓ Соёлын төв /ордон/-ийн үйл ажиллагаа, үйлчилгээнд хэрэглэгдэх нэр томъёо, ойлголт, тэмдэглэгээ;
- ✓ Соёлын төв /ордон/-ийн үйл ажиллагаа, үйлчилгээг хэмжих нэгж ба хэмжээ;
- ✓ Соёлын төв /ордон/-ийн үйл ажиллагаа, үйлчилгээнд тавигдах техникийн шаардлага;
- ✓ Соёлын төв /ордон/-ийн үйл ажиллагаа, үйлчилгээг хянах, шинжлэх, үнэлэх арга, арга зүй;
- ✓ Соёлын төв /ордон/-ийн үйл ажиллагаа, үйлчилгээг хүлээн авах журам;
- ✓ Бүтээгдэхүүнийг нь хаяглах, савлах, тээвэрлэх, хадгалах журам
- ✓ Соёлын төв /ордон/-ийн ажилтнуудад тавигдах шаардлага.
- ✓ Бүтээгдэхүүн, үйлчилгээ
- ✓ Бүтээгдэхүүн, үйлчилгээний бие даасан үе шат бүхэнд явагддаг үйл явц гэх мэтчилэн.

Соёлын төв /ордон/-ийн үйл ажиллагаа, үйлчилгээнд стандартчиллыг нэвтрүүлэх буюу үүнээс, тухайлбал техникийн зохицуулалтыг холбогдох дээд байгууллагаар батлуулснаар дараах зорилгыг хангах боломжтой болох юм.

1. Иргэдийн амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахад,
2. Хувь хүн, хуулийн этгээдийн өмч, төрийн болон нийтийн өмчийн өмчийг хамгаалахад, Байгаль орчны аюулгүй байдлыг хангахад,
3. Амьтан, ургамлын амь нас, эрүүл мэндэд аюулгүй байдлыг хангахад,
4. техникийн зохицуулалтыг дагаж мөрдөх;
5. Онцгой байдлын үед үүсэх эрсдлийг харгалзан үзэхэд,
6. Байгууламжийн аюулгүй байдлыг хангах зэрэгт онцгой ач холбогдолтой.

Стандартчиллын нөгөө нэг тал , сайн дурын үйл ажиллагаа буюу олон удаа ашиглагдах зориулалт бүхий дүрэм, журам ойлголтыг баталснаар:

- Шинжлэх ухаан, технологийн дэвшлийг хангах;
- Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;
- Нөөцийг зохистой ашиглах;
- Техникийн болон мэдээллийн нийцэмж;
- Судалгаа (туршилт) ба хэмжилтийн үр дүнг техникийн болон эдийн засаг-статистикийн өгөгдөлтэй харьцуулах;
- Бүтээгдэхүүний харилцан хамаарал, уялдааг тодорхойлох зэрэгт эрс шинэчлэл хийх боломжийг бүрдүүлж байгаа юм.

Ер нь соёлын байгууллагын тэр тусмаа соёлын төв /ордон/-ийн үйл ажиллагаа, үйлчилгээнд стандартчиллыг бий болгосноор дараах нийгмийн чиг үүрэг хэрэгжинэ.

1. Дэс дараалалд оруулах, эмхлэх чиг үүрэг: /олон янзын утгатай, үндэслэлгүй, шаардлагагүй зүйлүүдийг цэгцлэх , давхардал, хийдлийг арилгах/
2. Хамгаалах чиг үүрэг :Бүтээгдэхүүн (үйлчилгээ) хэрэглэгч, үйлдвэрлэгч, төрийн аюулгүй байдлыг хангах, соёл иргэншлийн, технологийн нөлөөнөөс байгаль орчныг хамгаалах, үйлчлүүлэгч, амьтан, ургамлын амь нас, эрүүл мэндийг хамгаалахад хүний хүч чармайлтыг нэгтгэдэг.
3. Нөөцийг арвилан хэмнэх чиг үүрэг:санхүү, материал, эрчим хүч, хөдөлмөр, байгалийн зэрэг аливаа нөөц хязгаарлагдмал байдгаас шалтгаалан нөөцийн зарцуулалтад шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хязгаарлалт тогтоох ач холбогдолтой.

4. Харилцаа, холбооны чиг үүрэг: хувь хүний хоорондын харилцаа, нөлөөлөл, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар, техник хангамж (компьютер гэх мэт) систем, мессеж дамжуулах сувгийг ашиглан хүмүүсийн харилцаа холбоо, харилцан үйлчлэлийг хангадаг.
5. Нийгэмшүүлэх чиг үүрэг: бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг амьдралын чанарын нэг хэсэг болгон сайжруулахыг зорьдог.
6. Мэдээллийн чиг үүрэг: аливаа гэрээний гол нөхцөл болох бараа бүтээгдэхүүний чанарын талаарх хамгийн тохиромжтой стандарт үзүүлэлтийг буй болгодог.
7. Хэм хэмжээ тогтоох чиг үүрэг: стандартчиллын объекттой холбоотой хэм хэмжээ, шаардлагыг (дүрмүүд, параметрийн утга, хэрэгжүүлэх нөхцөл) тодорхойлж өгдөг.
8. Баталгаажуулах чиг үүрэг: тодорхой шаардлагад нийцсэн стандартууд нь бүтээгдэхүүн ажил үйлчилгээний нотолгоо болно.

Үндэсний стандартын төрлүүд

Бүдүүвч №106



V. 3. Соёлын үйлчилгээ, үйл ажиллагааг стандартчилах хэрэгцээ шаардлага /соёлын төвийн жишээн дээр/.

Салбарын яамны захиалгаар бидний хийсэн “Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга зам ⁵⁸” судалгааны хүрээнд экспертүүдээс судалгаа авахад доорх

⁵⁸ “Соёлын үйлчилгээний хүртээмж” экспертын судалгааны нэгтгэл. СУСХ. 2019 он

асуулгын хариулт, дүгнэлт нь соёлын төв, ордны үйлчилгээ, үйл ажиллагаанд стандарт, чанарын удирдлагын асуудлууд тулгамдаад байгааг бас дахин баталсан юм.

Сүүлийн жилүүдэд аймаг нийслэл, сум дүүргийн болон бүс нутгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх зорилго бүхий орон нутгийн соёлын байгууллага болох соёлын төвүүд олноороо ашиглалтанд орж байна. Энэ нь төрөөс, мөн салбарын яамны бодлого, үйл ажиллагааны үр дүн, орон нутаг дах соёлын үйлчилгээ, үйл ажиллагааны орчинд орж байгаа өөрчлөлг шинэчлэл юм. Тухайлбал Увс аймгийн 19 сумнаас 15 суманд, Өвөрхангай аймгийн 18 сумаас 7 -д нь соёлын төвийн шинэ барилга ашиглалтанд орж нутгийн иргэдээ баярлуулж, бахархуулсан үйл явдал болсон нь үнэхээр цохон тэмдэглүүштэй амжилт билээ.

Зураг№1



Өвөрхангай аймгийн Уянга сумын соёлын төв

Зураг№2



Увс аймгийн Зүүнговь сумын соёлын төв

Хэдийгээр бидний хувьд дээрх амжилт шинэ алхам ч, шинэ зүйлийг эхнээс нь л хэрэгцээ шаардлагад нийцсэнээр хийх нь хүн хүч, материал, нийгмийн ашигт цагийг үр бүтээлтэй, үр ашигтай ашиглахад шаардлагатайг доорх жишээгээр харж байна.

Жишээлбэл: Шинэхэн барилгаа дөнгөж хүлээн авангуутаа л бидний хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгаа зүйлийг нь засаж залруулах, шинээр нь дахин засвар хийх

шаардлагатай болсон нь соёлын төвийн байгууламжийн хувьд нийтлэг тулгамдсан асуудлууд болсон байна.

Энэ будаг нь ханхалсан шинэ соёлын төвд тулгамдаад байгаа бэрхшээл нь:

- Хоёр хажуу талаасаа өгсөж орох зориулалттай хийгдсэн “Тайзны шат”-аар алхаад тайз руу орж буй хүмүүст хөшиг, хөгжим, аппартур шууд тээглэх бэрхшээл үүссэн байна. Тиймээс тайзыг хааж “зай эзлэх” болсон тул чанга яригчдыг ханандаа байршуулжээ.

Уул нь шат тайзны дунд хэсгийн урдуур налж өгссөн маягтай хийсэн бол тохиромжтой байх аж.

Зураг№3



- Тайзны “шум”-ны буюу техникийн өрөө нь зүүн хажуудаа байрласан байна. Энэ нь лоожтой, 2 давхар, суурин сандалтай “бага театр” загварын соёлын төвд тохиромжгүй бөгөөд тайзаа голлосон байх нь чухал юм.

Аль ч талынхаа дуугаралтыг сайн тохируулж, жигд сонсгож байж, “соёл, урлагийн” гэж бидний нэрлээд байгаа үйлчилгээнээс үзэгчид сэтгэл ханамж авна шүү дээ. Бид урагшаа тайзан дээр хүн дуулах ч юм уу, жүжиг тоглох хөдөлгөөнийг харж суунгаа дууг нь араасаа, эсвэл хажуу талаасаа сонсвол “урлагийн” гэх тодотголтой үйл ажиллагааны ямар “эффект”-ийн тухай бид ярих билээ?

Зураг№4



- Танхимын суурин сандал босоо, налуу нь хэт бага байх тохиолдолд үзэгчид үзвэр үзэхдээ арын хүнээ халхлах бэрхшээл үүсчээ. Сандлууд маань шууд налуу бус эгнээ эгнээгээрээ шаталсан налуу байх нь зохимжтой гэдгийг барилгын зураг төсөл гаргагчид, түүнийг батлагчид, захиалагчид анзаараагүй нь харамсалтай.

Зураг№5



- “Театр загвар”-ын суурин бэхэлгээтэй сандалтай энэ соёлын төвд бүжгийн талбай байхгүй. Иймээс үүдний танхимаа бүжгийн талбай болгосон нь нэг удаадаа л гэхэд нийтийн бүжигт оролцох 150-200 хүний ачаалал даах хүчин чадал, пистуль-ийг тооцсон болов уу?

Зураг№6



“Соёлын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах арга зам” судалгааны “Олон улсын жишиг харгалзсан улсын стандарт боловсруулах нь соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад үр нөлөөтэй болно гэдэгтэй Та санал нийлэх үү?” гэсэн асуулгад экспертүүд доорх байдлаар хариулжээ.

Асуулт: “Олон улсын жишиг харгалзсан улсын стандарт боловсруулах нь соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад үр нөлөөтэй болно гэдэгтэй Та санал нийлэх үү?”

Хүснэгт №105

№		
1	Бүрэн санал нийлнэ	114
2	Зарим талаар санал нийлнэ	78
3	Санал нийлэхгүй	8
4	Мэдэхгүй	12

Соёлын салбарт болон төрийн захиргаанд соёлын салбарыг хариуцан ажилладаг, соёлын төвийн ажилтнууд, энэ байгууллагын үйл ажиллагааг мэддэг экспертүүдийн судалгаанаас харахад 91% нь стандарт хэрэгтэй гэдэгтэй санал нийлнэ, зарим талаар санал нийлнэ гэж хариулсан бөгөөд өнөөдөр соёлын төв /ордон/-ийн үйлчилгээ, үйл ажиллагаанд чанарын удирдлага, тэр тусмаа стандарт, стандартчилалын асуудал тун чухал байна гэсэн дүгнэлт гарч байна.

Бүдүүвч №107




Мөн соёлын төв /ордон/-ийн улсын стандарт боловсруулахад зайлшгүй тусгах доорх асуудлууд байна гэж экспертүүд үзсэн байна.

Асуулт: Соёлын төв /ордон/-ийн улсын стандарт боловсруулахад зайлшгүй тусгах ямар зүйл байна вэ?

Хүснэгт №106

№		
1	Зориулалтын байрны стандарт	146
2	Техник тоног төхөөрөмжийн стандарт	101
3	Хувцас жижиг хэрэглэлийн стандарт	50
4	Үйл ажиллагааны тайлан бичилтийн стандарт	37
5	Хариулаагүй	0

Бүдүүвч №108



Санал асуулгад оролцогсдын 69,5% зориулалтын байрны стандарт, 48,1% тоног төхөөрөмжийн стандарт, 23,8% хувцас, жижиг хэрэглэлийн, 17,6% үйл ажиллагааны тайлан бичилтийн стандарт шаардлагатай гэж үзжээ.

V. 4. Олон улсын жишиг стандартууд.

Аймаг нийслэл, сум дүүргийн болон бүс нутгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх зорилго бүхий орон нутгийн соёлын байгууллага⁵⁹ болох соёлын төв, соёлын ордонгуудын үйлчилгээ үйл ажиллагааг стандартчилахын тулд олон улсын жишиг стандартуудыг судалж үзэх шаардлагатай юм.

Даяршлын эрин, вертуал ертөнцөд хамтран ажиллаж буй хөрш орнууд аялал жуулчлалын хамаарал бүхий бүс болох түншлэлийн үүднээс манай улсын соёлын төв, соёлын ордны үйлчилгээ, үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн олон улсын жишиг стандартад дүйцэхүйц хэм хэмжээг судлан боловсруулах шаардлагатай юм.

Иймээс хөрш зэргэлдээ орон Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард улсын манай улстай зарим нэгэн нийгэм эдийн засаг, газар нутаг, үндэстэн угсаатны өвөрмөц онцлогоороо тухайн социумдаа эзэлж буй байр сууриараа төстэй, ойролцоо улсын соёлын төв, ордонтой дүйцэхүйц соёл урлагийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээнд тавигддаг нийтлэг шаардлагуудыг судалж үзсэн болно. Тухайлбал:

⁵⁹Монгол улсын “Соёлын тухай хууль” 1996 он. III бүлэг. IV заалт. Соёл, урлаг шинэ нөхцөлд-VIII.УБ., 2017 он. 9-р тал.

1. Оросын Холбооны Улс /цаашид ОХУ гэх болно/-ын 21 Бүгд найрамдах улсын нэг, Алс Дорнодын холбооны тойрог, Алс Дорнодын эдийн эдийн засгийн бүст хамаарах Бүгд Найрамдах Саха Улс буюу Якут⁶⁰
2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс /цаашид БНХАУ гэх болно/-ын Өөртөө засах 5 орны нэг болох Өвөр Монголын Өөртөө Засах Орон⁶¹-зэрэг улс түмний манай соёлын төв /ордон/-той адил нийгмийн чиг үүрэг бүхий байгууллагуудын зарим нэг нийтлэг стандартыг судаллаа.

Ингэхдээ

- Газар нутгийн өргөн уудам байдал
- Үндэстэн угсаатны бүлэг
- Аж ахуй эрхэлж ирсэн уламжлал зэрэг онцлог шинжийг харгалзан үзэж дээрх улс орны соёл чөлөөт цагийн байгууллагын үйл ажиллагаа үйлчилгээнд баримталдаг стандартчиллын асуудлыг жишиг болгон судалсан болно.

Бүгд Найрамдах Саха Улс буюу Якут

Хүснэгт.№107

Нэгж	Оросоор	Сахагаар	Тоо	Чиг үүргийн хувьд дүйцэх соёлын байгууллага
Хот	Городской округ	Куорат (хороо)	2	Соёлын ордон, Ардын урлагийн ордон
Аймаг	Муниципальный район	Улуус (улс)	32	Клубууд

ОХУ-ын Засгийн газрын газраас “Суурин газруудад соёл-чөлөөт цагийн байгууламж байх норматив хэм хэмжээ” -г тогтоосон эрх зүйн актыг батлан нийгмийн хөгжлийн хурдац, хүн амын эрэлт хэрэгцээтэй уялдуулан удаа дараа нэмэлт өөрчлөлт оруулан мөрдлөг болгож ирсэн байна. Тухайлбал: одоо ОХУ-ын Засгийн газрын газраас 1996 оны 1063-р тогтоолоор "Нийгмийн норм ба жишиг хэм хэмжээ" (нэмэлт өөрчлөлт оруулсан. 2007 оны №923-р, 2014 № 581-р, 2017 № 95-р тогтоолуудаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна.) соёлын байгууламжийг газар нутаг засаг захиргааны нэгжийн онцлогтой уялдуулан байгуулж байна.

⁶⁰ <https://mn.wikipedia.org/wiki/%D0%A1%D0%B0%D1%85%D0%B0>

⁶¹ <https://mn.wikipedia.org/wiki/%D0%91>

ОХУ-ын Саха улс (Якутия)-ын Засгийн газрын Тэргүүний тамгын газраар дэмжигдэн, тус улсын Оюуны хөгжил, соёлын яамны боловсруулсан “Орон нутгийн соёл, чөлөөт цагийн байгууллагуудын үйл ажиллагааны жишиг /модельный/ стандарт” нь 2017 оны 03 дугаар сарын 28 нд батлагдсан байна.

Энэ стандарт нь оршил, нийтлэг үндэслэл, соёл, чөлөөт цагийн байгууллагуудын үйл ажиллагаа, соёл, чөлөөт цагийн байгууллагуудын үйл ажиллагааны зорилго, зорилтууд, үндсэн чиглэлийг тодорхойлохын зэрэгцээ соёл, чөлөөт цагийн байгууллагуудын төрөл, үйл ажиллагаа, үйлчилгээ, үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, тухайн байгууллагын нөөцийн хангалтын тухай стандартчилж өгсөн байна.

Орон нутгийн соёл, чөлөөт цагийн байгууллагуудын үйл ажиллагаанд нөөцийн хангалтыг дараах чиглэлүүдээр стандартчилжээ. Үүнд:

1. Зохицуулалт, хэм хэмжээний нөөц
2. Материал ба техник хангамжийн нөөц
3. Мэдээллийн нөөц
4. Санхүүгийн нөөц
5. Хүний нөөц
6. Хууль эрх зүйн орчин

Бүгд Найрамдах Саха (Якутия) улсын соёл, чөлөөт цагийн байгууллагуудын үйл ажиллагааны жишиг стандарт (цаашид жишиг стандарт гэж нэрлэх болно) нь ОХУ, Саха (Якутия) улсын хууль тогтоомжийн хүрээнд боловсруулагджээ.

Жишиг стандарт нь Бүгд Найрамдах Саха (Якутия) улсын орон нутгийн соёл-чөлөөт цагийн байгууллага /цаашид СЧЦБ гэх болно/-уудыг байгуулах, байрлуулах, түүнийг эзэмших, засвар үйлчилгээ хийх, хүн амд соёлын үйлчилгээ хүргэх, соёлын үнэт зүйлсийг хүртэх, соёлын амьдралд оролцох, соёлын байгууллагыг ашиглах иргэдийн үндсэн эрхийг хангах, үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, нөөцөөр хангуулан дэмжлэг авах, үр ашгийг нь үнэлүүлж, дүгнүүлэх асуудлуудыг тусгасан байна.

Энэ жишиг стандарт нь дараах онцлогтой. Үүнд:

- Жишиг стандарт нь орчин үеийн нөхцөлд соёл, чөлөөт цагийн байгууллагуудын зохист үйл ажиллагааг хангахад шаардагдах хамгийн доод түвшний зайлшгүй шаардлагатай хэм хэмжээг агуулсан байна.
- Жишиг стандарт нь зөвлөх шинж чанартай бөгөөд Саха (Бүгд Найрамдах Якутия) улсын орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд оршин суугчиддаа соёл

чөлөөт цагийн үйлчилгээ үзүүлэх үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх, орон нутгийн төсвийн зарлагын ангиллыг төлөвлөх, төсвийг хуваарилан, хэрэгжүүлэх, хяналт тавихад ашиглах боломжтой болох юм.

ОХУ-ын Үндсэн хуульд заасны дагуу ОХУ-ын иргэд соёлын амьдралд оролцох, соёлын байгууллагуудаар үйлчлүүлэх, соёлын үнэт зүйлсийг хүртэх, мөн НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн зарчим, түүнчлэн “Соёлын тухай ОХУ-ын хууль тогтоомжийн үндэс” хуульд тус тус заасны дагуу Оросын холбооны ард түмэн, иргэд, үндэстэн, угсаатны бүлгүүд соёлын үнэт зүйлсийг хүртэх, соёлын амьдралд чөлөөтэй оролцох эрх зүйн баталгааг бий болгох эрхийг хуульчлан батлахын зэрэгцээ ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2014 оны 12-р сарын 24-ний өдрийн 808 тоот тушаалаар батлагдсан "Төрийн соёлын бодлогын үндэс"-д тодорхойлсон зарчмуудыг үндэслэн төрийн эрх мэдэл бүхий байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын эрх, үүрэг, бүрэн эрхийг дараах байдлаар зааж өгсөн байна. Үүнд:

1. Соёлын үнэт зүйлсийг хүртэх, соёлын амьдралд оролцох, соёлын байгууллагуудаар үйлчлүүлэх эрхийг хэрэгжүүлэхдээ иргэдийн нутаг дэвсгэр, нийгмийн тэгш байдлыг хангах;
2. Соёлын үйл ажиллагааны дэд бүтцийг хөгжүүлэх;
3. Жижиг хот, хөдөөгийн сууринд соёлын таатай орчныг бүрдүүлэх, тухайлбал кино-видео үзвэрийг ч хүртэл хамарсан клубын сүлжээг байгуулах;
4. Театр, концерт, үзэсгэлэнгийн танхимуудын хөгжсөн сүлжээг бий болгох;
5. Оршин сууж буй газраас үл хамааран иргэд тоон болон мэдээлэл харилцаа холбооны технологийн тусламжтайгаар соёлын үнэт зүйлсийг хүртэх боломжийг хангах;

Соёлын байгууллагуудын үйлчилгээний хүртээмжийг хангах талаархи ОХУ-ын эрх зүй, хэм хэмжээний зохицуулалтад ОХУ-ын соёлын байгууллагуудын сүлжээг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, тэдний аюулгүй байдлыг хангах хоёрын тэнцвэргүй байдлыг арилгах, соёлын байгууламж дахь субъектүүдийн зохицуулалтын хэрэгцээг тодорхойлох нэгдсэн аргачлал зайлшгүй хэрэгтэй байгааг цохон тэмдэглэсэн байна.

Мөн дараах нийтлэг үндэслэлийг дүрэмчлэн зааж өгсөн байна.

1. Соёл, чөлөөт цагийн байгууллага нь Саха (Якутия) улсын нутаг дэвсгэрт төрийн соёлын бодлогыг хэрэгжүүлэх, ОХУ-ын иргэдийн соёлын амьдралд оролцох, соёлын байгууллагыг ашиглах, соёлын үнэт зүйлсийг хүртэх үндсэн хуулинд заагдсан эрхийг хангах субъект бөгөөд нутгийн захиргааны байгууллагууд орон

нутгийнхаа соёлын салбарын асуудлыг шийдвэрлэх эрх мэдлийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан байна.

2. Соёл, чөлөөт цагийн байгууллага нь хуулийн этгээд бөгөөд ОХУ, Саха (Бүгд Найрамдах Улс) улсын хууль тогтоомж болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын хууль тогтоомж (тухайн орон нутгийн удирдлагын “Соёл, чөлөөт цагийн байгууллага байгуулах тухай” захирамж, соёл, чөлөөт цагийн байгууллагын дүрэм, журам гэх мэт)- ийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.
3. Соёл, чөлөөт цагийн байгууллагыг орон нутгийн өөрөө удирдах байгууллагын засаг захиргаа үүсгэн байгуулахаар заасан.
4. Соёл, чөлөөт цагийн байгууллагыг үүсгэн байгуулагч нь байр, ажилтан, аюулгүй байдал, галын аюулгүй байдал, үндсэн үйл ажиллагааг зохион байгуулах, тоног төхөөрөмж худалдан авахад зориулагдсан санхүүжилтийг шаардлагатай хэмжээгээр нь хариуцжээ.
5. Соёл, чөлөөт цагийн байгууллага нь нас, хүйс, үндэс угсаа, боловсрол, улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, нийгмийн байдлаас үл хамааран бүх иргэдэд үйлчилгээ үзүүлдэг бөгөөд зарим үйлчилгээний нэр төрөлд Холбооны улсын 2010 оны № 436-ФЗ тоот "Хүүхдүүдийн эрүүл мэнд, хөгжилд хор хөнөөлтэй мэдээллээс хамгаалах тухай" хууль болон болон бусад зохицуулалтын эрх зүйн актуудад заасны дагуу үйлчилгээ хүртэгч зарим иргэдийн насны байдлыг харгалзан хязгаарлалт тогтоосон байдаг.
6. Соёл, чөлөөт цагийн байгууллага нь орон нутгийн хүн ам, иргэдэд хамгийн тохиромжтой горимоор соёлын болон чөлөөт цагийн үйлчилгээ иж бүрэн үйлчилгээ үзүүлнэ гэжээ.
7. Соёл, чөлөөт цагийн байгууллагын үйлчилгээг иргэний эрх зүйн харилцааны бүх субъектүүд, тухайлбал: орон нутгийн засаг захиргаа, хуулийн этгээд болон хувь хүмүүс захиалан хүртэж болохыг заасан байна.
8. Соёл, чөлөөт цагийн байгууллага нь ОХУ болон Бүгд Найрамдах Саха Улс (Якутия)-д үйл ажиллагаа явуулдаг төрийн, олон нийтийн, ашгийн болон ашгийн бус байгууллагууд, байгууллага, аж ахуйн нэгж, нийгэм, шинжлэх ухаан, боловсролын байгууллагууд гэх зэрэг янз бүрийн байгууллагуудтай түншлэлийн найрсаг харилцааг бий болгон, хүн амд хүргэх үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэхэд анхаардаг.

9. Соёл, чөлөөт цагийн байгууллага нь зөвхөн хууль, дүрэм, журамдаа нийцсэн зорилгодоо чиглэсэн үйл ажиллагаа явуулах бөгөөд улс төр, шашин шүтлэг, ашиг хонжооны дарамт шахалтанд өртөхгүй байх ёстой гэжээ.

10. Соёл, чөлөөт цагийн байгууллага нь жил бүр үүсгэн байгуулагчдад хийсэн ажлын тайлан гаргаж, гүйцэтгэлийн чанарын болон тоон үзүүлэлт, хүлээн авсан санхүүгийн эх үүсвэрийн зарцуулалтыг тайлагнахаар заажээ.

Энэхүү жишиг стандартад дараах нэр томъёо, ойлголтыг ашигласан байна.

Соёлын ордон/ууд/: */Дома культуры/* - хүчин чадал, тоног төхөөрөмж, мэргэшсэн хүний нөөц зэргээрээ хамаагүй их, өндөр түвшний соёл, чөлөөт цагийн байгууллага юм. Гол шинж чанар нь үйлчилгээний өргөтгөсөн хүрээ, харьяа салбаруудтай байна. Соёлын ордон нь өөрийн оршин байгаа газар нутгийн суурьшмал газар буюу суурин төдийгүй соёлын ордон байхгүй бусад газарт үйлчлэхийн зэрэгцээ хөдөөгийн клубын хувьд арга зүйн зөвлөгөө өгдөг төв нь байна. Мөн тэдгээр нь хот, бүс нутгийн төвлөрсөн төв, тосгодод байрлага. Соёлын ордонуудыг хүн амын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, ардын урлал, сайн дурын уран сайханчдыг хөгжүүлэх, нийгэм соёлын санаачлага, эх оронч хүмүүжлийг төлөвшүүлэх зорилгоор байгуулагдсан болно. Соёлын ордон/ууд/ нь бие даасан хуулийн этгээд байна.

Ардын урлагийн Ордон (төв): */Дома народного творчества (центры)/* - Биет бус соёлын өвийг төрөл зүйл, угсаатны бүлгийн онцлог шинжээр нь хадгалж, хамгаалах, уламжлалт бүтээлч туршлага, ур чадварыг орчин үеийн бүтээлч үйл явцад нэгтгэх аргачлал боловсруулах, ардын урлагийн наадам, урлаг сонирхогчдын фестиваль, нийтийг хамарсан баяр зэрэг бүтээлч үйл ажиллагааг зохион байгуулах, арга зүйгээр хангах зорилго бүхий соёл чөлөөт цагийн байгууллага юм. Тэдгээр нь салбарынхаа хувьд арга зүйн төвүүд нь болох ба бусад талаараа Соёлын ордонтой адил байна.

Чөлөөт цаг: Чөлөөт цаг гэдэг нь хүмүүсийн янз бүрийн хэрэгцээг хангахад чиглэсэн, бие хүний чөлөөт цагаар зохион байгуулагддаг олон янз, төрөл бүрийн үйл ажиллагааны цогц юм. Соёлын чөлөөт цаг нь сэтгэл хөдлөл, соён гэгээрүүлэх хандлагатай байдгаараа онцлог юм. Чөлөөт цаг нь *нэгдүгээрт:* сонирхогчдын бүтээлч үйл ажиллагаа, хүмүүс хоорондын болон бүлгийн харилцааны идэвхтэй хэлбэр, *хоёрдугаарт:* соёлын янз бүрийн арга хэмжээний идэвхгүй хэрэглээ гэсэн төрөл зүйлд ангилагдана.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс: */инвалиды/-* бие махбодь, сэтгэц, оюуны болон мэдрэмжийн байнгын бэрхшээлтэй, тэдгээр бэрхшээлээсээ шалтгаалан бусадтай нэгэн адил нийгмийн амьдралд үр ашигтайгаар, тэгш оролцох боломж нь хязгаарлагдсан хүмүүс

Соён гэгээрүүлэх-мэдээллийн арга хэмжээ: /информационно-просветительское мероприятие/ Соёлын хүрээнд хүний мэдээлэл авах, оюуны бусад хэрэгцээг хангахад чиглэсэн, тусгай, төлөвлөсөн (түр хугацаагаар ч байж болно), эсвэл тухайн үйл явдалд бэлтгэсэн зориулалтын газарт /тодорхой нутаг дэвсгэр, түүний зэргэлдээх газарт тусгай байр, барилга байгууламжид/ зохион байгуулагддаг нийтийг хамарсан, соён гэгээрүүлэх томоохон арга хэмжээ

Клубын үйлчилгээ: /Клубная услуга/ Хүмүүний амьдралын чанар, сэтгэл ханамжийг дээшлүүлэх, тухайн хүн оюун санааны болон ёс суртахууны хувьд өөрийгөө тодорхойлоход түлхэц болох хүн амын бүтээлч идэвхи санаачлагыг хөгжүүлэх тодорхой үр дүнд чиглэсэн, хэлбэр агуулгын хувьд олон талт хуулийн этгээдийн, эсвэл хувь хүний соёл- чөлөөт цагийн үйл ажиллагаа юм.

Соёлын үйл ажиллагаа: /Культурная деятельность/ соёлын үнэт зүйлийг хадгалах, бий болгох, түгээх, өмчлүүлэх үйл ажиллагаа.

373	Нөөцийн дижитал сан (ТВ)	0.3	10	Массын соёл, биет бус соёлын өвийг агуулсан дижитал нөөц	Судалгааг CD хийх, онлайнаар ашиглахаар дискний массив боловсруулалт хийх, соёлын талаар мэдээлэл солилцох төслийг хэрэгжүүлэх зэрэг массын соёлын янз бүрийн уран зохиолын нөөцийг дижитал боловсруулалт хийх талаар дурьджээ. Олон нийтийн соёлын уран зохиолын нөөцийн дагуу дижиталчлах нөөцийн нийт хэмжээг тодорхойлно.
		0.2	8		
		0.1	5		
374	Дижитал үйлчилгээний үйл ажиллагааны тоо (зүйл)	3	10	Дижитал үйлчилгээнд онлайн сургалт, үзэсгэлэн, сургалт, тоон мэдээллийн эх үүсвэрийг ашиглан үйлчилгээ явуулах, зайны сургалт явуулах зэрэг үйлчилгээ орно.	2014 оны онлайн асуулгад суурилсан мэдээлэл.
		2	8		
		1	5		
411	党支部建设		10		2011 оноос хойш үнэлгээний жил дэх системийн хамгийн шилдэг намын салбар, уг хэсгийг оюун санааны соёл иргэншлийн барилгын дэвшилтэт нэгж гэж үнэлсэн бөгөөд нарийн бичгийн дарга нь энэ тогтолцооны маш сайн намын ажилтан (намын гишүүн) эсвэл намын гишүүнээр үнэлэгдэж, энэ системийн шилдэг намын гишүүнээр үнэлэгджээ.

					Салбарын ажилд дээрх шагнал байхгүй бол 5 оноо, салбар (эсвэл гишүүн) сахилгын зөрчилтэй бол 0 оноо авна.
412	Дунд түвшний	100	10	2014 оны дунд болон түүнээс дээш түвшний удирдах ажилтнуудыг жилийн эцсийн үнэлгээний “чадвартай” харьцаанд үндэслэн.	2014 онд дунд болон түүнээс дээш түвшний ажилтнуудын (музей төвшин, хэлтсийн орлогч зэрэг) жилийн эцсийн үнэлгээний жагсаалтыг гаргана.
	болон тэргүүлэх	90	8		
	боловсон хүчний ажлын түвшин (%)	80	5		
42	Захирал		20		
421	Захирлын чанар		10	Их дээд сургууль, номын санч эсвэл түүнээс дээш зэрэгтэй байх шаардлагагүй.	Кураторын үндсэн чанарууд нь улс төрийн чанар, соёлын чанар орно. Улс төрийн чанарын шаардлага нь боловсон хүчний "дөрвөн модернизация" стандартад нийцсэн байх, мэргэжлийн ур чадварын хүчтэй мэдрэмж, ажлын ардчилсан хэв маяг, олны анхаарлыг татах гэх мэт зүйлсэд нийцсэн байх; соёлын чанар нь коллежийн боловсрол эсвэл түүнээс дээш зэрэг шаарддаг.
422	Захирлын иж бүрэн үнэлгээ		10	2014 оны жилийн эцсийн үнэлгээний үр дүнд үндэслэн тэрээр 8 оноотой, 10 оноотой, үндсэн болон доороос доош мэргэшээгүй байна.	Оноо нь 2014 оны жилийн эцсийн захирлуудын үнэлгээний үр дүн эсвэл нэгжийн үнэлгээний үр дүнгээс хамаарна. Нэгжийн үнэлгээ маш сайн, дэвшилтэт байдаг тул үүнийг кураторын хувийн онцлох үнэлгээ гэж үзэж болно.
43	Төрөл бүрийн дүрмийг		30		

	боловсруулж хэрэгжүүлэх				
431	Удирдлагын янз бүрийн системийг бий болгох, сайжруулах (аюулгүй байдал, аюулгүй байдлын системийг оруулаад)		15		Шуудангийн менежмент, бизнесийн удирдлага, зорилтот удирдлага, боловсон хүчний менежмент, санхүүгийн өмчийн менежмент, аюулгүй байдал, онцгой байдлын менежментийн шаардлагыг бүрэн хангасан. Дүрэм, журмын 2011-2014 оны шинэчилсэн найруулга 50 хувь хүрэх шаардлагатай байна. 2 оноо хасч байгаа. Төрөл бүрийн зохицуулалтын текстийг өгөх.
432	Системийн гүйцэтгэл		15		Системийн хэрэгжилтийн тайлан, системийн хэрэгжилтийг тусгасан хурлын тэмдэглэл, 2011-2014 оны жилийн эцсийн аудитын үр дүнгийн тайланг гаргаж өгөх. Хэрэв системийн хэрэгжилт сайн байгаа бөгөөд дээрх мэдээлэл бүрэн хийгдсэн бол төгс оноог авах боломжтой. Хэрэв мэдээлэл дутуу байвал 5-10 оноог хасна.
44	Масс сэтгэл ханамжийн түвшин		30		

441	Олон нийтийн эрэлт, санал хүсэлтийг хангах механизмыг бий болгох		10	Вэбсайт дээр санал хүсэлтийн багана байрлуулах, санал өгөх хайрцгийг байрлуулах, утсыг олон нийтэд хяналт тавих, захирлын хүлээн авах өдрийг товлох, олон нийтийн форумыг тогтмол зохион байгуулах, олон нийтийн санал хүсэлтийг авах механизмыг бий болгох. Зүйл тус бүрт 2 оноо.	Холбогдох материал эсвэл уулзалтын протокол шаардлагатай.
442	Соёлын төвийн ажилд олны сэтгэл ханамж (%)	90	20	Гуравдагч этгээдийн үнэлгээг соёлын захиргааны хэлтэс олон нийтийн сэтгэл ханамжийн судалгааг явуулдаг бөгөөд гаргасан асуулгад хамрагдах хүмүүсийн тоо 200-аас доошгүй, нөхөн сэргээх түвшин 80% -иас багагүй байна.	Үнэлгээний байдал, шалгалтын дүгнэлт өгөх. Сэтгэл ханамжийн судалгааны асуултыг Хавсралт 5-т харуулав.
		85	15		
		80	10		
5	Үзүүлэлтийг сайжруулах		50		
51	2011 оноос хойш Соёлын яамны нэрэмжит, сайшаалтай		7	Үүнд үндэсний соёлын системийн дэвшилтэт хамтын нийгэмлэг (хувь хүн), Соёлын яамны "Одон шагнал" (бүтээл, төсөл, хамтлагийн одууд орно) болон бусад нэр, хүлээн	Ялагч болох тухай нотлох баримтыг өгөх.

				зөвшөөрөлт, соёлын музейн дүрийн шагналууд болон бусад шагналууд орно.	
52	2011 оноос хойш намын дээд хороо, засгийн газраас энэ цолыг хүртсэн.		5	Энэ нь соёлын дээд түвшний байгууллага, түүний дотор хамт олон, хувь хүн гэсэн цолыг олгодог.	
53	Шинэчлэл, үйлчилгээний инновацийн анхны үр дүн		5	Орчин үеийн нийтийн соёлын үйлчилгээний тогтолцоог бий болгох талаар 18-р төв хорооны 3-р чуулганы хуралдааны шаардлагыг биелүүлж, компанийн засаглалын бүтэц, салбарын салбарын тогтолцоо, стандартчиллын бүтээн байгуулалтын тодорхой чиглэлд шинэчлэл, шинэчлэлийг хийлээ.	
54	Брэнд арга хэмжээ эсвэл онцлох төслийг боловсруулах		5	Брэндийн үйл ажиллагаа эсвэл онцлох төслүүд нь гурван жилийн турш тасралтгүй явагддаг, бүхэл бүтэн эрх мэдлийг хамарсан, өргөн нөлөөг бий болгож, олон нийтэд түгээмэл байдаг үйл ажиллагаа,	2011 оноос хойш брэндийн арга хэмжээнд (эсвэл онцлох төслийг боловсруулах) тусгай материал бүрдүүлэх шаардлагатай.

				төслийг хэлнэ. Дор хаяж 3 брэнд арга хэмжээ, төсөл шаардах.	
55	Соёлын танхимын үйлчилгээнд нийгмийн хөрөнгө татах		15	Соёлын төвийн үйлчилгээнд нийгмийн хөрөнгө татахаас гадна 100,000 юаниас 5 оноо, 100,000 юаниас дээш, нэмэлт 10,000 юань тус бүр 1 оноо авахад хамгийн дээд тал нь 15 цэгээс хэтрэхгүй байна.	Нийгмийн санг татахдаа ивээн тэтгэх, хамтын ажиллагаа гэх мэт санхүү, тоног төхөөрөмж болон бусад зүйлийг багтаасан болно (үүнийг хөрвүүлж болно).
56	Тусдаа барилга, барилгын талбай		10	Хэрэв барилгын талбайн хэмжээ нь хамгийн дээд хэмжээнээс давсан бол 500 хавтгай дөрвөлжин метр тус бүр 5 оноотой бол дээд хэмжээ нь 10 цэгээс хэтрэхгүй байх ёстой.	
57	Ахлах ажилтнууд		3		

V.5. Дүгнэлт, санал.

Соёлын үйлчилгээний хүртээмжийн судалгааны хүрээнд БСШУСЯ буюу захиалагчаас өгөгдсөн даалгавар ёсоор Соёлын төв, соёлын ордны орчин, хүний нөөц, үйлчилгээнд тавигдах олон улсын жишиг стандартыг судлан стандартчилах үйл ажиллагаанд шаардлагатай дараах санал дүгнэлтийг гаргаж байна.

Соёлын төв / ордон/-ийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, менежментийн тогтолцооны чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлчилгээ үзүүлэгчдийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон тулгамдсан асуудлуудыг стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэл гэсэн эрх зүйн үндсийг тогтоосноор зохицуулах боломжтой болох юм.

Стандартчилал нь бүтээгдэхүүн, үйлчилгээний харилцан орлуулалт, мэдээлэл, техник, хэмжилт, сорилтын нэгдмэл, нийцтэй, аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтээр, дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагаа бөгөөд тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичиг бол стандарт юм.

Харин “техникийн зохицуулалт гэдэг нь бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, стандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг эш татаж, эсхүл тэдгээрийн агуулгыг тусгаж эрх бүхий байгууллагаас баталсан заавал дагаж мөрдөх баримт бичиг”-ийг хэлдэг.

Үүнээс гадна соёлын төв /ордон/-ийн стандартчиллын асуудлын хүрээнд тохирлын үнэлгээ буюу бүтээгдэхүүн, ажилтны ур чадвар, менежментийн тогтолцоо нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг зайлшгүй судлан үзэх шаардлагатай юм.

Ер нь онолын үүднээс стандартчилах бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг дараах байдлаар объектынх нь хувьд ангилан үздэг байна.

Стандартчлал /standardization, стандартизация/-ын мөн чанар нь бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг үйлдвэрлэх, цэгцлэх, эргэлтэд оруулах, түүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн, олон удаа ашиглагдах зориулалт бүхий дүрэм, журам ойлголтыг буй болгох сайн дурын үйл ажиллагаа гэдгийг цохон тэмдэглэж байна.

Соёлын төвөөс үзүүлэх үйлчилгээний хувьд нэр томъёо, үндсэн ойлголтууд, тэмдэглэгээг тодорхойлох, явуулын үйлчилгээ, дугуйлангийн ажилд тавигдах шаардлага, тэдгээр ажил үйлчилгээнд шаардагдах техник, материал хангамжийн нөхцлийг тодорхойлох, ажилтнуудад тавигдах байгууллагын хэм хэмжээг тодорхойлох,

харин байгууллагын үйл ажиллагааны хувьд удирдлага зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ажил амралтын цагийг зохицуулах, үйлчлүүлэгч хүлээн авах журам, төлөвлөлт, тайлагналт, бүртгэл мэдээлэл боловсруулах, үр дүнг үнэлэх хяналтын арга гэх зэрэг үйл явцыг хэмжихүйц болохоор стандарчилах нь соёлын төвийн үйлчилгээ үйл ажиллагааг чанарын шинэ шатанд гаргах боломжийг бүрдүүлэх юм.

Мөн соёлын төвийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулахад аль хэсгийг нь техникийн зохицуулалтаар, ямар үйл ажиллагааг стандартаар зохицуулж болохыг харуулахын тулд техникийн зохицуулалт, стандарт гэсэн хоёр ойлголтын зарчмын ялгааг доорх хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт №

Баримт бичиг	Статус	Зохицуулах объект	Ашиглалтын мөн чанар	Ашиглаж буй контент /зохицуулалтын асуудал/		Нийгмийн үүрэг
				Баримт бичигт / бүхэлд нь/	Бүтээгдэхүүнд	
Техникийн зохицуулалт	Эрх бүхий байгууллагаас баталсан	Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг ба үйл явц	Заавал биелэгдэх	1.Бүтээгдэхүүн, үйл явцын жагсаалт 2. Таних тэмдэг, журам 3. Шаардлага. Тохирлын үнэлгээ хийх дүрэм, хэлбэр	1.Бүтээгдэхүүн, түүний буй болох үйл явцын аюулгүй байдлын шаардлага 2.Хаяг, тэмдэглэл, баглаа боодол, дагалдах баримт бичигт тавигдах шаардлага	Аюулгүй байдал
Стандарт	Стандартчил -лын баримт бичиг	Ажил, үйлчилгээ, үйлдвэрлэл, үйл явц	Сайн дурын үндсэн дээр	Техникийн шаардлага	/Хэрэглээний/ Техникийн бүх шинж чанарт тавигдах шаардлага	Өрсөлдөх чадвар

Тухайлбал аюулгүй байдлын тухай стандартчилал нь бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээ, тэдгээрийн бүх мөчлөгт хамаатай бөгөөд **түүнийг техникийн зохицуулалтаар шийдвэрлэн эрх бүхий байгууллагаас баталсан, заавал биелүүлэх шинж чанартай хэм хэмжээ** байдаг.

Соёлын төвийн барилга байгууламжид /үүнд: тайз, хөшиг, үзэгчдийн суудал зэрэг нь үзэгчдэд болон тэнд ажиллаж, ажил үүргээ гүйцэтгэж буй мэргэжилтнүүдэд ч аюулгүй байх/ баримтлах аюулгүй ажиллагааг хангахад чиглэгдсэн **техникийн**

зохицуулалт хэрэгтэй бөгөөд энэ нь зөвхөн төрийн соёлын байгууллагад хэмээн хязгаарлагдахгүй үзэгчид иргэд рүү чиглэсэн соёл чөлөөт цагийн үйлчилгээ, үйл ажиллагаа явуулдаг бүх хэвшлийн байгууллагын заавал мөрдөх хэм хэмжээ байх ёстой юм.

Техникийн зохицуулалтын зорилго нь хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад оршиж, түүнийг нийтээр заавал дагаж мөрдөх учиртай юм.

Төр, олон нийт, иргэдийн сайн дурын байгууллагаас хүн амын дунд соёл, хүмүүжил, чөлөөт цагийн ажил явуулах түшиц газар, хүмүүсийн өсөн нэмэгдэж буй оюуны болон соёл, чөлөөт цагийн эрэлт хэрэгцээг хангах, тэдэнд мэдлэг, боловсрол, хүмүүжил олгох, авьяас билгээ нээн хөгжүүлэхэд нь идэвхтэй туслах үүрэг бүхий орон нутгийн соёлын байгууллага⁶⁴ болсон соёлын төв нь стандартчиллыг нэвтрүүлснээр:

- Олон янзын утгыг нэг ойлголтонд оруулж, үндэслэлгүй, шаардлагагүй зүйл, үйл ажиллагааг цэгцлэх, давхардал, хийдлийг арилган дэс дараалалд оруулж, эмхлэх боломжтой болно.
- Үргэлж хязгаарлагдмал байдаг материал, эрчим хүч, хөдөлмөр, байгалийн болон бусад нөөцийн зарцуулалтад шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хязгаарлалт тогтоон арвилан хэмнэх боломжийг нэмэгдүүлнэ.
- Соёлын төвийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг үйлчлүүлэгчид, бас ажиллагсдын амьдралын чанарын нэг хэсэг болгон сайжруулж нийгэмшүүлэх боломжийг буй болгоно.
- Соёлын төвийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанарын талаарх хамгийн тохиромжтой үзүүлэлтийг стандартчилан тодорхойлсноор ямар ч гэрээ хийсэн гэрээний гол нөхцөл нь тодорхой байх ач холбогдолтой болно.
- Соёлын төвийн ажил, үйлчилгээний стандартчиллын объектыг тодорхойлж, тэдгээртэй холбоотой хэм хэмжээ, шаардлагыг (дүрмүүд, параметрийн утга, хэрэгжүүлэх нөхцөл) тодорхойлох боломжийг нээнэ.
- Мөн тодорхой шаардлагад нийцсэн стандартууд нь бүтээгдэхүүн ажил үйлчилгээний нотолгоо, баталгаажуулалт болно.
- Хүмүүсийн хоорондын харилцаа, нөлөөлөл, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар, техник хангамжийн систем, мессеж дамжуулах суваг зэргийг нэг

⁶⁴ Сумын соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм. БСШУ-ны сайдын тушаал №83. 2011 он. 1-р хавсралт

голдрилд оруулан хүмүүсийн ажил хэрэгч, төвөггүй харилцаа холбоо, харилцан үйлчлэлийг буй болгоно.

- Хамгийн гол нь бүтээгдэхүүн (үйлчилгээ) хэрэглэгч, үйлдвэрлэгч, төрийн аюулгүй байдлыг хангах, соёл иргэншлийн, технологийн нөлөөнөөс байгаль орчныг хамгаалах, үйлчлүүлэгч, амьтан, ургамлын амь нас, эрүүл мэндийг хамгаалахад хүний хүч чармайлтыг нэгтгэсэн хамгаалалтын механизмыг бий болгоно.
- Соёлын төвийн дэргэд ажилладаг номын сан, орон нутаг судлах танхимын үйл ажиллагааны чиглэл, үндсэн чиг үүргийг тодорхойлж аймгийн хэмжээнд ажиллаж буй тодорхой чиг үүргийн музей, номын сангаас ялгарах онцлогийг нь харгалзан тусгай жишиг хэм хэмжээ гарган стандартчилан зохицуулж өгөх шаардлагатай.

Харин соёлын төвийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг өөрсдөө баталсан дүрэм журмаар зохицуулахаар бүтээгдэхүүн үйлчилгээний үйл явцыг нарийн эрэмбэлж, удирдлага, менежментын аргыг хэрэглэх боломж нээлттэй байгааг анхаарах хэрэгтэй гэж үзэж байна.

Ер нь цаашид чиг үүргийн яам буюу БСШУСЯ-ны зүгээс аймаг нийслэл, сум дүүргийн болон бүс нутгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх зорилго бүхий орон нутгийн соёлын байгууллага болох соёлын төвүүдийн үйл ажиллагааны болон удирдлага зохион байгуулалтын эрс шинэчлэл, өөрчлөлтийг хийх шаардлага, тулгамдсан хэрэгцээг үндэслэн тэдний үйл ажилагаанд чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх эхний алхам болох стандартчиллыг цогцоор нь нэвтрүүлэхийн тулд энэ дээрх сэдвээр шинжлэх ухааны судалгааг хийж, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх саналыг дэвшүүлж байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт

Соёлын төв, ордон нь иргэдэд соёлын үйлчилгээ үзүүлдэг, хувь хүн болон нийгмийн оюун санаа, бие бялдар, өв соёл, уламжлалыг дээдлэн хөгжүүлэхэд чухал үүрэг, ач холбогдолтой байгууллага юм.

Иймд соёлын үйлчилгээ, үнэлгээний эрх зүйн таатай орчин, нөхцлийг бүрдүүлэх, хангах, ажилтан, ажиллагсдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг тогтмол

явуулж байх, төр засгийн бодлого, баримт бичгүүдтэй танилцах сургалт, лекц, семинар зохион байгуулж байх нь цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой юм.

Мөн энэ чиглэлийн сургалтын үйл ажиллагаанд соёлын ажилтнуудын оролцоо ихээхэн сул байгаа нь манай экспертийн судалгаанаас ажиглагдсан юм.

Соёлын төв, ордны соёл, чөлөөт цагийн үйл ажиллагааны өнөөгийн түвшинд хэрэглэгчид сэтгэл хангалуун бус байгаа бөгөөд тогтмол зохион байгуулдаг соёл, чөлөөт цагийн үйл ажиллагаа төлөвлөлт зохион байгуулалт, чанар хүртээмж зохих түвшинд хүрэхгүй байна. Иймд соёл, чөлөөт цагийн агуулга, хэлбэрийн хувьд хэрэглэгчдийн өнөөгийн хүсч буй хэрэгцээ шаардлагыг цаашид нарийвчлан судалж, зорилтот зах зээлээ өргөжүүлэн тэлэх чадвар бүхий үйл ажиллагаа, үйлчилгээ болгон өргөжүүлэх шаардлага байна.

Нэг. Орон нутгийн удирдлага нь тухайн орон нутгийн онцлогт тулгуурлан соёл урлаг, соёлын өвийг хадгалж хамгаалах чиглэлийн хөтөлбөрийг ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэх, соёл, урлагийн байгууллагын ажиллагсдыг мэргэшүүлж, тэднийг чадваржуулахын төлөө дэмжиж ажиллах, соёлын өвийн брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, соёлын биет болон биет бус өвийн бүртгэл мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулж, хүүхэд багачууд, иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг олон талт ажлыг зохион байгуулах удирдлагаар хангах шаардлагатай байна.

Соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад нэн тэргүүнд шийдвэрлэх зүйл нь санхүүжилт нэмэгдүүлэх, хүний нөөцийн тогтвортой ажиллах нийгмийн баталгааг хангах, төрийн бодлогын зохицуулалтыг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах давтан сургалтыг тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

Үүнд: Мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах зэрэг сургалтыг сургалтыг зохион байгуулах шаардлагатай. Ялангуяа бүс нутгийн онцлог бүхий уран сайхны язгуур соёлын хичээлийг ардын авъяастнаар заалгаж, тэднийг заах арга зүйд сургах мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах нь СББӨ-ийг өвлөн уламжлуулах тухай ЮНЕСКО-ийн конвенцийг хангахад чухал хүчин зүйл болно. Мөн соёлын төвийн менежерүүдийг “Соёлын боловсрол” олгох сургалтанд хамруулах гэх мэт/.

Мөн соёлын ажилтнууд мэргэжлийн ур чадвараа сайжруулах, сургалтанд хамрагдах, аттестатчлалаар зэрэг дэвээ тогтоож цалин урамшууллын систем тодорхой болгохыг онцлон тэмдэглэж байв.

Цаашид соёлын төв, ордонд ажиллах хүний нөөцийн асуудалд анхаарах, ялангуяа мэргэжил боловсрол, ур, чадвар эзэмшүүлдэг их дээд сургуулийн сургалтын агуулгыг сайжруулах шаардлагатай байна.

Ярилцлагын судалгаанд орон нутгийн онцлог, түүх, соёлын уламжлалыг илэрхийлсэн үйл ажиллагааг бүтээлчээр эрэлхийлэн ажиллаж байгаа тухай олон баримтуудыг дурдсан нь соёлын төв, ордны дэвшилт тал болж байна.

Мөн ихэнх соёлын төв жил бүр хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байгаа нь сайшаалтай юм.

Орон нутгийн соёлын төвүүдийн орчны болон үйл ажиллагааны стандарт байхгүйгээс шалтгаалан хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн шалгуур үзүүлэлт гарахад бэрхшээлтэй байна.

Хоёр. Соёл, чөлөөт цагийн үйл ажиллагааны хэлбэр үр өгөөжтэй байвал оролцоо нэмэгдэх тул зохион байгуулж буй ажлын хэлбэр, агуулга, аргаа шинэчлэх хэрэгцээ шаардлага байгааг анхаарах нь зүйтэй.

Үйлчилгээний бодит гүйцэтгэл, хүлээлтийн харьцуулалтын үр дүнд сэтгэл ханамж бий болно. Хүлээлт хангагдсан тохиолдолд үйлчлүүлэгч сэтгэл ханамжтай, эсрэг тохиолдолд сэтгэл ханамжгүй байдаг. Энэ үүднээс иргэдээс соёлын үйлчилгээг сайжруулахад тэдний санаа бодлыг судалж, эрэлт хэрэгцээнд тулгуурлах хандлагыг дэмжиж эрчимжүүлэх. Энэ хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчлөхийн тулд юун түүрүүнд удирдлага зохион байгуулалтын түвшинд шинэ арга, хэлбэрийг нэвтрүүлэх, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэн хөгжүүлэх хэрэгтэй юм.

Гурав. Соёлын ажилтнуудын зүгээс хүн хүч, материаллаг баазын хүчин чадлын бодит боломжинд тулгуурлан сайн ажиллаж байгаа боловч тодорхой хүчин зүйлээс шалтгаалан үйлчилгээг чанартай хүргэж чадахгүй байна. Судалгаанд оролцогчид одоо мөрдөгдөж буй эрх зүйн орчны тухайд хангалттай бус, шаардлага хангахгүйг илэрхийлэхийн зэрэгцээ үнэлэх аргачлал, шалгуурыг боловсронгуй болгох нь зөв зүйтэй гэж үзэж байна. Тухайлбал, Орон нутгийн –Аймгийн-Хотын гэх мэтээр үнэлгээний шалгуур үзүүлэлтийг ялгаатай тогтоох. Үнэлгээний арга тодорхойгүй тул шагнал, үр дүнгийн урамшууллын шатлал болон шалгуур тодорхойгүй байна.

Дөрөв. Соёлын төв, ордны дуу, хөгжим, бүжгийн дугуйлан хичээллэх заал талбай, үзвэрийн танхим, номын сангийн зай талбайн хүртээмж дунд зэрэг, тохижилт хангалтгүй, хашаа, хаягжилт, мэдээллийн самбар, цэцэрлэгжүүлэлт зэрэг гадна тохижилт, арчилгаа, техник хэрэгсэл хангалтгүй, ариун цэврийн өрөө, өлгүүрийн үйлчилгээ муу гэсэн үнэлгээ өгсөн байна.

Соёлын төв, ордны барилга шинээр баригдаж байгаа нь сайшаалтай боловч стандартын шаардлага хангасан нь цөөн байна. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Тарагт сумын соёлын төв, Увс аймгийн Тэс сумын соёлын төв зэргийг нэрлэж болно.

Мөн Өвөрхангай аймгийн соёлын төвийн барилгын зураг төслийг хийхдээ мэргэжлийн байгууллагатай зөвлөлдсөний үндсэн дээр барьсан тул харьцангуй стандартын шаардлагыг хангахуйц барилга боловч барилгын явц дунд зарим нэг зүйл өөрчлөгдсөнөөр дахин засварлах шаардлага гарч байгаагаас харвал, соёлын төв бол театр, чуулга биш соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулдаг төв учраас бүс нутгийн онцлогийг илэрхийлсэн өнгө үзэмж, дизайнтай, соёл, урлагийн үйлчилгээ үзүүлэхэд нийгмийн бүлэг бүрийн /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ шаардлагыг хангасан барилгын зургийг бүтээх явдал чухал байна.

Тав. Судалгаанд оролцогчид соёлын төв, ордны ажилтнуудыг орон нутгийн баяр, наадам, урлаг спортын наадам, номын сан, нүүдлийн соёлын үйлчилгээ, дугуйлангийн үйл ажиллагааг сайн, харин түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах сурталчилгаа, төрийн бодлого, шийдвэрийн мэдээлэл, урлагийн боловсрол олгох, нийгмийн түншлэл, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настай иргэдэд зориулсан ажлыг хангалтгүй байна гэжээ. Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд соёлын үйлчилгээг үзүүлэхэд дээрхи орчин нөхцөл нөлөөлдөг байна.

Соёлын төв, ордны иргэдэд чиглэсэн соёлын үйл ажиллагааны чанар, хүтээмжийг нэмэгдүүлэхэд санхүү, мэргэжлийн хүний нөөцийн хангалт, зориулалтын барилга, үйл ажиллагааг хэвийн явуулах тоног төхөөрөмжийн хүрэлцээ зэрэг нь нэн тулгамдсан асуудал болж байна.

Тоног төхөөрөмжийн чанар, хүрэлцээ хангамжийг сайжруулахад бүтээгдэхүүн нийлүүлэх компани хэрэглэгчийг шууд холбох нь чухал юм. /Судалгааны явцад соёлын төвийн ажилтнуудтай хийсэн уулзалт-зөвлөгөөний үеэр техник, тоног төхөөрөмжийг авахад тендер зарладаг нь бүтээгдэхүүний үнэ өсөх, чанар зэрэгт нөлөөлж байгааг өгүүлсэн билээ/.

Соёлын төв /ордон/-оос сургалт, дугуйлан зохион байгуулахад баримтлах сургалтын хөтөлбөр стандартыг бүс нутгийн онцлогийг харгалзан шинээр боловсруулж, мөрдөх шаардлагатай. /Уулзалт-зөвлөгөөний үеэр өөрийн боломжоор явуулдаг тухай ярьсан юм/

Зургаа. Соёлын төвөөс үзүүлэх үйлчилгээний хувьд нэр томъёо, үндсэн ойлголтууд, тэмдэглэгээг тодорхойлох, явуулын үйлчилгээ, дугуйлангийн ажилд тавигдах шаардлага, тэдгээр ажил үйлчилгээнд шаардагдах техник, материал хангамжийн нөхцлийг тодорхойлох, ажилтнуудад тавигдах байгууллагын хэм хэмжээг тодорхойлох, харин байгууллагын үйл ажиллагааны хувьд удирдлага зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ажил амралтын цагийг зохицуулах, үйлчлүүлэгч хүлээн

авах журам, төлөвлөлт, тайлагналт, бүртгэл мэдээлэл боловсруулах, үр дүнг үнэлэх хяналтын арга гэх зэрэг үйл явцыг хэмжихүйц болохоор стандарчилах нь соёлын төвийн үйлчилгээ үйл ажиллагааг чанарын шинэ шатанд гаргах боломжийг бүрдүүлэх юм.

Мөн соёлын төвийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулахад аль хэсгийг нь техникийн зохицуулалтаар, ямар үйл ажиллагааг стандартаар зохицуулж болохыг харуулахын тулд техникийн зохицуулалт, стандарт гэсэн хоёр ойлголтыг хэрэглэх шаардлагатай.

Төр, олон нийт, иргэдийн сайн дурын байгууллагаас хүн амын дунд соёл, хүмүүжил, чөлөөт цагийн ажил явуулах түшиц газар, хүмүүсийн өсөн нэмэгдэж буй оюуны болон соёл, чөлөөт цагийн эрэлт хэрэгцээг хангах, тэдэнд мэдлэг, боловсрол, хүмүүжил олгох, авьяас билгээ нээн хөгжүүлэхэд нь идэвхтэй туслах үүрэг бүхий орон нутгийн соёлын байгууллага⁶⁵ болсон соёлын төв нь стандартчиллыг нэвтрүүлснээр:

- Олон янзын утгыг нэг ойлголтонд оруулж, үндэслэлгүй, шаардлагагүй зүйл, үйл ажиллагааг цэгцлэх, давхардал, хийдлийг арилган дэс дараалалд оруулж, эмхлэх боломжтой болно.
- Үргэлж хязгаарлагдмал байдаг материал, эрчим хүч, хөдөлмөр, байгалийн болон бусад нөөцийн зарцуулалтад шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хязгаарлалт тогтоон арвилан хэмнэх боломжийг нэмэгдүүлнэ.
- Соёлын төвийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг үйлчлүүлэгчид, бас ажиллагсдын амьдралын чанарын нэг хэсэг болгон сайжруулж нийгэмшүүлэх боломжийг буй болгоно.
- Соёлын төвийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанарын талаарх хамгийн тохиромжтой үзүүлэлтийг стандартчилан тодорхойлсноор ямар ч гэрээ хийсэн гэрээний гол нөхцөл нь тодорхой байх ач холбогдолтой болно.
- Соёлын төвийн ажил, үйлчилгээний стандартчиллын объектыг тодорхойлж, тэдгээртэй холбоотой хэм хэмжээ, шаардлагыг (дүрмүүд, параметрийн утга, хэрэгжүүлэх нөхцөл) тодорхойлох боломжийг нээнэ.
- Мөн тодорхой шаардлагад нийцсэн стандартууд нь бүтээгдэхүүн ажил үйлчилгээний нотолгоо, баталгаажуулалт болно.

⁶⁵ Сумын соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм. БСШУ-ны сайдын тушаал №83. 2011 он. 1-р хавсралт

- Хүмүүсийн хоорондын харилцаа, нөлөөлөл, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар, техник хангамжийн систем, мессеж дамжуулах суваг зэргийг нэг голдрилд оруулан хүмүүсийн ажил хэрэгч, төвөггүй харилцаа холбоо, харилцан үйлчлэлийг буй болгоно.
- Хамгийн гол нь бүтээгдэхүүн (үйлчилгээ) хэрэглэгч, үйлдвэрлэгч, төрийн аюулгүй байдлыг хангах, соёл иргэншлийн, технологийн нөлөөнөөс байгаль орчныг хамгаалах, үйлчлүүлэгч, амьтан, ургамлын амь нас, эрүүл мэндийг хамгаалахад хүний хүч чармайлтыг нэгтгэсэн хамгаалалтын механизмыг бий болгоно.

Харин соёлын төв /ордон/-ийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг өөрсдөө баталсан дүрэм журмаар зохицуулахаар бүтээгдэхүүн үйлчилгээний үйл явцыг нарийн эрэмбэлж, удирдлага, менежментийн аргыг хэрэглэх боломж нээлттэй байгааг анхаарах хэрэгтэй юм.

Зөвлөмж

Соёлын ордуудын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх стратегийн үзэл баримтлалыг Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Соёлын үйлдвэрлэлийн хөтөлбөр зэрэгт уялдуулах нь чухал юм.

Нөгөө талаас, соёлын төв, ордуудын хөгжлийн өнөөгийн түвшинг өндөр хөгжилтэй улс орнуудын туршлага, олон улсын байгууллагын стандарт, менежмент, маркетингийн аргуудтай уялдуулах, нэвтрүүлэх шаардлагатай байна гэж үзэж байна. Мөн төрийн дэмжлэг, зохицуулалтгүйгээр ялангуяа орон нутгийн соёлын төв, ордныг соёлын бодлогын либераль загвараар дан ганц зах зээлийн механизм, зохицуулалтад тулгуурлан хөгжүүлэх боломжгүй юм. Өнөөдөр соёлын төв, соёлын ордуудын үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулахад шийдвэрлэвэл зохих асуудлуудад дараах зүйлүүдийг оруулж байна. Үүнд:

1. Соёлын төв, ордуудын үйлчилгээний хүртээмжийг хүн амын амралт, чөлөөт цагийн эрэлтэд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, бүтээлч орчинг бий болгох замаар нэмэгдүүлэх.,

2. Соёлын төв, ордны үйлчилгээний чанарыг үнэлэхэд орчин үеийн үйлчилгээний чанарын үнэлгээний SERVQUAL загвар, хэрэглэгчийн хөндлөнгийн үнэлгээний жишиг загварыг ашиглах.,

3. Соёлын төв, ордонд чанарын менежментийн ISO 9001 2015 стандарт болон ISO 29993 стандартыг нэвтрүүлэх нь албан ёсны боловсролоос гадуур сургалтын үйлчилгээнд тавигдах хамгийн бага шаардлагуудын багцыг заасан үйлчилгээний стандарт бөгөөд энэхүү стандартыг судалж нэвтрүүлэх боломжийг хайх.,

4. Үйлчилгээний чанарыг сайжруулахад үйлчилгээ төвтэй соёлыг нэвтрүүлэх.,

5. Соёлын үйлчилгээний барилга байгууламжийн нормыг тооцохдоо хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД30-01-04-т заасны дагуу тооцох шаардлагатай бөгөөд хэлбэр хэмжээний хувьд заавал нэг загвартай байх шаардлагагүй бөгөөд орон нутгийн онцлог, нөхцлийг харгалзан үзэх.,

6. Соёлын үйлчилгээний стандарт, үнэлгээний аргачлалыг боловсруулахад нэр томъёоны тайлбарыг тодорхой, ойлгомжтой байдлаар хэрэглэх.,

7. Соёлын үйлчилгээний хөндлөнгийн үнэлгээг их дээд сургууль, төрийн бус байгууллагуудыг оролцуулан, нээлттэй зарлаж, шалгаруулалт, гэрээгээр хийх.,

8. Ингэхдээ үнэлгээг тогтоосон аргачлалын дагуу, мөн "хөндлөнгийн", үзэгчийн үнэлгээ явуулах боломж нөөцийг дэмжих, бүрдүүлэх үүнийг шалгуур үзүүлэлтэд оруулах. үнэлгээ тус бүрийн дараагаар үнэлгээний аргачлал, зарчимд сайжруулалт хийж байх.,

9. Соёлын төв, ордны хүний нөөцийг бэлтгэдэг их дээд сургуулийн хичээлийн агуулга хөтөлбөрийн үзэл баримтлал, үндсэн чиглэлийг эргэж харах, сайжруулах, ялангуяа хүний эрх, нийгэм соёл, гэр бүлийн гэх мэт хөгжил дэвшлийн санааг тусгах.,

Санал.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед аймаг нийслэл, сум дүүргийн болон бүс нутгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх зорилго бүхий орон нутгийн соёлын байгууллага⁶⁶ болох соёлын төвүүдийг Монгол орны бараг сум болгонд байгуулан материаллаг бааз байгуулж соёлын төвийн сүлжээ, бүхэл бүтэн тогтолцоог бий болгосон энэ амжилтыг эвдэж өөрчлөхгүйгээр, зах зээлийн өнөөгийн нөхцөлд улам хөгжүүлэн төрөөс бодлогоор дэмжих шаардлагатай байа.

Иймээс нэн тэргүүнд дараах алхамуудыг хийх саналыг дэвшүүлж байна.

⁶⁶Монгол улсын “Соёлын тухай хууль” 1996 он. III бүлэг. IV заалт. Соёл, урлаг шинэ нөхцөлд-VIII.УБ., 2017 он. 9-р тал.

- Соёлын төв /ордон/-ийн үйлчилгээ үйл ажиллагааг үнэлэх, сургалт дугуйлан, клубуудын үндсэн чиглэл, үзэл баримтлал зэргийг боловсруулахын тулд эдгээр байгууллагын улсын үзлэгийг зохион байгуулан паспортжуулах.,
- Стандартчлал нь бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг үйлдвэрлэх, цэгцлэх, эргэлтэд оруулах, түүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн, олон удаа ашиглагдах зориулалт бүхий дүрэм, журам ойлголтыг буй болгох сайн дурын үйл ажиллагаа учраас энэ чиглэлийн судалгаа хийдэг байгууллага, хувь хүн, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, анхан шатны байгууллага дээр ажиллагсдаас бүрдсэн ажлын хэсэг байгуулан, үйл ажиллагааг нь санхүүжүүлэн дэмжлэг үзүүлэх.,
- Соёлын төв /ордон/-ийн барилга байгууламж, гадаад дотоод орчин нь тухайн орон нутгийн байгаль, газарзүйн онцлог, суурьшин амьдарч буй угсаатны аж төрөх байдал, зан заншил онцлогтой холбогдсон уран сайхны илэрхийлэл бүхий дизайн хийцтэй байхаас эхлээд иргэдийн амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдал, үйлчлүүлэгчдийн өмч, төрийн болон нийтийн өмчийн өмчийг хамгаалах, байгаль орчны аюулгүй байдлыг хангах бүтэц, хийц, хамгаалалттай байх нийтлэг шаардлагатай байдгийг харгалзан үзэж техникийн зохицуулалтыг боловсруулах, түүнийг эрх бүхий байгууллагаар батлуулах, дагаж мөрдөхөд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх.,

ДОЛОО. АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ЭХ СУРВАЛЖ

Нэг сэдэвт бүтээл:

1. Амартүвшин М. Орон нутаг дахь төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамж, нөлөөлж буй хүчин зүйлс. -УБ., 2015
2. Аюуш С. Соёл гэгээрлийн ажил чөлөөт цаг. -УБ., 1988.
3. Баатар Г. Алжаал тайлах соёл. -УБ., 2008.
4. Белостоцкая А.А., Круглов А.В. Оценка качества в системе маркетинга услуг. - СПб.: Изд-во СПбГУЭФ, 2009.
5. БНМАУ-ын соёлын түүх (1941-1960) дэд боть. -УБ., 1986.
6. Боловсролын салбарын эрх зүйн эх сурвалж. -УБ., 2012.
7. Даваасамбуу П. БНМАУ-ын соёл гэгээрлийн ажлын түүхэн замнал. -УБ.,1990.
8. Даваасамбуу П. Ардын боловсрол, соёл-урлаг, шинжлэх ухааны талаархи хууль тогтоомжийг системчилсэн эмхэтгэл. УБ.,1990
9. Долгорсүрэн Ж. Соёлын бодлого соёл, урлагийн салбарын хувьчлал. -УБ., 2010.
10. Жаргалсайхан Ц. Соёлын төв, соёлын ордны ажилтан нарт тусламж. -УБ., 2016.
11. Затева Н.А., Татарова С.П. Деятельность учреждений культуры Республики Бурятия:сравнительный анализ. -Улан-Үдэ.,2018

12. Монголын соёлын түүх. Урлахуйн аймаг. Гутгаар боть. УБ.1999.
13. Монгол улсын түүх. V боть. -УБ., 2004.
14. Соёл урлаг шинэ нөхцөлд-VII. -УБ., 2014.
15. Монгол улсын үндэсний статистикийн хороо. Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал, -УБ., 2011.
16. Пунсалдулам Б. Шинэ соёл Монголд төлөвшсөн түүх (XX зуун). -УБ., 2018.
17. ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс. Гэгээрлээр бичигдэх он жилүүд. - УБ., 2005.
18. Эрхэмтөгс Ж. Монгол улсад соёлын бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх арга зам. Бизнесийн удирдлагын докторын зэрэг горилсон бүтээл. Удирд: Оюунцэцэг Л. - УБ., 2016.

Ном, сурах бичиг:

1. Алтанцоож С. Зочлох үйлчилгээний чанарын удирдлага. УБ.,2017 он
2. Баатар Г. Соёлын ажлын онол арга зүй. -УБ., 2008.
3. Багшийн хөгжил. Баримтын эмхэтгэл. УБ.,2018.
4. Батсүх Б., Батжаргал Ж. Дуу хөгжим заах арга зүй. Ред. Баярхүү П. УБ.,1992.
5. Даваасүрэн М., Сосорбарам Т. Европын стандартыг Монголд нутагшуулах асуудал. -УБ., 2011.
6. Жарков А.Д. Теория и технология культурно-досуговой деятельности. -Москва ,2007.
7. Зөвлөх багшийн арга зүй, туршлага. УБ.,2019.
8. Ичинхорлоо Ш. Сургалтын онол, хэрэглээ. УБ.,2013.
9. МАХН-аас урлаг-утга зохиолын талаар гаргасан тогтоол шийдвэрүүд /1921-1966/. УБ.1967.
10. Монгол улсын үндэсний статистикийн хороо. Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал, -УБ., 2011.
11. Мөнхдалай З. Номын сан мэдээллийн байгууллагад мөрдөх стандартын эмхэтгэл. -УБ., 2013.
12. Оюундэлгэрэх Ш., Жипах Х. Соёлын менежмент, маркетинг. -УБ., 2010.
13. Отгонсүрэн Я .Үйлчилгээний маркетинг. -УБ., 2012.
14. ССАЖЯ. Соёл урлаг шинэ нөхцөлд, цуврал 2, 3, 4, 5 ,7. -УБ., 2000, 2003, 2005, 2010.
15. Соёл, урлаг шинэ нөхцөлд – ҮII. Жаргалсайхан Ц. Эмх. -УБ.,2012

16. Соёл, урлаг шинэ нөхцөлд-VIII. УБ., 2017 он.
17. Сосорбарам Т., Баянмөнх П. Үйлчилгээний чанарын удирдлага. -УБ., 2013.
18. Сосорбарам Т. Төрийн албаны стандартын удирдлагын зарим асуудал. -УБ., 2011.
19. Сосорбарам Т. Чанарын нэгдсэн удирдлага. -УБ., 2009.
20. Соёлын төв чанартай үйлчилгээ. Төслийн тайлан. -УБ., 2007.
21. Соёлын үйлчилгээ-хүний хөгжилд. Төслийн тайлан. -УБ., 2007.
22. Сургалтын технологи, үзэл баримтлал, онол арга зүйн зарим асуудал. Ред. Пүрэв О., Содномваанчиг Г. УБ.,2001.
23. Төлөвлөлт, хяналт- шинжилгээ, үнэлгээний гарын авлага. -УБ.,2016
24. Туул Т. Ардын тайзны бүжиг. УБ.,2012.
25. Үйлчилгээний чанарыг сайжруулах арга замууд. СЭЗДС-ийн ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл. -УБ., 2016
26. Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийх 10 алхам. -УБ., 2014
27. Чилхаасүрэн О. Стандарт, чанарын үндсэн асуудал. -УБ., 2014.

Англи хэлээр:

1. Basic Texts of the 2005 Convention on the Protection and Promotion of the Diversity of Cultural Expressions. page 5. UNESCO, 2019 Edition.
2. Gregory J. Cize, Amy A Germuth, Audra E Kosh, Lorrie A Schmid, 2016.
3. Re|shaping cultural policies: advancing creativity for development. 2005 Convention global report, Summary. page 10. UNESCO, 2018.
4. Susanne Bosh, *Evaluation criteria – How to measure art and culture projects* 2004.
5. Ravelli L.J. *Museum Texts: Communication Frameworks*. London: Routledge, 2006
6. *A Checklist Evaluating Credentialing Resting Programs*, The Evaluation Center, Western Michigan University Susanne Bosh, *Evaluation criteria – How to measure art and culture projects* 2004.
7. Using the SERVQUAL Model to assess Service Quality and Customer Satisfaction. Umea School of Business, 2010.

Толь бичиг:

1. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. -УБ., 1966.
2. ШУА-ийн ХЗХ. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. V Боть. -УБ., 2008.

Эрх зүйн баримт бичиг:

1. Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс, музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS:5634:2006.
2. Монгол улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого. -УБ., 2012.
3. Монгол улсын соёлын тухай хууль. -УБ.,1996.
4. Монгол улсын статистикийн эмхэтгэл. -УБ., 2018.
5. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал. -УБ., 2008.
6. Монгол улсын хууль. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай. 2017.
7. Модельный стандарт Деятельности муниципального учреждения культуры клубного типа Красноярского края. Москва.,2010.
8. Модельный стандарт деятельности учреждений культурно-досугового типа вологодской области. Вологда., 2013.
9. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага. /Requirements and services of museums/. MNS:97.195 2006.
10. Мэргэжлийн урлагийн байгууллагын орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага. **MNS:6476 - 2014.**
11. Номын сангийн орчин нөхцөл үйл ажиллагаанд тавигдах шаардлага. MNS: 5272-2007.
12. Нийтийн номын сангийн үйлчилгээ: ОУНСХ/ЮНЕСКО удирдамж .-УБ.,2003
13. Нийтийн номын сангуудын тайлан 2016 .-УБ.,2017
14. Нийтийн номын сангуудын тайлан 2015 .-УБ.,2016
15. Нийтийн номын сангуудын тайлан 2014 .-УБ.,2015
16. Нийтийн номын сангуудын тайлан 2013 .-УБ.,2014
17. Нийтийн номын сангуудын тайлан 2012 .-УБ.,2013
18. ОХУ-ын Соёлын яамны 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 599-р тоот тушаалын хавсралт
19. Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай 2005 оны конвенцын үндсэн барим бичгүүд. ЮНЕСКО. УБ.,2017
20. Стандартчилал тохиролын үнэлгээний тухай хууль. -УБ., 2003.
21. Сумдын хөгжлийн загвар. Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоол.
22. Сумын соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм. БСШУ-ны сайдын тушаал №83. 2011 он.
23. Хүний хөгжлийн Илтгэл 2015. Хүний хөгжлийн төлөө хөдөлмөрлөх нь. Нэгдсэн Үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр. 2015

24. ЮНЕСКО-гийн дэлхий дахины тайлан илтгэл. Соёлын төрөл зүйл, соёл хоорондын харилцааг тэтгэхүй. -УБ., 2005.

Орос хэлээр:

1. Н.А.Затеева, С.П. Татарова. Деятельность учреждений культуры Республики Бурятия:сравнительный анализ. Улан-Үдэ., 2018
2. Большая Советская энциклопедия. М.: Сов. Энци., 1969, 1978.
3. Воротникова Е.Ю. Социокультурные аспекты музейного сервиса. Т. 11, No. 4 (74).2017.
4. Гнедовский М.Б., Дукельский В.Ю. Музейная коммуникация как предмет музееведческого исследования // Музеи России: поиски, исследования, опыт работы. СПб, 1995.
5. План мероприятий ("дорожная карта") "Изменения в отраслях социальной сферы, направленные на повышение эффективности сферы культуры- УТВЕРЖДЕН распоряжением Правительства Российской Федерации от 28 декабря 2012 года N 2606-р(с изменениями на 28 апреля 2015 года)
6. Приказ Министерства культуры Российской Федерации от 22.11.2016 №2542. «Об утверждении показателей, характеризующих общие критерии оценки качества оказания услуг организациями культуры» (зарегистрирован Минюстом России 02.12.2016 регистрационный № 44542) (далее - приказ Минкультуры России № 2542).
7. Приказ Министерства культуры РФ от 7 марта 2017 г. № 261. Независимая оценка качества условий оказания услуг организациями культуры
8. Приказ Министерства культуры РФ от 22 мая 2018 г.№765. О внесении изменений в Положение о выплатах стимулирующего характера руководителям федеральных государственных учреждений, находящихся в ведении Министерства культуры Российской Федерации, утвержденное приказом Министерство культуры РФ от 16 сентября 2013 г. N1351
9. Указ Президента Российской Федерации от 07.05.2012 №597. «О мероприятиях по реализации государственной социальной политики» и постановление Правительства Российской Федерации от 30.03.2013 №286 «О формировании независимой системы оценки качества работы организаций, оказывающих социальные услуги».

Социологийн судалгааны тайлан

1. Нийслэлийн соёл, урлагийн газар. “Нийслэлийн соёл, урлагийн байгууллагын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, соёлын үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэх төсөл боловсруулах суурь судалгаа” төслийн тайлан. СУИС. УБ., 2018.
2. Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн харъяа “Уурхайчин” соёлын ордны хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа. Судалгааны тайлан. СУИС ТУС. 2016.
3. Хүн амд хүргэх соёл урлагийн үйлчилгээний тулгамдсан асуудлууд. Хавсарга судалгааны тайлан. Төслийн удирдагч: Алтанцэцэг Ч., гүйцэтгэсэн: Тунгалаг Д., Анхбаяр Ц. СУСХ. -УБ., 2010.
4. Монголын соёлын үйлдвэрлэл, соёл урлагийн хувьсал өөрчлөлт (төслийн тайлан). СУСХ-ийн архивын сан хөмрөг. Х-2, Д-1, Хн-13. -УБ.2013.
5. “Соёл урлагийн салбарын хөгжил” социологийн судалгааны тайлан. УБ., 2008

Сонин

1. Үнэн сонин. 1988. VI.25, №152/17055.

Цахим эх сурвалж

URL: <http://www.wikipedia.mn>

URL: <http://www.legalinfo.mn>

URL: <http://www.google.com>

URL: <http://www.estandart.gov.mn>

URL: http://www.masm.gov.mn/mn/images/pdf/MLSUT_webd.pdf

URL: <https://uk.pinterest.com/explore/cultural-center/?lp=true>

URL: <http://www.thetattooedtravelers.com/polynesian-cultural-center/>

URL: <https://uk.pinterest.com/pin/402298179192086570/>

URL: <http://www.lcsd.gov.hk/en/hkcc/index.html> hongkong

URL: <http://www.discoverhongkong.com/ca/see-do/arts-performance/arts-venues/hong-kong-cultural-centre.jsp>

<https://www.boell.de/en/educulture/education-culture-evaluation-criteria-How-to-measure-art-and-culture-projects-14370.html>

<https://www.biodiversitya-z.org/content/cultural-services/>

http://knowledge-askhar.blogspot.com/2017/06/blog-post_84.html

<https://mongoltoli.mn/dictionary/detail/100011>
<http://1212.mn>
https://www.ifla.org/node/1025?fbclid=IwAR1k_j1KQNN3s_TUcUkzxAfeHv8LxFP9dl6DBJ445OunJLRDtsJJq4swHKY
<http://www.ala.org/tools/research/librariesmatter/category/return-investment-roi?page=1>
https://www.ifla.org/node/1025?fbclid=IwAR1k_j1KQNN3s_TUcUkzxAfeHv8LxFP9dl6DBJ445OunJLRDtsJJq4swHKY
https://urbanintellectuals.com/malawian-teen-taught-build-windmill-junk-brought-power-village-learned-library-books/?fbclid=IwAR0tDRZNNK3DnTYVvzsR2wptvjElfvi5OLhIL_ZlSwggK67drvVPabriX
<10>
<https://glosbe.com/en/en/cultural%20activity>
<http://www.unesco.org/new/en/culture/themes/armed-conflict-and-heritage>
<http://whc.unesco.org/en>
<http://www.unesco.org/new/en/culture/themes/illicit-trafficking-of-cultural-property>
<https://ich.unesco.org/en/>
<https://en.unesco.org/creativity/>
<https://www.unidroit.org/instruments/cultural-property/1995-convention>
<http://www.unesco.org/new/en/culture/themes/underwater-cultural-heritage/>
<http://www.unesco.org/eri/la/convention.asp?KO=31038&language=E&order=alpha>
www.boell.de/en.educulture/education-culture-evaluation-criteria-How-to-measure-art-and-culture-projects-14370.html
<https://icom.museum/en/activities/standards-guidelines/museum-definition/>
<https://admmegion.ru/gov/laws/detail.php?ID=54584>
<http://www.yarsale-muzey.ru/tinybrowser/files/dokumenty/08/model-nyy-standart.pdf>
https://uk-tisul.ru/upload/DOK/Музей/музей_standart_kachestva.pdf
<https://www.legalinfo.mn/law/details/9020?lawid=9020>
https://www.ifla.org/node/1025?fbclid=IwAR1k_j1KQNN3s_TUcUkzxAfeHv8LxFP9dl6DBJ445OunJLRDtsJJq4swHKY
https://urbanintellectuals.com/malawian-teen-taught-build-windmill-junk-brought-power-village-learned-library-books/?fbclid=IwAR0tDRZNNK3DnTYVvzsR2wptvjElfvi5OLhIL_ZlSwggK67drvVPabriX
<10>

